



N P M
M O N G O L I A



ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

ННА - 67
ДАА - 340
Ц-945

Хянан тохиолдуулсан:

Ядамжавын **ЦЭЛМЭН**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор (Ph.D), профессор

Тайлан боловсруулсан:

Шагдарын **ҮНЭНТӨГС**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Бандийн **ДЭЛГЭРМАА**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан референт

Нанзаддоржийн **МАНЛАЙБААТАР**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Сургалт хариуцсан референт

Гиваасамбуугийн **ДЭЛГЭРБАЯР**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Сурталчилгаа хариуцсан референт

Доржсүрэнгийн **НЯМДОРЖ**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, хууль зүйн доктор (Ph.D)

Энх-Амгалангийн **СҮЛДБАЯР**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Тогтоол шийдвэр, бүртгэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Баттулгын **ИВЭЭЛ**

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Хяналт шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Эх бэлтгэл, хэвлэсэн:

“Эс Пи Ар” ХХК

ISBN 978-9919-0-6745-8

АГУУЛГА

| | |
|--|---|
| ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА..... | 7 |
| УДИРТГАЛ..... | 8 |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

| | |
|---|----|
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа-2025, хүрсэн түвшин, хүлээгдэж буй гүйцэтгэл | 15 |
|---|----|

ХОЁРДУГААР БҮЛЭГ

| | |
|--|-----|
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ | 67 |
| 2.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ..... | 70 |
| 2.2.Цагдаагийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.. | 97 |
| 2.3.Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ..... | 112 |
| 2.4.Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ..... | 138 |
| 2.5.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ..... | 159 |
| 2.6.Их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад хийсэн хяналт шинжилгээ | 178 |

ГУРАВДУГААР БҮЛЭГ

| | |
|---|-----|
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт | 193 |
|---|-----|

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

| | |
|--|-----|
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа | 219 |
|--|-----|

ТАВДУГААР БҮЛЭГ

| | |
|--|-----|
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа | 239 |
|--|-----|

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

| | |
|--|-----|
| Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт | 263 |
|--|-----|

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдал279

НАЙМДУГААР БҮЛЭГ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 2022-2025 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт303

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ317

САНАЛ339

ХАВСРАЛТ343

Хавсралт 1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэхтэй холбоотой үндэсний эрх зүйн баримт бичиг345

Хавсралт 2. Эрүү шүүлтгүй Монголын төлөө - Улаанбаатарын тунхаглал.....354

Товчилсон үгийн жагсаалт 366

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Долоодугаар бүлэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”-ны эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд ХЗБХ-нд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.” гэж заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг боловсруулан танилцуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга”-ын хэрэгжилт, дүгнэлт зөвлөмжид дурдагдсан асуудлыг анхаарч, хүний эрхийг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан саналыг хүндэтгэн, хэрэгжүүлж ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж хэрэгжүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны мэдээлэл, олон улсын байгууллагын дүгнэлтэд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа-2025, хүрсэн түвшин, хүлээгдэж буй гүйцэтгэл”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт”, “Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдал”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 2022-2025 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн, ахиц дэвшил” гэсэн 8 бүлэгтэйгээр, дүгнэлт, саналын хамт боловсрууллаа.

УДИРТГАЛ

Эрүү шүүлт тулгах буюу эрүүдэн шүүх аливаа үйлдэл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу гэмт хэрэгт тооцогддог бөгөөд буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах нь төрийн шууд үүрэг юм. Үүнтэй адил хүнийг хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх зарим төрлийн үйлдлийг мөн олон улсын эрх зүйн зохицуулалтын дагуу гэмт хэрэг хэмээн үзэж, хариуцлага хүлээлгэдэг. Төр нь төрийн албан хаагч албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж хүнийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ хувь хүн, бүлэг болон хуулийн этгээдийн дээрх хууль бус үйлдлийн улмаас хүний эрх зөрчигдөх явдлаас хамгаалах үүрэгтэй.

Монгол Улс 2015 онд эрүүгийн хуульдаа эрүү шүүлт тулгах гэмт хэргийг төрийн бүх албан хаагчид хамаарах байдлаар гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлсон боловч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид л хамаатай гэсэн уламжлалт ойлголт амь бөхтэй оршсоор байна.

Хуулийг иргэдэд таниулах, үр дагавар, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажил дутмаг байгаа бөгөөд гэмт хэрэг, зөрчлийг үйлдэгдсэний дараах шалгах, шийдвэрлэх ажилд хэт анхаарч, төсөв хөрөнгө, хүний нөөцийг хуваарилж байгаа ч үр дүн сул, иргэдийн хохирол бодитой барагдахгүй, зөрчигдсөн эрх боломжит байдлаар сэргээгдэхгүй хэвээр байгаад дүгнэлт хийх цаг болсон.

Олон улсын эрх зүйн суурь, амин чухал үнэт зүйл болсон амьд явах эрх болон эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрөөс хүндэтгэн хамгаалах үндсэн үүрэгтэй бөгөөд аливаа хэлбэрээр үгүйсгэж үл болно. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр бүрэн хориглосон. Тухайлбал, зэвсэгт мөргөлдөөн, террорист халдлагын эсрэг ажиллагаа болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ч эрүүдэн шүүхийг хориглодог. Уг зохицуулалт нь олон улсын эрх зүйн суурь зарчим тул тухайн улс холбогдох олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон эсэхээс үл хамааран заавал мөрдөх олон улсын эрх зүйн императив шинжтэй (*jus cogens*) хэм хэмжээнд хамаарна. Энэхүү хүний эрхийн хамгаалалтыг аливаа хэлбэрээр үгүйсгэх, хязгаарлах боломжгүй.¹

Технологи, хиймэл оюун ухааны хөгжил огцом хурдацтай өрнөж буй өнөө үед “эрүүдэн шүүх”, “хүнлэг бус, хэрцгий, доромж харьцаа”, “хүний нэр төрийг доромжлох”-той холбоотой олон улсын эрх зүйн ойлголт, тодорхойлолт, шалгуур үзүүлэлтүүд улам бүр тэлж, шинэ агуулгаар баяжигдаж байна. Хиймэл оюун ухаан бодит хэрэглээнд өргөнөөр нэвтэрч буй нь хүний халдашгүй, чөлөөтэй байх, нэр төрөө хамгаалуулах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хувийн нууцаа хамгаалуулах эрхүүдийг зөрчих бодит эрсдэлийг үүсгэж байна. Алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, өгөгдөл цуглуулах системүүд хүний бие махбод,

1 “Улс гомдол гаргасан тохиолдолд олон улсын эрх зүй зөрчигдсөн эсэхийг тогтоон шийдвэрлэх бүрэн эрх нь Олон улсын шүүхэд хадгалагдана” (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн салшгүй хэсэг болох 1945 оны 6 дугаар сарын 26-нд батлагдаж, 1945 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсон Олон улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b)-д заасан).

Where a complaint is submitted by a State, the International Court of Justice has competence to declare whether a violation of customary international law has in fact occurred (Article 38(1)(b), Statute of the International Court of Justice, annexed to the Charter of the United Nations, 26 June 1945, T.S. 993, entered into force Oct. 24, 1945, and incorporated therein by Article 92)

сэтгэл зүй, үзэл бодол, хувийн шинжтэй мэдээллийг цуглуулж, гуравдагч этгээдэд дамжуулах явдал түгээмэл болж, улмаар ялгаварлан гадуурхах, доромжлох, хүнлэг бус байдлаар харьцах нөхцөлийг бүрдүүлж байна. Эдгээр шинэ харилцааг зохицуулах эрх зүйн орчин одоогоор бүрэн төлөвшөөгүй, хангалтгүй хэвээр байгаа нь хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас үүдэх хохирлыг нөхөн төлүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх механизмыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Олон улсын эрх зүй нь бие даан оршин тогтнодог тогтолцоо бус бөгөөд олон талт гэрээний талуудын практик, тайлбар, шүүх, арбитрын шийдвэр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын /НҮБ/ тусгай илтгэгчдийн тайлан, дүгнэлт зэрэг нь бодитой нөлөө үзүүлдэг. Хүний эрхийн соёл, нийгмийн үнэт зүйлсийн хөгжилтэй уялдан “эрүүдэн шүүх” гэх ойлголт нь анх конвенц, хуульд заасан хүрээнээс давж, илүү өргөн агуулгаар тайлбарлагдах болсон талаар олон улсын судалгаануудад тэмдэглэгдэж байгаа бөгөөд Монгол Улсын хувьд ч шинэ үйлдэл, эс үйлдэхүй бүртгэгдэх шинжтэй байгаа нь анхаарал татна.

Олон улсын болон бүс нутгийн байгууллагууд харилцан шүүхийн практик, экспертүүдийн санал дүгнэлтээс суралцан, илүү уялдаа холбоотой, нэгдмэл эрх зүйн тогтолцоог аажмаар бүрдүүлж байна. Үүний нэг жишээ нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тайланг иш татан, гэрээний хороодын зөвлөмжид нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг шинэчлэх, түүний хэрэгжилтийг гэрээний хороод болон олон улсын түвшинд эргэн тогтмол тайлагнах тогтолцоо төлөвшсөнийг дурдаж болно.

НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодын дүгнэлт, зөвлөмжүүд нь хууль зүйн хувьд цаг хугацааны явцад өөрсдийн зөвлөх эрх мэдлийн уян хатан боломжийг ашиглан эрүүдэн шүүхийн тодорхойлолт, төрийн хүлээх үүрэг, хэрэгжилтийн хүрээг мэдэгдэхүйц тэлж ирсэн нь хүний эрхийн соёлыг дэлхий даяар бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах явдлаас хамгаалах чиглэлд гарсан хамгийн өргөн хүрээтэй ахиц дэвшлийн нэг нь улс орнуудад хүний эрхийн үндэсний урьдчилан сэргийлэх механизмуудыг байгуулах явдал юм. Энэ хүрээнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг, 2002 онд тус конвенцын Нэмэлт протоколыг баталсан бөгөөд Монгол Улс тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

Нэмэлт протоколын суурь үзэл баримтлал нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлж, хүний эрхийг сахин хамгаалах нь бүх нийтийн үүрэг, хариуцлага болохыг хүлээн зөвшөөрч, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний болон олон улсын тогтолцоог бүрдүүлэхэд оршдог.

Гэхдээ Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг нэгдэн орсон Монгол Улсын Олон улсын гэрээний шаардлагад нийцүүлж байгуулах нь хамгаас чухал юм.

Монгол Улсын хувьд өнгөрсөн зууны 1937 оны хэлмэгдүүлэлт², энэ зууны эхээр болсон 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн³ сонгуулийн маргаантай холбоотой эсэргүүцлийн жагсаал, үймээн самуун, түүнийг хүч хэрэглэн тараах явцад гарсан хар бараан хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг давтан гаргуулахгүй байлгах, олон улсын түвшинд хүний эрхийн хяналт тэнцлийг тавьдаг, тайлагнадаг байх, хүний эрхийн механизмын хяналтыг бэхжүүлэх нь үндэсний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөөс урьдчилан сэргийлэх онцгой ач холбогдолтой.

Олон улсын туршлагаас судлахад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нэгдэн орсон улс орнууд Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг (NPM)-ыг байгуулах, үйл ажиллагааг нь эхлүүлэх, цаашид бэхжүүлэх явцад тогтолцооны, санхүүгийн, улс төрийн шинжтэй олон бэрхшээлүүдтэй тулгарч ирсэн байна. Үүний зэрэгцээ Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага (NPM) анхлан байгуулсан зарим улсын туршлага нь манай улсын хувьд үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, тэргүүн туршлагыг нутагшуулахад ач холбогдолтой сургамж болж байна. Иймд ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагааны замнал, хуримтлуулсан туршлага, ололт амжилт болон бодит үр нөлөөг иж бүрнээр нь эргэн дүгнэхэд одоо тохиромжтой цаг үе юм.

Тухайлбал, Гүрж, Аргентин, Чили, Унгар, Их Британи, Энэтхэг, Израил, Киргиз, Норвег, Перу, Турк, Филиппин, Өмнөд Африк, Тунис, Индонез улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол (OPCAT)-д нэгдэн орж, Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулсан анхдагч улсуудын нэг юм. Эдгээр улсын Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагуудын санаачилгаар ЭШЭК-д нэгдэн орж, ҮҮСБ-аа байгуулсан анхдагч улс орнууд хамтран Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ)-ийн санхүүжилтээр “Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх нь үр дүнтэй юу?” сэдэвт олон улсын судалгааг хэрэгжүүлж, уг судалгааны үр дүнд тулгуурлан цаашдын бодлого, үйл ажиллагааны стратегийг тодорхойлсон байна.⁴

Тус судалгаанд нийт 16 улс оролцож, 20 гаруй судлаач дөрвөн жилийн хугацаанд хамтран ажилласан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд хүмүүсийг анх баривчилсан мөчөөс нь эхлэн хамгаалах үр нөлөөтэй эрх зүйн баталгааг бүрдүүлэх нь эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга хэмжээ болохыг тогтоожээ. Түүнчлэн эрүүдэн шүүлт болон түүнтэй адилтгах хэрцгий,

2 1937 оны хэлмэгдүүлэлтийн үеэр судлаачдын таамгаар 20,000-35,000 хүн буудуулж амь насаа алдсан, баривчлагдсан гэж үздэг. Энэ үед их хэмжээний эрүүдэн шүүлт, хүнлэг бус үйлдлүүд, улс, үндэстний эсрэг чиглэсэн хядлага, цаазаар хороох ажиллагаанууд өрнөсөн жил байжээ. Эдгээр үйл явдал нь нөхцөл, шалтгаанаараа өөр боловч олон хүнийг эрүүдэн шүүж, хилсээр хэрэг тулган цаазалж, хүний эрх ноцтой зөрчигдсөн юм. (Dr. Daniel Schmäcking, *Alle Jahre wieder: Regierungskrise in der Mongolei*, 2007; Др. Даниел Шмюкин, Рафаэлла Хэлф, Социалист нийгмийн үеийн Монгол оронд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт, 2017, Konrad-Adenauer-Stiftung e.V.; Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын эмхэтгэл, 1997).

3 Amnesty International-ийн 2009 онд нийтэлсэн англи хэл дээрх тайланд 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод болсон сонгуулийн маргаантай холбоотой эсэргүүцлийн жагсаал, үймээн самуун, түүнийг хүч хэрэглэн тараах явцад гарсан хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг баримтад тулгуурлан судалсан байна. Уг тайланд 700 гаруй хүнийг баривчилсан бөгөөд баривчлагдсан иргэдийг цагдаагийн төв хашаа руу авч явах явцад болон саатуулах хугацаанд хүч хэрэглэх, амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулах, эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах үйлдлүүд гарсан тухай олон тооны гомдол бүртгэгдсэнийг дурджээ. Мөн албадан саатуулах, эрүүдэн шүүх болон хүний эрхийн бусад ноцтой зөрчилтэй холбоотой гомдлуудыг шалган шийдвэрлэх ажиллагаа удаашралтай, үр нөлөө багатай явагдсан талаар онцлон тэмдэглэсэн байна (Amnesty International, *The Legacy of the 1 July 2008 Riot in Mongolia*, 2009). <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/asa300032009en.pdf>

4 Does Torture Prevention Work? Liverpool University Press 2016. <https://www.jstor.org/stable/j.ctt1gpcbd7>

хүнлэг бус харьцаа үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, нотолгоонд суурилсан үр нөлөөтэй мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах нь урьдчилан сэргийлэх бодлогын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохыг дүгнэсэн байна. Энэхүү судалгаа нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлд үндэсний болон олон улсын түвшинд хийсэн анхдагч нотолгоонд суурилсан үнэлгээ юм. Судалгааны үр дүн нь энэ салбарт ажиллах хүмүүст анхаарч хэрэгжүүлэх боломжтой тэргүүлэх чиглэлийг гаргаж, юунд тулгуурлан ажиллавал үр дүнтэй болохыг тодорхойлсноороо онцлог.

Хүний эрхийн хараат бус хяналтын байгууллагуудын (NPM) үйл ажиллагаа нь тухайн улсад эрүү шүүлт буурдаг, түүнээс урьдчилан сэргийлэхэд бодит, эерэг нөлөө үзүүлдэг болохыг судалгаагаар нотолсон байна. Судалгааны хүрээнд мөн эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд ашиглах боломжтой аргачлал, үнэлгээний загварыг боловсруулсан нь чухал ач холбогдолтой байв.

Монгол Улсын хувьд Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (ЭШУСҮА)-ны санаачилгаар, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар “Монгол Улсад эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн анхны суурь судалгаа”-г 2025 онд хийж гүйцэтгэсэн⁵ бөгөөд тус судалгааны үр дүнд ҮУСБ-ыг бэхжүүлэх боломжит арга замуудыг тодорхойлсон байна. Судалгаанд тулгуурлан эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсад хүний эрхийн хамгааллын үндэсний тогтолцоо бэхжиж, хүний эрхийн нөхцөл байдал шат ахих бодит боломж бүрдэх талаар дүгнэлт гарсан.

Судалгааны зорилго нь эрүүдэн шүүх явдлын төлөв байдал, шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогч судлал, урьдчилан сэргийлэх чиглэлээр нарийвчлан судлах, хууль эрх зүйн болон үйл ажиллагааны бодлого, тодорхой шийдвэр гаргах чиглэлийг тодорхойлох, эрүүдэн шүүх гэмт явдлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх тусгайлсан арга замыг тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн.⁶

“Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн судалгаа”-г УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд болон УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал нарын ахалсан 3 ажлын хэсгийн хуралдаан, УИХ-ын гишүүдэд танилцуулж, өргөн барихаар боловсруулж буй холбогдох хуулийн төсөлд тусган ажиллаж байна.⁷

Иймд “Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх нь үр дүнтэй юу?”, “Ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх нь оновчтой вэ?” гэсэн суурь асуултуудад хариу өгөх зорилгоор Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс

5 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх 2024 оны үйл ажиллагааны тайлангийн Хавсралт судалгаа бүлэг. <https://d.parliament.mn/tusul/de28a983-49cf-48c4-b35a-2c8d9fa6f293>

6 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) хэрэгжиж эхэлснээс хойш эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрчимжиж, тэдгээрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, иргэдийн болон шинжээчдийн судалгаанаас харахад тодорхой үр дүнд хүрсэн байна. Монгол Улсад эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох криминологийн судалгаа. Монголын Криминологичдын холбоо. 2025 он. <https://d.parliament.mn/tusul/de28a983-49cf-48c4-b35a-2c8d9fa6f293>

7 УИХ-ын даргын захирамжаар Хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий УИХ-ын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. <https://d.parliament.mn/tusul/592cd558-7c3b-4afc-bb78-ff366f3f6c10>

өргөн хүрээний суурь судалгаа хийж, түүний үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах зарчмыг баримталж ажиллалаа.

Олон улсад Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага болон түүний нөлөөллийг үнэлэхдээ дараах хоёр аргачлалаар үнэлдэг. Үүнд үйл явц (process) болон үр дүн (outcomes) гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Үйл явцын үнэлгээ нь Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын хараат бус байдал, санхүүгийн болон хүний нөөцийн хангалт, институтийн нийт чадавхыг тодорхойлоход чиглэнэ. Өөрөөр хэлбэл, Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага нь өөрт ногдсон чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай институтийн "орц"-оор хангагдсан эсэхийг үнэлэхэд оршино. Үүнийг үнэлэхдээ санхүү, хүний нөөц, үйл ажиллагааны хараат бус байдал, олон талт байдлын үнэлгээний хэрэгслийг ашиглаж, хараат бус зарчмуудад тусгагдсан стандартуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлдог.

ҮУСБ-ын бодит үйл ажиллагааг, тухайлбал хаалттай байгууллагуудад хийж буй айлчлалын давтамж, урьдчилан мэдэгдээгүй айлчлалын хэрэгжилт, саатуулагдсан хүмүүстэй хийдэг ярилцлагын нууцлал, тайлангийн ил тод байдлыг үнэлнэ.

Үр дүнгийн үнэлгээ нь ҮУСБ-ын үйл ажиллагааны богино болон урт хугацааны үр нөлөөг тодорхойлоход чиглэнэ. Богино хугацаанд байгууллагаас дэвшүүлсэн санал, асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжүүд бодитоор хэрэгжиж байгаа эсэхийг шалгах нь үндсэн шалгуур болдог. Энэ нь урт хугацаандаа эдгээр зөвлөмжийн үр дүнд эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хүнлэг бус харьцаа бодитоор буурч байгаа эсэхийг үнэлэхэд төвлөрдөг.

Олон улсын судалгааны үр дүнгээс харахад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь зөвхөн хууль тогтоомж батлах, техникийн хяналтын хэрэгсэл нэвтрүүлэх, сургалт зохион байгуулахаар хязгаарлагдахгүй, харин хараат бус хяналт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хамарсан иж бүрэн систем буюу тогтолцоо бүрдсэн байхыг шаарддаг.

Иймд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодлого, механизмын үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлсний үр дүнд тухайн улс оронд эрүүдэн шүүх болон бусад хууль бус үйлдлээс үүдэн хүний эрх зөрчигдөх тохиолдол мэдэгдэхүйц буурч, хууль сахиулах байгууллагад иргэдийн итгэх итгэлийг сэргээх эерэг хандлага ажиглагдаж байна.

Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орж, үүрэг хүлээсэн улсын хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлгийн 17, 18, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх бололцоог олгох шаардлагатай байна.

Тус конвенц, түүний Нэмэлт прокотолд заасны дагуу дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус байдал, үр нөлөөг дээшлүүлэх замаар шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шийдвэртэй бүрэн хараат бусаар ажиллах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь анх байгуулагдсанаас хойш 4 жилийн хугацаанд Засгийн газрын болон төрийн зарим байгууллагууд, тухайлбал аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад нийт 193 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 922 заалт бүхий 96 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэн, зөвлөмж тус бүрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшлийг тооцон ажилласан байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт 81.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан чиг үүргийн дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийж байна. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөл бүхий нийт 843 газарт, давтагдсан тоогоор жилд 150000 /нэг зуун тавин мянга/ орчим хүн богино, дунд, урт хугацаагаар байрлаж байна. Энэ хүрээнд нэн тэргүүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор зорилтот бүлгийн 37000 гаруй хүнд тогтмол хүрч ажиллан, хяналт шинжилгээ хийн, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хяналт шинжилгээ хийх газар нь 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийг хамардаг бөгөөд үйл ажиллагааны хүрээ өргөн юм. Гэвч Засгийн газраас төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотгол хийх шийдвэрт бас өртөж 10 албан хаагчийнхаа 2 албан хаагчийн цомхотгуулж, үндсэн чиг үүргийг ердөө 8 албан хаагч хэрэгжүүлж байгаа нь бодит ачаалалтай харьцуулахад хангалтгүй бөгөөд албан хаагчдын ажиллах нөхцөл хүнд, баталгаагүй, орон тоо, төсөв, санхүү, техник хэрэгслийн хангалт нь хуульд заасан шаардлагад нийцэхгүй, эрсдэл бүхий нөхцөл хэвээр байгааг тайланд тусгаж 4 дэх жилдээ УИХ-д танилцуулж байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаар баталсан CAT/C/MNG/CO/3 дугаар Ажиглалт, дүгнэлтэд Монгол Улсын Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдаад удаагүй хэдий ч стратеги төлөвлөгөөгөө баталж, богино хугацаанд чадавхжиж, үр нөлөөтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн бөгөөд эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ахиц дэвшил гаргасныг онцлон тэмдэглэсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь дээр дурдсан хаалттай, алслагдсан, тархай байрласан объектуудад ямар ч цаг үед саадгүй хүрэлцэн очих, хаалттай бүсэд нэвтрэх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг гэнэтийн хяналт шинжилгээ хийх онцгой бүрэн эрхээ бодитой хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байгааг дурдах нь зүйтэй. Энэхүү механизм нь эрүү шүүлт гарсны дараа шалгах арга барилд бус, харин гарч болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлж,

тогтмол хяналт шинжилгээ хийх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг. Үүний зэрэгцээ тогтолцооны хувьд өөрчлөх шаардлагатай нөхцөл байдлыг илрүүлэн тогтоож, засаж сайжруулах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж, санал хүргүүлж, хэрэгжилтийг хангууллаа.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны явцад эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангах чиглэлээр тодорхой үр дүнд хүрч, ахиц дэвшил гарч байгаа боловч нөхцөл байдал харилцан адилгүй хэвээр байгаа тул төрөөс тогтолцооны түвшинд сайжруулахад чиглэсэн холбогдох арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА-2025, ХҮРСЭН ТҮВШИН, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

НЭГ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, улмаар УИХ-аас 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн томилогдсоноор Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхлээд дөрөв дэх жилийн тайлангаа боловсруулан танилцуулж байна.


Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (ХЭҮКтХ)-ийн Долоодугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх (ЭШУС) асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, баталгаа болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн үндэс, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх чиг үүргийг хуульчлан баталгаажуулсан.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлгийн 17, 18, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”



Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, Улсын Их Хурал тус тус соёрхон баталсан.



Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй.

Нөгөөтээгүүр Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлэгт заасан Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын эрхлэх асуудлын хүрээ, чиг үүрэг, зохицуулалтын харилцаа Монгол Улсад нэгэн адил үйлчилнэ.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (ХЭҮКтХ)-ийн Долоодугаар бүлгээр зохицуулсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалт, чиг үүрэгт тусгагдаагүй бусад харилцааг Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ болох Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлэгт заасан зохицуулалтыг шууд хэрэгжүүлж ажиллах бүрэн эрхтэй болно.

Энэхүү олон улсын эрх зүйн болон үндэсний хууль тогтоомжийн үйлчлэл, зохицуулалтын талаар гурав дахь жилдээ төрийн байгууллагуудад, тэр дундаа Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бүрдүүлэгч үндсэн

байгууллагад ойлгуулах, таниулах, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах талаар хүндрэлтэй, ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Хүний эрхийн шинэ механизм нутагшуулах, олон улсын эрх зүйн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжийн адил үйлчлэлд хууль хэрэглээний түвшинд мөрдөж, хэрэглэх соёл, төлөвшилд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Энэ талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн гэрээний хороодоос удаа дараа Монгол Улсад олон улсын гэрээ, конвенцод хууль тогтоомжоо нийцүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх замаар шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авах чиглэлээр чармайн ажиллаж, хэрэгжилтийг тайлагнан, холбогдох зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөөр ирсэн байна.⁸

Үйлчлэх хүрээний хувьд аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийж, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, олон нийтэд сурталчлах, судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй хамтран ажиллах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн гэрээний хороодоос 8 удаагийн зөвлөмж, дүгнэлт гарган Монгол Улсад ирүүлсэн. Мөн УИХ-ын 2023-2025 оны хооронд гарсан 5 удаагийн тогтоол гарч, НҮБ-ын гэрээ конвенцод хууль тогтоомжоо нийцүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар төсөв санхүү, хүний нөөцийн бие даасан, хараат бус байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай шийдвэрүүд гарч, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Гэвч бодит байдал дээр УИХ-ын тогтоолууд, НҮБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас бодит алхам хийгдэхгүй удааширч байгааг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт зааснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил тутам ХЗБХ-нд танилцуулж, УИХ-аар хэлэлцсэнтэй холбогдуулан батлагдсан УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэг, УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг, УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 77 дугаар тогтоолын 9 дэх хэсэг, мөн УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар авах арга хэмжээний талаар зааж, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

⁸ Хүний эрхийн форум 2025. Монгол Улсын Засгийн газраас хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, анхаарах асуудлууд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмарын илтгэл. 2025.12.10



Эдгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй бөгөөд Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байгааг анхаарна уу.

Улсын Их Хурлын Хүний эрхийн анхны хяналтын сонсголыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсгол зохион байгуулсан. Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхтэй холбоотой асуудлын талаарх нөхцөл байдлын талаар хөндөгдөн хэлэлцэгдсэн. Улмаар хяналтын сонсголттой холбогдуулан УИХ-ын мэргэжлийн байнгын хороо болох Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 09 дүгээр тогтоол гарч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар даалгасан.

УИХ-ын даргын 2025 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан УИХ-ын гишүүдийн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий 1 ажлын хэсэг, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийг хангахтай холбогдуулан УИХ-ын гишүүдээс

бүрдсэн 2 ажлын хэсэг байгуулагдан, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүрэгтэйгээр ажиллаж байна.⁹

⁹ Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан. УИХ-ын 2025 оны Намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал. <https://www.parliament.mn/nn/76196/>

ХОЁР. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт: Монгол Улсын ХЭҮКтХ-ийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан заалтуудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийлгэхийг Улсын Их Хурлын ХЗБХ-нд даалгасан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар ЭШУС үндэсний ажиллагаанаас хараат бус судлаачдын багаар “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа” захиалан гүйцэтгүүлсэн.

ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэсэн¹⁰.

ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалтын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколтой нийцэж байгаа эсэх болон холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Тус судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй, ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэж байна гэж дүгнэгдсэн.¹¹

Түүнчлэн ЭШУС үндэсний үйл ажиллагаа нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод заасан хяналт шинжилгээ хийх газрыг хязгаарласан, хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг олгохгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь тогтоогдсон гэж дүгнэсэн. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр Монгол Улсын ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулсан 22 заалтын зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна.

¹⁰ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338>

¹¹ Монгол Улсын Хүний эрхийн комиссын тухай хуулийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй, ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэхүйц байгаа нь энэхүү дүн шинжилгээгээр тогтоогдож байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ 2024 он. Ж.Амарсанаа нар. <https://d.parliament.mn/tusul/de28a983-49cf-48c4-b35a-2c8d9fa6f293>



2. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаасаа ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоол батлагдсан.

Тус тогтоолын 2 дугаар зүйлийн е-д “Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх криминологи судалгаа болон энэ төрлийн гомдол шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл байдлын талаар хөндлөнгийн судалгааны байгууллагаар суурь судалгаа хийлгэх” гэж заасан. УИХ-ын ХЗБХ-ны захиалгаар ЭШУС үндэсний ажиллагаанаас хараат бус судлаачдын багаар (Монголын Криминологичдын холбоо) “Монгол Улсад эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн анхны суурь судалгаа”-г захиалан гүйцэтгүүлсэн.

Судалгааны зорилго нь эрүүдэн шүүх гэмт явдлын төлөв байдал, шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогчийн судлал, урьдчилан сэргийлэх чиглэлээр нарийвчлан судлах, хууль эрх зүйн болон үйл ажиллагааны бодлого, тодорхой шийдвэр гаргах чиглэлийг тодорхойлох, эрүүдэн шүүх гэмт явдлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх илүү үр дүнтэй, тусгайлсан арга замыг тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн¹².

Энэхүү судалгааг 2017-2024 онд бүртгэгдсэн Эрүүдэн шүүх гэмт явдалтай холбоотой гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг (төрийн нууцтай холбоотой гэмт хэрэг хамрагдаагүй болно) болон эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагаар ирүүлсэн гомдлуудыг (2020-2024 он) дүн шинжилгээ хийх, мөн эрүүдэн шүүхтэй холбоотой олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүд, холбогдох бусад баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх аргыг ашиглан явуулсан.

Энэхүү 2 суурь судалгааг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон УИХ-ын даргын 2025 оны захирамжаар байгуулагдсан УИХ-ын гишүүдийн ажлын хэсгийн хуралдаануудад танилцуулсан болно.

Хоёр жил дараалан хийсэн суурь шинжтэй эдгээр судалгааны дүнг захиалга өгсөн ХЗБХ-нд танилцуулж, холбогдох арга хэмжээ авч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хүргүүлсэн болно. Холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хүний эрхийг хангах тогтолцоог бэхжүүлэхэд чухал алхам гэдгийг анхаарах нь зүйтэй.

¹² Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) хэрэгжиж эхэлснээс хойш эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрчимжиж, тэдгээрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, иргэдийн болон шинжээчдийн судалгаанаас харахад тодорхой үр дүнд хүрсэн байна. Монгол Улсад эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох криминологийн судалгаа. Монголын Криминологичдын холбоо., 2025 он. <https://d.parliament.mn/tusul/de28a983-49cf-48c4-b35a-2c8d9fa6f293>

ГУРАВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (цаашид ЭШЭК гэх)-ын Нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байна.



Тус нэмэлт протоколын 17 дугаар зүйлд “Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага (цаашид “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага”) байгуулах, томилох,

эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд оролцогч улсуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүргийг хүлээлгэсэн.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 дүгээр сарын 11-ээс 20-ны өдрүүдэд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц, түүний Нэмэлт протоколын хүрээнд олгогдсон эрхийн дагуу айлчлал хийж зөвлөмжид (b) Үндэсний урьдчилан сэргийлэх механизмд олгох эрх хэмжээ, бүрэн эрхийг хуульд тусгах, эсхүл үндсэн хуулийн үг хэллэгээр тодорхой илэрхийлэх, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын үйл ажиллагаа явуулах бие даасан, хараат бус байдлыг хуулиар баталгаажуулах, практикт хэрэгжүүлэх талаар тусгагдсан билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.12-т “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.

Тухайлбал, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж хуульчилсан.

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар¹³ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас “...ЭШЭК-ын Нэмэлт протоколд заасны дагуу ЭШУС үндэсний механизмыг бий болгох үйл явцыг хурдасгах, ...хүний эрх чөлөөг хязгаарладаг бүхий л газарт хараат бусаар тогтмол хийх хяналт, шинжилгээг бэхжүүлэх;” зөвлөмжийг ирүүлсэн.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 3-аас 14-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлалын хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаарх урьдчилсан дүгнэлтэд хараат бус байдал алдагдсан байгааг анхааруулсан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит 54 дүгээр чуулганаар хэлэлцэн баталж Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн “Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Монгол Улсад хийсэн айлчлалын тайлан, зөвлөмж”-ийн “(б) Хүний нөөцийг сонгох асуудалд Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын бие даасан байдлыг хангах; Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын нэгжийг 10-с дээш хүний бүрэлдэхүүнтэй болгож, чиг үүргийг нь хангалттай нөөцийн хуваарилалттайгаар аль болох хурдан эхлүүлэх; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд өөрийн үйл ажиллагаанд зориулагдсан санхүүжилтийг бие даан хуваарилах боломжийг олгох замаар Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын санхүүгийн бие даасан байдлыг хангах;” гэж заасан.

Дани улсын Копенхаген хотноо 2023 оны 11 дүгээр сарын 6-аас 8-ны өдрүүдэд болсон Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын олон улсын 14 дүгээр хурлаар баталсан “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх дэлхий нийтийн төлөвлөгөө - Тунхаглал”-ын В. Урьдчилан сэргийлэх. а) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколыг соёрхон батлах, бие даасан, хангалттай нөөцтэй Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг томилохыг дэмжинэ” гэж заасан.

Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь удаагийн тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний

¹³ 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Хүний эрхийн төлөв байдлын ээлжит ерөнхий хэлэлцүүлэгт Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцээд 170 зөвлөмж өгсөн. <https://www.upr-mongolia.mn/?cmd=Content&menuid=41&id=227>

Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт уриалж, зөвлөмж ирүүлсэн.¹⁴

НҮБ-ын Хүний эрхийн Хороо (ICCPH)-ны 143 дугаар чуулган Женев хотноо 2025 оны 03 дугаар сарын 10, 11-ны өдрүүдэд хуралдаж, Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын ээлжит долоо дахь илтгэлийг 4195, 4196 дугаар хуралдаанаараа хэлэлцэж, 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 4212 дугаар хуралдаанаараа ажиглалт, дүгнэлтийг баталж, Монгол Улсад зөвлөмж ирүүлсэн¹⁵.

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр зүй бус харьцах явдлын эрсдэл дэлхий даяар нэмэгдэж байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх үүрэг улс үндэстнүүдэд хүлээлгэсэн.

Монгол Улсын Их Хурлаас хүний эрхийн чиглэлээр анх удаагийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонголыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Энэ нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирол нөхөн барагдуулах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбогдуулан энэхүү нээлттэй сонголыг зохион байгуулсан. Үүний мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоол батлагдсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд

14 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь удаагийн тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж:

14. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд

14.1 Санхүү болон хүний нөөцөөр хангах, тэр дундаа Конвенцын Нэмэлт протоколын дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа бүх төрлийн байранд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн мэргэшсэн салбар дундын мэргэжилтнүүдээр хангах болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн нэгжийн бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархан эрхийг хуулиар тогтоох.

14.2 Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвөөс хараат бус байх нөхцөлийг хангах.

14.3 Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33.1.1 дэх хэсэг болон түүний тайлбарт нэмэлт өөрчлөлт оруулан Конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ерөнхий тайлбарын 1 (2024)-д заасны дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан бүх газруудын нэгдсэн жагсаалтыг тусгах

15 НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 143 дугаар чуулган (2025 оны 03 дугаар сарын 3-28-ны өдрүүд)-аар Монгол Улсад өгөх ССРР/С/МНГ/7 зөвлөмж баталсан.

хамаарахгүй.” гэж заасан бөгөөд 2 дахь хэсэгт “Хэрэв олон улсын болон бусад дотоодын хуульд уг ойлголтыг илүү өргөн утгаар хэрэглэдэг бол энэ зүйл нь тэдгээрт хохирол учруулахгүй.” гэж эрүү шүүлт тулгахаас өргөн хүрээнд хамгаалах боломжийг бусад улсуудад бүрдүүлжээ.

Мөн тус конвенцын 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улсууд эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзнэ. Энэ нь эрүүдэн шүүхийг завдах, түүнд оролцох, хамтран оролцоход хамаарна.”, 2 дахь хэсэгт “Оролцогч улс бүр ийм гэмт хэрэг үйлдэгчид хэргийн нөхцөл байдлыг нь харгалзан зохих шийтгэл ногдуулна.” гэж тодорхой заажээ.

Монгол Улс эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд “Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх” зарчмыг хуульчилсан бөгөөд 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.”, 16.12 дугаар зүйлд “Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх” зарчмыг хуульчилсан бөгөөд 1 дэх хэсэгт “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй гэж тус тус заасан.

Гэвч эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж, эрүү шүүлт тулгаж авсан, тайлбар мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын:

4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

б/эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 37 дугаар “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын:

8. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

а/шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно.” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;

б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 77 дугаар “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын:

6. Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар:

ё/гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр эхлэн барагдуулах, түүнчлэн хохирлыг нөхөн төлөх төсвийн эх үүсвэрийг гэм буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого зэргээс бүрдүүлэх зохицуулалт бүхий Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх сангийн тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төслийг боловсруулах;

ж/эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүйн, эрүүл мэнд, нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн харилцаанд эргэн ороход дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулах.

7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг судалж, шаардлагатай гэж үзвэл хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;

б/Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлэгт зохицуулсан “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлах;

в/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх;

г/Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах;

д/эрүү шүүлт тулгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хараат бусаар хянан шалгах бие даасан бүтэц байгуулах.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.10-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ” гэж заасан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоол батлагдсан. Үүнд:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар:

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг оролцоог тодорхойлох, хүний нөөц чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь удаагийн тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжийг “2025-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч ажиллаж байна.

Улсын Их Хурлын хяналтын сонголыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

зохион байгуулсан “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголоор хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхтэй холбоотой асуудал болон цэргийн анги, байгууллага дахь дүрмийн бус харьцааны талаарх нөхцөл байдлын талаар хөндөгдөн хэлэлцэгдсэн.

Цэргийн анги байгууллагын байрлалд цэргийн алба хаагч, хүний амь нас хохирсон тохиолдол:

- 2022 онд 2;
- 2023 онд 7;
- 2024 онд 1.

Хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдол:

- 2022 онд 9;
- 2023 онд 8;
- 2024 онд 9 тус тус бүртгэгджээ.

Эдгээр тоо баримт нь бүгд хугацаат цэргийн алба хаагч хохирсон үзүүлэлт биш боловч цэргийн ангийн байрлалд үйлдэгдэж байгаагаар анхаарал татаж байна.

Зэвсэгт хүчний жанжин штабын мэдээлэлд 2021 оноос 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 5 хугацаат цэргийн алба хаагч амь насаа алдсан, 16 офицер ахлагч, 13 хугацаат цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна. Үүний шалтгаан нөхцөлийг дүрмийн бус харьцааны зөрчил, эрүүл мэнд суурь өвчний улмаас, ар гэр, найз нөхдийн хүрээнд үүссэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй, цэргийн албанаас шантарч өөрийн биед санаатай гэмтэл учруулсан гэж үзжээ.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2023 оны 06 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 14 цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон¹⁶ байна.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт зэвсэгт хүчний хэмжээнд 2020-2024 онд иргэдээс 49250 өргөдөл, гомдол ирүүлснээс Хүний эрх, эрх чөлөө, дүрмийн бус харилцааны талаар гаргасан 25 өргөдөл, гомдол ирүүлж, 19 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, 6 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн байна.¹⁷

Түүнчлэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд дурдагдсанаар сүүлийн 10 жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагад 468 эрх зүйн зөрчил буюу гэмт хэрэг, сахилгын зөрчил бүртгэгдсэний 242 нь зэвсэгт хүчинд хамааралтай байна. Зэвсэгт хүчний хэмжээнд бүртгэгдсэн 242 зөрчлийн 144 нь гэмт хэргийн шинжтэй, 98 нь сахилгын зөрчил байна. Дээр дурдсан 98 сахилгын зөрчлийн 41 нь буюу 41.8 хувь нь дүрмийн бус харьцаа, 24 нь буюу 24.4 хувь нь хугацаат цэргийн албанаас оргон зайлсан зөрчил байгаа талаар

16 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дахь илтгэл. <https://d.parliament.mn/tu-sul/6910f213-5cfc-4464-8189-ec1d42554c89>

17 УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаарх хяналтын сонсголын мэдээлэл. <https://www.parliament.mn/>

холбогдох судалгаа дүн шинжилгээ гарчээ¹⁸.

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Цэргийн саатуулах байранд 2019-2024 онд нийт 23 цэргийн албан хаагч саатуулагдсан байна¹⁹.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжөөр “Сахилгын тусгаарлан саатуулах байрын ажиллах журам”-ыг 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр УЕП, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан А/31,А/74 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

Цаашид эрүү шүүлтийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох, сургалт, нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх нь зүйтэй.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн чухлыг эргэн санаж, НҮБ-ын хүний эрхийн механизм, тэдгээрийн хараат бус шинжээч, ажлын хэсгийн зөвлөмжийг гарцаагүй хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад шинээр бүрэлдэн бий болж байгаа эмзэг цаг үе гэдгийг мэдэрч, маш олон хаалттай хаалганы цаана байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахыг чухалчлан, хууль тогтоогч, ОУБ, ТББ, хүний эрхийн болон нийгмийн зүтгэлтэн, судлаач, иргэдийн оролцоо, дэмжлэг нэн хэрэгтэй байгааг тодотгон, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах арга хэмжээг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Эрүүгийн хууль, бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

1.1. УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРЬЖ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХААР БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн барьсан.

¹⁸ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл. <https://d.parliament.mn/tusul/6910f213-5cfc-4464-8189-ec1d42554c89>

¹⁹ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх 2024 оны үйл ажиллагааны тайлан. <https://d.parliament.mn/tusul/de28a983-49cf-48c4-b35a-2c8d9fa6f293>



Улсын Их Хурлын даргын захирамжаар хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий УИХ-ын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэхүү хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслүүдэд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарим хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилготой дараах зохицуулалтууд тусгагдсан байна.

Эрүү шүүлт тулгах, хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг НҮБ-ын гэрээний хороод болон олон улсын хүний эрхийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор боловсруулах Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх, хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах баривчлах шийтгэлийг цөөрүүлэх, Улсын Их Хурлаас баталсан зарим хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдлүүдийг шинээр тусгах зэрэг зохицуулалт бүхий Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнуудад бий болдог хүндрэл, чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, зарим төрлийн хэргийн харьяаллын алдааг засах зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үүнтэй холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгох зохицуулалт бүхий Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зохицуулалт бүхий Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэгдэж байна.

2.1. ХУУЛЬ, ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ БОЛГОСОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР

Улсын Их Хурлаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэж, хүний эрх, эрх чөлөөг хангах, урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх, эрх зүйн орчныг олон улсын стандарттай нийцүүлэх, хараат бус, үр нөлөөтэй хэрэгжүүлэх талаар Засгийн газар болон холбогдох байгууллагуудад тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасан тогтоолуудыг удаа дараа баталж ирсэн. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар Албан даалгавар гарч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг даалгасан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт зааснаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил тутам ХЗБХ-нд танилцуулж, УИХ-аар хэлэлцсэнтэй холбогдуулан батлагдсан УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэг, УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг, УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 77 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг, мөн УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар авах арга хэмжээний талаар зааж, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хорооны гишүүд ЭШУС үндэсний ажиллагааны тайлантай танилцан, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд дараах тогтоол батлагдсан. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол;²⁰
2. Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол;²¹

²⁰ УИХ-ын 2023 оны 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар

А/Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

Б/Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах. www.legalinfo.mn

²¹ УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг. ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:

8/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

А/Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно.” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

3. Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол;²²
4. Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоол;²³
5. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг

9/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

А/Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох”-ыг Засгийн газарт даалгасан.

Б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. www.legalinfo.mn

²² Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг. ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд: Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийх чиглэлээр:

1/Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын ХЗБХ болон Хүний эрхийн дэд хороонд даалгасан. www.legalinfo.mn

²³ Улсын Их Хурлын 2025 оны 77 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын:

6/Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар:

ё/гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр эхлэн барагдуулах, түүнчлэн хохирлыг нөхөн төлөх төсвийн эх үүсвэрийг гэм буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого зэргээс бүрдүүлэх зохицуулалт бүхий Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх сангийн тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төслийг боловсруулах;

ж/эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүйн, эрүүл мэнд, нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн харилцаанд эргэн ороход дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулах.

7/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг судалж, шаардлагатай гэж үзвэл хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;

б/Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлэгт зохицуулсан “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлах;

в/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх;

г/Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах;

д/эрүү шүүлт тулгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хараат бусаар хянан шалгах бие даасан бүтэц байгуулах. www.legalinfo.mn

- хамгаалахтай холбогдсон Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоол.²⁴
6. Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-г батлах тухай” 42 дугаар тогтоол Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратегийн зорилтын 5.3-т “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан.
 7. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай” 21 дүгээр тогтоол (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн)
 8. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр УИХ-ын бие даасан 5 тогтоол, хавсарсан 2 тогтоол, Хууль зүйн байнгын хорооны 1 тогтоол, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсан нь Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн томоохон бодлогын арга хэмжээ болсон. Тус тогтоолууд хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, замын зургийг тодорхойлж, бодитой ахиц гарахад чухал түлхэц үзүүлсэн.

Харин Улсын Их Хурлаас баталсан дээрх тогтоолууд нь Монгол Улсын Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх гол бодлогын баримт бичгүүд боловч тэдгээрийн хэрэгжилт хангагдахгүй байгаа нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг бодлогын түвшинд хүлээн зөвшөөрсөн хэвээр үлдээж, дотоодын хууль эрх зүйн болон тогтолцооны бодит өөрчлөлтөд шилжүүлж чадахгүй байна.

Энэ нь УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн асуудал нь зөвхөн нэг байгууллага, салбарын хүрээний асуудал бус, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд олон улсын гэрээний үүргийг бодитоор хэрэгжүүлэх чадварт нөлөөлж буй тогтолцооны шинжтэй асуудал болохыг илтгэнэ.

²⁴ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар:

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

2020-2024 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүүдэн шүүлтийг таслан зогсоох чиглэлд УИХ-ын чухал тогтоол, шийдвэрүүд батлагдаж, бодитой ахиц өөрчлөлт гарсан. Үндсэн хууль, төрөлжсөн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр иргэдийн эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрхийг баталгаажуулсан, түүнийг хангах, хамгаалах үйл ажиллагааг дэмжих, бэхжүүлэхэд тодорхой ахиц гарсан байна.

Монгол Улс олон улсын конвенц, гэрээ, пактуудаар хүлээсэн үүргээ биелүүлж, Хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын гэрээний хороодод тайлагнах механизм бүрдүүлж, парламентаас манлайлж ажиллах, гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээний заалтыг шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын гэрээний үүрэг, зөвлөмжийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд тогтмол тайлагнадаг журамд шилжиж, эрүүдэн шүүлтийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлын “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголыг зохион байгуулдаг болсныг олон улсын хүний эрхийн байгууллагуудын зүгээс үнэлж, бүс нутгийн хэмжээнд сайн туршлагаар тооцож байр сууриа илэрхийлэн сайшааж байгааг дурдаж байна.²⁵

Энэ үүргийн дагуу ЭШУС үндэсний ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд тогтмол оролцож, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, судалгаа, дүгнэлт гаргах зэрэгт бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.

Улсын Их Хурлын дээрх тогтоолуудын хэрэгжилтийг Засгийн газар цаг хугацаанд нь тайлагнаж, хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

25 НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дарга Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд жилийн тайлангаа танилцуулав. Chair of the Subcommittee on Prevention of Torture Presents Annual Report to the Committee against Torture <https://www.ohchr.org/en/meeting-summaries/2025/04/chair-subcommittee-prevention-torture-presents-annual-report-committee>

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо (SPT) гишүүн орнуудын эрүүдэн шүүхийн эсрэг үйл ажиллагаатай холбоотой тайлан, нийтлэлүүдийг сайшаан хүлээн авч, эдгээр нь эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа, шийтгэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна гэж үзсэн. Түүнчлэн НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь 2024 оны тавдугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалын дараах нууц тайлангаа Монгол Улсад (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмд - ЭШУСҮА, NPM) дамжуулж, уг айлчлалын тайланг олон нийтэд ил болгож, сайн туршлагыг дагахыг Монгол Улсад уриалсан байна.

<https://www.ohchr.org/en/press-releases/2025/02/un-torture-prevention-body-postpones-first-2025-visit-amid-un-liquidity>

3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улсын Их Хурлын дээрх тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүй байгааг холбогдох байгууллагуудаас хийсэн дүн шинжилгээгээр тогтоосон байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээ

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.7 дахь заалт, 115.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан”-д дүн шинжилгээг хийсэн.

Улсын Их Хурлаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын нийт 5 тогтоолын биелэлтэд Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийхэд биелэлт дунджаар 45.8 хувь буюу “хэрэгжилт хангалтгүй” байна гэж дүгнэгдсэн. Засгийн газарт даалгасан үүргийн хэрэгжилт үр дүнгүй байна гэж гарчээ.

2. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээ

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр 04-ны хуралдаанаар танилцуулсан бөгөөд дээрх тогтоолын заалтууд “хэрэгжээгүй” гэж үнэлэгдсэн байна.

3. ЭШУСҮА-ны дүн шинжилгээ, тайлагнал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс дээрх тогтоолуудын хэрэгжилтийн дүн шинжилгээ хийхэд тогтоолуудын зорилго бодит ахиц, тогтвортой өөрчлөлт болж хэрэгжээгүй нь тогтоогдсон.

Энэ хүрээнд хэрэгжилтийг гаргаж Улсын Их Хурлын Тамгын газарт 2025 оны 10 дугаар сарын 02-ны 08/1689 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

УИХ-ын 2023 оны 35, 2024 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилт:

- Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолоор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаарх 1 зорилт, 2 арга хэмжээ, 2024 оны 37 дугаар тогтоолоор 2 зорилт, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус Засгийн газарт даалгасан. Гэвч хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр эдгээр 5 арга хэмжээ “хэрэгжээгүй” буюу 0 хувиар үнэлэгдсэн.
- Тогтоолуудын хэрэгжилтийн талаарх тайланг УИХ-ын ХЗБХ-нд хороонд танилцуулах хугацаа нийтдээ 2 жил 10 сараар удааширсан нь хяналт, хариуцлагын тогтолцоо бодитоор ажиллахгүй байгааг илтгэнэ.

УИХ-ын 2024 оны 114 дүгээр тогтоолын хэрэгжилт:

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тэмдэглэхтэй холбогдуулан хүний эрхийг хангах үндэсний механизмыг бэхжүүлэх, хүний эрхийн боловсрол, сургалт, мэдээллийг

өргөжүүлэх, хүний эрхийн зөрчлийг урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар болон холбогдох байгууллагуудад даалгасан байна. Энэхүү тогтоолын хүрээнд хараат бус судлаачдын баг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, эрх зүйн зохицуулалт нь олон улсын шаардлагад бүрэн нийцээгүй, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, үр нөлөөтэй ажиллах нөхцөл хангалтгүй байгааг дүгнэсэн байна.

УИХ-ын 2025 оны 77 дугаар тогтоолын хэрэгжилт:

- Улсын Их Хурлын 2025 оны 77 дугаар тогтоолоор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаарх 7 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд үүнээс 1 зорилт, 5 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийсэн байна. Одоогийн байдлаар эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилт хуулийн төсөл боловсруулах, судлах зэргээр бэлтгэл ажлыг хангаж ажилласан хэдий ч хэрэгжилт, тогтолцооны өөрчлөлт бодитоор гараагүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын Их Хурлаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг хэлэлцэн баталсан тогтоолуудаар бодлогын зөв чиглэл өгч ирсэн боловч эдгээр тогтоолын хэрэгжилтийг бодит үр дүнд хүргэх, тогтвортой өөрчлөлт бий болгох алхам хэрэгжихгүй байна. Ялангуяа 35, 37 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хэрэгжээгүй, 77 дугаар тогтоолын хэрэгжилт бодит үр дүнгүй байгаа нь УИХ-ын хяналт, хариуцлагын тогтолцоог шинэ түвшинд авч үзэх үндэслэлтэй байна.

Тухайлбал, УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолын 9 дэх зүйлийн б-д “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх” гэж заасан. Энэхүү заалтыг хэрхэн хэрэгжүүлж, НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлан шийдвэрлэх талаар хийгдэж буй ажил тодорхойгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолын 4 дэх хэсгийн Б-д “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.”, УИХ-ын 2024 оны 77 дугаар тогтоолын 7 дахь хэсгийн Д-д “Эрүү шүүлт тулгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хараат бусаар хянан шалгах бие даасан бүтэц байгуулах” гэж УИХ-ын 2 удаагийн тогтоолд заасан.

Эдгээр тогтоолын хэрэгжилтийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024, 2025 оны 5 дугаар сарын хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэрэгжилт хангалтгүй, Засгийн газраас УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж дүгнэсэн.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийн талаарх Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг Засгийн газраас анхаарч, даалгасан үүргийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зохистой байна.

1. Улсын Их Хурлын тогтоолуудад удаа дараа давтагдан тусгагдсан боловч бодит шийдэлд хүрээгүй дараах асуудлууд байна. Үүнд:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн гэрээний хороодоос Монгол Улсад ирүүлсэн удаа дараагийн Зөвлөмжид нийцүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;

- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бие даасан, тодорхой бүлэгтэй болгох;
- Эрүү шүүлтийн гомдол, мэдээллийг хараат бусаар шалгах бие даасан бүтэц байгуулах;
- Эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээлэлд хөөн хэлэлцэх хугацаа үл хамааруулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- Хүний эрхийн сургалтын нэгдсэн, заавал мөрдөх хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах зэрэг асуудлууд орно.

2. Засгийн газарт удаа дараа үүрэг, чиглэл өгч байгаа боловч дараах асуудал шийдвэрлэгдэхгүй хэвээр байна.

- УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах хяналт, хариуцлагын тогтолцоо сул, байгууллагын тогтолцооны шинэчлэл хангалтгүй;
- Хэрэгжилт хангаагүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн болон байгууллагын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй;
- Тогтоолын заалтууд бодлогын баримт бичгийн түвшинд үлдэж, эрх зүйн бодит өөрчлөлт, байгууллагын тогтолцооны шинэчлэлд шилжихгүй байгаа нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үр нөлөөг сааруулдаг;
- Зөвхөн нэг салбар, нэг байгууллагын гүйцэтгэл бус, УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах хяналт, хариуцлагын тогтолцоо сул.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд Засгийн газрын зарим байгууллага, түүнчлэн аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлан ажилласан.

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн тухай бүр зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан боловч зөрчил, дутагдал давтан гарсаар байгаа тул ХЗБХ-нд танилцуулж, Улсын Их Хурлаар хэлэлцсэний үндсэн дээр батлагдсан дээрх тогтоолуудад тусгагдсан асуудалд анхаарч, цаашид холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдгээр тогтоолын хэрэгжилтийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024, 2025 оны 5 дугаар сарын хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэрэгжилт хангалтгүй, Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж дүгнэсэн байгааг ХЗДХЯ-аас анхаарч ажиллах шаардлагатай байгааг гурав дахь удаагийн тайландаа дахин тэмдэглэж байна.

Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Энэхүү хуульд заасан бүрэн эрхийн дагуу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх асуудлаар Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд холбогдох хуулийн төслийг боловсруулан, УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаарх зөвлөмжүүдийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 08/07 дугаар Зөвлөмж, мөн Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарт 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 08/01 дугаар Зөвлөмжөөр хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар гарсан. Монгол Улсын Ерөнхий сайдын Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасугай” гэж заасан.

4.1. НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГААС МОНГОЛ УЛСАД ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ, ТОГТООЛ, ДҮГНЭЛТ

4.1.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодын тайлагналын механизмын талаар

НҮБ-ын Гэрээний хороодын тайлагналын механизм нь хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон улс орнууд тухайн гэрээг хэрэгжүүлж буй талаарх тогтмол тайлангаа НҮБ-ын холбогдох хороодод хүргүүлж, хянуулдаг тогтолцоо билээ. Улс орнууд анхны тайлангаа гэрээнд нэгдсэний дараа, улмаар 4 жил тутамд дараагийн тайлангуудыг ирүүлдэг. Эдгээр тайланд тухайн улсын хууль тогтоомж, бодлого, практик үйл ажиллагаа нь хүний эрхийн гэрээний заалтуудтай хэрхэн нийцэж буйг тайлбарладаг.

Тайланг хэлэлцэх явцад:

- Гэрээний хороо тухайн улсын тайланг судалж,
- Асуултын жагсаалт (List of Issues) хүргүүлж,
- Улсын төлөөлөгчидтэй албан ёсны хэлэлцүүлэг (constructive dialogue) явуулдаг.

Гэрээний хороод:

- Дүгнэлт, зөвлөмж (Concluding Observations) гаргаж,
- Давуу ахиц дэвшил, тулгамдсан асуудал,
- Засаж сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлдог.

Тайлагналын механизмд:

- Иргэний нийгмийн байгууллагууд,
- Үндэсний хүний эрхийн байгууллагууд,
- Омбудсмены алба зэрэг оролцогчид хөндлөнгийн (shadow/alternative) тайлан хүргүүлэх замаар тухайн улсын Засгийн газрын тайлагнал үнэн бодитой эсэхийг хянаж, хувь нэмэр оруулж болдог.

Энэхүү НҮБ-ын Гэрээний хороодын тайлагналын механизм нь улс орнуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах, олон улсын стандартыг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй байдаг.

4.1.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжүүд

НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодын тайлагналын механизмын дагуу Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн талаарх Монгол Улсын илтгэлийг Засгийн газар НҮБ-ын гэрээний хороодод тодорхой хугацаанд хамгаалж, Зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласнаа тайлагнаж ирсэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2020 оны 36 дугаар чуулганы хуралдаан, 2021 оны 50 дугаар чуулганы хуралдаан, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны хуралдааны 54 дүгээр чуулганы хуралдаан, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны (CAT) 2024 оны 81 дүгээр хуралдаан, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн (ICCPR) 2025 оны 4212 дугаар хуралдаан, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны (SPT) 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу Монгол Улс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бие даасан, хараат бус байдлаар бий болгох арга хэмжээ авах” талаар удаа дараа зөвлөмж гарган ирүүлсэн. Үүнд:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хорооны 2016 оны 08 дугаар сарын 2, 3-ны өдрийн 1443, 1445 дахь хуралдаанаар Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэлийг хэлэлцээд, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 1453 дахь хуралдаанаар баталсан CAT/C/MNG/2 зөвлөмж;
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, CAT/OP/MNG/1 зөвлөмжүүд”;
3. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2020 оны 36 дугаар чуулганы хуралдаанаас гаргасан A/HRC/46/9/Add.1 зөвлөмж,

4. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 50 дугаар чуулганы ерөнхий хуралдаанаас гаргасан A/HRC/WG.6/50/MNG/2 зөвлөмж;
5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Ерөнхий ассамблейн Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн батлаад Монгол Улсад ирүүлсэн A/HRC/54/51/Add.2 зөвлөмж;
6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны (CAT) 2024 оны 81 дүгээр хуралдааны Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын ээлжит Монгол Улсын 3 дахь тайланг хэлэлцэж, Ажиглалт, Дүгнэлт баталж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос ирүүлсэн CAT/C/MNG/CO/3 зөвлөмж²⁶;
7. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн (ICCPR) 2025 оны 4212 дугаар хуралдааны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 7 дахь тайланг хэлэлцэж, ирүүлсэн CCPR/C/MNG/CO/7 зөвлөмж²⁷; Тус зөвлөмжид эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар тусгайлан тусгасан.
8. НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны (SPT) 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаас Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны CAT/OT/MNG/RPNPM/R-I зөвлөмж гарган ирүүлсэн.²⁸

4.1.3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн гэрээний хороодоос өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт

НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодоос эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангахтай холбогдуулан өгсөн удаа дараагийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс хангалтгүй байгаа тул эрчимжүүлэх шаардлагатай байгааг 2016-2025 оны хооронд НҮБ-ын чуулганы ерөнхий хуралдаануудаас гаргасан албан ёсны дүгнэлтэд удаа дараа дурдаж, Монгол Улсын Засгийн газарт 8 удаагийн зөвлөмж өгч иржээ.

НҮБ-ын гэрээний хороодоос өмнө өгсөн зөвлөмжийн биелэлтээ дүгнэн хэлэлцэхдээ Монгол Улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор

²⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд 2157, 2160 дугаар хуралдаанаараа Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан.

²⁷ НҮБ-ын Хүний эрхийн Хорооны (ICCPR) нь 2025 оны 03 дугаар сарын 10, 11-ны өдрүүдэд хуралдсан Монгол Улсын ээлжит долоо дахь илтгэлийг 4195, 4196 дугаар хуралдаанаараа хэлэлцэж, 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 4212 дугаар хуралдааны CCPR/C/MNG/CO/7 ажиглалт, дүгнэлтийг баталлаа.

²⁸ For Mongolia's NPM (National Preventive Mechanism) in 2025, the UN SPT (Subcommittee on Prevention of Torture) likely continues to focus on strengthening its operational independence, ensuring full implementation of OPCAT (Optional Protocol to the UN Convention against Torture) recommendations, and potentially addressing issues highlighted in past confidential reports, with general global SPT themes including police training (like Méndez Principles) and improving prison conditions, as seen in their 2024/2025 activities. <https://share.google/cbBSxT3m7UI5jgax> <https://www.ohchr.org/en/press-releases/2024/05/un-torture-prevention-body-revisit-mongolia>

өмнө авсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, эргэн тайлагнаж ажиллахыг дахин дараагийн зөвлөмждөө 6 удаа тусгаж ирсэн байна²⁹.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны гишүүдийн зүгээс “Монгол Улс ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт уриалсан³⁰.

Тухайлбал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгохыг удаа дараа сануулсаар ирсэн бөгөөд энэ удаад ч дахин сануулж байгаагаа уламжилсан байна³¹.

Энэ талаар Монгол Улсын Их Хурал болон Олон улсын парламентын холбооны хамтран 2025 оны 3 дугаар сард зохион байгуулсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан, хэлэлцүүлэг (UPR-Universal Periodic Review)-ийн үйл явц дахь Монгол Улсын Их Хурлын оролцоо, НҮБ-ын гишүүн орнуудаас хүлээн авсан зөвлөмжүүд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог хангах талаарх асуудлын талаарх уулзалт-хэлэлцүүлгийн үеэр тусгайлан хөндөгдсөн³².

29 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь удаагийн тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж:

14. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

14.1. Санхүү болон хүний нөөцөөр хангах, тэр дундаа Конвенцын Нэмэлт протоколын дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа бүх төрлийн байранд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн мэргэшсэн салбар дундын мэргэжилтнүүдээр хангах болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн нэгжийн бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархан эрхийг хуулиар тогтоох.

14.2. Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвөөс хараат бус байх нөхцөлийг хангах.

14.3. Монгол Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33.1.1 дэх хэсэг болон түүний тайлбарт нэмэлт өөрчлөлт оруулан Конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ерөнхий тайлбарын 1 (2024)-д заасны дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан бүх газруудын нэгдсэн жагсаалтыг тусгах

30 The UN SPT welcomed such publications as this contributes to strengthen prevention of torture and ill-treatment. The UN SPT also transmitted its confidential report to Mongolia following the visit to the State party in May 2024 and invited Mongolia to follow the practice of making the visit report public. <https://www.ohchr.org/en/press-releases/2025/02/un-torture-prevention-body-postpones-first-2025-visit-amid-un-liquidity>

31 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх. https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en.

32 Хүний эрхийн төлөв байдлын үнэлгээний талаарх цахим уулзалт-хэлэлцүүлэг <https://www.parliament.mn/pn/74289/>

Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний хороодоос Монгол Улсад удаа дараа дүгнэлт гарган, зөвлөмж өгч ирсэн бөгөөд эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь Монгол Улсын НҮБ-ын гишүүн орнуудын өмнө хүлээсэн үүрэг, нэр төрийн асуудал болж байгааг анхаарах болсон байна.

Хатуухан дүгнэхэд, НҮБ-ын гэрээний хороодын тайлагналын механизмын хүрээнд Монгол Улс хүний эрхийн асуудлаарх ээлжит тайлангаа дөрвөн жил тутам хэлэлцүүлж, өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлүүлдэг. Иймд уг механизмд эргэн тайлагнах шалгуур үзүүлэлт, салбар дундын уялдаа холбоог хангах зохицуулалтыг Засгийн газар тогтоож, холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэн, тогтмол тайлагнадаг байнгын механизм бүрдүүлэх нь зүйтэй юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн биелэлт хангагдаагүй байна.

4.1.4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний хороодоос өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангахаар төлөвлөж буй арга хэмжээ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 20 дугаар зүйлийн (F) хэсэгт заасны дагуу, Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны урьдчилсан ажиглалт, дүгнэлтийн 51-д тусгасныг үндэс болгон НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодоос өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөний төслийг боловсруулан, хэрэгжүүлэх байгууллагуудыг тусгаж ажиллаж байгааг сайшаан тэмдэглэж байна. Үүнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь удаагийн тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос (CAT) Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг 2025-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” төсөл;*

2. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 7 дахь тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан НҮБ-ын Хүний эрхийн хорооноос (ICCPR) Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” төсөл.**

Нөгөөтээгүүр Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна. Нэмэлт протоколын үзэл санаа, зохицуулалтыг хоёрдмол утга, өөр өөр байдлаар тайлбарлахгүйгээр нэг мөр хэрэгжилтийг хангах нь чухал байна.

| НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос (CAT) Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг 2025-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний төсөлд тусгагдсан байдал | | |
|--|---|---|
| Дөрөв. Урьдчилан сэргийлэх үндэсний механизм (NPM) | | |
| | Зөвлөмжийн дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
| 4.1 | <p>14. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд</p> <p>14.1. Санхүү болон хүний нөөцөөр хангах, тэр дундаа Конвенцын Нэмэлт протоколын дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа бүх төрлийн байранд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн мэргэшсэн салбар дундын мэргэжилтнүүдээр хангах болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн нэгж бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархан эрхийг хуулиар тогтоох</p> | <p>-Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжүүд болон холбогдох бусад шийдвэр, зөвлөмж, тайлан, үнэлгээнд дурдсан асуудлыг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах;</p> <p>-Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний нэгжийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хуулийн үр дагаврын судалгааг хийх үйл ажиллагааны бие даасан байдлыг хангасан хуулийн хэрэгжилтийг хангах;</p> |
| 4.2 | 14.2. Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвөөс хараат бус байх нөхцөлийг хангах. | -Судалгааг үндэслэн шаардлага бол хууль болон холбогдох бусад баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах; |
| 4.3 | 14.3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33.1.1 дэх хэсэг болон түүний тайлбарт нэмэлт өөрчлөлт оруулан Конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ерөнхий тайлбарын 1 (2024)-д заасны дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан бүх газруудын нэгдсэн жагсаалтыг тусгах | <p>-Төсвийн асуудлаар холбогдох арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>-Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>-Хуулийн холбогдох заалтын хуулийн хэрэгжилтэд хуулийн үр нөлөөний судалгааг хийж, судалгааны дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авах.</p> |

| <p>НҮБ-ын Хүний эрхийн хорооноос (ICCPR) Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний төсөлд тусгагдсан байдал</p> | | |
|--|--|---|
| <p>Ес. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу Хүний нэр төрийг доромжлон харьцахыг хориглох талаар (NPM)</p> | | |
| | <p>Ирүүлсэн зөвлөмжийн агуулга, дугаар</p> | <p>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> |
| <p>9.1</p> | <p>21. Оролцогч улс эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцах үйлдлийг бүрмөсөн устгах зорилгоор эрс шийдэмгий арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:</p> <p>(а) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйл болон тус Пактын 7 дугаар зүйлд заасантай бүрэн нийцсэн эрүүдэн шүүхийн тодорхойлолтыг тусгах зорилгоор хууль, тогтоомждоо шинэчлэх</p> | <p>-Хуль, тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцод нийцүүлж буй талаарх судалгаа, үнэлгээ хийх, судалгааны дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авах</p> <p>-Хууль, тогтоомж олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх</p> |
| <p>9.2</p> | <p>б) Төрийн албан хаагчдын үйлдсэн эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцахтай холбоотой үйлдлийг мөрдөн шалгах бие даасан механизмыг бий болгох тухай хуулийг батлах, уг байгууллагын мөрдөн байцаагчид болон эдгээр үйлдлүүдийн сэжигтэн холбогдогч этгээдүүд хоорондоо ямар нэгэн бүтэц эсвэл албан тушаалын хувьд хамааралгүй, бие даасан байдалтай байх нөхцөлийг хангах</p> | <p>-Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус харилцах, хүний нэр төрийг доромжлох хэргийг мөрдөн шалгах хараат бус механизмыг бий болгосон хуулийн төслийг боловсруулах</p> |
| <p>9.3</p> | <p>(в) Эрүүдэн шүүх болон хүнлэг бус харилцсан бүхий л гомдлыг Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага (Станбулын протокол)- д зааснаар нэн даруй, бүрэн, үр дүнтэй, ил тод, шударга байдлаар мөрдөн шалгаж, холбогдогч этгээдийг яллах, буруутай нь тогтоогдвол зохих шийтгэл оногдуулах, хохирогчид нөхөн төлбөр олговор олгохыг баталгаажуулах</p> | <p>-Станбулын протоколыг монгол хэлэнд орчуулан албажуулах</p> <p>-Орчуулсан гарын авлагыг ашиглан сургалтын хөтөлбөр боловсруулах</p> <p>-Сургалтын хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулах</p> |

| | | |
|-------------------|--|--|
| <p>9.4</p> | <p>(с) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлохоос урьдчилсан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах, тэр дундаа шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын алба хаагч, эрүүл мэнд шүүх шинжилгээний ажилтнуудад хүний эрхийн талаарх сургалтыг мөрдөн шалгах болон мэдээлэл цуглуулах зорилгоор үр дүнтэй ярилцлага авах зарчим (Мендезийн зарчим) зэрэг олон улсын хүний эрхийн стандартын талаар сургалтуудыг тогтмол заах.</p> | <p>-Хууль сахиулах байгууллагын алба хаагч, прокурор, шүүгч, эмч, шүүхийн шинжээч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдэд зориулсан анхан болон шаталсан сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах -Байгууллагын сургалтын хуваарьт жил бүр оруулж батлуулах; -Батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу сургалтыг тогтмол зохион байгуулах.</p> |
| <p>9.5</p> | <p>23. Оролцогч улс ганцаарчлан хорихтой холбоотой хууль, тогтоомж болон практик туршлагаа Пакт болон Хоригдлуудтай харьцах НҮБ -ын наад захын жишиг дүрэм (Нелсон Манделагийн дүрэм) зэрэг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай. Ингэхдээ ганцаарчлан хорих шийтгэл нь зөвхөн онцгой тохиолдолд хамгийн эцсийн арга хэмжээ болгон, хамгийн богино хугацаагаар (15 хоногоос хэтрүүлэхгүй байх) ногдуулах, мөн</p> | <p>-Хууль, тогтоомж олон улсын гэрээ, конвенцод нийцэж буй эсэх талаарх хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, үнэлгээ хийх; -Судалгаанд үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулах;</p> |

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11-д заасан бүрэн эрхийн хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 01 дүгээр сарын 2-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө–г баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна³³.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Монгол Улсын ХЭҮКтХ-д заасан зарчимд нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагааны Алсын харааг “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” гэж тодорхойлон, эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судалж, ЭШУС үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч байх эрхэм зорилгыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн орноор элсэж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон холбогдох хүний эрхийн гэрээ, конвенцод нэгдэг

³³ НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026 он) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан байна. https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en.

орсноор “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэхгүй байх” үүргийг хүлээсэн.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас санаачлан, “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх эрхийг ханган ажиллах талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Казахстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ) болон Шүүхийн сахилгын хороо, Улсын Ерөнхий Прокурор, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран **“Эрүү шүүлтгүй Монголын төлөө - УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ”** уриалгыг хамтран баталж, хэрэгжүүлэхээ илэрхийллээ.

Монгол Улсын төрийн холбогдох байгууллагууд тус уриалгад нэгдэн ажиллахаа албан бичгээр илэрхийлж, **“Эрүү шүүлтгүй Монголын төлөө - УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ”**-ын үзэл санаанд нэгдэн, байгууллагынхаа хэмжээнд төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулж байгаа нь чухал үр дүнтэй боллоо.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГЖИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, А/02 дугаар тушаалаар “ЭШУС хэлтсийн дүрэм”, 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх “Аргачлал батлах тухай” А/03 дугаар тушаал, 2025 оны А/02 дугаар тушаалаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-ыг хуульд заасны дагуу тус тус батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс нь тайлант хугацаанд 7 албан хаагчтайгаар ажилласан.

3. Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд энэ 2025 оны тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудын үзүүлэлтийг 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон мэдээлэлтэй харьцуулахад өссөн дүнтэй байна.

4. ЭШУС үйл ажиллагааны хүрээнд олон улсын болон төрийн байгууллагууд, иргэний нийгмийн холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах,

хамтарсан төлөвлөгөө баталж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд үр дүнтэй хамтран ажилласан нь бодит үр дүнд хүрсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлын удирдлагууд, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд, УИХ-ын Тамгын газар, Шүүхийн сахилгын хороо, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын Өмгөөлөгчдийн холбоо зэрэг төрийн байгууллагуудтай хамтран ажилласан.

Мөн НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ) зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэв.

Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд болох Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо, Митчелл сан ТББ, Иргэдийн шударга шүүх ТББ, Сэтгэл зүйн мэдрэмж ТББ, Монголын эрэгтэйчүүдийн холбоо, Ирээдүйн босго ТББ-уудтай нягт хамтран ажиллаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, бодлогын дэмжлэг, туслалцаа авах, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлсэн.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОЙМ

Тайлант хугацаанд ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүргийн хүрээнд хийсэн ажлуудаас товчлон танилцуулъя.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ³⁴

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2025 онд хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд иргэн өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч явах боломжгүй **65 байршилд** урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Үүнд хорих байгууллага, цагдан хорих болон түр, албадан саатуулах байр, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ахмад настны асрамжийн газар, сургуулийн дотуур байр, цэргийн сахилгын байр зэрэг олон төрлийн байгууллага хамрагдсан.

Эдгээр хяналт шинжилгээгээр иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн **51 зөвлөмжийг** холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.

³⁴ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 2 дугаар бүлэг.

Зөвлөмжийн мөрөөр дээрх байгууллагуудад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, бодит өөрчлөлт, сайжруулалт хийгдсэн нь онцлох үр дүн байв.

Тухайлбал: Зэвсэгт хүчний Жанжин штаб **111 сая төгрөг**, хяналт шинжилгээнд хамрагдсан оюутны дотуур байрны урсгал засварт **4 тэрбум 552 сая**, эд хогшил, тоног төхөөрөмж, амьдралын орчныг сайжруулах чиглэлээр худалдан авсан бараа бүтээгдэхүүнд **479 сая** төгрөг зарцуулсан байна.

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2025 оны тайлант хугацаанд нийт 11,000 километр зам туулж, 65 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш нийт 49,696 километр зам туулж, 193 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг асуудал эрхэлсэн гишүүний баталсан А/02 дугаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-ын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлсэн.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 2022-2025 онд эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар олон улсын жишиг стандарт болон дотоодын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж, судалгааг нийт 7,785 иргэн, 1,654 төрийн албан хаагчаас авсан.
- Тайлант хугацаанд 1,709 иргэн, 189 төрийн албан хаагчаас, 238 оюутан, 25 багш, алба хаагч, 135 хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын үйлчлүүлэгч, 211 хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын алба хаагчдаас асуумж авсан.
- ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан 1,739 иргэнтэй ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, зөвлөгөө өгсөн.
- Тайлант хугацаанд 419 хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад хэлбэрээр эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, 38 оюутан, 506 төрийн албан хаагчтай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж зөвлөгөө өгсөн.

Хүснэгт 3

| № | Үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | Нийт |
|---|--|---------|---------|---------|---------|-------|
| 1 | Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ | 23 | 48 | 57 | 65 | 193 |
| 2 | Туулсан зам (километрээр) | 10614 | 17810 | 10172 | 11100 | 49696 |
| 3 | Асуумж (эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдээс) | 1650 | 2803 | 1623 | 1709 | 7785 |
| 4 | Асуумж (төрийн албан хаагчдаас) | 304 | 850 | 311 | 189 | 1654 |
| 5 | Оюутнуудаас | | | | 238 | 239 |
| 6 | Багш, алба хаагчдаас | | | | 25 | 25 |
| 7 | Хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын үйлчлүүлэгчдээс | | | | 135 | 135 |
| 8 | Хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын алба хаагчдаас | | | | 211 | 211 |
| 9 | Ганцаарчилсан уулзалт ярилцлага | 459 | 675 | 415 | 494 | 2043 |

2025 онд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд авсан асуумжийн тоон мэдээлэл

Хяналт шинжилгээний хүрээнд асуумжаас гадна ганцаарчилсан уулзалт, ярилцлага нийт 494 удаа хийсэн бөгөөд үүнээс 415 нь эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдтэй, 84 нь албан хаагчидтай хийгдсэн болно.

Хүснэгт 4

| № | Байгууллага | Эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдээс | Албан хаагчдаас | Хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын үйлчлүүлэгчдээс | Оюутнуудаас |
|---|---|--------------------------------------|-----------------|--|-------------|
| 1 | ШШГБ | 1635 | 147 | | |
| 2 | Цагдаагийн байгууллага | 74 | 42 | | |
| 3 | Сэтгэцийн эрүүл мэндийн төв | | 159 | 15 | |
| 4 | Хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар | | 52 | 120 | |
| 5 | Сургуулийн дотуур байр | | 25 | | 238 |
| 6 | Ганцаарчилсан уулзалт ярилцлага (цагдаагийн байгууллагын тоо ороогүй) | 271 | 84 | 415 | 494 |

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмж³⁵

- Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс 474 заалт бүхий 51 зөвлөмж, ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойших нийт 922 заалт бүхий 96 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв.
- Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт 85.0 хувьтай үнэлэгдсэн бөгөөд ЭШУС үндэсний ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хүргүүлсэн нийт 96 зөвлөмжийн хэрэгжилт 81.0 хувьтай байна.
- Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-ыг баталж, хяналт шинжилгээний арга, үе шат, удирдамж, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг бий болголоо.
- Уг дотоод журмыг мөрдөж ажилласнаар хяналт шинжилгээний төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, тайлагнал нэгдсэн стандарттай болж, үйл ажиллагааны уялдаа, хариуцлага, үр нөлөө бодитоор нэмэгдэх нөхцөл бүрдэв.
- Гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлага алдсан албан тушаалтанд хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, хариуцлага тооцуулах санал хүргүүлэн ажиллав.
- Тайлант хугацаанд ЭШУС үндэсний ажиллагаа нь зөвлөмжийн хэрэгжилтийг бодитоор дэмжих, тогтолцооны түвшний сул талыг арилгах, зөрчил давтагдах эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд төвлөрөн ажиллав.

Зөвлөмжийн хэрэгжилт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн жилийн тоон үзүүлэлт, ерөнхий хэрэгжилтийн хувийг 2022-2025 оны байдлаар нэгтгэн харуулав.

Зөвлөмжийн хэрэгжилтийн жилийн үзүүлэлт:

Хүснэгт 5

| № | | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|-----------------------------|------------|------------|------------|------------|------------|
| 1 | | 72.0% | 86.0% | 80.0% | 85.0% | 81.0% |
| 2 | Зөвлөмжийн хэрэгжилт | 10 зөвлөмж | 20 зөвлөмж | 15 зөвлөмж | 51 зөвлөмж | 96 зөвлөмж |
| 3 | | 70 заалт | 224 заалт | 154 заалт | 474 заалт | 922 заалт |

³⁵ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 8 дугаар бүлэг.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд хариуцлага тооцсон байдал

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэж заасан.

Энэ хүрээнд зөвлөмжийг биелүүлээгүй, илэрсэн зөрчлийг арилгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, хэрэгжилтийг хугацаанд нь хангаагүй, хангалтгүй хэрэгжүүлсэн, эсхүл алба хаагчийн үйлдэл нь эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах зөрчилд хүргэсэн гэж үзсэн тохиолдолд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал гарган ажилласан.

Асуудал эрхэлсэн гишүүнээс 2025 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагууд дотоод хяналт шалгалт зохион байгуулж, ирүүлсэн тайлан, нотлох баримтад үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар тайлагнасан байна. Үүнд:

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд хариуцлага тооцсон байдал:

Хүснэгт 6

| № | Байгууллага | Гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн, дутуу биелүүлсэн албан тушаалтанд тооцсон хариуцлага | Хариуцлага тооцуулсан албан хаагчийн тоо |
|-------------|---|--|--|
| 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага | Албан тушаал бууруулах, чөлөөлөх, сануулах, цолны мөнгө хасах | 12 |
| 2 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | Албан тушаал бууруулах, сануулах, цалин бууруулах | 8 |
| 3 | Цагдаагийн байгууллага | Албан тушаал бууруулах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ | 2 |
| 4 | Соёл урлагийн их сургууль (дотуур байр) | Сахилгын арга хэмжээ | 1 |
| Нийт | | | 23 |

ХЭҮКТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй тохиолдолд албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргахаар заасан.

Хуулиар олгосон энэхүү бүрэн эрхийн хүрээнд холбогдох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэлт³⁶

ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж ирүүлсэн гомдол, мэдээллээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллахын зэрэгцээ түүний дагуу ямар арга хэмжээ авсан талаар эргэж мэдээлэх, эргэж мэдэгдээгүй албан газруудад дахин албан бичиг хүргүүлэн шийдвэрлэлтийн мэдээллийг авч, үр дүнг тооцож ажиллав.

Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаар тайлант хугацаанд нийт 61 гомдол, мэдээлэл ирүүлсэн байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2025 оны байдлаар иргэд, хуулийн этгээдээс нийт 61 гомдол мэдээлэл ирүүлснээс биечлэн болон цахимаар уулзаж зөвлөгөө өгсөн-20, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад шилжүүлсэн-4, Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газруудад шилжүүлсэн-20, Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн-9, Төрийн албаны зөвлөлд шилжүүлсэн-1, Хууль зүй дотоод хэргийн яаманд шилжүүлсэн-1, Эрүү болон Иргэний шүүхэд шилжүүлсэн-1, Албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн-2 гомдол мэдээлэл байна.

Холбогдох байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн байдал:

Хүснэгт 7

| Байгууллага / Арга хэмжээ | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|---|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| Биечлэн уулзсан, хариу өгсөн | 8 | 26 | 36 | 23 | 93 |
| ШШГЕГ, харьяа ШШГБ | - | 8 | 17 | 5 | 30 |
| Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газрууд | 1 | 8 | 15 | 21 | 45 |
| Авлигатай тэмцэх газар | 1 | 12 | 19 | 9 | 41 |
| Цагдаагийн ерөнхий газар | - | 2 | 1 | - | 3 |
| Шүүхийн сахилгын хороо | - | 1 | 2 | - | 3 |
| Хууль зүй, дотоод хэргийн яам | - | - | 4 | 1 | 5 |
| Төрийн албаны зөвлөл | - | - | - | 1 | 1 |
| Эрүү болон иргэний хэргийн шүүх | - | - | - | 1 | 1 |
| Өмгөөлөгчдийн холбоо | - | - | 1 | - | 1 |

³⁶ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 6 дугаар бүлэг.

| | | | | | |
|--|-----------|-----------|-----------|-----------|------------|
| Ерөнхийлөгчийн Тамгын газар | - | - | 1 | - | 1 |
| Монголын хүүхдийн сан (төлөөлөгчийн газар) | - | - | 1 | - | 1 |
| ХЭҮК-ын ГХШХ-т гомдолд нэгтгэсэн | - | - | 1 | - | 1 |
| Ижил утгатай гомдлыг нэгтгэн шалгуулахаар шилжүүлсэн | - | 2 | - | - | 2 |
| Гомдлыг түр хаасан | 1 | - | - | - | 1 |
| Талархал илэрхийлсэн | - | - | 1 | - | 1 |
| Нийт | 11 | 59 | 99 | 61 | 230 |

Харьяаллын дагуу шилжүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдал:

Хүснэгт 8

| Он | Албан байгууллага | Шилжүүлсэн гомдлын тоо | Албан бичгээр хариу ирүүлсэн | Хариу ирүүлээгүй бусад хэлбэр | Шийдвэрлэлт хувь |
|-------------|-------------------------|------------------------|------------------------------|-------------------------------|------------------|
| 2022 | Авлигатай тэмцэх газар | 1 | 1 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 1 | 1 | 0 | 100% |
| | Бусад (биечлэн уулзсан) | 9 | - | - | 100% |
| 2023 | Авлигатай тэмцэх газар | 10 | 7 | 3 | 70% |
| | УЕПГ, харьяа прокурор | 7 | 4 | 3 | 57% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 6 | 2 | 4 | 30% |
| | Цагдаагийн байгууллага | 3 | 0 | 3 | 0% |
| | Шүүхийн сахилгын хороо | 1 | 1 | 0 | 100% |
| | Бусад | 32 | - | - | 100% |

| | | | | | |
|-------------|-------------------------------------|----|----|---|------|
| 2024 | Авлигатай тэмцэх газар | 19 | 19 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 15 | 15 | 0 | 100% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 17 | 17 | 0 | 100% |
| | Цагдаагийн байгууллага | 1 | 1 | 0 | 100% |
| | Хууль зүй, дотоод хэргийн яам | 3 | 0 | 3 | 0% |
| | Шүүхийн сахилгын хороо | 1 | 1 | 0 | 100% |
| | Шүүхийн ерөнхий зөвлөл | 1 | 1 | 0 | 100% |
| | Ерөнхийлөгчийн Тамгын газар | 1 | 0 | 1 | 100% |
| | Өмгөөлөгчдийн холбоо | 1 | 0 | 1 | 0% |
| | Бусад | 40 | - | - | 100% |
| 2025 | Авлигатай тэмцэх газар | 9 | 9 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 21 | 21 | 0 | 100% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 5 | 4 | 1 | 80% |
| | Эрүүгийн болон иргэний хэргийн шүүх | 1 | 1 | 0 | 100% |
| | Хууль зүй, дотоод хэргийн яам | 1 | 0 | 1 | 0% |
| | Төрийн албаны зөвлөл | 1 | 0 | 1 | 0% |
| | Бусад | 23 | | | 100% |

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар нийт 229, үүнээс тайлант хугацаанд нийт 61 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт³⁷

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойш 2022-2025 оныг дуустал нийт 605 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 96190 хүнийг хамруулсан.

Тайлант хугацаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийг таниулах сургалтыг 386 удаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 171 цаг тус тус зохион байгуулж, нийт **55335** (давхардсан тоогоор) шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, алба хаагчид, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газар болон сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн суралцагч, сонсогч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.

ЭШУС үндэсний ажиллагаанаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дотоод нөөцдөө тулгуурлан эсхүл зөвлөмж, шаардлагын мөрөөр сургалт зохион байгуулах ажлыг тухайн хамт олон, байгууллага, салбарын хэмжээнд дангаар болон хамтран, сургагч багшаар дамжуулан хэрэгжүүллээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 224 сургагч багш, энэ чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхэлдэг багш, судлаач, иргэний нийгмийн байгууллын идэвхтэн, зүтгэлтнүүдээс төдийгүй олон улсын байгууллага (АРТ)-ын сургагч багш, зөвлөхүүдээс сургалт зохион байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон бусад олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль, тогтоомж (Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль)-д заасан үндэслэл, журмын дагуу хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс ангид байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшүүлэх зорилгоор үр дүнтэй сургалт зохион байгуулахыг зөвлөмжүүдэд тухай бүр даалгаж, сургалтын талаар ирүүлсэн тайланг үнэлж ирсэн. Түүнчлэн, эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдэд эрхээ хамгаалах, бусдад таниулах, хүний эрхийг ойлгох, баяжуулах, дэмжих талаар мэдээлэл, сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ирсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас зохион байгуулсан сургалт: УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс “Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн талаар анхаарах зарим асуудал”, “Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалт зохион байгуулж, нийт 471 прокурор хамрагдсан. Мөн нэгж прокурорын газрууд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүх

³⁷ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 3 дугаар бүлэг.

болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 сургалтыг зохион байгуулж, 1126 төрийн албан хаагч хамрагдсан.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт: Тус газраас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 онд нийт 5 удаагийн сургалт зохион байгуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Баянгол дүүргийн Цагдаагийн газар, Бүртгэл, хяналтын төв, мөн ЦЕГ-ын сургагч багш нар зэрэг 400 орчим алба хаагч “Эрүү шүүлт”, “Авлигын гэмт хэрэг, Хүний эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх”, “Авлигын гэмт хэрэг, эрүү шүүлт”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар” сэдэвтэй сургалтад хамрагдсан.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан сургалт: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2025 оны байдлаар эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний эрхийг алба хаагчид болон иргэд, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу 342 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 46756 алба хаагч, иргэд хамрагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулсан сургалт: Тус байгууллагаас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7-д “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, олон нийтэд мэдээлэх” гэж заасныг үндэслэн Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлээр харьяа 38 салбар нэгжийн 40 сургагч багшийн зохион байгуулсан сургалтад 3290 алба хаагч, 1139 хоригдол, ерөнхий боловсролын сургуулийн 94 сурагч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 145 этгээд, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын 45 алба хаагч зэрэг нийт давхардсан тоогоор 4713 алба хаагч (хоригдол, сурагч, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд) 171 цагийн сургалтад хамрагдсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн 73 сургагч багшийг 2023 онд бэлтгэн гэрчилгээ олгосон бол ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагатай (АРТ) хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тус тус зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд **нийт 2632 хүнийг хамруулж**, танхимын сургалтаар **151 сургагч багшийг** бэлтгэн гэрчилгээ гардуулснаар ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд **нийт 224 сургагч багшийг** бэлтгэсэн.

Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгагдсан Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх суурьтай сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтийн талаар Боловсролын яам, холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт мэдээлэл өгч, сургалтын хөтөлбөрт тусгахаас гадна нэгж хичээлийн агуулга бүрд хүний эрхийн судлагдахууныг оруулах нь зайлшгүй болохыг харилцан хэлэлцсэн.

Аюулгүй байдал, иргэн, өмч хамгаалал, эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг төдийгүй бусад салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад хүний эрх, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдмэл ойлголт, мэдлэг олгох, ур чадвар, дадал эзэмшүүлэх, хүний эрхийг дээдлэх хандлага төлөвшүүлэх Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлэхээр ажилласан.

Хүснэгт 9

| № | Үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | нийт |
|---|-------------------------------------|---------|---------|---------|---------|-------|
| 1 | Сургалт, хэлэлцүүлэг, таниулах ажил | 31 | 37 | 151 | 386 | 605 |
| 2 | Бэлтгэгдсэн сургагч багш | - | 73 | 151 | 1100 | 1324 |
| 3 | Сургалтад хамрагдсан хүний тоо | 3357 | 4858 | 32640 | 55335 | 96190 |

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа³⁸

- Тайлант хугацаанд “ЭШУС үндэсний ажиллагааны 2025-2026 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийг батлан, таван үндсэн чиглэлийг тодорхойлж ажиллалаа.
- Энэ хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер, инстаграм болон цахим хуудсаар дамжуулан 300 удаагийн хүний эрхийн талаар мэдлэг ойлголт, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон бусад арга хэмжээний талаар контент (бичлэг, reels, story, poster хэлбэрээр) нийт мэдээ мэдээлэл, 365 удаагийн телевиз, сайт, сонины ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжууллаа. Цахим орчинд давхардсан тоогоор урт, богино хугацаагаар 2,5 сая хүнд шууд хүрч, хандалтын хувь 2024 оноос хандалтын тоо 3 дахин өссөн байна.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас төлөвлөн хэрэгжүүлсэн 5 үндсэн ажлын хүрээнд олон нийтэд мэдээлсэн нийт мэдээллийн тоон үзүүлэлтийг 2024 оны тайлант хугацааны үзүүлэлттэй адил байгаач хандалт 3 дахин өссөн.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг таниулах ажлын хүрээнд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, телевиз, Монголын Үнэн сонин, “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” булан, 10 удаагийн подкастыг хийж ажилласан нь сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 2025 онд бүрэн гүйцэтгэж дуусав.
- Төрийн албан тушаалтнууд, иргэдэд эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн талаар болон эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, мэдээллийг тогтмол хүргэх зорилгоор УЕПГ, АТГ, ЦЕГ, ШШГЕГ, Нийслэлийн цагдаагийн газар, СЭМҮТ-тай хамтран ажиллах төлөвлөгөө батлуулан ажиллаж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн агуулга бүхий анимейшн, контент бүтээл зэрэг сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан газруудын хүлээлгийн өрөө, эргэлт уулзалтын танхимын дэлгэцээр, албан хаагчдын цахим хаяг, дотоод сургалт, шугамын радио зэрэг бүхий л боломжит хувилбарыг ашиглан тогтмол давтамжтай түгээсэн.
- ЭШУСҮА-ны 2022, 2023 оны төсөвт эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлах хүрээнд тодорхой төсөв хуваарилагдаагүй бол 2024, 2025 оны төсөвт сурталчилгааны зардал хуваарилагдсан нь тайлант хугацаанд эрүү шүүлтээс ангид байх хүний эрх, эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлан таниулах, сурталчилгааны хэрэглэгдэхүүн бүтээх үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргахад эерэг нөлөө үзүүлсэн.
- Улсын Их Хурлын Тамгын газраас ЭШУСҮА-ны 2024 оны тайланд хийсэн дүн шинжилгээгээр өгсөн зөвлөмжийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан ёсны www.npmmongolia.mn цахим хуудсыг хийж, олон нийтэд мэдээллээ түгээж байна.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын албан ёсны цахим хуудас (National Preventive Mechanisms, Treaty Bodies Subcommittee on Prevention of Torture <https://www.ohchr.org/en/treaty-bodies/>)

³⁸ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 4 дүгээр бүлэг.

spt/national-preventive-mechanisms)-ны НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны танилцуулгын Үндэсний урьдчилан сэргийлэх механизмуудын жагсаалтын хэсэгт Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нэр NPM-Mongolia, цахим хуудасны www.prtmongolia.mn линкийг байршуулан ажиллаж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн ажлын хүрээнд 2023-2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний давтамж, хамрах хүрээ, хүртээмжийг харьцуулсан статистик үзүүлэлтийг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 10

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|----|---|-------------------------------|--------------------------------|---------------------------------|-------------------------------------|
| 1 | Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэд олон нийтэд цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажилласан мэдээ, мэдээллийн тоо | 15 мэдээ, мэдээлэл | 90 мэдээ, мэдээлэл | 311 мэдээ, мэдээлэл | 300 мэдээ, мэдээлэл |
| 2 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар түгээсэн контентын хамгийн их хандалт | Постер -15000 Бичлэг -5800 | Постер -18000 Бичлэг -45800 | Постер -36000 Бичлэг -51,200 | Постер -21,000 Бичлэг -1,500,000 |
| 3 | Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар бэлтгэн түгээсэн телевиз, сайт, сонины дүрстэй болон хэвлэмэл ярилцлагын тоо | 7 удаа | 136 удаа | 321 удаа | 365 удаа |
| 4 | Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээлэл түгээсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо | 11 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 36 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 77 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 90 хэвлэл мэдээллийн хэрэгсэл |
| 5 | Reels хэлбэрийн богино контент | - | - | 20 удаа | 24 удаа |
| 6 | Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх урт хугацааны видео бичлэг | 1 удаа | 5 удаа | 20 удаа | 25 удаа |
| 7 | Нугалбар хуудас | - | 2,000 ширхэг | 5,000 ширхэг | 2,000 ширхэг |
| 8 | Сурталчилгааны хэрэглэгдэхүүн (судалгаа, гарын авлага) | 1 нэр төрөл | 2 нэр төрөл | 4 нэр төрөл | 4 нэр төрөл |
| 9 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн тоо | 18 | 37 | 155 | 263 |
| 10 | Сонины нийтлэл | 1 | 4 | 5 | 17 |

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх үйл ажиллагаа³⁹

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) олон улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Николь Хогг 2025 оны 9 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийлээ. Ерөнхий нарийн бичгийн дарга Николь Хоггийг дагалдан тус нийгэмлэгийн НҮБ-ын гишүүн орнуудын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хариуцсан ахлах зөвлөх Бен Бакланд, Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан ахлах зөвлөх Нид Сатжипанон, Шинэ Зеландын Цагдаагийн газрын суперинтендант (дэд дарга) Гэри Алкок нар хүрэлцэх ирсэн. Айлчлалын хүрээнд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, Хүний эрхийн дэд хорооны дарга нартай уулзаж, Монгол Улсын НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмж, хүний эрхийн шинэ механизмыг нутагшуулах, дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах талаар санал солилцсон.

Энэхүү айлчлал нь 2024 онд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүд Монгол Улсад хийсэн хоёр дахь албан ёсны айлчлалын мөрөөр НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны өмнөх айлчлалаас гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх, шинэхэн байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутаг дахь оролцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд түлхүү анхаарах болно” хэмээн энэхүү айлчлалын зорилгыг тодорхойлсон. Энэ нь өндөр ач холбогдолтой айлчлал болсон.

Мөн айлчлалын хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба хаагчдыг чадавхжуулах, мөн хорих байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах явцад үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд (Мендезийн зарчмууд)-ыг нутагшуулах, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний олон улсын туршлага”, “Эрүү шүүлтээс ангид байх эрхийг олон нийтэд сурталчлах бусад улс орнуудын сайн туршлага”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга, мөн чанар, сайн туршлага”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний хүчин чармайлт, олон нийтийн оролцоо, харилцааны сайн туршлага”, “Цагдан хорих газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх арга зүй”, “Мониторуудыг хэрэгжүүлэх зарчим” сэдвүүдээр тус тус сургалт явуулж чадавхжуулсан. Мөн хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг НЦУГ, түүний харьяа зарим байгууллагад хийлээ.

Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссар, Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тэргүүний урилгаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн болон ЭШУСҮА-ны албан хаагчид 2025 оны 6 дугаар сарын 1-6-ны өдрүүдэд Варшав хотод ажиллаж, туршлага судалсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дагуу байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тусгай сангийн дэмжлэгээр 2025-2026 онд “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх

³⁹ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 5 дугаар бүлэг.

үндэсний механизмыг бэхжүүлэх нь” сэдэвт төсөл шалгарч, санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн тухай бидэнд 2025 оны 6 дугаар сард мэдэгдсэн. Санхүүжилт олгох үйл явц үргэлжилж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) болон Ази, Номхон далайн орнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын форум (АФФ) хамтран санхүүжилтийг шийдвэрлэсний үндсэн дээр Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2025 онд техникийн туслалцаа үзүүлэх ажлыг эхлүүлж, олон улсын сургагч багш бэлтгэх урт хугацааны хамтарсан төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд 2025 онд Монгол Улсад 4 удаа ажлын айлчлал зохион байгуулж, үндэсний ажиллагааны болон хууль, хяналтын байгууллагын алба хаагчдыг хамрууллаа.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагын санхүүжилтээр НҮБ-ын “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” буюу Мендезийн зарчмуудыг монгол хэл рүү орчуулж, гарын авлага хэвлүүлж, нутагшуулах сургалтад Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх албаны удирдлага болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий нийт 2090 алба хаагчийг хамруулсан. Мөн Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран прокурорын байгууллагын 70 алба хаагчид зориулсан “Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалт-хэлэлцүүлгийг зохион байгуулж, хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүндэтгэн ажиллах арга барилыг хэвшүүлэхэд чиглэн ажиллав.

Дэлхийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын холбоо (GANHRI), Ази-Номхон далайн форум (АФФ), Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ)-аас хамтран зохион байгуулсан “Эрх чөлөөгөө хасуулсан газруудад гомдол, мэдээлэл хүлээн авах механизм” сэдэвт хэлэлцүүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төлөөлөл оролцож, олон улсын сайн туршлагыг судлав.

Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг энэ оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Энэ хүрээнд Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, ШСХ, УЕПГ, АТГ, ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ЦЕГ, ШШГЕГ, ШШЕГ, ХБХХЕГ, СЭМҮТ, МӨХ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Казахстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ) болон иргэний нийгмийн байгууллага, судлаачдын төлөөлөл оролцон зохион байгуулсан.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын үеэр оролцогчид “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ”

буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгыг дэвшүүлэн Монгол Улсын төрийн холбогдох байгууллагуудыг тус уриалгад нэгдэн ажиллах санаачилгыг гаргасан.

“УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгад Монгол Улсын Шүүхийн Сахилгын Хороо, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ"-д нэгдэж байгаагаар албан тоотоор мэдэгдэж, харьяа албадуудаараа аян зохион байгуулж Эрүү шүүлт гаргахгүй байх амлалт авч ажиллаж байна.

НҮБ-ын Суурин зохицуулагч, БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллага, Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллага, АНУ-ын ЭСЯ-ны төлөөлөлтэй хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд уулзаж, хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон.

ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл олон Хүний эрхийн үндэсний байгууллагуудын оролцоотой, эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 цуврал вебинарт оролцож, илтгэл хэлэлцүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа⁴⁰

Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа.

Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагуудтай 2025 онд хамтран ажиллах үндсэн чиглэлээ тодорхойлов.

“Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, “Митчелл сан” ТББ-ын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны саналуудыг үндэслэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ын хамтран боловсруулан батлан, хэрэгжилтийг ханган ажиллав.

Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны санаачилгаар “Эрүү шүүлтгүй Монгол Улс - Өмгөөлөгчийн оролцоо” сэдэвт өглөөний уулзалтыг Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологичдын холбоотой хамтран зохион байгуулав.

⁴⁰ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 5 дугаар бүлэг.

Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас зохион байгуулсан “Эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь” уулзалт-хэлэлцүүлэгт ЭШУСҮА-ны төлөөлөл оролцож, гарсан зөвлөмжид санал хүргүүлсэн.

Ази-Номхон далайн форум (APF), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагуудаас (АРТ) хамтран зохион байгуулсан “Хүний эрхийн үндэсний байгууллагууд НҮБ-ын гэрээний хороодтой харилцах нь” сэдэвт цахим уулзалтад ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл оролцов.

Монголын Криминологийн холбооны судлаачдын багтай ХЭҮК/2025/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологийн (суурь судалгаа) судалгаа хийх” ажлыг гүйцэтгүүллээ. Гэрээний дагуу “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” дэд сэдвийн хүрээнд судалгаа хийв.

ЭШУС үндэсний ажиллагаа нь Монголын криминологичдын холбооны судлаачидтай хамтран ажиллаж “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн судалгаа” сэдвээр судалгаа хийж, тус судалгааг ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайланд хавсарган хэвлэн, нийтэлсэн.

Тус “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн судалгаа”-г УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд болон УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсгийн хуралдаанд УИХ-ын гишүүдэд танилцуулсан. Мөн Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүдэд танилцуулж, хэлэлцүүлсэн.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн сүүдрийн тайлан ба “Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо” сэдвээр “Митчелл сан” ТББ-аас алба хаагчдад дотоод сургалт зохион байгуулсан.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хүүхэд, залуучуудын амьдрах орчин, стандарт, ёс зүй, боловсрол, төлөвшлийн асуудлаар мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах талаар санал солилцов.

“Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт, хэрэгжилтийн төлөв байдлыг 4 бүсэд судлах, судалгаанд суурилсан нөлөөллийн ажил хэрэгжүүлэх төслийг боловсруулж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүргүүлж, шалгаруулсан.

НҮБ-ын Тусгай сангийн дэмжлэгээр 2025-2026 онд “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн “Хүүхэд, өсвөр үеийнхний нүдээр эрүү шүүлтгүй Монгол орон” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, шилдэг бүтээлүүдийг олон нийтэд түгээв.

“Митчелл сан” ТББ-тай хамтран ШШГЕГ-ын 403, 407 дугаар анги болон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй хүүхдүүд, нярайтай эхчүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх уулзалт хэлэлцүүлгийг хийв.

**ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ
ХҮРЭЭНД 2022 - 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХАРЬЦУУЛАЛТ**

Хүснэгт 11

| № | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|----|---|----------|---------------------|---------------------|----------|
| 1 | Хяналт шинжилгээгээр туулсан зам | 10614 км | 17810 км | 10172 км | 11100 км |
| 2 | Хяналт шинжилгээ хийсэн газар | 23 | 48 | 57 | 65 |
| 3 | Ганцаарчлан уулзаж, ярилцсан, зөвлөгөө өгсөн хүний тоо | 459 | 675 | 415 | 469 |
| 4 | Асуумжид оролцсон эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн тоо | 1650 | 2803 | 1623 | 2082 |
| 5 | Асуумжид оролцсон ШШГБ, хууль сахиулах байгууллагын алба хаагч нар, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын ажилтнууд, төрийн албан хаагч нар | 304 | 850 | 311 | 425 |
| 6 | ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн Зөвлөмж | 10 | 25 /1-22 заалт-тай/ | 15 /1-19 заалт-тай/ | 51 |
| 7 | Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээр зохион байгуулсан нийт сургалтын тоо | 31 | 37 | 151 | 386 |
| 8 | Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн хүний тоо | - | 73 | 151 | 1100 |
| 9 | Сургалтад хамрагдсан хүний тоо | 1662 | 4858 | 32640 | 55335 |
| 10 | ЭШУС үндэсний ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, мэдээлэл | 53 | 90 | 311 | 300 |
| 11 | Зурагт хуудас, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын танилцуулгын цуврал | 17 | 76 | 77 | 22 |
| 12 | Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл | 6 | 66 | 114 | 61 |

ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ



N | P | M
MONGOLIA

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ





N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах зорилгоор олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хуульд заасан газруудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх, эрх, эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх, тогтоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2022-2025 онд хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд иргэн өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч явах боломжгүй 193 байршилд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 96 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн. Тайлант хугацаанд буюу 2025 онд 65 байршилд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Үүнд хорих байгууллага, цагдан хорих болон түр, албадан саатуулах байр, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмад настны асрамжийн газар, цэргийн сахилгын байр, сургуулийн дотуур байр зэрэг олон төрлийн байгууллага хамрагдсан. Хяналт шинжилгээний явцад тогтоогдсон эрсдэлийн нөхцөл байдлыг үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 51 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга зүй төлөвшиж, эрсдэлийн шалтгаан, нөхцөлийг тогтвортой үнэлэх боломж бүрдсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан 2024 оны А/03 дугаар аргачлал практикт нутагшсанаар урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний чанар мэдэгдэхүйц сайжирсан.

ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдсан 2022 онд бүтэц бүрэлдэх, арга зүй төлөвших үе шат үргэлжилж байсан тул тухайн жилийн зөвлөмж, заалтын тоо хэмжээ харьцангуй бага байсан бол 2023-2025 онд хяналт шинжилгээний давтамж нэмэгдэж, хэрэгжилтийн үнэлгээний аргачлал жигдэрснээр зөвлөмжийн агуулга өргөжин нэмэгдсэн.

Улмаар урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ 2025 онд өмнөх жилүүдээс хамгийн өргөн түвшинд хүрч, илэрсэн эрсдэлийн шалтгаан, нөхцөлийг нарийвчлан тодорхойлох боломж бүрдсэнтэй холбоотойгоор зөвлөмж болон заалтын тоо мэдэгдэхүйц өссөн бөгөөд үндэсний механизмыг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх эерэг ахиц гарсан.

| | |
|------|---|
| 2.1. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ |
| 2.2. | Цагдаагийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ |
| 2.3. | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ |
| 2.4. | Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ |
| 2.5. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ |
| 2.6. | Их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад хийсэн хяналт шинжилгээ |

2.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.13, 16.14 дэх заалт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд заасан хүний халдашгүй, чөлөөтэй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын (цаашид “Конвенц” гэх) 2, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйл, тус конвенцын Нэмэлт протоколын 1, 3, 4, 17, 18, 19, 20, 21, 22, 35 дугаар зүйл; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7, 8 дугаар бүлгээр баталгаажуулсан Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 2.1 дэх хэсэг “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах

боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх” гэсэн бүрэн эрхийн хүрээнд 2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиуд, цагдан хорих, саатуулах, баривчлах байранд тогтмол хяналт шинжилгээг хэрэгжүүлэн ажиллав.

Хорих ял эдэлж буй хүн, цагдан хоригдсон, баривчлагдсан хүмүүсийн эрүү шүүлтээс ангид байх, тэдэнд заяасан эрхийн хэрэгжилт, байрлаж буй орчин нөхцөл, дэглэм, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй байдлын стандарт, хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт зэрэг хүний эрхийн хэрэгжилтэд шууд нөлөөлөх хүчин зүйлсийг хяналт шинжилгээний хүрээнд цогцоор үнэлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад хорих анги болон цагдан хорих байрны ажиллах зарчим, дотоод зохион байгуулалт, удирдлагын хяналтын тогтолцоо, өргөдөл гомдлын механизм, ил тод байдал, хариуцлагын хэрэгжилтэд төвлөрч ажилласан.

Энэхүү тайлан нь 2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үр дүн, илрүүлсэн нөхцөл байдал, тогтолцооны түвшний үнэлгээ, байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмж болон түүний хэрэгжилтийн явц, цаашид анхаарах шаардлагатай асуудлыг нэгтгэн дүгнэв.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих анги, цагдан хорих, баривчлах нийт 17 газар урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийсэн. Мөн өргөдөл гомдлын хүрээнд хорих анги, цагдан хорих төв байруудад тухай бүр очиж ажиллав.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг дараах хорих анги, цагдан хорих болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжүүдэд хэрэгжүүлэв. Үүнд:

- ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги
- ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги
- Хэнтий аймаг дахь ШШГГ-ын 419 дүгээр нээлттэй хорих анги
- Ховд аймаг дахь ШШГГ-ын 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги
- Булган аймаг дахь ШШГГ-ын 439 дүгээр хаалттай хорих анги
- Дархан-Уул аймаг дахь ШШГГ-ын 445 дугаар нээлттэй хорих анги
- ШШГЕГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих анги
- Орхон аймаг дахь ШШГГ-ын 437 дугаар нээлттэй, хаалттай хорих анги
- Говь-Алтай аймаг дахь ШШГГ
- Багануур дүүрэг дэх ШШГГ
- Өвөрхангай аймаг дахь ШШГГ
- Баян-Өлгий аймаг дахь ШШГГ
- Баянхонгор аймаг дахь ШШГГ
- Дорнод аймаг дахь ШШГГ
- Увс аймаг дахь ШШГГ
- Архангай аймаг дахь ШШГГ
- Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь ШШГХ



Эрх нь хязгаарлагдсан цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж буй хүмүүсээс ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандсан өргөдөл, хүсэлтийн дагуу ШШГЕГ-ын харьяа 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги, 421 дүгээр нээлттэй хорих анги, 461 дүгээр хаалттай хорих ангиудад тус тус хяналт шинжилгээ хийж ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиуд, аймаг, дүүрэгт байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, цагдан хорих байр, саатуулах байр нийтэд нь хамрагдсан. Илэрсэн асуудал, иргэдийн өргөдөл гомдлын дагуу тодорхой нэгжүүдэд нэмэлт хяналт шинжилгээ хийж нөхцөл байдлыг газар дээр нь баталгаажуулсан.

Хяналт шинжилгээний аргачлал нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-д заасан зарчим, шалгуур үзүүлэлт, үе шат, зохион байгуулалтын шаардлагад үндэслэн хэрэгжсэн. Байрлаж буй орчин нөхцөлийн эрүүл ахуйн стандарт, амьдралын бүсийн нөхцөл, агааржуулалт, гэрэлтүүлэг, ариун цэвэр, аюулгүй ажиллагаа, уулзалтын нөхцөл, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хөдөлмөрийн байр, камерын хяналтын систем зэрэг эрүү шүүлтээс ангид байх баталгаанд шууд нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэв.

Ярилцлага, асуумжийн аргаар алба хаагч, хорих ял эдэлж буй хүн, цагдан хоригдож байгаа хүн болон саатуулагдсан хүнээс мэдээлэл авч, илэрсэн нөхцөл байдлыг баримт бичиг, орчны үнэлгээтэй тулган баталгаажуулсан. Өргөдөл, гомдолд хийсэн хяналт шинжилгээний явцад байгууллагад мөрдөгдөж буй дотоод дүрэм, журам, дэглэмийн хэрэгжилт, хариуцлагын тогтолцоо, удирдлагын хяналтын механизмын бодит байдлыг тодруулсан.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа газар, хэлтсүүдэд хийсэн хяналт шинжилгээгээр хорих ял эдэлж буй, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлтэй, зөрчилтэй нөхцөл байдал олон байршилд давтамжтай илэрч байгааг тогтоосон.

Хяналт шинжилгээний явцад хорих байрны орчны эрүүл ахуйн шаардлага хангахгүй байдал, амьдрах байрны стандарт зөрчигдөх, хүмүүсийг нэг байрлалд удаан хугацаагаар суулгах нөхцөл бүрдэх, эм, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байх, алба хаагчдын зүй бус харилцаа, хандлага, ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдол гаргах боломж бодитоор хэрэгжихгүй байх, хяналтын камерын бүртгэл, мэдээллийн сангийн хадгалалттай холбоотой доголдол зэрэг асуудлууд удаа дараа илэрсэн.

Мөн алба хаагч болон эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн хооронд илрэн гарч буй таагүй харилцаа, ёс зүйгүй байдал, бүдүүлэг үг хэллэг хэрэглэн айлган сүрдүүлэх, шахалт, дарамт үзүүлэх, сэтгэл санааг шаналган зовоох шинжтэй харилцаа, хандлага ярилцлага, асуумжаар давтамжтай илэрсэн. Эдгээр нөхцөл байдалтай холбогдуулан 2022 оноос хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт 46 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хяналт шинжилгээний явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй зарим тохиолдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шалгуулахаар шилжүүлэн ажилласан байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нь тухайн газар, хэлтсийн өдөр тутмын зохион байгуулалттай холбоотой ганц нэг доголдол бус, харин эрүү шүүлтээс ангид байх эрхийн үндсэн баталгааг бүрэн хангах боломжийг хязгаарлаж буй системийн түвшний тогтолцооны хүндрэл,



дутагдал олон байршилд тогтвортой оршиж байгааг илтгэж байна. Түүнчлэн байгууллагын удирдлагын түвшинд гарсан өөрчлөлт бүрийн үед өмнө эхлүүлсэн үйл ажиллагааны залгамж чанар алдагдах, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд удаашрах хандлага ажиглагдсаар ирсэн нь хяналт шинжилгээгээр тогтоогдов.

3.1. Байр, орчны нөхцөлтэй холбоотой тогтоогдсон нөхцөл байдал



Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад амьдрах байрны стандарт, багтаамж, ашиглалтын байдал жигд бус, стандартын шаардлага хангахгүй нөхцөл олон байршилд тогтоогдов. Амьдрах ерөөний талбай хүрэлцээгүй, ор дутагдалтай, хоригдлуудыг шахцалдаж байрлуулах, зарим тохиолдолд шалан дээр унтуулдаг нөхцөл илэрсэн. Мөн дотоод цагийн хуваарь мөрдөх нэрийдлээр хоригдол, цагдан хоригдож байгаа хүмүүсийг нэг байрлалд удаан хугацаагаар суулгах нөхцөл арилаагүй байдал ажиглагдсан.

Агааржуулалт, гэрэлтүүлгийн хувьд цонх онгойх боломжгүй, агаар солилцох систем ажиллахгүй, өрөөнүүдэд чийг, мөөгөнцөр үүссэн, гэрэлтүүлэг хангалтгүй нөхцөл олон газарт тогтоогдсон. Ханын нэвчилт, чийгшил ихтэйгээс үүдэлтэй эвдрэл, хөгц үүссэн байдал орчны үзлэгээр баталгаажсан бөгөөд энэ нь амьдрах орчны эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна.

Ариун цэврийн байгууламжийн хувьд ашиглалтын хугацаа дууссан, эвдэрч гэмтсэн, халуун усгүй, дулааны хангамж доголдолтой, бохирын шугам, сантехникийн тоноглол хуучирсан нөхцөл байдал нийтлэг илэрсэн. Зарим байршилд ариун цэврийн байгууламжийн хүртээмж хангалтгүй, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн зохион байгуулалт жигд бус байв.

Дээрх нөхцөл байдал нь хорих ял эдэлж буй, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийн өдөр тутмын амьдрах орчинд тавигдах наад захын шаардлага хангагдахгүй байгааг харуулж, олон байршилд давтамжтай илэрч байна.

3.2. Хоол, хүнс, ундны усны нөхцөл

Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад хоол, хүнс, ундны усны чанар, хүртээмж нь жигд бус, зарим байршилд стандартын шаардлага хангахгүй нөхцөл тогтоогдов. Ундны усны хувьд усны хатуулаг ихтэй, үнэр, амттай, ус таталтын горим тогтворгүй, тасалдах тохиолдол олон байршилд илэрсэн. Зарим байгууллагад амьдрах бүс рүү ундны усыг гар аргаар, том хэмжээний саванд хоригдлоор зөөвөрлүүлж байгаа нь аюулгүй ажиллагааны эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор хүн гэмтсэн тохиолдол ч гарсан..

Хоол хүнсний хувьд хоолны төрөлжилт хангалтгүй, илчлэг, тэжээллэг чанарын шаардлага жигд хангагдахгүй, махан бүтээгдэхүүний хангамж тасалдах, хүнсний бүтээгдэхүүний чанар, боловсруулалтын горим алдагдсан байдал тогтоогдсон. Хоолны хадгалалт, гал тогооны ариун цэврийн нөхцөл, хүнсний түүхий эдийн бэлтгэл, цэвэрлэгээтэй холбоотой зөрчил зарим байршилд илэрсэн.

Хоолны амт, чанар, хүртээмжтэй холбоотой гомдол хоригдол, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийн зүгээс ярилцлага, асуумжаар давтамжтай илэрхийлэгдсэн. Тухайлбал, хоолны нэг хэвийн байдал, махан хоол ховор, авриц /үлдэгдэл/-аар хийсэн хоол байнга өгдөг, хүнсний хэмжээ хүрэлцэхгүй байх, тодорхой төрлийн хоол тогтмол давтагдах зэрэг нөхцөл байдал мэдээлэгдсэн.

Дээрх нөхцөл байдал нь хоол, хүнс, ундны усны хүртээмж, чанарт тавигдах наад захын шаардлага хангагдахгүй байгааг харуулж, зарим байршилд удаа дараа давтагдан илэрч байна.

3.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөхцөл



Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад хорих ял эдэлж буй, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн анхан болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалт жигд бус, зарим байршилд хангалтгүй нөхцөл тогтоогдов. Эрүүл мэндийн ажилтны орон тоо

хүрэлцээгүй, эмч, сувилагчийн ажлын ачаалал өндөр, эрүүл мэндийн үйлчилгээ тасалдах нөхцөл байдал олон байршилд ажиглагдсан.

Эмийн хангалтын хувьд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц тогтворгүй, эмийн олголт тасалдах, архаг хууч өвчтэй хүмүүст тогтмол хяналт, эмчилгээ хийх боломж хязгаарлагдмал нөхцөл илэрсэн. Зарим байршилд эмийн хэрэглээ, олголтын бүртгэл жигд бус, эмчилгээний заавар, хяналтын баримтжуулалт хангалтгүй байв.

Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, шаардлагатай шинжилгээ, оношилгоонд хамруулах зохицуулалт хязгаарлагдмал, гадны эмнэлэгт шилжүүлэх ажиллагаа удаашрах, яаралтай тусламж үзүүлэх хугацаа сунжрах тохиолдол илэрсэн. Яаралтай тусламжийн үеийн тээвэрлэлт, зохион байгуулалт, хариуцлагын тодорхой байдал байршил бүрд харилцан адилгүй байна.

Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хувьд сэтгэл зүйчийн оролцоо тогтмол бус, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сорил, дэмжлэгийн ажил жигд хэрэгжихгүй нөхцөл байдал ажиглагдсан. Сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаатай холбоотойгоор хоригдол, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийн сэтгэл зүйн байдалд анхаарах боломж хязгаарлагдмал байна.

Дээрх нөхцөл байдал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал, зохион байгуулалтад хүндрэл байсаар байгааг харуулж, зарим байршилд удаа дараа давтагдан илэрч байна.

3.4. Аюулгүй байдлын нөхцөл, камерын хяналтын нөхцөл



Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад аюулгүй байдлыг хангах, зүй бус харилцаа, хүч хэрэглэсэн, дарамт шахалт үзүүлсэн байж болзошгүй үйлдлийг илрүүлэх, баримтжуулахад чиглэсэн камерын хяналтын тогтолцоо жигд бус, зарим байршилд бүрэн ажиллагаатай бус байлаа. Камерын байршил, дүрс бичлэгийн өнцөг хангалтгүй, харанхуй бүс үүссэн, камерын төхөөрөмж эвдэрсэн, бичлэг тасалдах тохиолдол олон газарт илэрсэн.



Камерын бичлэг хадгалалтын хувьд хадгалах хугацаа жигд мөрдөгдөхгүй, мэдээллийн сангийн найдвартай ажиллагаа хангалтгүй, бичлэгийг татан шалгах, ашиглах боломж хязгаарлагдмал нөхцөл тогтоогдсон. Зарим байршилд камерын хяналтын өрөөний зохион байгуулалт, хяналт тавих алба хаагчийн үүрэг, хариуцлага тодорхой бус, бүртгэл, тэмдэглэл нэг мөр хөтлөгдөхгүй нөхцөл тогтоогдсон.



Энгэрийн камерын хэрэглээний хувьд өдөр тутмын хэрэглээнд тогтмол нэвтрээгүй, журам, зааврын хэрэгжилт сул, ашиглалтын бүртгэл жигд бус байдал илэрсэн. Зарим байгууллагад энгэрийн камер ашиглахгүй байх, эсхүл тодорхой нөхцөлд унтраах, тасалдуулах тохиолдол гардаг талаар хоригдол, цагдан хоригдож байгаа хүмүүс ярилцлага, асуумжаар мэдээлсэн.



Аюулгүй байдлын бусад зохицуулалтын хүрээнд жижүүрийн тэмдэглэл, харуул хамгаалалтын бүртгэл, осол, зөрчлийн талаарх мэдээлэл баримтжуулах ажиллагаа жигд бус, дотоод хяналтын механизм бүрэн хэрэгжихгүй нөхцөл байдал тогтоогдсон.

Дээрх нөхцөл байдал нь аюулгүй байдлыг хангах, зүй бус харилцаа, хүч хэрэглэсэн байж болзошгүй үйлдлийг бодитойгоор илрүүлэх, шалгах, нотлох боломжийг хязгаарлах эрсдэлтэй байдал олон байршилд давтамжтай илэрч байгааг харуулж байна.

3.5. Хөдөлмөр эрхлэлт, шагналын хоногийн зохицуулалтын нөхцөл

Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад хорих ял эдэлж буй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломж, ажлын байрны хүртээмж, зохион байгуулалт байгууллага хооронд харилцан адилгүй, жигд бус нөхцөл тогтоогдов. Зарим байршилд хөдөлмөр эрхлэх ажлын байр хүрэлцээгүй, үйлдвэрлэлийн болон туслах ажлын төрөл хязгаарлагдмал, удаан хугацаанд хөдөлмөр эрхлээгүй байдал нэлээдгүй байв.



Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хувьд хамгаалах хэрэгсэл дутмаг, аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол, нэг мөр хийгдэхгүй, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ бүрэн хийгдээгүй байдал зарим байгууллагад ажиглагдсан. Хүнд хүчир ажил гүйцэтгүүлэхдээ хамгаалах хэрэгсэлгүйгээр ажиллуулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой бүртгэл, хяналт жигд бус байх нөхцөл тогтоогдсон.



Шагналын хоног олголтын зохицуулалтын хувьд шалгуур, нөхцөл тодорхой бус, алба хаагчийн дүгнэлт, үнэлгээнд тулгуурласан ялгаатай практик давамгайлж, ижил нөхцөлд хөдөлмөр эрхэлсэн хүмүүсийн хооронд жигд бус байдал үүсэх нөхцөл байдал илэрсэн. Шагналын хоног олголттой холбоотой бүртгэл, тайлагнал, хоригдолд мэдээлэх ажиллагаа байгууллага хооронд харилцан адилгүй байна.



Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой мэдээлэл, дотоод журам, ажлын байрны нөхцөл, шагналын хоног олгох шалгуурын талаарх мэдээллийг хорих ял эдэлж буй хүмүүст ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тогтмол танилцуулах ажиллагаа хангалтгүй байдал зарим байршилд ажиглагдсан.



Дээрх нөхцөл байдал нь хөдөлмөр эрхлэх боломж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, шагналын хоногийн зохицуулалттай холбоотой хэрэгжилт жигд бус байгааг харуулж, зарим байршилд давтамжтай илэрч байна.

3.6. Алба хаагчдын харилцаа, ёс зүйн нөхцөл



Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад алба хаагчдын зүгээс хорих ял эдэлж буй, цагдан хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүстэй харилцах харилцаа, хандлагын жигд бус байдал ажиглагдсан. Ярилцлага, асуумжаар чанга дуугаар загнах, бүдүүлэг, доромж үг хэллэг хэрэглэх, айлган сүрдүүлэх өнгө аяс бүхий харилцаа илэрч байгаа талаар давтамжтай мэдээлэл ирсэн.

Зарим байршилд шаардлага тавих, дэглэм сахиулах нэрийдлээр хүний нэр төрд халдахуйц үг хэллэг хэрэглэх, дарамт үзүүлэх шинжтэй харилцаа гарч болзошгүй нөхцөл бүрдсэн талаар хоригдол, цагдан хоригдож байгаа хүмүүс мэдээлсэн. Алба хаагчдын харилцаанд ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн харилцааны стандарт жигд мөрдөгдөхгүй байна.

Мөн өргөдөл, гомдол гаргасан, эсхүл гаргах оролдлого хийсэн хүмүүстэй холбоотойгоор сөрөг хандлага, дарамт шахалт үүсэх эрсдэлтэй талаар мэдээлэл өгсөн тохиолдол зарим байршилд илэрсэн. Алба хаагчдын зүгээс эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүстэй харилцахдаа хүний эрхийн талаарх ойлголт, ёс зүйн хэм хэмжээг нэг мөр баримтлах байдал хангалтгүй байгааг хяналт шинжилгээний явцад тогтоосон.

Алба хаагчдын хоорондын дотоод харилцаа, ажлын дарамт, ачаалалтай холбоотой зөрчил, үл ойлголцол нь зарим тохиолдолд хоригдол, цагдан хоригдож байгаа хүмүүстэй харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байгааг ярилцлагаар дурдсан.

Дээрх нөхцөл байдал нь алба хаагчдын харилцаа, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт байгууллага хооронд жигд бус, зарим байршилд давтамжтай илэрч байгааг харуулж байна.

3.7. Өргөдөл гомдлын механизмын бодит нөхцөл

Хяналт шинжилгээнд хамрагдсан хорих анги, цагдан хорих болон саатуулах байруудад өргөдөл, гомдол гаргах боломж, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалт жигд бус, бодитоор хэрэгжихгүй нөхцөл байдал зарим байршилд тогтоогдов. Өргөдөл, гомдол гаргахтай холбоотой мэдээллийн самбар хуучирсан, шинэчлэгдээгүй, маягт, саналын хайрцгийн байршил тодорхой бус, хүртээмж хангалтгүй байдал ажиглагдсан.



Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх ажиллагаа жигд бус хэрэгжиж, бүртгэлийн дэвтэр бүрэн хөтлөгдөхгүй, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн явц удаашрах, хариу өгөхгүй орхих тохиолдол илэрсэн. Зарим байршилд өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг хоригдол, цагдан хоригдож байгаа хүмүүст ойлгомжтой, ил тод хэлбэрээр хүргэх ажиллагаа хангалтгүй байна.



Ярилцлага, асуумжаар өргөдөл, гомдол гаргасан, эсхүл гаргах оролдлого хийсэн хүмүүстэй холбоотойгоор сөрөг хандлага, дарамт шахалт үүсэх эрсдэлтэй талаар мэдээлэл өгсөн тохиолдол зарим байршилд илэрсэн. Мөн өргөдөл, гомдлыг дотооддоо шийдвэрлэх нэрийдлээр гадагш шилжүүлэхгүй байх, удирдлагын түвшинд хаагдах нөхцөл бүрддэг талаар мэдээлэл ирсэн.



Өргөдөл, гомдолтой холбоотой баримт бичиг, камерын бичлэг, уулзалтын тэмдэглэл зэрэг нотлох мэдээллийг дагалдуулан шалгах, хадгалах ажиллагаа жигд бус, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хадгалалт тогтворгүй байдал зарим байгууллагад ажиглагдсан.



Дээрх нөхцөл байдал нь өргөдөл, гомдлын механизм бодитоор, үр нөлөөтэй хэрэгжихгүй байгааг харуулж, зарим байршилд давтамжтай илэрч байна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН АВСАН АРГА ХЭМЖЭЭ



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалтай холбогдуулан тэдгээрийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа газар, хэлтсүүдэд чиглэсэн арга хэмжээг зөвлөмжийн хүрээнд үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд зарим байгууллагад байр, орчны нөхцөл, үйлчилгээний зохион байгуулалт, дотоод журам, ажлын зохион байгуулалтад тодорхой өөрчлөлт орж, үйл ажиллагааны наад захын жишиг дээшилсэн талаар байгууллагууд мэдээлсэн. Тухайлбал, орчны тохижилт, камержуулалтын шинэчлэл, дотоод зохион байгуулалтын өөрчлөлт, алба хаагчдад чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулагдсан байна.

4.1. Байр, орчны нөхцөлтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн байр, орчны нөхцөлтэй холбоотой арга хэмжээний хүрээнд амьдрах байрны дотоод зохион байгуулалтыг өөрчлөх, өрөө тасалгаанд засвар үйлчилгээ хийх, ханын чийг, мөөгөнцөр үүссэн хэсгийг цэвэрлэх, засварлах, агааржуулалтын эвдэрсэн системийг засварлах, солих, гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Мөн ариун цэврийн өрөө, шүршүүрийн хэсгийг засварлах, нэмэгдүүлэх, сантехникийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, бохирын шугам, ус зайлуулах хоолойн доголдлыг арилгах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар байгууллагууд зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд хавсрагдах зураг, нотломжийн хамт ирүүлсэн.



Дулаан, халуун усны хангамжийг сайжруулах чиглэлээр бойлер, халаалтын шугамд засвар үйлчилгээ хийх, халуун усны олголтын хуваарьт өөрчлөлт оруулах, өвлийн улиралд дулаан алдагдлыг бууруулах зорилгоор цонх, хаалганы дулаалгыг сайжруулах ажлыг зарим байгууллагад хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын давтамжийг нэмэгдүүлэх, цэвэрлэгээний зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр дотоод байгуулалтын өөрчлөлт хийсэн байгууллагууд цөөнгүй байна.

Барилга байгууламжийн насжилт, төсөв, санхүүгийн хязгаарлагдмал байдал, засвар үйлчилгээний бодлого, төлөвлөлт хангалтгүй зэрэг шалтгаанаас үүдэн байр, орчны нөхцөлтэй холбоотой зарим суурь асуудал бүрэн шийдэгдээгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгааг хяналт шинжилгээний явцад тогтоосон.

4.2. Хоол, хүнс, ундны усны нөхцөлтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн хоол, хүнс, ундны усны чанар, хүртээмжтэй холбоотой асуудлыг арилгах хүрээнд гал тогоо, хоол үйлдвэрлэлийн хэсгийн дотоод зохион байгуулалтыг сайжруулах, тоног төхөөрөмжийг засварлах, шинэчлэх, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, боловсруулалтын горимд өөрчлөлт оруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн гал тогооны ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлын давтамжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдалтай холбоотой дотоод хяналтыг чангатгах арга хэмжээг зарим байгууллагад хэрэгжүүлсэн талаар мэдээлсэн.

Хоол хүнсний хангамж, зохицуулалтын хүрээнд хоолны нэр төрөл, жорын давтамжийг өөрчлөх, хоолны порц, илчлэгийн тооцоололд анхаарах, мах, хүнсний ногоо зэрэг түүхий эдийн нийлүүлэлтийг жигдрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Зарим байгууллагад хоолны цэсийг шинэчлэх, улирлын онцлогт тохируулан хоолны төрөлжилтийг нэмэгдүүлэх оролдлого хийсэн талаар зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна.

Ундны усны хүртээмжийг сайжруулах хүрээнд ус түгээх цэгийн зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, ус хадгалах сав, шугам хоолойн цэвэрлэгээ, ариутгал хийх, ус таталтын хуваарийг тодорхой болгох зэрэг арга хэмжээг зарим байршилд хэрэгжүүлсэн байна. Мөн ундны усны чанарт анхаарах, усны аюулгүй байдлыг хангахтай холбоотой дотоод зохицуулалтыг сайжруулахаар ажиллаж байна.

Хоол, хүнс, ундны усны хангамжтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгаа бөгөөд хүнсний хангамжийн тогтвортой байдал, хоолны төрөлжилт, ундны усны чанар, хүртээмжтэй холбоотой зарим асуудал холбогдох газруудад бүрэн шийдэгдээгүй, хэрэгжих шатанд байгаа талаар тайлагнасан.

4.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалттай холбоотой асуудлыг арилгах хүрээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, эмч, сувилагчийн орон тоо, зохион байгуулалтад анхаарах, эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоод зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар байгууллагууд мэдээлсэн.

Эмийн хангалтыг сайжруулах хүрээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, эмийн олголт, хадгалалт, бүртгэлийн журамд өөрчлөлт оруулах, архаг хууч өвчтэй хүмүүст эмчилгээ, хяналтыг тогтмол хийх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Мөн эмийн хэрэглээ, олголттой холбоотой бүртгэл, баримтжуулалтыг сайжруулах чиглэлээр дотоод зохицуулалт хийсэн байна.

Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, шаардлагатай шинжилгээ, оношилгоонд хамруулахтай холбоотойгоор гаднын эмнэлэгт шилжүүлэх зохион байгуулалтыг тодорхой болгох, яаралтай тусламж үзүүлэх үед тээвэрлэлт, шуурхай ажиллагааг

сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар зарим байгууллага зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хувьд сэтгэл зүйчийн оролцоог нэмэгдүүлэх, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, дэмжлэгийн ажлыг зохион байгуулах, сэтгэл зүйн үнэлгээ, сорил, зөвлөгөө өгөх ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байгууллагууд байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгаа бөгөөд эмийн хангалт, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээний тогтмол байдалтай холбоотой зарим асуудал бүрэн шийдэгдээгүй байгааг хяналт шинжилгээний явцад тогтоосон.

4.4. Аюулгүй байдал, камерын хяналттай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн аюулгүй байдал, камерын хяналтын тогтолцоотой холбоотой асуудлыг арилгах хүрээнд камерын хяналтын системийн бүрэн ажиллагааг хангах, бичлэг хадгалалтын зохион байгуулалтыг сайжруулах, харагдахгүй бүсийг багасгах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн.



Эдгээр арга хэмжээний хүрээнд эвдэрсэн, ажиллагаагүй камерын төхөөрөмжийг засварлах, солих, шинээр суурилуулах, камерын байршлыг өөрчлөх, бичлэг хадгалах сервер, мэдээллийн сангийн багтаамж, найдвартай ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байна. Мөн камерын хяналтын өрөөний зохион байгуулалтыг сайжруулах, жижүүрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, бүртгэл, тэмдэглэл хөтлөлтийг нэг мөр болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.



Энгэрийн камерын хэрэглээтэй холбоотойгоор алба хаагчдыг энгэрийн камераар хангах, ашиглалтын заавар, журмыг танилцуулах, хэрэглээний бүртгэл, хяналтыг сайжруулах, камерын хэрэглээг тодорхой нөхцөлд тогтмол мөрдүүлэх чиглэлээр дотоод зохицуулалт хийсэн талаар байгууллагууд зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна.



Түүнчлэн аюулгүй байдлыг хангахтай холбоотой жижүүр, харуул хамгаалалтын

зохион байгуулалт, осол, зөрчлийн талаарх мэдээлэл баримтжуулах ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байгууллагууд байна.

Аюулгүй байдал, камерын хяналттай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгаа бөгөөд камерын бүрэн хамрах хүрээ, бичлэг хадгалалтын тогтвортой байдал, энгэрийн камерын хэрэглээтэй холбоотой зарим асуудал бүрэн шийдэгдээгүй байгааг хяналт шинжилгээний явцад тогтоосон.

4.5. Хөдөлмөр эрхлэлт, шагналын хоногийн зохицуулалттай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны хүртээмж, шагналын хоногийн зохицуулалттай холбоотой арга хэмжээний хүрээнд ажлын байрны төрөл, тоог нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн болон туслах ажлын зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчлэх, хамгаалах хэрэгслийн хангалтыг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан талаар байгууллагууд мэдээлсэн. Мөн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой дотоод журам, ажлын хуваарь, хяналтын зохицуулалтыг тодорхой болгох талаар зарим байгууллагад өөрчлөлт хийсэн байна.



Шагналын хоног олголтыг хуулийн хүрээнд олгох шалгуур, нөхцөлийг тодорхой болгох, бүртгэл, тайлагналын ажиллагааг сайжруулах, шагналын хоног олголттой холбоотой мэдээллийг хоригдол, ял эдэлж буй хүмүүст ойлгомжтой хэлбэрээр хүргэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна. Зарим байгууллагад шагналын хоног олголтыг дотоод хяналтын хүрээнд нэг мөр болгох оролдлого хийсэн байна.

Түүнчлэн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой бүртгэл, баримтжуулалт, хяналтыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой осол, зөрчлийг бүртгэх, мэдээлэх зохицуулалтыг сайжруулах чиглэлээр дотоод зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байгууллагууд байна.

Хөдөлмөр эрхлэлт, шагналын хоногийн зохицуулалттай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгаа бөгөөд ажлын байрны хүртээмж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, шагналын хоног олголтын жигд байдалтай холбоотой зарим асуудал бүрэн шийдэгдээгүй байгааг хяналт шинжилгээний явцад тогтоосон.

4.6. Алба хаагчдын харилцаа, ёс зүйтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн алба хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой асуудлыг арилгах хүрээнд хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэргэжлийн харилцааны стандартыг мөрдүүлэх, алба хаагчдад хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, мэргэжлийн ёс зүй, зүй бус харилцаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, танилцуулга зохион байгуулах, дотоод журам, зааврыг шинэчлэх, алба хаагчдын ажлын байрны харилцаанд мөрдөх шаардлагыг тодорхой болгох ажлыг хэрэгжүүлсэн талаар байгууллагууд зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна.

Мөн удирдах болон гүйцэтгэх түвшний алба хаагчдын харилцаа, сахилга хариуцлагатай холбоотой дотоод хяналтыг сайжруулах, гомдол, мэдээлэлд хариу өгөх, зүй бус харилцаа гарсан тохиолдолд дотооддоо шалгах, арга хэмжээ авах зохион байгуулалтыг тодорхой болгох чиглэлээр зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байгууллагууд байна.

Эдгээр арга хэмжээ нь алба хаагчдын харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, зүй бус харилцаа давтагдахаас сэргийлэхэд чиглэсэн боловч бодит нөхцөл байдалд хэрэгжилтийн түвшин, тогтвортой байдал нь байгууллага бүрд харилцан адилгүй хэвээр байгааг хяналт шинжилгээний явцад ажигласан.

4.7. Өргөдөл, гомдлын механизмтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн өргөдөл, гомдол гаргах боломж, түүний шийдвэрлэлттэй холбоотой асуудлыг арилгах хүрээнд өргөдөл, гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааг тодорхой болгох, мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр өргөдөл, гомдол гаргахтай холбоотой мэдээллийн самбар, танилцуулгыг шинэчлэх, саналын хайрцаг, маягтын байршлыг тодорхой болгох, бүртгэлийн дэвтэр, хяналтын хуудсыг нэг мөр болгох, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг дотоод журамд тусгах зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн талаар байгууллагууд зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд тусгасан байна.

Мөн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг гаргагчид хүргэх, шийдвэрлэлтийн шат дамжлагыг ойлгомжтой болгох, холбогдох баримт бичиг, камерын бичлэг, тэмдэглэлийг хадгалах, баримтжуулах ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод зохицуулалт хийсэн байгууллагууд байна. Зарим байршилд өргөдөл, гомдол гаргасантай холбоотой сөрөг нөлөөлөл, дарамт үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар анхаарч, удирдлагын түвшинд хяналт тавих зохион байгуулалт хийсэн талаар мэдээлсэн.

ТАВ. НҮБ-ЫН «НЕЛЬСОН МАНДЕЛАГИЙН ДҮРЭМ» (ХОРИГДОЛТОЙ ХАРЬЦАХ НААД ЗАХЫН ЖИШИГ ДҮРЭМ)-ИЙГ ЗӨРЧСӨН ТОХИОЛДЛУУД

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2025 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах нөхцөл үүсгэсэн, НҮБ-ын «Нельсон Манделагийн дүрэм» (Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм)-ийг зөрчсөн тохиолдол хэд хэд тогтоогдсон. Дараах онцлох тохиолдлууд нь илэрсэн зөрчил, доголдлын ноцтой шинжийг нэгтгэн харуулж байгаа бөгөөд эдгээр нь ярилцлага, асуумж, орчны үзлэг, албан бичиг, дүрс бичлэг, тайлбар зэрэг бодит эх сурвалжаар баталгаажсан болно.



Тохиолдол-1 Ховд аймаг дахь 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

Хяналт шинжилгээний хүрээнд хорих ангийн амьдралын бүсийн орчин нөхцөлд үзлэг хийхэд өрөөнүүд чийгтэй, мөөгөнцөр үүссэн, агааржуулалт хангалтгүй, зарим өрөөний цонх онгойх боломжгүй байдал тогтоогдсон. Хорих ял эдэлж буй хүмүүсийн амьдралын бүсийн агаар солилцоо хэвийн бус, битүү орчинд удаан хугацаагаар байдаг нөхцөл бүрдсэн нь тодорхой байв.

Мөн нийтээр нь нэг цэгийн байрлалд удаан хугацаагаар суулгадаг зохион байгуулалттай холбоотойгоор бие махбодын болон сэтгэл санааны дарамтад ордог талаар мэдээлэгдсэн. Асуумжид дурдсанаар “Өрөөнд чийг үнэртэж, хоног бүр чийгтдэг, тоос, мөөгөнцөр гардаг. Удаан суугаад байхаар толгой их өвддөг” гэж бичсэн нь орчны үзлэгээр тогтоогдсон ханын сэв, нэвчилт, агааржуулалтын хоолойн эвдрэл зэрэг бусад баримтаар давхар баталгаажсан.

Агааржуулалтгүй, чийгтэй битүү орчин нь эрүүл, аюулгүй орчинд байх баталгааг алдагдуулах, хүнлэг бус, тэвчишгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх шинжтэй гэж үзэн уг нөхцөлийг арилгах талаар асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тодорхой тусгасан. Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд зарим өрөөнд засвар хийж, ханын мөөгөнцөр цэвэрлэх, агааржуулалтын хоолойг хэсэгчлэн солих зэрэг арга хэмжээ авсан талаар холбогдох зураг, нотломжийн хамт тайлагнан ирүүлсэн.

Тохиолдол-2 Орхон аймаг дахь 437 дугаар нээлттэй, хаалттай хорих анги

Хяналт шинжилгээний хүрээнд тус хорих ангид камерын хяналтын доголдолтой холбоотой асуудлаар ажлын хэсэгт мэдээлэл ирүүлсэн. Үзлэг, мэдээллийн явцад камерын хяналтын систем бүрэн ажиллагаатай бус, дүрс авах өнцөг хүрэлцээгүй, тодорхой хэсэгт харанхуй бүс үүссэн нөхцөл тогтоогдсон. Камерын

бичлэг тасалдах хугацаанд алба хаагчийн зүгээс хорих ял эдэлж буй хүнд зүй бус харилцаа гарсан тухай мэдээлэл ярилцлага, асуумжаар бүртгэгдсэн.

Ярилцлагын үеэр “Камер хүрэхгүй буланд авч орж загнадаг, тэгэх үед бичлэг байдаггүй” гэж хэлсэн бол асуумжид “Камер унтрах үед дуудан загнадаг”, “Харагдахгүй хэсэгт оруулж айлгадаг” гэж бичсэн нь олон давтамжтай илэрхийлэгдсэн.

Камерын хяналт бүрэн ажиллагаатай бус, харанхуй бүс үүссэн нөхцөл байдал нь хяналт, хариуцлагын механизм жигд хэрэгжих боломжийг хязгаарлаж, хүнтэй зүй бус харилцах, айлган сүрдүүлэх шинжтэй үйлдэл гарах нөхцөл бүрдүүлж байгааг арилгах талаар асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тусгасан.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд зарим камерын төхөөрөмжийг шинээр суурилуулах, серверийн багтаамжийг сайжруулах ажил эхлүүлсэн, энгэрийн камерын хэрэглээг нэмэгдүүлэх чиглэл өгсөн талаар байгууллагаас холбогдох зураг, нотломжийн хамт тайлагнан ирүүлсэн.

Тохиолдол-3 ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги

Хяналт шинжилгээний хүрээнд тус хорих ангид ундны ус зөөвөрлөхтэй холбоотойгоор хорих ял эдэлж буй хүн бие махбодын гэмтэл авсан тохиолдол тогтоогдсон. Тус байгууллагад ундны усыг том хэмжээний саваар зөөвөрлөх ажлыг хорих ял эдэлж буй хүмүүсээр гүйцэтгүүлдэг зохион байгуулалттай байв.

Зөөвөрлөх явцад аюулгүй ажиллагааны шаардлага хангагдаагүйн улмаас бие махбодын гэмтэл авсан талаараа ярилцлагын үеэр “Усыг бид өөрсдөө том саванд хийж чирдэг байсан, сав халтираад хөл хавчуулагдсан” гэж мэдээлсэн бол асуумжид “Ус зөөх ажлыг аюулгүй хийлгэдэггүй, хүнд зүйлийг бид өөрсдөө зөөдөг” гэж бичсэн.

Дээрх мэдээлэлтэй холбогдуулан эмнэлгийн тусламж үзүүлсэн талаар холбогдох бүртгэл хөтлөгдсөн, ослын талаарх мэдээлэл байгууллагын бүртгэлд тэмдэглэгдсэн нь хяналт шинжилгээний явцад тогтоогдсон.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй, хамгаалалтын хэрэгсэлгүйгээр хүнд ажил хийлгэх зохицуулалт нь хорих ял эдэлж буй хүний бие махбодын халдашгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байгаатай холбогдуулан уг нөхцөлийг арилгах талаар асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тусгасан.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд ундны ус татах шугамыг шинэчлэх ажил эхлүүлсэн, ачаалал ихтэй, эрсдэлтэй ажлыг хорих ял эдэлж буй хүмүүсээр гүйцэтгүүлэхгүй байхаар зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан талаар байгууллагаас тайлагнан ирүүлсэн.

Тохиолдол-4 Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

Хяналт шинжилгээний хүрээнд тус байгууллагад алба хаагчийн зүй бус үг хэллэг хэрэглэх, чанга дуугаар загнаж сүрдүүлэх, доромж шинжтэй хандлага гаргадаг талаар хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож байгаа хүмүүсээс ажлын хэсэгт мэдээлэл ирүүлсэн.

Ярилцлагын үеэр “Шаардлага тавих нэрийдлээр чанга дугардаг, айлгадаг үг хэлдэг” гэж хэлсэн бол асуумжид “Хэл амаар доромжилдог алба хаагч бий”, “Айлган сүрдүүлэх байдал гардаг” гэж бичсэн нь олон давтамжтай илэрхийлэгдсэн.

Дээрх мэдээлэлтэй холбогдуулан алба хаагчдын харилцаа, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зүй бус харилцаанаас урьдчилан сэргийлэх шаардлагатайг асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тусгасан.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд алба хаагчдад хууль тогтоомж, холбогдох олон улсын эрх зүйн баримт бичгийн суурь зарчим, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүстэй харилцах ёс зүйн шаардлагын талаар танилцуулах, “Ёс зүйн дэд хороо”-ны зөвлөгөөн зохион байгуулж, алба хаагчдад үүрэг, чиглэл өгөх, яриа, таниулга хийх арга хэмжээг авсан талаар байгууллагаас мэдээлсэн. Мөн сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах, алба хаагчдын үүрэг гүйцэтгэл, харилцаанд хяналт тавих чиглэлээр төлөвлөн ажиллаж байгаа талаар тайлагнан ирүүлсэн.

Тохиолдол-5 Дархан-Уул аймаг дахь 445 дугаар нээлттэй хорих анги

Хяналт шинжилгээний хүрээнд тус хорих ангид хорих ял эдэлж буй хүмүүсийг байрлуулах өрөөний талбай хүрэлцээгүй, ор дутагдалтай, шахцалдаж байрласан, улмаар чөлөөтэй хөдөлгөөн хийх боломж хязгаарлагдсан, амьдрах талбайн стандарт хангахгүй нөхцөл байдал илэрсэн.

Өрөөнөөс гарах боломж хязгаарлагдмал, дотоод цагийн хуваарийг мөрдөж ажиллах нэрийдлээр хөдөлмөрийн заалтгүй хоригдлуудыг нэг цэгийн байрлалд удаан хугацаагаар суулгадаг талаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, асуумжид нийтлэг илэрхийлэгдсэн. Үүнтэй холбоотойгоор биеийн ачаалал нэмэгдэх, сэтгэл санааны дарамттай байдал үүсдэг талаар мэдээлсэн.

Хяналт шинжилгээгээр өрөөний багтаамж стандартын доод хэмжээнд хүрээгүй, орнуудын хооронд чөлөөтэй хөдлөх зайгүй байдал илэрсэн. Дээрх нөхцөлтэй холбогдуулан хорих ял эдэлж буй хүнийг нэг байрлалд удаан хугацаагаар суулгадаг, хөдөлгөөнийг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг нэг мөр арилгах талаар асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тусган хүргүүлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд өрөөний дотоод зохион байгуулалтыг өөрчлөх, ор байршлыг тохируулах, амьдралын бүсэд гарах цагийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан талаар байгууллагаас мэдээлсэн.

Тохиолдол-6 Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Хяналт шинжилгээний хүрээнд тус газарт хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож байгаа хүмүүсийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх механизм бодитоор хэрэгжихгүй, зохион байгуулалт жигд бус байгаагаас хүсэлт шийдвэрлэх үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй, хүсэлтүүд шийдвэрлэлтийн шатанд удаашрах, зарим тохиолдолд хариу өгөхгүй хаагддаг нөхцөл илэрсэн.

Өргөдөл, гомдлын талаарх мэдээллийн хүртээмж сул, саналын хайрцгийн байрлал тодорхой бус, бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтлөхгүй байх зэрэг зохион

байгуулалтын доголдол давтамжтай илэрсэн. Мэдээллийн самбар хуучирсан, шинэчлэгдээгүй, өргөдөл, гомдол хүлээн авах аргачлалыг ойлгомжтой байдлаар танилцуулаагүй байдал хяналт шинжилгээний явцад тогтоогдсон.

Ярилцлагын үеэр “Гомдол гаргавал хариу ирдэггүй, ихэнхдээ юу болсныг хэлдэггүй” гэж мэдүүлсэн бол асуумжид “Хүсэлт өгсөн ч шийдвэр нь тодорхой биш, удаан хүлээлгэдэг”, “Гомдлын хайрцагт хийсэн зүйл хариу авч чаддаггүй” гэж бичсэн.

Дээрх нөхцөлтэй холбогдуулан өргөдөл, гомдлын механизмыг бодитоор хэрэгжүүлэх, хүсэлт шийдвэрлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, бүртгэл, тайлагналын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатайг асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжид тусгасан.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд саналын хайрцгийг шинэчилж, байршуулалтыг сайжруулах, өргөдөл, гомдлын маягыг стандартчилах, бүртгэлийн дэвтрийг шинэчлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан талаар байгууллагаас мэдээлсэн.

ЗУРГАА. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН АГУУЛГА

Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах нөхцөл, амьдрах орчны болон байгууллагын дотоод зохион байгуулалтын зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор асуудал эрхэлсэн гишүүнээс 2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт 474 заалт бүхий 17 зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн дүн шинжилгээ хийхэд зарим чиглэлд тодорхой ахиц гарсан боловч удирдлага, зохион байгуулалтын түвшний суурь доголдол бүрэн шийдэгдээгүй хэвээр байгааг тогтоосон. Байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, нотломж, газар дээрх хяналт шинжилгээ, ярилцлага, асуумжийн дүнг харьцуулан үзэхэд зөвлөмжийн зарим заалт хэсэгчлэн хэрэгжсэн боловч хүний нэр төрийг хүндэтгэн харьцах, эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцааг таслан зогсоох суурь баталгааг бүрэн хангах түвшинд хүрээгүй байна.

Хэрэгжилтийн түвшин байгууллага хооронд харилцан адилгүй байсан бөгөөд зарим хорих анги, салбар нэгжид орчны тохижилт, камержуулалтын шинэчлэл, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр ахиц гарсан бол бусад байгууллагад хүний эрх зөрчигдөх эрсдэл бүхий нөхцөл хэвээр хадгалагдаж байв. Зөвлөмжийн хэрэгжилт хэсэгчилсэн, хугацаа хэтэрсэн, эсхүл бүрэн биелүүлээгүй тохиолдол нийтлэг байлаа.

Хяналт шинжилгээний явцад амьдрах орчны эрүүл ахуй, камерын хяналтын бүрэн ажиллагаа, өргөдөл гомдлыг шийдвэрлэх тогтолцоо, алба хаагчдын ёс зүй, эрүүл мэндийн үйлчилгээ, уулзалтын зохион байгуулалт зэрэг асуудал давтамжтай илэрч байгаа нь зөвлөмжийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд тогтмол хянах, хангах дотоод механизмыг бүрэн төлөвшүүлээгүй хэвээр байгааг илтгэж байна.

Мөн зарим байгууллага зөвлөмжийн хэрэгжилтэд ахиц гаргасан талаар тайлагнасан боловч ирүүлсэн нотломжийн баримт нь газар дээрх хяналт шинжилгээний бодит нөхцөл байдалтай зөрсөн тохиолдол цөөнгүй байв. Энэ нь зөвлөмжийн хэрэгжилтийг зөвхөн байгууллагын тайлангаар үнэлэх боломжгүй бөгөөд зайлшгүй давтан, газар дээрх хяналт хийх шаардлагатай байдаг.

Түүнчлэн зөвлөмж биелүүлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын хариуцлага сул, хэрэгжилтийн хугацааг мөрдөхгүй байх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний бодит байдал болон тайлангаар ирүүлсэн мэдээллийн хооронд зөрүү гарах явдал нийтлэг хэвээр байна. Иймд зарим чиглэлд ахиц гарсан хэдий ч байгууллагын соёл, удирдлага, хариуцлагын тогтолцоонд шаардлагатай суурь өөрчлөлт бодитоор төлөвшөөгүй хэвээр байна.

Энэ жилийн хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил дутагдлыг үндэслэн, байгууллага хоорондын нөхцөл байдлын ялгаа болон хэрэгжилтийн бодит боломжийг харгалзан тодорхой, хэрэгжүүлэхүйц арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж газруудад хүргүүлсэн болно.

Зөвлөмжийн хэрэгжилтийг байгууллага тус бүрийн ирүүлсэн биелэлтийн мэдээлэл, газар дээр нь хийсэн хяналт шинжилгээний үр дүн, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь, ярилцлага, асуумжийн мэдээлэлтэй тулган үнэлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилт нэгж бүрд харилцан адилгүй, зарим байгууллагад ахиц гарсан боловч суурь доголдлыг бүрэн арилгасан түвшинд хүрээгүй байна. Хэрэгжилтийг дараах байдлаар ангилан дүгнэлээ.

Хүснэгт 13

| № | Зөвлөмжийн чиглэл | Хамрах агуулга |
|---|---|--|
| 1 | Амьдрах орчны стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдал | Амьдралын бүсийн чийг, мөөгөнцөр, агааржуулалт, өрөөний стандарт даац, нэг байрлалд удаан суулгах зөрчлийг арилгах, ариун цэврийн байгууламж, дулаан, халуун усны хүртээмж, барилга байгууламжийн ашиглалтын насжилтаас үүдэлтэй доголдлыг шийдвэрлэх. |
| 2 | Камерын хяналт, ил тод байдлын тогтолцоо | Камерын хяналтын бүрэн ажиллагаа, харанхуй бүсийг арилгах, бичлэг хадгалалтын хугацаа, чанар, серверийн найдвартай ажиллагаа, энгэрийн камерын хэрэглээ, камер доголдох тохиолдолд шуурхай засварлах. |
| 3 | Алба хаагчийн ёс зүй, хүний эрхийн мэдлэг, хариуцлага | Зүй бус харилцааг таслан зогсоох, эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх сургалт, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, зөрчил гаргасан алба хаагчид хариуцлага тооцох механизм, шинээр орсон болон ээлжийн алба хаагчдын хүний эрхийн сургалт тогтмол зохион байгуулах. |
| 4 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар | Эмч, сувилагчийн хүрэлцээ, эмийн хангалт, яаралтай болон төрөлжсөн тусламж, архаг өвчтэй хүмүүсийн хяналт, сэтгэл зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ авахад саад болж буй дотоод зохион байгуулалтын хүндрэлийг шийдвэрлэх. |

| | | |
|---|---|--|
| 5 | Ажил, сургалт, нийгэмшил, нийгмийн дэмжлэг | Хөдөлмөр эрхлэх боломж, мэргэжлийн сургалт, бүтээлч үйл ажиллагаа, хоригдлын зан үйлийн өөрчлөлт, нийгэмшилд чиглэсэн хөтөлбөр боловсруулж ажиллах. |
| 6 | Өргөдөл, гомдол шийдвэрлэх, мэдээллийн ил тод байдал | Өргөдөл, гомдлыг ил тод, бодитой шийдвэрлэх тогтолцоо, саналын хайрцаг, мэдээллийн самбар, маягтын хүртээмж, гомдол шалгах хугацаа, нууцлал, гомдлыг далдлах, хаах зохисгүй практикийг таслан зогсоох. |
| 7 | Баривчлах, саатуулах төвийн үйл ажиллагаа | Саатуулах байрны амьдрах нөхцөл, ариун цэвэр, хоол, мэдээллийн хүртээмж, утсаар ярих, өмгөөлөгчтэй уулзах, өргөдөл гомдол гаргах эрхийн баталгаа, стандарт, протоколын шинэчлэл хийх. |
| 8 | Алба хаагчийн ажиллах нөхцөл, хууль ёсны эрх | Ажлын ачаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хамгаалах хэрэгсэл, ёс зүйн хэм хэмжээ, алба хаагчийн нэр төр, хууль ёсны эрх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байх. |
| 9 | Удирдлага, дотоод зохион байгуулалт, хяналтын тогтолцоо | Зөвлөмжийн хэрэгжилтийн хяналт, тайлагналын бодит байдал, стандартчилал, камерын нэгдсэн техник хангамж, амьдрах талбай, хөдөлгөөний жишиг стандарт, өргөдөл гомдлын цахим систем, сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх. |

ДОЛОО. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

7.1. Зөвлөмжийн хэрэгжилтийн нэгтгэсэн үнэлгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн нэгтгэсэн дундаж үнэлгээ 84.3 хувьтай байна. Энэ нь өмнөх онуудтай харьцуулахад зөвлөмжийн хэрэгжилт тогтвортой өсөх хандлагатай байгааг илтгэж байгаа бөгөөд байгууллагын түвшинд тодорхой ахиц гарсныг харуулж байна.

Хэрэгжилтийн түвшин байгууллага хооронд харилцан адилгүй байгаа бөгөөд зарим байгууллагад орчны нөхцөл, камержуулалт, хөдөлмөрийн зохион байгуулалтын чиглэлээр бодит сайжруулалт ажиглагдсан бол бусад байгууллагад өмнө тогтоогдсон зөрчил, дутагдал бүрэн арилаагүй, давтан илэрч байгаа нөхцөл байдал хэвээр хадгалагдсаар байгаа тул цаашид тогтвортой сайжруулах шаардлагатай байна.

7.2. Зөвлөмжийн хэрэгжилтийн түвшнээр ангилсан үнэлгээ

Хүснэгт 14

| Ангилал | Байгууллагын нэр | Хэрэгжилт (%) |
|--------------------------------|---|---------------|
| Өндөр | Дорнод аймаг дахь ШШГГ | 96.0 |
| | Архангай аймаг дахь ШШГГ | 92.5 |
| | Булган аймаг дахь 439 дүгээр хаалттай хорих анги | 92.0 |
| | Баянхонгор аймаг дахь ШШГГ | 92.0 |
| | Баян-Өлгий аймаг дахь ШШГГ | 90.0 |
| Дунд | Завхан аймаг, Тосонцэнгэл сум дахь ШШГХ | 87.5 |
| | Орхон аймаг дахь 437 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | 86.5 |
| | Говь-Алтай аймаг дахь ШШГГ | 86.0 |
| | Хэнтий аймаг дахь ШШГГ | 85.0 |
| | Хэнтий аймаг дахь 419 дүгээр нээлттэй хорих анги | 85.0 |
| | Увс аймаг дахь ШШГГ | 85.0 |
| | ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги | 83.0 |
| | Багануур дүүрэг дэх ШШГХ | 80.5 |
| | ШШГЕГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих анги | 80.0 |
| Сайжруулах шаардлагатай | Өвөрхангай аймаг дахь ШШГГ | 76.0 |
| | Ховд аймаг дахь 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | 70.0 |
| | ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | 66.5 |
| Нийт (дундаж) | | 84.3 |

7.3. Хэрэгжилт өндөр байгууллагуудад ажиглагдсан нийтлэг ахиц

Хэрэгжилтийн түвшин 90 ба түүнээс дээш хувьтай байгууллагуудад амьдрах орчны засвар, тохижилт, камерын хяналтын системийн шинэчлэл, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулалтыг өргөжүүлэх чиглэлээр бодит ахиц ажиглагдсан. Мөн зөвлөмжийг байгууллагын дотоод зохион байгуулалттай уялдуулан хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад дотоод хяналт тавих механизм харьцангуй тогтворжсон байдал илэрсэн нь зөвлөмжийн хэрэгжилтийг бодитой хангахад эерэг нөлөө үзүүлж байна.

7.4. Хэрэгжилт дунд түвшинд байгаа байгууллагуудад илэрч буй нийтлэг эрсдэл

Хэрэгжилт 80-89 хувьтай байгууллагуудад зөвлөмжийн ихэнх заалт хэрэгжсэн боловч амьдрах орчны стандартын тогтвортой мөрдөлт, өргөдөл, гомдлын бодит хэрэгжилт, камерын бүрэн ажиллагаа, хөдөлмөрийн зохион байгуулалтын жигд байдал дээр эрсдэл хадгалагдсаар байна. Эдгээр байгууллагад авсан арга хэмжээ нь тодорхой хугацаанд үр дүн гаргасан боловч зарим тохиолдолд тогтвортой хэвшээгүй, хэрэгжилтийн чанар байгууллага хооронд харилцан адилгүй байдал ажиглагдсан.

7.5. Сайжруулах шаардлагатай байгууллагуудад илэрч буй нөхцөл байдал

Хэрэгжилт 79 ба түүнээс доош хувьтай байгууллагуудад өмнө тогтоогдсон зөрчил, дутагдал давтан илэрч, зөвлөмжийн хэрэгжилт бодит өөрчлөлт авчраагүй нөхцөл байдал хэвээр байна. Эдгээр байгууллагад зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын сул тал, хэрэгжилтийг хянах дотоод механизмын тогтворгүй байдал, тайлагнал болон бодит нөхцөл байдлын хооронд зөрүү гарах тохиолдол илэрч байна.

7.6. Зөвлөмжийн хэрэгжилтийн 2022-2025 оны харьцуулсан үнэлгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 2022 онд ойролцоогоор 60.0 хувь, 2023 онд 70.0 хувь, 2024 онд 76-78 хувь, 2025 онд 84.3 хувь болж жил дараалан өссөн байна. Энэ нь амьдрах орчны засвар, камержуулалтын шинэчлэл, хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулалтыг өргөжүүлэх зэрэг бодит арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тодорхой ахиц гарсныг харуулж байна.

Үүний зэрэгцээ өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, камерын хяналтын тогтвортой ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, алба хаагчдын ёс зүй, харилцаатай холбоотой асуудлаар байгууллагуудын хооронд ахиц жигд бус хэвээр байгаа нь тогтоогдлоо.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэж заасан. Энэхүү зохицуулалтын дагуу зөвлөмжийг биелүүлээгүй, илэрсэн зөрчлийг арилгах зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, хангалтгүй хэрэгжүүлсэн, эсхүл алба хаагчийн үйлдэл нь эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах зөрчилд хүргэсэн гэж үзсэн тохиолдолд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал гарган ажилласан.

Асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага, албан тушаалтанд 2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр дотооддоо хяналт шалгалт явуулж, ирүүлсэн тайлан, нотолгоонд үндэслэн дараах бодит арга хэмжээг авсан талаар тайлагнагдсан байна. Үүнд:

1. Булган аймаг дахь 439 дүгээр хаалттай хорих ангид Харуул хамгаалалтын ажил эрхэлсэн дэд дарга, ахмад Ч.С нь хүний эрхийн зөрчилтэй холбоотой дотоод шалгалтын дүнд албан тушаалаас чөлөөлөгдсөн.
2. Ахлах төлөөлөгч, хошууч Э.О нь албан үүргээ хангалттай биелүүлээгүй, хоригдолтой харьцахдаа зөрчил гаргасан нь тогтоогдсон тул албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, холбогдох ангид шилжүүлэн томилогдсон.
3. Нэр дурдагдсан бусад 5 алба хаагчийн хувьд хоригдлуудын мэдүүлэгт үндэслэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар

холбогдох Цагдаагийн байгууллага болон Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн.

4. ШШГЕГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих ангид ээлжийн дарга, дэслэгч Д.Б, хамгаалалтын ажилтан, ахлагч Б.Б нарын зүй бус харилцаатай холбоотой гомдлын дагуу дотоод шалгалт хийж, ёс зүйн сануулга өгч хариуцлага тооцсон.
5. Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, дэд хурандаа Н.Б нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангаагүй үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.1.1}-т заасны дагуу “цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах” сахилгын шийтгэл ногдуулсан;
6. Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа Г.Г-д “цолны мөнгийг 1 сар хүртэл хугацаагаар хасах” сахилгын шийтгэл ногдуулсан;
7. Тус газрын архив, бичиг хэргийн ажилтан, дэд ахлагч Б.Х-д Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2-т зааснаар “нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан.

Дээрх арга хэмжээнүүд нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасан хариуцлагын механизм Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд бодитоор хэрэгжиж байгааг харуулж байна. Зөвлөмжийн мөрөөр дотоод шалгалт зохион байгуулж, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаал бууруулах, албан тушаалаас чөлөөлөх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах зэрэг арга хэмжээ авсан нь хариуцлагын тогтолцоо ажиллаж буй бодит жишээ болж байна.

Гэсэн хэдий ч сахилгын түвшний арга хэмжээ нь хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаан, нөхцөлийг бүрэн арилгах хангалттай баталгаа болж чадахгүй бөгөөд удирдлагын хариуцлагын тогтолцоо, байгууллагын дотоод хяналт, урьдчилан сэргийлэх механизмыг системийн түвшинд бэхжүүлэх шаардлага хэвээр байна. Хүний эрхийн зөрчил үүсэх нөхцөлийг таслан зогсоох, зөвлөмжийн хэрэгжилтийг бодитоор баталгаажуулах, цаашдын хариуцлагын механизмыг үр дүнтэй болгоход байгууллагын удирдлагын оролцоо, хариуцлагын соёл, дотоод зохион байгуулалтын шинэчлэл зайлшгүй чухал болох нь 2025 оны хэрэгжилтийн үнэлгээгээр тодорхой харагдлаа.

ЕС. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

9.1. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний нэгдсэн үр дүн

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнгээс харахад эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлд байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой ахиц, бодит өөрчлөлт гарч эхэлсэн байна. Амьдралын бүсийн орчны нөхцөл, камерын хяналт, эрүүл мэндийн үйлчилгээ, алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, хандлагад эерэг өөрчлөлт ажиглагдаж, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний нөлөө бодитоор илэрч байна.

Түүнчлэн хүний эрхийн зөрчлийг нуун дарагдуулах бус ил тод мэдээлж, засаж сайжруулах хандлага нэмэгдэж, зөвлөмжийн хэрэгжилтийг удирдлагын түвшинд хэлэлцэх, тайлагнах давтамж нэмэгдсэн нь урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэв.

9.2. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн гол эерэг үр дүн

Хүснэгт 15

| Асуудлын хүрээ | Илэрсэн бодит ахиц |
|---------------------------------------|---|
| Амьдрах орчин | Засвар, шинэчлэлтийн ажил нэмэгдэж, ариун цэврийн байгууламж, агааржуулалт, гэрэлтүүлгийн нөхцөл сайжирсан. |
| Камерын хяналт | Камерын төхөөрөмжийг шинэчлэх, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, харанхуй бүсийг арилгах чиглэлээр арга хэмжээ хэрэгжсэн. |
| Эрүүл мэнд | Үзлэг, эмчилгээний зохион байгуулалт сайжирч, өвчний хяналт, бүртгэл илүү тогтолцоотой болсон. |
| Алба хаагчийн мэдлэг, хандлага | Хүний эрх, ёс зүйн сургалт, танилцуулах ажил тогтмолжиж, харилцааны соёлд тодорхой эерэг өөрчлөлт ажиглагдсан. |
| Өргөдөл, гомдол | Эрхийн талаарх ойлголт нэмэгдэж, гомдол, хүсэлтийг илүү бодитой, баримттайгаар гаргах хандлага нэмэгдсэн. |
| Урьдчилан сэргийлэх нөлөө | Эрсдэлийг эрт шатанд илрүүлэх, даамжрахаас өмнө арга хэмжээ авах боломж өргөжсөн. |
| Ил тод байдал | Хүний эрхийн мэдээллийн самбар, танилцуулга байршуулж, мэдээллийн хүртээмж сайжирсан |

9.3. Цаашид анхаарах суурь асуудлууд

Зөвлөмжийн хэрэгжилтэд тодорхой ахиц гарсан хэдий ч хяналт шинжилгээний үр дүнгээс харахад зарим суурь асуудал давтамжтай илэрч, бүрэн шийдэгдээгүй хэвээр байна. Эдгээр асуудал нь хүний нэр төрийг хүндэтгэх, эрүү шүүлтээс ангид байх баталгааг бодитоор хангахад эрсдэл үүсгэж болзошгүй тул цаашид анхаарлын төвд авч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 16

| Асуудлын хүрээ | Бүрэн шийдвэрлээгүй асуудал |
|------------------------|---|
| Амьдрах орчин | Чийг, мөөгөнцөр, агааржуулалт, ариун цэврийн байгууламжийн доголдол олон байгууллагад давтамжтай илэрсэн. |
| Камерын хяналт | Камерын хяналтын бүрэн ажиллагаа хангагдаагүй, бичлэг тасалдах, харанхуй бүс үүсэх эрсдэл бүрэн арилгагдаагүй. |
| Нотлох баримт | Камерын хяналтын тогтолцоо бүрэн ажиллагаатай бус байгаагаас зөрчлийг нотлон тогтоох боломж хязгаарлагдах эрсдэл илэрсэн. |
| Өргөдөл, гомдол | Ил тод байдал сул, шийдвэрлэх хугацаа зөрчигдөх, бүртгэл дутуу хөтлөгдөх тохиолдол ажиглагдсан. |

| | |
|-------------------------|--|
| Ёс зүй, харилцаа | Алба хаагчийн зүй бус харилцаа зарим нэгжид ужгирсан шинжтэй байна. |
| Дотоод хяналт | Хариуцлагын механизм тодорхойгүй, илэрсэн зөрчлийг эцэслэн шийдвэрлэх дотоод хяналт сул байна. |
| Тайлагнал | Ирүүлсэн тайлан газар дээрх бодит нөхцөл байдалтай нийцэхгүй тохиолдол зарим байгууллагад илэрсэн. |
| Нөөц, санхүү | Засвар үйлчилгээ, камерын систем, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт тогтворгүй байна. |
| Эрүүл мэнд | Эмийн хүрэлцээ, төрөлжсөн эмнэлгийн тусламжийн зохицуулалт хангалтгүй байна. |
| Сургалт | Хүний эрх, харилцааны соёлын сургалт системтэй, тогтвортой хэрэгжихгүй байна. |

9.4. Ерөнхий үнэлгээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилт нь байгууллагуудын үйл ажиллагаанд бодит ахиц авчирч, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлд тодорхой суурь өөрчлөлт бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч суурь доголдол, системийн түвшний асуудал бүрэн арилаагүй хэвээр байгаа нь цаашдын шатанд удирдлага, дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, хэрэгжилтийн чанарыг тогтворжуулах шаардлага байсаар байна.

АРАВ. ДҮГНЭЛТ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, түүний үр дүнгээс харахад эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлд тодорхой ахиц, бодит өөрчлөлт гарсан нь тогтоогдов.
2. Хорих байгууллагын амьдрах орчны нөхцөлийг сайжруулах, камерын хяналтын системийг шинэчлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, ёс зүйн төлөвшлийг тогтмолжуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт бодит үр нөлөөтэй хэрэгжиж байгааг илтгэв.
3. Асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд бүрэн хангаагүй, хэрэгжилтийн тайлагнал газар дээрх бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байх, хариуцлагын тогтолцоо жигд бус хэрэгжиж байгаа зэрэг удирдлага, дотоод хяналтын сул талууд нийтлэг хэвээр, тогтолцооны шинжтэй оршсоор байж болзошгүй.

01. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас 2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах, саатуулах нийт 17 газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, 474 заалт бүхий 17 зөвлөмж хүргүүлэв. Мөн өргөдөл, гомдлын хүрээнд хорих анги, цагдан хорих төвүүдэд тухай бүр очиж ажиллав. Түүнчлэн 2022 оноос хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт 46 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хяналт шинжилгээний явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй зарим тохиолдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шалгуулахаар шилжүүлэн ажиллав.

02. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 2022 онд ойролцоогоор 60.0 хувь, 2023 онд 70.0 хувь, 2024 онд 78.0 хувь, 2025 онд 84.3 хувь болж жил дараалан өссөн байна. Энэ нь амьдрах орчны засвар, хяналтын камерын системийн шинэчлэл, ял эдэлж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулалтыг өргөжүүлэх зэрэг бодит арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тодорхой ахиц гарсныг илтгэнэ.

Үүний зэрэгцээ өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, камерын хяналтын тогтвортой ажиллагаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, алба хаагчдын ёс зүй, харилцаатай холбоотой асуудлуудын хэрэгжилт байгууллагуудын хооронд харилцан адилгүй, ахиц жигд бус хэвээр байна.

03. ХАРИУЦЛАГА

Асуудал эрхэлсэн гишүүнээс 2025 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагууд дотоод хяналт шалгалт зохион байгуулсан. Ирүүлсэн тайлан, нотлох баримтад үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албан тушаал бууруулах, чөлөөлөх, сануулах, цолны мөнгө хасах зэрэг нийт 12 албан хаагчид арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар тайлагнаж ирүүлсэн.

04. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүнгээс харахад эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлд байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой ахиц, бодит өөрчлөлт гарч эхэлсэн. Амьдрах орчны нөхцөл, камерын хяналтын тогтолцоо, эрүүл мэндийн үйлчилгээ, алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, хандлагад зэрэг өөрчлөлт ажиглагдаж, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний нөлөө бодитоор илэрч байна.

Түүнчлэн хүний эрхийн зөрчлийг нуун дарагдуулах бус ил тод мэдээлж, засаж сайжруулах хандлага нэмэгдэж, зөвлөмжийн хэрэгжилтийг удирдлагын түвшинд хэлэлцэх, тайлагнах давтамж өссөн нь урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэв.

05. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Зөвлөмжийн хэрэгжилтэд тодорхой ахиц гарсан хэдий ч хяналт шинжилгээний дүнгээс харахад амьдрах орчны нөхцөл, камерын хяналтын тогтолцооны бүрэн ажиллагаа, зөрчлийг нотлон тогтоох боломж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн ил тод байдал, алба хаагчдын ёс зүй, харилцаа, дотоод хяналтын үр нөлөө, тайлагналын бодит байдал, санхүүжилтийн тогтвортой байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүний эрхийн сургалтын тогтолцоотой холбоотой суурь асуудлууд зарим байгууллагад давтамжтай илэрч байна. Эдгээр нөхцөл байдал нь хүний нэр төрийг хүндэтгэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн баталгааг бодитоор хангахад тодорхой эрсдэл үүсгэх хүчин зүйл хэвээр байгаа тул цаашид анхаарлын төвд авч, системтэй арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

2.2. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийг цогцлоох зорилтыг Үндсэн хуулиараа тунхаглаж, төрийн бүх байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хүндэтгэн хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг хүлээдэг. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13, 16.14 дэх хэсэгт зааснаар хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх, эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах аливаа хэлбэрээс ангид байх эрхтэй бөгөөд уг эрхийг ямар ч нөхцөлд үгүйсгэх, хязгаарлахыг хориглосон суурь зарчим үйлчилнэ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нэгдэн орсон улсын хувьд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрсдэл бүхий нөхцөл, шалтгааныг илрүүлж арилгах, эрх чөлөөгөө хасуулсан болон хязгаарлагдсан орчинд буй хүний эрхийн баталгааг бодитоор хангах олон улсын үүргийг хүлээсэн. Эдгээр олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд баримтлагдах хэм хэмжээ болдог.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7, 8 дугаар бүлэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч явах боломжгүй бүх газарт тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, тогтолцооны шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэх бүрэн эрхийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд олгосон.

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа иргэний эрх, эрх чөлөөг холбогдох хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлах онцгой бүрэн эрх эдэлдэг. Иймээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хүний эрхийн зөрчил, тэр дундаа эрүү шүүлт тулгах, зүй бус харьцаа үүсэх эрсдэлтэй шууд холбогддог бөгөөд уг эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нь төрийн хүлээсэн үүргийн салшгүй хэсэг юм.

Энэхүү зорилго, эрх зүйн үндэслэлийн хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу 2025 онд Монгол Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын харьяа эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөө, иргэдийг угтах хэсэг зэрэг хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдаж болзошгүй орчинд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хэрэгжүүлэв. Хяналт шинжилгээ нь цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйл ажиллагаа, байгууллагын дотоод зохион байгуулалт, стандарт, журам, бодит нөхцөл байдал нь хүний эрхийн олон улсын болон дотоодын хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг үнэлэх, илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгуулахад чиглэгдсэн

болно. Тайлангийн энэ бүлэгт цагдаагийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ, эрх зүйн үндэслэл, зорилгыг тодорхойлж, хяналт шинжилгээгээр тогтоогдсон бодит нөхцөл байдал, авсан арга хэмжээ, хүргүүлсэн зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилтийн үнэлгээг хүний эрхийн мандатын хүрээнд нэгтгэн дүгнэж тусгав.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Монгол Улсын хэмжээнд Цагдаагийн байгууллагын 19 газар, хэлтсийн харьяа эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөө, иргэдийг угтах хэсэг зэрэг нийт 48 объектод урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хэрэгжүүлж, илэрсэн нөхцөл байдалд 16 зөвлөмж хүргүүлсэн.

Хяналт шинжилгээг дангаар болон олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хамтарсан ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлсэн бөгөөд хамрах хүрээ, арга зүй нь хүний эрхийн олон улсын стандарт, үндэсний эрх зүйн зохицуулалтад нийцсэн болно.

2.1. Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагын нэгтгэсэн жагсаалт

Хүснэгт 17

| № | Байгууллага, газар, хэлтэс | Байршил | Хяналт хийсэн объектын төрөл | Зөвлөмж илгээсэн эсэх | Зөвлөмжийн заалтын тоо | Тайлбар |
|---|--|---------|---|-----------------------|------------------------|---|
| 1 | Цагдаагийн ерөнхий газрын даргад | УБ | Бодлого, зохион байгуулалт | Илгээсэн | 18 | Хяналт шинжилгээний явцад тогтоогдсон нөхцөл байдал |
| 2 | ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба | УБ | Эрүүлжүүлэх, саатуулах төв | Илгээсэн | 3 | Биометрик болон бүртгэлийн асуудал |
| 3 | ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба | УБ | Мэдүүлэг авах өрөө | Хууль ёсны шаардлага | - | Хамтарсан хяналт шинжилгээ |
| 4 | Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс | УБ | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 4 | ЭШУС-ын ажлын хэсэг |

| | | | | | | |
|----|---|-------|---|----------------------|---|----------------------------------|
| 5 | Баянзүрх дүүргийн Цагдаагийн 3 дугаар хэлтэс | УБ | Мэдүүлэг авах өрөө | Хууль ёсны шаардлага | - | Төлөвлөгөөт бус хяналт |
| 6 | НЦУГ, НХЖХГ, Эрүүлжүүлэх, саатуулах төв | УБ | Эрүүлжүүлэх, саатуулах төв | - | - | Олон улсын хамтарсан ажлын хэсэг |
| 7 | Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 5 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 8 | Баянхонгор аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 7 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 9 | Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 4 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 10 | Завхан аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | - | - | Зөвлөмж хүргүүлээгүй |
| 11 | Завхан аймаг, Тосонцэнгэл сумын сум дундын ЦХ | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 6 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 12 | Архангай аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 4 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 13 | Ховд аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 4 | ЭШУС-ын ажлын хэсэг |

| | | | | | | |
|-------------|--|-------|---|------------------------------|----|------------------------|
| 14 | Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 3 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 15 | Увс аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 6 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 16 | Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 8 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 17 | Орхон аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 6 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 18 | Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 5 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 19 | Хэнтий аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 10 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| 20 | Дорнод аймгийн Цагдаагийн газар | Аймаг | Эрүүлжүүлэх, саатуулах байр; мэдүүлэг авах өрөө | Илгээсэн | 5 | ЭШУС-ын ажлын хэсэг |
| Нийт | | | 48 объект | 98 заалт / 16 зөвлөмж | | |

Хяналт шинжилгээ нь нийслэл болон орон нутгийг хамарсан өргөн хүрээнд хэрэгжсэн бөгөөд эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөөнд хүний эрхийн эрсдэл бодитоор оршиж байгааг харуулсан. Иймд дараагийн бүлэгт хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн нийтлэг зөрчил, авсан арга хэмжээг дэлгэрэнгүй авч үзнэ.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНД АВСАН АРГА ХЭМЖЭЭ



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг 2025 онд хэрэгжүүлэх явцад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдах эрсдэл бүхий дараах нийтлэг нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүр зөвлөмж

хүргүүлж, шаардлага тавьж ажилласан.

3.1. Эрүүлжүүлэх, саатуулах байранд тогтоогдсон нөхцөл байдал, түүнд авсан арга хэмжээ

Улсын хэмжээнд 1964-2025 оны хоорондох 61 жилийн хугацаанд нийт 35 эрүүлжүүлэх, саатуулах байр ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь 10,567 м² талбай бүхий 202 өрөөнд нийт 967 хүн хүлээн авах хүчин чадалтай байна. Хяналт шинжилгээгээр эрүүлжүүлэх, саатуулах байранд амьдрах орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт хангагдаагүй, хүний эрхийн зөрчил үүсэх бодит эрсдэл хадгалагдаж буй нь тогтоогдсон.



Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаас авсан асуумж, ярилцлагын дүнгээс харахад хүний нөөцийн хомсдол, ажлын ачаалал их, ээлжийн зохион байгуулалт оновчгүй, мэргэшүүлэх болон ажлын байранд чиглэсэн сургалт хангалтгүй, сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ сул зэрэг асуудал нийтлэг илэрч байна.



Хяналт шинжилгээгээр дараах нийтлэг зөрчил, дутагдал тогтоогдсон. Үүнд:

- Байр, өрөө тасалгааны хүрэлцээ муу, агааржуулалт, дулаан, чийгшлийн хэмжээ, зохицуулалт хангалтгүй;
- Ариун цэврийн өрөө, угаалгын нөхцөл стандартын шаардлага хангахгүй;
- Эм, эмнэлгийн анхан шатны тусламж, эрүүл мэндийн хяналт сул;
- Камерын хяналтын системийн байршил, бүртгэл, файлын хадгалалт хангалтгүй;
- Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл авах боломж хязгаарлагдмал.





Дээрх нөхцөл байдал нь 2019 оны “Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага” MNS 5527:2019” стандартын шаардлагыг бүрэн хангаагүйгээс шалтгаалж байсан бөгөөд албадан эрүүлжүүлэгдэж буй иргэдийн эрүүл мэнд, амь насанд эрсдэл учрах, цаашлаад хүний эрхийн ноцтой зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас идэвх санаачилга гарган ажиллаж “Эрүүлжүүлэх үйлчилгээний ерөнхий шаардлага” (MNS 5527:2025)-ыг шинэчлэн 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгааг онцлон тэмдэглэж байна. Гэвч урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр 2025 онд илэрсэн эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх, шинэчлэн баталсан стандартын шаардлагад нийцүүлэх зүй ёсны ажил, арга хэмжээг цаашид зохион байгуулах нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх учир холбогдолтой.

Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага, албан тушаалтанд:

1. Стандарт, журмыг нэг мөр мөрдүүлэх;
2. Камерын хяналт, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах;
3. Хүний нөөц, сургалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг газар дээр нь шалган үнэлж ажилласан.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гарсан тохиолдлууд

Нийслэл болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байранд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, архаг өвчтэй, сэтгэцийн болон зүрх, судасны эмгэгтэй иргэдийн эрүүл мэндийн байдалд цаг тухайд нь хяналт тавих хүний нөөц, техник хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт дутмаг, эрүүл мэндийн байгууллагатай хамтын ажиллагааны уялдаа сул, алба хаагчдын анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадвар хангалтгүй байгаатай холбоотойгоор 2025 онд 6 хүн, 2026 оны эхний байдлаар 2 хүн, нийт 8 хүн амь насаа алдсан.



Энэ нь эмнэлгийн шуурхай тусламж, үйлчилгээ болон цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааны уялдаа сул, албан тушаалтнуудын ажилдаа хандах хандлага, анхны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадвар хангалтгүй, мөн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу байгаатай холбоотой.

Иймд байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, алба хаагчид болон эмнэлгийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, шаардлагатай техник хэрэгсэл, анхны тусламжийн эм болон бусад хэрэгслээр хангах шаардлагатай.

3.2. Мэдүүлэг авах өрөөнд тогтоогдсон нөхцөл байдал, түүнд авсан арга хэмжээ

Мэдүүлэг авах өрөөнд хийсэн хяналт шинжилгээгээр зарим өрөөнд камерын байршил нэг чиглэлд хандсан, эсхүл бүрэн ажиллагаагүй, ашиглалтын бүртгэл хөтлөгдөөгүй, прокурорын зөвшөөрлийн хугацаа дууссан байхад ашигласан, нотлох баримтын аюулгүй байдлыг хангаагүй зэрэг зөрчил илэрсэн.



Эдгээр зөрчил нь Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 23-ны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг хангаагүй, эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг баталгаажуулах хяналтын механизмыг сулруулж буй бодит нөхцөл болохыг тогтоосон.





Иймд ашиглалтын бүртгэл, хяналтыг сайжруулах, камерын бүрэн бүтэн байдлыг хангах, удирдлагын түвшний хяналтыг нэмэгдүүлэх талаар шаардлага тавьж, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийн тайланг үнэлсэн.

3.3. Алба хаагчдын сургалт, соён гэгээрүүлэх ажил

Алба хаагчдад хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийн агуулга, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн уялдаа, практик хэрэгжилтийн талаар тогтмол, жигд сургалт зохион байгуулагдаагүй нь тогтоогдсон. Сургалтын давтамж, агуулга нь орон нутаг бүрд харилцан адилгүй, үр нөлөөг үнэлэх тогтолцоо сул байна.

Энэ хүрээнд алба хаагчдын мэдлэг, хандлагыг сайжруулах, хүний эрхэд суурилсан харилцааг төлөвшүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.

3.4. Иргэдийг угтах хэсэгт хүний эрхийн баталгааг хангах асуудал

Иргэдийг угтах хэсэгт эрүү шүүлтээс ангид байх эрх, өмгөөлөгч авах, гомдол гаргах эрхийн талаарх мэдээлэл, танилцуулга дутмаг,

зарим тохиолдолд нийтэд хүртээмжгүй байрлуулсан байдал илэрсэн.

Хяналт шинжилгээний явцад уг дутагдлыг арилгуулах чиглэлээр газар дээр нь шаардлага тавьж, мэдээллийн самбар, гарын авлага, танилцуулгыг шинэчлэх, хүртээмжтэй байрлуулах талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн үнэлгээгээр уг нөхцөл сайжирсан байна.

ДӨРӨВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд Цагдаагийн байгууллагын 19 газар, хэлтсийн харьяа 48 объектод урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, илэрсэн зөрчил, дутагдал, эрсдэл бүхий нөхцөл байдлыг арилгуулах, хүний эрхийн баталгааг бодитоор хангах зорилгоор нийт 16 зөвлөмж (98 заалт)-ыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Зөвлөмжийг боловсруулахдаа хяналт шинжилгээгээр тогтоогдсон бодит нөхцөл байдал, хүний эрхийн олон улсын болон үндэсний стандартын шаардлага, тухайн газар, хэлтсийн онцлогийг харгалзан үзэж, хэрэгжилтийг бодитоор хангахуйц, хэмжигдэхүйц байдлаар тусгасан.

4.1. Зөвлөмжийн ерөнхий чиглэл

Цагдаагийн байгууллагад хүргүүлсэн зөвлөмжүүд нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарсан. Үүнд:

1. Эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин, стандарт

- 2019 оны MNS 5527:2019 стандартын шаардлагыг бүрэн хангах;
- Камерын хяналтын системийн байршил, бүртгэл, хадгалалтыг сайжруулах;
- Эмнэлгийн анхан шатны тусламж, эрүүл мэндийн хяналтыг бодитоор хэрэгжүүлэх.

2. Мэдүүлэг авах өрөөний ашиглалт, хяналт

- Монгол Улсын Ерөнхий прокурорын А/01 дугаар тушаалаар батлагдсан шаардлагыг нэг мөр мөрдүүлэх;
- Камерын бүрэн бүтэн байдал, ашиглалтын бүртгэлийг тогтмолжуулах;
- Удирдлагын түвшний хяналтыг сайжруулах.

3. Алба хаагчдын сургалт, чадавх

- Хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн агуулгаар тогтмол сургалт зохион байгуулах;
- Сургалтын үр нөлөөг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Ажлын байранд суурилсан мэргэшүүлэх сургалтыг нэмэгдүүлэх.

4. Иргэдийг угтах хэсгийн хүртээмж, мэдээлэл

- Эрүү шүүлтээс ангид байх эрх, гомдол гаргах боломжийн талаарх мэдээллийг нийтэд хүртээмжтэй байрлуулах;
- Мэдээллийн самбар, гарын авлагыг шинэчлэх.
- Зөвлөмжийн хэрэгжилтийн зохион байгуулалт
- Зөвлөмжийг хүлээн авах, хэрэгжүүлэх, тайлагнах хариуцлагын тогтолцоог тодорхой болгох;
- Хэрэгжилтийн тайланг нотлох баримттай ирүүлэх.




4.2. Хүргүүлсэн зөвлөмжийн нэгтгэсэн мэдээлэл

Хүснэгт 18

| № | Хүлээн авсан байгууллага | Зөвлөмжийн огноо | Зөвлөмжийн дугаар | Заалтын тоо |
|-------------|--|------------------|-------------------|------------------------------|
| 1 | Цагдаагийн ерөнхий газрын даргад | 2025.03.28 | 08/05 | 18 |
| 2 | ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд | 2025.05.02 | 08/06 | 3 |
| 3 | Говь-Алтай аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/17 | 4 |
| 4 | Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэст | 2025.09.18 | 08/18 | 4 |
| 5 | Хэнтий аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/19 | 10 |
| 6 | Дорнод аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/20 | 5 |
| 7 | Ховд аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/21 | 4 |
| 8 | Өвөрхангай аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/25 | 5 |
| 9 | Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газарт | 2025.09.18 | 08/26 | 3 |
| 10 | Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт | 2025.10.08 | 08/32 | 7 |
| 11 | Увс аймгийн Цагдаагийн газарт | 2025.10.08 | 08/33 | 6 |
| 12 | Архангай аймгийн Цагдаагийн газарт | 2025.10.14 | 08/39 | 4 |
| 13 | Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт | 2025.10.17 | 08/42 | 8 |
| 14 | Орхон аймгийн Цагдаагийн газарт | 2025.10.21 | 08/44 | 6 |
| 15 | Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн хэлтэст | 2025.10.29 | 08/48 | 6 |
| 16 | Сүхбаатар аймгийн Цагдаагийн газарт | 2025.11.19 | 08/50 | 5 |
| Нийт | | | | 98 заалт / 16 зөвлөмж |

ТАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Цагдаагийн байгууллагад 2022-2025 онуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвлөмж тус бүрийн хэрэгжилтийн байдал, авсан арга хэмжээний бодит үр дүн, давтамжтай илэрч буй хүндрэл, эрсдэлийг нэгтгэн дүгнэв.

5.1. Өмнөх онуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ (2022-2024)

Өмнөх жилүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээнээс харахад цагдаагийн байгууллагын удирдлагын түвшинд хүний эрхийн асуудлыг анхаарах хандлага нэмэгдсэн хэдий ч хэрэгжилт жигд бус, зарим заалтын биелэлт цаасан дээр л биелсэн шинжтэй хэвээр байгааг тогтоов.

Хүснэгт 19

| № | Он | Зөвлөмжийн дугаар | Хүлээн авсан байгууллага | Зөвлөмж тоо | Ерөнхий үнэлгээ (%) |
|---|------|-------------------|----------------------------------|-------------|---------------------|
| 1 | 2022 | 08/01 | Төв аймгийн Цагдаагийн газар | 1 | 85.0 |
| 2 | 2023 | 08/01 | Цагдаагийн ерөнхий газар | 2 | 70.0 |
| 3 | 2023 | 08/13 | Сэлэнгэ аймаг, Мандал сумын СДЦХ | 1 | 100.0 |
| 4 | 2024 | 08/06 | Цагдаагийн ерөнхий газар | 3 | 70.0 |
| 5 | 2024 | 08/08 | НЦУГ-ын дарга | 1 | 83.0 |
| 6 | 2024 | 08/13 | Баянгол дүүргийн ЦХ | 1 | 93.0 |

Эдгээр үнэлгээнээс харахад зарим газар, хэлтэст зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эерэг жишээ байгаа боловч стандарт, журам, хяналтын механизмыг байгууллагын хэмжээнд тогтолцоогоор шийдээгүй нөхцөл байдал хэвээр байна.

5.2. 2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ

ЭШУС үндэсний ажиллагаанаас 2025 онд хүргүүлсэн 16 зөвлөмж (98 заалт)-ын хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр дунджаар 85.04 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үнэлгээ нь зөвлөмж тус бүрийн заалтын хэрэгжилтийн бодит байдал, нотлох баримтад тулгуурласан болно.

| № | Зөвлөмж хүлээн авсан байгууллага | Заалтын тоо | Ерөнхий үнэлгээ |
|-------------|--|-------------|-----------------|
| 1 | Цагдаагийн ерөнхий газар | 18 | 87.7% |
| 2 | ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба | 3 | 90.0% |
| 3 | Говь-Алтай аймгийн ЦГ | 4 | 85.0% |
| 4 | Багануур дүүргийн ЦХ | 4 | 85.0% |
| 5 | Хэнтий аймгийн ЦГ | 10 | 84.0% |
| 6 | Дорнод аймгийн ЦГ | 5 | 84.0% |
| 7 | Ховд аймгийн ЦГ | 4 | 95.0% |
| 8 | Өвөрхангай аймгийн ЦГ | 5 | 82.0% |
| 9 | Баян-Өлгий аймгийн ЦГ | 3 | 87.0% |
| 10 | Баянхонгор аймгийн ЦГ | 7 | 84.0% |
| 11 | Увс аймгийн ЦГ | 6 | 85.0% |
| 12 | Архангай аймгийн ЦГ | 4 | 75.0% |
| 13 | Дархан-Уул аймгийн ЦГ | 8 | 82.5% |
| 14 | Орхон аймгийн ЦГ | 6 | 85.0% |
| 15 | Завхан аймаг, Тосонцэнгэл сумын СДЦХ | 6 | 87.5% |
| 16 | Сүхбаатар аймгийн ЦГ | 5 | 82.0% |
| Нийт | | 98 | 85.04% |

5.3. Үнэлгээний дүгнэлт

Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээнээс дараах нийтлэг асуудал тодорхойлогдлоо. Үүнд:

- Стандарт, журам, камерын хяналтын доголдол давтамжтай илэрч байгаа;
- Хэрэгжилтийн тайланг нотлох баримтгүй, тайлбарын түвшинд ирүүлсэн тохиолдол цөөнгүй;
- Удирдлагын түвшинд хяналт, хариуцлагын тогтолцоо тогтворжоогүй.
- Зарим газар, хэлтэст зөвлөмжийг бодитоор хэрэгжүүлж, орчин нөхцөлийг сайжруулсан, хүний эрхийн эрсдэлийг бууруулсан эерэг ахиц ажиглагдаж байна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт байгууллага, албан тушаалтан нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэйг хуульчилсан. Харин 35.4 дэх хэсэгт уг зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлийг тогтоосон.

6.1. Хуулийн 35.4 дэх хэсэг хэрэгжих нөхцөл бүрдсэн бодит жишээ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын даргад хүргүүлсэн зөвлөмжид заасан арга хэмжээг хуульд заасан 30 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн талаар хариу ирүүлээгүй, улмаар хугацаа дууссанаас 57 хоногийн дараа тайлбар хүргүүлсэн.

Увс аймгийн Цагдаагийн газрын дарга нь хүргүүлсэн зөвлөмжид заасан арга хэмжээг хуульд заасан 30 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн талаар хариу ирүүлээгүй, улмаар хугацаа дууссанаас 35 хоногийн дараа ирүүлсэн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35.3 дахь хэсгийн шаардлагыг зөрчсөн нөхцөл байдал тогтоогдсон.

Энэхүү нөхцөл байдалд гишүүнээс тухайн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг хуулийн дагуу эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн боловч цагдаагийн удирдлагаас хуульд заасан хариуцлагын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгаа гэж дүгнэх үндэслэлтэй.

6.2. Авсан арга хэмжээний үр дүн, үнэлгээ

Дээрх саналыг үндэслэн байгууллагын дотоод шалгалт явуулсан боловч эцэст нь “албан тушаал бууруулах” арга хэмжээг аваагүй, харин “сануулах” сахилгын шийтгэл оногдуулсан нь хуульд заасан хариуцлагын арга хэмжээг оногдуулаагүй гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Энэ нь:

- Зөвлөмжийн хууль зүйн хүчин чадлыг сулруулсан;
- Хуулийн 35.4 дэх хэсгийн урьдчилан сэргийлэх, хариуцлагажуулах зорилгыг бүрэн хэрэгжүүлээгүй;
- Хүний эрхийн зөрчил гаргасан, эсхүл зөрчил арилгаагүй үйлдэлд бодит хариуцлага тооцох механизмыг хэлбэр төдийн хэрэгжүүлсэн нөхцөл байдал гэж үнэлэх үндэслэлтэй.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35.4 дэх хэсэг нь зөвлөмжийг үл хэрэгсэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллага, албан тушаалтныг хүний эрхийн зөрчлийн төлөө бодитоор хариуцлагажуулах зорилготой зохицуулалт юм. Гэвч энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ хариуцлагын арга хэмжээг буруу хэрэглэсэн нь хуулийн зорилго, агуулгад нийцээгүй, цаашид ижил төрлийн зөрчил давтагдах эрсдэлийг хадгалж үлдээж байна.

Иймд 35.4 дэх хэсэгт заасан хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ:

- Хуульд заасан үндэслэл, шалгуурыг нэг мөр баримтлах;
- Зөвлөмжийг үл биелүүлсэн, хугацаа хэтрүүлсэн нөхцөлд хариуцлагыг хуульд зааснаар тооцох;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх эрх зүйн баталгааг сулруулахгүй байх шаардлагатай гэж дүгнэж байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд Цагдаагийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ нь нийслэл болон орон нутгийг хамарсан өргөн хүрээнд хэрэгжиж, хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдах эрсдэл бодитоор оршиж буй орчин, үйл ажиллагаанд чиглэсэн, баримтад суурилсан үнэлгээ хийх боломжийг бүрдүүлээ.

Хяналт шинжилгээний дүнгээс харахад эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөө зэрэг орчинд стандарт, журам, хяналтын механизмын хэрэгжилт жигд бус, зарим тохиолдолд хэвшмэл хандлага хэвээр байгааг тогтоов. Камерын хяналтын бүрэн бүтэн байдал, ашиглалтын бүртгэл, эрүүл мэндийн анхан шатны тусламж, алба хаагчдын сургалт, ачаалал, сэтгэл зүйн дэмжлэгийн асуудал нь хүний эрхийн зөрчил үүсэх суурь нөхцөл болж байгааг хяналт шинжилгээний явцад илрүүлсэн.

Үүний зэрэгцээ зарим газар, хэлтэст өмнөх жилүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр бодит арга хэмжээ авч, орчин нөхцөлийг сайжруулсан, камерын хяналт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн эерэг ахиц ажиглагдсан нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа бодит үр нөлөөтэй хэрэгжих боломжтойг харуулж байна.

Гэсэн хэдий ч зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнах, хариуцлага тооцох түвшинд тогтолцооны сул тал арилаагүй хэвээр байж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35.4-т заасан хариуцлагын зохицуулалт бодитоор, нэг мөр хэрэгжихгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хууль зүйн ач холбогдол, урьдчилан сэргийлэх үр нөлөөг сулруулах, цаашид ижил төрлийн зөрчил давтагдах эрсдэлийг бий болгож болзошгүй нөхцөл юм.

Иймд цаашид:

- Эрүү шүүлт, зүй бус харьцаа үүсэх эрсдэлийг стандарт, журам, хяналтын механизмын бодит хэрэгжилтээр бууруулах;
- Алба хаагчдын хүний эрхэд суурилсан мэдлэг, хандлагыг тогтолцоотой сургалтаар бэхжүүлэх;
- Зөвлөмжийн хэрэгжилтэд бодит хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;
- Хуулийн 35.4-т заасан хариуцлагын арга хэмжээг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Эдгээр арга хэмжээг тууштай хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор хамгаалах, улмаар “эрүү шүүлтгүй, хүний эрхийг дээдэлсэн цагдаагийн байгууллага” төлөвших эрх зүйн болон тогтолцооны суурь бэхэжнэ.

01.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд Цагдаагийн байгууллагын 19 газар, хэлтсийн 48 объектод урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, илэрсэн зөрчил, дутагдал, эрсдэл бүхий нөхцөл байдлыг арилгуулах, хүний эрхийн баталгааг бодитоор хангах зорилгоор нийт 16 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, газар дээр нь шаардлага тавьж ажилласан. Зөвлөмжийг хяналт шинжилгээгээр тогтоогдсон бодит нөхцөл байдал, хүний эрхийн стандартын шаардлага, тухайн газар, хэлтсийн онцлогийг харгалзан хэрэгжилтийг бодитоор хангахуйц, хэмжигдэхүйц байдлаар тусгасан.

02.

ЗӨВЛӨМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Цагдаагийн байгууллагын хэмжээнд зөвлөмжийн биелэлт 85.04 хувь буюу "хэрэгжих шатанд" байна. Цагдаагийн ерөнхий газар 87.7%, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба 90%, Говь-Алтай аймгийн ЦГ 85%, Багануур дүүргийн ЦХ 85%, Хэнтий аймгийн ЦГ 84%, Дорнод аймгийн ЦГ 84%, Ховд аймгийн ЦГ 95%, Өвөрхангай аймгийн ЦГ 82%, Баян-Өлгий аймгийн ЦГ 87%, Баянхонгор аймгийн ЦГ 84%, Увс аймгийн ЦГ 85%, Архангай аймгийн ЦГ 75%, Дархан-Уул аймгийн ЦГ 82.5%, Орхон аймгийн ЦГ 85%, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын СДЦХ 87.5%, Сүхбаатар аймгийн ЦГ 82% тус тус үнэлэгдсэн.

03.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт байгууллага, албан тушаалтан нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэйг хуульчилсан. Мөн 35.4 дэх хэсэгт уг зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлийг тогтоосон бөгөөд зөвлөмж хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.

04.

АНХААРАХ АСУУДАЛ

Алба хаагчдаас авсан асуумж, ярилцлагын дүнгээс дүгнэхэд хүний нөөцийн хомсдол, ажлын ачаалал, ээлжийн зохион байгуулалт оновчгүй, мэргэшүүлэх болон ажлын байранд чиглэсэн сургалт хангалтгүй, сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ сул зэрэг асуудал нийтлэг илэрч байна. Иймд хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, сэтгэл судлалын чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.

05.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагааны стандарт, журам, хяналтын механизмыг цогцоор нь уялдуулан зохион байгуулах;

Зөвлөмжийн хэрэгжилтэд бодит хяналт тавьж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор хамгаалах, улмаар "эрүү шүүлтгүй, хүний эрхийг дээдэлсэн цагдаагийн байгууллага" төлөвших эрх зүйн болон тогтолцооны суурийг бэхжүүлэх.

2.3. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13, 16.14 дэх заалт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд заасан эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийг хангах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагаа нь бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол зохион байгуулан хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д зааснаар хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан, тухайн этгээд өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч явах боломжгүй бүх газар эрүү шүүлт, зүй бус харьцаа үүсэх эрсдэлийг тогтолцооны түвшинд илрүүлэх, урьдчилан сэргийлэх нь ЭШУС-ын үндсэн чиг үүрэгт хамаарна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь шүүхийн шийдвэрийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй, иргэдийн эрх чөлөө бодитоор хязгаарлагдан байрлаж, эмчлүүлдэг нэгжүүдтэй.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг дараах агуулгын хүрээнд хэрэгжүүлэв. Үүнд:

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд хүч хэрэглэх, зүй бус харьцаа, хайхрамжгүй хандах нөхцөл үүсэх эрсдэл байгаа эсэх;
- Сэтгэцийн эмгэгтэй, эрх чөлөө хязгаарлагдсан иргэдийн хүний эрхийн баталгаа, аюулгүй, хүнлэг орчинд эмчлүүлэх нөхцөл хангагдаж буй байдал;
- Хүний эрхийн зөрчил, хүч хэрэглэх, зүй бус харьцаа, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлийг тухай бүр илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, харьяаллын дагуу шилжүүлэх тогтолцоо бодитоор хэрэгжиж байгаа эсэх;
- Өмнөх жилүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт бодит нөхцөлд үзүүлсэн нөлөөлөл, эрсдэлийг бууруулах үр дүнг үнэлэх.

Сэтгэцийн эмгэг судлалын төрөлжсөн мэргэшлийн дөрвөн клиник, асрамжийн хоёр клиник, яаралтай тусламжийн нэг клиник, сүрьеэгийн хэвтүүлэн эмчлэх тасагт урт болон богино хугацаагаар 530 орчим хүнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх хүртээмжтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс F00-F99 ангиллын оноштой 244 хүн, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн хүнд шүүхийн шийтгэх тогтоолоор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 33 хүнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тус тус үзүүлж байна.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад, түүнчлэн өмнөх жилүүдэд илэрсэн хүний эрхийн эрсдэл, нөхцөл байдлыг харгалзан тус байгууллагын удирдлагад 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/51 дугаартай хоёр удаагийн зөвлөмж хүргүүлсэн.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй, иргэдийн эрх чөлөө бодитоор хязгаарлагдсан орчинд эрүү шүүлт, зүй бус харьцаа, хайхрамжгүй хандах нөхцөл үүсэх эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэв. Хяналт шинжилгээний явцад цуглуулсан баримт, байгууллагын баримтжуулалт, газар дээрх нөхцөл байдал болон өмнөх жилүүдийн зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээлэлд тулгуурлан хүний эрхийн эрсдэлийн түвшнийг дараах чиглэлүүдээр үнэлэв.

2.1. Хүч хэрэглэсэн, зүй бус харьцаа гарах нөхцөл бүрдсэн байдал

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад цуглуулсан баримт, камерын бичлэг, газар дээрх нөхцөл байдлыг үндэслэн албадан эмчилгээ хэрэгжиж буй орчинд хүч хэрэглэсэн, зүй бус харьцааны шинжтэй үйлдэл гаргахгүй байх орчин, нөхцөл бүрдсэн эсэхийг тогтоов.

Хүснэгт 21

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал | Холбогдох хүний эрхийн асуудал |
|-------------------------------------|--|---|
| Бие махбодод халдсан шинжтэй үйлдэл | Камерын бичлэгт эмнэлгийн ажилтан болон харуул хамгаалалтын чиг үүрэг бүхий албан хаагчид албадан эмчлүүлж буй иргэнийг барьж тогтоох, түлхэх, хүчээр хөдөлгөөнийг хязгаарласан байж болзошгүй дүрс бичлэг үлдсэн. | Хүнлэг бус, зүй бус харьцаанаас ангид байх эрхийг хангахтай холбоотой хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |
| Хайхрамжгүй хандах шинжтэй нөхцөл | Эмчлүүлэгчид шаардлагатай тусламж, дэмжлэгийг цаг тухайд нь үзүүлэхгүй удаашруулах, хяналт сул орхих, эрсдэлтэй нөхцөлд ганцааранг нь үлдээхтэй нийцэх нөхцөл байдал ажиглагдсан. | Эрх чөлөө хязгаарлагдсан этгээдэд аюулгүй, хүнлэг орчинд байх эрхийг хангах зохицуулалтын хэрэгжилт |
| Дотоод хяналтын зохион байгуулалт | Зүй бус харьцааны шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг даруй бүртгэх, баримтжуулах, удирдлагын түвшинд үнэлэх ажиллагаа тогтмол, нэг мөр хэрэгждэггүй шинж ажиглагдсан. | Зүй бус харьцааг илрүүлэх, бүртгэх, үнэлэх дотоод хяналтын зохицуулалтын хэрэгжилт |
| Хараат бус шалгалтын нөхцөл | Гомдол, мэдээллийг хараат бусаар шалгах дотоод журам, практик бүрэн төлөвшөөгүй, шалгалтын үе шат, хариуцагч, хугацааны нэг мөр ойлголт тодорхой бус байна. | Гомдол, мэдээллийг хараат бусаар шалгах хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |

2.2. Камерын хяналт, баримтжуулалтын тогтолцооны нөхцөл байдал

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад камерын байршил, бичлэгийн чанар, хадгалалт, ашиглалт болон удирдлагын түвшний зохион байгуулалтын баримтад тулгуурлан камерын хяналтын хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэв.

Хүснэгт 22

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал |
|---------------------------|---|
| Камерын харагдах хүрээ | Зарим клиник, тасагт камерын харагдах өнцөг нь өрөө, коридорын бүх хэсгийг хамарч чадахгүй, эмчлүүлэгч-ажилтны харилцаа бүрэн тусгагдахгүй байна. |
| Бичлэгийн чанар | Зарим камерт бичлэгийн нягтаршил хангалтгүй, хөдөлгөөнийг тодорхой ялган харах боломж хязгаарлагдмал байна. |
| Бичлэг хадгалалт | Камерын бичлэгийг тогтмол хугацаанд тасралтгүй хадгалах, архивлах ажиллагаа нэгжүүдийн түвшинд жигд бус хэрэгжиж байна. |
| Ашиглалтын зохицуулалт | Камерын бичлэгийг шалгах, ашиглах, шилжүүлэхтэй холбоотой дотоод журам, стандарт тодорхой бус, мөрдөх зааварчилгаа нэг мөр биш байна. |
| Удирдлагын түвшний хяналт | Камерын хяналтаар илэрсэн нөхцөл байдалд удирдлагын түвшинд тогтмол үнэлгээ хийж, арга хэмжээ авах уялдаа хангалтгүй байна. |

2.3. Гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах дотоод механизмын нөхцөл байдал

Хяналт шинжилгээний явцад гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шалгах, харьяаллын дагуу шилжүүлэх, шийдвэрлэлтийг баримтжуулахтай холбоотой зохион байгуулалтын баримтад тулгуурлан дотоод механизмын хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэв.

Хүснэгт 23

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал | Холбогдох хүний эрхийн асуудал |
|-----------------------------|--|---|
| Гомдол, мэдээллийн бүртгэл | Эмчлүүлэгч, асруулагч болон албан хаагчаас ирсэн гомдол, мэдээллийг нэгтгэн ангилж, дүн шинжилгээ хийх тусгай бүртгэлийн тогтолцоо жигд төлөвшөөгүй байна. | Гомдол, мэдээллийг бүртгэх, ангилах хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |
| Шалгалтын зохион байгуулалт | Гомдол, мэдээллийг шалгах хугацаа, хариуцсан нэгж, аргачлалыг тодорхойлсон дотоод зохицуулалт тодорхой бус, хэрэгжилт тогтмол биш байна. | Гомдол, мэдээллийг шалгах хугацаа, журмын зохицуулалтын хэрэгжилт |

| | | |
|------------------------------|---|---|
| Харьяаллын дагуу шилжүүлэх | Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байж болзошгүй гомдол, мэдээллийг харьяаллын байгууллагад шуурхай шилжүүлэх практик жигд бус байна. | Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй мэдээллийг шилжүүлэх зохицуулалтын хэрэгжилт |
| Шийдвэрлэлтийн баримтжуулалт | Шийдвэрлэлтийн явц, авсан арга хэмжээг баримтжуулах, архивлах ажиллагаа нэг мөр биш, зарим тохиолдолд нотлох баримтын бүрдэл дутуу байна. | Шийдвэрлэлтийн явцыг баримтжуулах, архивлах зохицуулалтын хэрэгжилт |
| Дарамтаас хамгаалах баталгаа | Гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд дарамт, сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх баталгаа, зохион байгуулалтын механизм бүрэн төлөвшөөгүй байна. | Гомдол гаргасан этгээдийг дарамтаас хамгаалах хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |

2.4. Эмнэлгийн ажилтны аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл

Хяналт шинжилгээний явцад эмнэлгийн ажилтны аюулгүй ажиллагаа, ажлын орчны хамгаалалт, ээлжийн зохион байгуулалт, сэтгэл зүйн ачаалалтай холбоотой баримт мэдээлэлд тулгуурлан хөдөлмөрийн нөхцөлийн хэрэгжилтийн түвшнийг үнэлэв.

Хүснэгт 24

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал | Холбогдох хүний эрхийн асуудал |
|-------------------------------------|--|--|
| Ажлын байрны аюулгүй байдал | Эмчлүүлэгчийн зүй бус үйлдэл гарах эрсдэлтэй нөхцөлд ажилтныг хамгаалах орчны зохион байгуулалт, техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ хангалтгүй байна. | Аюулгүй орчинд ажиллах хөдөлмөрийн эрхийг хангах зохицуулалтын хэрэгжилт |
| Бие махбодын халдлагад өртөх боломж | Эмчлүүлэгчийн зүгээс халдлага үйлдэх боломжит нөхцөлд ажилтнууд үүрэг гүйцэтгэж байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. | Ажилтныг хүчирхийллээс хамгаалах хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |
| Сэтгэл зүйн ачаалал | Өндөр ачаалал, стрессийг бууруулах дэмжлэг, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжих үйлчилгээ тогтмол зохион байгуулагдахгүй байна. | Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцөлийг хангах зохицуулалтын хэрэгжилт |
| Ээлжийн зохион байгуулалт | Шөнийн ээлжид хамгаалалт, дэмжлэг, хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй нөхцөл давтамжтай үүсэж байна. | Ажлын ачааллыг зохистой хуваарилах зохицуулалтын хэрэгжилт |
| Дотоод зохицуулалт | Ажилтны аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлийг эрсдэлээр үнэлж бууруулах дотоод журам, практик бүрэн төлөвшөөгүй байна. | Ажилтны аюулгүй байдлын дотоод зохицуулалтын хэрэгжилт |

2.5. Хүний нөөц, чадавх, сургалтын тогтолцоотой холбоотой нөхцөл байдал

Хяналт шинжилгээний явцад хүний нөөцийн бүрдүүлэлт, албан хаагчдын мэргэжлийн чадавх, хүний эрх, ёс зүй, зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтын төлөвлөлт, хэрэгжилтийн баримтад тулгуурлан үнэлгээ хийв.

Хүснэгт 25

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал | Холбогдох хүний эрхийн асуудал |
|----------------------------------|--|---|
| Хүний нөөцийн хүрэлцээ | Зарим клиник, тасагт албан хаагчийн тоо, бүтэц нь бодит ачаалалтай харьцуулахад хүрэлцэхгүй, сул орон тоо удаан хугацаанд нөхөгдөхгүй байна. | Эрх чөлөө хязгаарлагдсан этгээдэд зохих тусламж үзүүлэх зохицуулалтын хэрэгжилт |
| Албан хаагчдын мэргэжлийн чадавх | Эмчлүүлэгчтэй харилцах, хямралт нөхцөлийг хүч хэрэглэлгүйгээр зохицуулах ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлага тогтмол зохион байгуулагдахгүй байна. | Зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чадавхыг хангах зохицуулалтын хэрэгжилт |
| Хүний эрх, ёс зүйн сургалт | Хүний эрх, мэргэжлийн ёс зүй, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт системтэй, үнэлгээтэй хэрэгжихгүй байна. | Хүний нэр төрийг хүндэтгэх баталгааны хэрэгжилт |
| Сургалтын төлөвлөлт | Сургалтын хэрэгцээг үнэлэх, жилийн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. | Хүний эрх, ёс зүйн сургалтыг хэрэгжүүлэх хуульд заасан зохицуулалтын хэрэгжилт |
| Сургалтын үр нөлөө | Сургалтын үр дүн практикт хэрэгжиж байгаа эсэхэд дүн шинжилгээ, хяналт тогтмол хийгдэхгүй байна. | Сургалтыг төлөвлөх, хэрэгжилтийг хянах зохицуулалтын хэрэгжилт |

2.6. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хууль зүйн баталгааны хэрэгжилттэй холбоотой нөхцөл байдал

Хяналт шинжилгээний явцад шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, түүнтэй холбоотой баримтжуулалт, мөн эмчлүүлэгчийн мэдээлэл авах, тайлбар шаардах, гомдол гаргах боломж бодит нөхцөлд хэрхэн хангагдаж буйд үнэлгээ хийв.

Хүснэгт 26

| Асуудлын төрөл | Тогтоогдсон нөхцөл байдал | Холбогдох хүний эрхийн асуудал |
|-----------------------------|--|--|
| Шүүхийн шийдвэрийн мэдээлэл | Шүүхийн шийдвэрийн агуулга, хэрэгжих хугацаа, сунгах үндэслэлийн талаарх мэдээллийг эмчлүүлэгчид ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн эсэхийг нотлох баримтжуулалт нэгжүүдийн түвшинд жигд бүрдээгүй байна. | Шүүхийн шийдвэрийн талаарх мэдээлэл авах эрхийг хангах зохицуулалтын хэрэгжилт |

| | | |
|--|--|---|
| Давтан хянан үзэх зохион байгуулалт | Албадлагын арга хэмжээг хуульд заасан хугацаанд давтан хянан үзсэн эсэхтэй холбоотой бүртгэл, хяналтын зохион байгуулалт тогтмол хэрэгжихгүй байна. | Эрх чөлөөг хуульд заасан хугацаанд хязгаарлах зохицуулалтын хэрэгжилт |
| Дуусгавар болгохтой холбоотой баримтжуулалт | Албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх эсхүл дуусгавар болгох тухай шийдвэрийн хэрэгжилтийг баримтжуулах ажиллагаа жигд биш, нотлох баримтын бүрдэл дутмаг тохиолдол байна. | Албадлагын арга хэмжээг үндэслэлгүй үргэлжлүүлэхээс сэргийлэх зохицуулалтын хэрэгжилт |
| Мэдээлэл авах, тайлбар хүсэх, гомдол гаргах боломж | Эмчлүүлэгч өөрийн эрх зүйн байдлын талаар мэдээлэл авах, тайлбар шаардах, гомдол гаргах боломж бодит нөхцөлд хэрхэн хангагдаж буй нь баримтжуулалтаар хангалттай нотлогдохгүй байна. | Өөрийн эрх зүйн байдлын талаар мэдээлэл авах эрхийг хангах зохицуулалтын хэрэгжилт |
| Дотоод хяналтын уялдаа | Албадлагын арга хэмжээний явц, үр дүнг удирдлагын түвшинд тогтмол хянах, дүн шинжилгээ хийх зохион байгуулалтын уялдаа сул байна. | Албадлагын арга хэмжээний дотоод хяналтын зохицуулалтын хэрэгжилт |

ГУРАВ. ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ ЗӨРЧИГ ДӨЖ БОЛЗОШГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд хүч хэрэглэсэн, зүй бус харьцаа, үл хайхрах шинжтэй үйлдэл бодитоор илэрсэн, мөн ийм төрлийн үйлдэл давтагдах, нуугдах, зохих журмын дагуу бүртгэгдэж, хариу арга хэмжээ авч чадаагүйгээр үлдэх эрсдэл бүхий нөхцөл байдал бүрдсэн нь баримтаар тогтоогдлоо.

Эдгээр нөхцөл байдал нь тухайн орчинд хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлийг нэг удаагийн, санамсаргүй шинжтэй бус, харин дотоод хяналт, хариу арга хэмжээний тогтолцооны сулралтай холбоотой болохыг харуулж байна.

3.1. Камерын бичлэгээр бодитоор илэрсэн нөхцөл байдал

Хүснэгт 27

| Тохиолдлын төрөл | Бодитоор илэрсэн нөхцөл байдал | Баримтын эх сурвалж |
|---|--|----------------------------|
| Хүч хэрэглэсэн үйлдэл | Эмчлүүлэгчийг барьж тогтоох, түлхэх, хүчээр хөдөлгөөн хязгаарлах шинжтэй үйлдэл тодорхой хугацаанд тасралтгүй бичигдсэн нь камерын бичлэгээр тогтоогдсон | Камерын бичлэг |
| Тусламж, хяналт хангалтгүй хэрэгжсэн байдал | Эмчлүүлэгчийг тодорхой хугацаанд хяналтгүй орхисон, шаардлагатай тусламж үзүүлэхийг удаашруулсан нөхцөл байдал бичлэгт үлдсэн | Камерын бичлэг |

| | | |
|----------------------------|--|----------------|
| Харилцааны зохисгүй хэлбэр | Эмчлүүлэгчид хандсан доромжлох өнгө аяс бүхий үг хэллэг, зохисгүй харилцаа бичигдсэн | Камерын бичлэг |
| Орчны зохион байгуулалт | Зарим тасгийн зохион байгуулалтаас үүдэн камерын хяналтгүй бүсүүд тогтоогдсон | Камерын бичлэг |

3.2. Гомдол, мэдээллээр бодитоор илэрсэн нөхцөл байдал

Хүснэгт 28

| Тохиолдлын төрөл | Бодитоор илэрсэн нөхцөл байдал | Баримтын эх сурвалж |
|-------------------------|---|---------------------------|
| Эмчлүүлэгчийн гомдол | Эмнэлгийн ажилтны зүгээс зохисгүй харьцсан, бие махбодын хүч хэрэглэсэн байж болзошгүй талаар эмчлүүлэгчээс гомдол ирүүлсэн тохиолдол бүртгэгдсэн | Гомдлын бүртгэл |
| Асруулагчийн мэдээлэл | Асруулагчийн зүгээс эмчлүүлэгчид үзүүлж буй харьцаа, орчны нөхцөлтэй холбоотой асуудлыг мэдээлсэн тохиолдол бүртгэгдсэн | Бичгээр ирүүлсэн мэдээлэл |
| Албан хаагчийн мэдээлэл | Албан хаагч хамт ажиллагсдын зүй бус үйлдэл, зохион байгуулалтын доголдлын талаар мэдээлэл өгсөн тохиолдол бүртгэгдсэн | Албан хаагчийн тайлбар |
| Давтан гомдол | Нэг асуудлаар давтан гомдол, мэдээлэл ирүүлсэн байдал тогтоогдсон | Гомдлын бүртгэл |
| Нууцлалтай мэдээлэл | Нууцлал хүссэн нөхцөлд гомдол, мэдээлэл ирүүлсэн тохиолдол бүртгэгдсэн | Бүртгэлийн тэмдэглэл |

3.3. Ярилцлага, газар дээр нь хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

Хүснэгт 29

| Тохиолдлын төрөл | Баримтаар тогтоогдсон үйл баримт | Баримтын эх сурвалж |
|--------------------------------|---|---|
| Эмчлүүлэгчтэй хийсэн ярилцлага | Эмчлүүлэгч тодорхой хугацаанд өрөөнөөс гарах боломжгүй байлгасан, хяналтгүй орчинд удаан хугацаагаар үлдээсэн талаар мэдээлсэн нь тухайн үеийн орчны зохион байгуулалттай тулган шалгахад нийцсэн | Ярилцлагын тэмдэглэл |
| Асруулагчтай хийсэн ярилцлага | Асруулагч эмчлүүлэгчийн биед гэмтэл үүссэн талаар мэдээлсэн ба уг мэдээлэл нь эмнэлгийн үзлэгийн тэмдэглэлтэй цаг хугацааны хувьд давхцаж байгаа нь тогтоогдсон | Ярилцлагын тэмдэглэл, эмнэлгийн бүртгэл |
| Ажилтантай хийсэн ярилцлага | Ээлжийн үед хүний нөөц хүрэлцээгүйгээс нэг ажилтан олон эмчлүүлэгчид хяналт тавьдаг талаар мэдээлсэн нь ээлжийн хуваарьтай тулган шалгахад баталгаажсан | Ярилцлагын тэмдэглэл, ээлжийн хуваарь |

| | | |
|------------------------------|--|---|
| Газар дээрх хяналт шинжилгээ | Тасгийн өрөө, коридорын зохион байгуулалт нь эмчлүүлэгчийг хараа хяналтгүй үлдээх боломж бүрдүүлж байгааг бодитоор тогтоосон | Газар дээрх тэмдэглэл |
| Орчны аюулгүй байдал | Зарим хэсэгт камерын харагдах хүрээ дутмаг байгааг газар дээр шалгаж, камерын байршилтай тулган баталгаажуулсан | Газар дээрх тэмдэглэл, камерын зураглал |

ДӨРӨВ. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ, АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад, түүнчлэн өмнөх жилүүдэд илэрсэн хүний эрхийн эрсдэл, нөхцөл байдлыг харгалзан тус байгууллагын удирдлагад 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/51 дугаартай нийт хоёр удаагийн зөвлөмж хүргүүлсэн.



Эдгээр зөвлөмж нь гарсан цаг хугацаа, эрсдэлийн нөхцөлөөрөө ялгаатай боловч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, хариу арга хэмжээний тогтолцоог сайжруулах зорилгод чиглэсэн нийтлэг агуулгатай байна.



4.1. 08/01 дугаартай зөвлөмжийн үндсэн агуулга

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01 дугаартай зөвлөмжөөр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд хүний эрхийн дараах эрсдэлүүдийг хөндөн, урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээ авахыг чиглэл болгосон. Үүнд:

- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шинжтэй үйлдэл үүсэх эрсдэл;
- камерын хяналт, бичлэгийн баримтжуулалт, ашиглалт хангалтгүй хэрэгжиж байгаа байдал;

- гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах дотоод механизм тогтвортой, ил тод хэрэгжихгүй байгаатай холбоотой хүндрэл;
- харуул хамгаалалтын болон эмнэлгийн ажилтны харилцаа, хүч хэрэглэхтэй холбоотой дотоод зохицуулалтын тодорхой бус байдал;
- хүний нөөц, сургалт, мэргэжлийн чадавхын дутагдлаас үүдэлтэй давтамжтай илэрч буй эрсдэл.

4.2. 08/51 дугаартай зөвлөмжийн үндсэн агуулга

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/51 дугаартай зөвлөмж нь камерын хяналтаар бие махбодын зүй бус харьцааны шинжтэй үйлдэл бодитоор илэрсэн онцгой нөхцөлд үндэслэн гарсан бөгөөд дараах асуудлыг онцолсон. Үүнд:

зүй бус харьцаа илэрсэн тохиолдлыг шуурхай бүртгэх, баримтжуулах, үнэлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

холбогдох албан хаагчдад хариуцлага тооцох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх;

удирдлагын түвшний дотоод хяналт, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх;

албадан эмчилгээ, хүч хэрэглэхтэй холбоотой дотоод заавар, бодит практикийн зөрүүг арилгах.

4.3. Зөвлөмжийн дагуу байгууллагаас авсан арга хэмжээ

СЭМҮТ-ийн удирдлагаас ирүүлсэн тайлан, мэдээлэлд дурдсанаар зөвлөмжийн хүрээнд дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- камерын хяналтаар илэрсэн зүй бус харьцааны шинжтэй үйлдэлтэй холбогдуулан холбогдох албан хаагчдын үйл ажиллагаанд дотоод шалгалт явуулж, зарим албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан;
- харуул хамгаалалтын чиг үүрэг, эмчлүүлэгчтэй харьцахтай холбоотой дотоод заавар, чиглэлийг тодруулж, удирдлагын түвшинд анхаарал хандуулсан;
- камерын хяналтын ашиглалт, хадгалалт, шалгалтад удирдлагын хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр үүрэг өгсөн;
- гомдол, мэдээлэл хүлээн авах сувгийг тодорхой болгож, удирдлагын түвшинд танилцуулах, шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

4.4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн газар дээрх дахин үнэлгээ



08/51 дугаартай зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайланг СЭМҮТ-ээс 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/1176 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд уг тайлан, хавсаргасан мэдээлэлд үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр газар дээр нь дахин үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийн бодит байдалтай танилцсан.

Дахин үнэлгээгээр дараах арга хэмжээнүүд бодитоор хэрэгжиж эхэлсэн нь тогтоогдлоо. Үүнд:

- захирлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/395 дугаар тушаалаар “Дотоод хяналтын ажилтан”-ыг үндсэн орон тоонд томилж, дотоод хяналтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хэрэгжүүлэх зохион байгуулалтын суурь бүрдүүлсэн;
- камерын хяналтын байршил, харагдах орчинд дүн шинжилгээ хийж, доголдсон камеруудыг засварлаж, шинээр камер суурилуулан төв серверт холбосон;
- камерын бичлэгийг тогтмол шалгах, зүй бус харьцаа илэрсэн тохиолдолд шуурхай баримтжуулах, удирдлагад танилцуулах, дотоод үнэлгээ хийх зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлсэн;
- гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор дотоод заавар, чиглэл өгч, хэрэгжилтийг эхлүүлсэн;
- албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг сайжруулах хүрээнд ХАБЭА хариуцсан мэргэжилтнийг үндсэн орон тоонд томилсон.

4.5. Зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн нэгдсэн үнэлгээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон газар дээр нь хийсэн дахин үнэлгээний дүнгээс үзэхэд СЭМҮТ-ээс тодорхой зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлсэн нь эерэг мөн өөрчлөлт боловч:

- авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь ихэвчлэн тодорхой тохиолдолд хариу өгсөн шинжтэй, урьдчилан сэргийлэх тогтолцооны түвшинд бүрэн төлөвшөөгүй;
- зүй бус харьцааг давтамжтайгаар илрүүлэх, таслан зогсоох системчилсэн зохион байгуулалт бүрэн бүрдээгүй;



- камерын хяналтаар илэрсэн эрсдэлд удирдлагын түвшинд тогтмол дүн шинжилгээ хийх, сургалт, хяналтын давтамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ хэвээр;
- гомдол, мэдээлэл шалгах механизмын ил тод байдал, хараат бус байдлын баталгаа бодит нөхцөлд сул хэвээр байна.

Иймээс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах эрсдэлийг бууруулахад чиглэсэн зөвлөмжийн хэрэгжилтийн бодит байдал тогтолцооны түвшинд, урьдчилан сэргийлэх чиглэлд үргэлжлэн анхаарах шаардлагатай хэвээр байна гэж үзэв.

ТАВ. ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэж заасан.



Энэхүү хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд хүргүүлсэн 08/01, 08/51 дугаартай зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, камерын хяналтаар илэрсэн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шинжтэй байж болзошгүй үйлдлүүдтэй холбогдуулан хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагаас уг саналыг хэлэлцэж, дотоод шалгалт явуулсны үндсэн дээр сахилгын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч Л.Б-д албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, ахлах сувилагч Г.О-д хурлын протоколоор сануулах арга хэмжээ авсан байна. Мөн туслах сувилагч Ц.П-д гурван сарын хугацаанд, Г.Г-д хоёр сарын хугацаанд тус тус үндсэн цалинг 20 хувиар бууруулах шийдвэр гаргасан бөгөөд сувилагч О.Т, Л.Я, Э.О болон туслах сувилагч Д.Б нарт албан тушаалд сануулах сахилгын арга хэмжээ авсан байна.



Дээрх сахилгын арга хэмжээг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар баталж, хэрэгжилтийг ханган ажилласан нь тухайн байгууллагын түвшинд зүй бус харьцаанд хариу арга хэмжээ авах, хариуцлага тооцох зохицуулалт бодитоор хэрэгжиж эхэлснийг харуулж байна.

Гэсэн хэдий ч авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тодорхой илэрсэн тохиолдолд хариу өгсөн шинжтэй байгаа бөгөөд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах үйлдэл үүсэх суурь нөхцөл, шалтгааныг тогтолцооны түвшинд арилгах, урьдчилан сэргийлэх зохион байгуулалт, хяналтын тогтолцоог тогтвортой бүрдүүлэх асуудалд цаашид онцгойлон анхаарах шаардлагатай.

ЗУРГАА. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД

6.1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал В.Баярмаад хүргүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/02 дугаартай зөвлөмжөөс.

1.Тогтоогдсон нөхцөл байдал:

- “Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадан эмчилгээ хийлгэж байгаа эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны эмчлүүлэгчид болон сэтгэц эмгэг судлалын шинжилгээ хийлгэж байгаа хүнийг нэг дор, нэг жигүүрт, тусгаарлах хаалгагүй тасалгаанд байрлуулан, албадан эмчилж байгаа нь сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчид, эмч, эмнэлгийн ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн.”
- “Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт харуул хамгаалалтын албан үүрэг гүйцэтгэж байсан хамгаалалтын ажилтан ахлагч О.Б нь 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 08 цагийн орчим албадан эмчлүүлэгч Г.О-г тавьсан шаардлагыг биелүүлсэнгүй гэх шалтгаанаар алгадаж зүүн шанаа орчимд улайлт, баруун нүдэнд хөхрөлт үүсгэн гэмтэл учруулсан нь ... баримтаар тогтоогдсон.”
- “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчийн шүүхийн тогтоолд тусгагдсан хугацаа дуусгавар болсон эсхүл ... энэхүү арга хэмжээг зогсоосон тохиолдолд ... Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникт албадан эмчилгээг үргэлжлүүлэн хийж байгаа нь ... зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа нь тогтоогдлоо.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- “Ажил үүргээ гүйцэтгэх явцад эмч, эмнэлгийн ажилтнууд болон албадан эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан эсхүл хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх нь зөрчигдөж болзошгүй тохиолдол бүрийг эмнэлэг, үйлчилгээний зөрчлийн бүртгэл хяналтаар баримтжуулах;”
- “Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг эмч, эмнэлгийн ажилтнуудад олгох сургалтыг зохион байгуулах;”
- “Харуул хамгаалалтын алба хаагч, Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн ажилтнуудын хувцас солих өрөөг тусгаарлах.”

6.2. Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хүргүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/05 дугаартай зөвлөмжөөс.

1.Тогтоогдсон нөхцөл байдал:

- “2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг ял, албадлагын арга хэмжээ гэж тодорхойлон албадлагын арга хэмжээний төрөлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хуульчилж гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд тухайн хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахаар бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ гэж заасан.”
- “Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.’ гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд, захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй нөхцөл байдал хяналт шинжилгээний явцад тогтоогдлоо.”
- “Энэхүү эрх зүйн зохицуулалтын хүрээнд яллагдагчийг Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчидтэй хамт эмчийн хяналтад байлгаж, дүгнэлт гаргасан тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны Дугаар А-240/А-369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам’-д энэхүү агуулга тусгагдаагүй байна.”
- “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчийн шүүхийн тогтоолд тусгагдсан хугацаа дуусгавар болсон эсхүл ... энэхүү арга хэмжээг зогсоосон тохиолдолд гэр бүлийн гишүүн, төрөл, садан, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй эсхүл тэдгээр нь хүлээн авахаас татгалзсаны улмаас Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникт

албадан эмчилгээг үргэлжлүүлэн хийж байгаа нь ... журмын 4.8-д заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа нь тогтоогдлоо.”

- “Энэ нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан эмчлүүлэгчид шүүхийн тогтоолгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэглэж, тухайн эмчлүүлэгчид бүх насаар нь албадан эмчилгээ хийх нөхцөл байдал үүссэн байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад ... заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байна.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх зохицуулалтыг ялгамжтай хэрэглэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;”
- “Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тодорхой тусгах асуудлыг судлах, шийдвэрлүүлэх;”
- “Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар А-240/А-369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам’-ыг шинэчлэн, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангуулах;”

6.3. Хууль зүй, дотоод хэргийн сайдад Х.Нямбаатарт хүргүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/07 дугаартай зөвлөмжөөс.

1.Тогтоогдсон нөхцөл байдал:

- “2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг ял, албадлагын арга хэмжээ гэж тодорхойлон албадлагын арга хэмжээний төрөлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хуульчилж гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд тухайн хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахаар бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ гэж заажээ.”
- “Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.’ гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд, захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй нөхцөл байдал хяналт шинжилгээний явцад тогтоогдлоо.”
- “Энэхүү эрх зүйн зохицуулалтын хүрээнд яллагдагчийг Сэтгэцийн эрүүл

мэндийн Үндэсний төвийн Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчидтэй хамт эмчийн хяналтад байлгаж, дүгнэлт гаргасан тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны Дугаар А-240/А-369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-д энэхүү агуулга тусгагдаагүй байна.”

- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчжээ.”
- “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчийн шүүхийн тогтоолд тусгагдсан хугацаа дуусгавар болсон эсхүл ... энэхүү арга хэмжээг зогсоосон тохиолдолд гэр бүлийн гишүүн, төрөл, садан, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй эсхүл тэдгээр нь хүлээн авахаас татгалзсаны улмаас Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникт албадан эмчилгээг үргэлжлүүлэн хийж байгаа нь ... журмын 4.8-д заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байгаа нь тогтоогдлоо.”
- “Энэ нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан эмчлүүлэгчид шүүхийн тогтоолгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэглэж, тухайн эмчлүүлэгчид бүх насаар нь албадан эмчилгээ хийх нөхцөл байдал үүссэн байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байна.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тодорхой тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;”
- “Сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргахад яллагдагчийг тодорхой хугацаанд эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байлгаж, ажиглалт хийх шаардлагатай тохиолдолд шүүх нь шинжээчийн саналыг үндэслэн яллагдагчийг эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байлгах агуулгыг захиргааны хэм хэмжээний актад тусгах;”
- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх зохицуулалтыг ялгамжтай хэрэглэх зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах;”
- “Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар А-240/А-369 хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангуулах;”

6.4. Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт хүргүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 08/01 дугаартай зөвлөмжөөс.

1. Тогтоогдсон нөхцөл байдал:

- “Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А-240/А-369 дүгээр хамтарсан тушаалаар баталсан ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам’-ын 5.1-д ‘Хамгаалалтын нэг ээлжид 2-оос доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна’ гэснийг зөрчин нэг хамгаалалтын алба хаагч үүрэг гүйцэтгэж байснаас дээр дурдсан Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу ирүүлэх хуульд заасан хугацааны дотор буюу 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлэгч Ө.Х усанд орох өрөөний дулааны шугамаас боомилсон байдалтай нас барсан тохиолдол гарсан.”
- “Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 08/08 дугаартай Зөвлөмжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаад хүргүүлж, уг Зөвлөмжид ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам’-ын 5.1-д заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт нэг ээлжид 2 алба хаагчийг ажиллуулах болон холбогдох бусад асуудлыг тусгасан.”
- “Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн албан бичигт Баривчлах төвөөс 3 алба хаагчийг шилжүүлэн нийт 6 хамгаалалтын ажилтныг зохих хуваариар ажиллуулан журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байгааг мэдэгдсэн байна.”
- “Гэвч Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Асрамжийн нэгдүгээр клиникт 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан албадан эмчлүүлэгч П.Б өөрийгөө боомилон нас барсан харамсалтай тохиолдол дахин гарсан нь тус төвийн удирдлагын дотоод ажлын зохион байгуулалт хангалтгүй байгааг илэрхийлж байна.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд албадан эмчлүүлэгчдийн хүний эрхийг хангах, болзошгүй эрсдэл, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.”

6.5. Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт хүргүүлсэн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 08/07 дугаартай зөвлөмжөөс.

1. Тогтоогдсон нөхцөл байдал:

- “Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.’ гэж заасан боловч ... эмнэлгийн

чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь ... шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй байна.”

- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, ... шүүх уг арга хэмжээг зогсоосон ч ... асран хамгаалагчгүй ... албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй нөхцөл байдал хэвээр.”
- “Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А-240/А-369 хамтарсан тушаалаар баталсан ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих’ журмын 4.8-д ... заалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна.”
- “Өөрөөр хэлбэл асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй байгаа асуудал шийдвэрлэгдээгүй.”
- “Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн албадан эмчлүүлэгчдийн батлагдсан орны тоо 37 байхаас нийт 43 хүн албадан эмчилгээнд байна.”
- “Хууль зүй дотоод хэргийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам’-ын 5.4.5 дахь хэсэг ... гэсний дагуу ... 24 цагаар төмөр гав хэрэглэж байгаа эмчлүүлэгчдийг хүний эрх эрүүл мэндэд ээлтэй байдлаар өөрчлөх буюу хүнлэг хандах.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- “Албадан эмчилгээ дууссан ч асран хамгаалагчгүй иргэдийг эмнэлэгт байлгасаар байгаа, орны даац хэтэрсэн, тусгай хэрэгслийг удаан хугацаагаар хэрэглэж буй нөхцөл байдлыг тогтоож, эрх зүйн болон зохион байгуулалтын шийдэл гаргах.”

6.6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Г.Анхболдод хүргүүлсэн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01 дугаартай зөвлөмжөөс

1. Тогтоогдсон нөхцөл байдал:

- “Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг ‘Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.’ гэж заасан боловч ... эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь ... шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй байна.”
- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, ... шүүх уг арга хэмжээг зогсоосон ч ... асран хамгаалагчгүй ... албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй нөхцөл байдал хэвээр.”
- “Өөрөөр хэлбэл асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй байгаа асуудал шийдвэрлэгдээгүй.”

2. Зөвлөмжийн холбогдох заалт:

- Холбогдох хууль, журмыг шинэчлэх.
- Асран хамгаалагчийн зохицуулалтыг шийдвэрлэх.
- Хяналт, бүртгэлийг сайжруулах.

6.7. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Ууганцэцэгт хүргүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/51 дугаартай зөвлөмжөөс

1.Тогтоогдсон нөхцөл байдал:

- “Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт 24 цагаар төмөр гав хэрэглэж байгаа эмчлүүлэгчдийг хүний эрх, эрүүл мэндэд ээлтэй байдлаар шийдвэрлээгүй.”
- “Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн албадан эмчлүүлэгчдийн батлагдсан орны тоо 37 байхаас нийт 43 хүн албадан эмчилгээнд байсан; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд мөрдөгдөж буй 1 хүнд оногдох талбайн хэмжээг 2 м² гэж тогтоосон байдаг бол нийт ерөөний даац хэтэрсэн, зарим ерөөнд 11 хүн байгаа нь стандарт шаардлагыг хангахгүй хэвээр.”
- “Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн этгээдийн сэтгэцийн байдал нь тогтвортой, засрал сайжралын байдалд орсноор цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн шинжээчийн дүгнэлт, хяналтын прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг арга хэмжээг зогсоосон ч хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл эцэг эх, төрөл садан нь асран хамгаалалтдаа авахаас татгалзсаны улмаас албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй нөхцөл байдал хэвээр.”
- “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй асуудал шийдвэрлэгдээгүй.”
- “Албадан эмчлүүлэгчийн эргэлт уулзалтын бүртгэл; ... эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ дууссан эмчлүүлэгчийн бүртгэл; ... албадан эмчилгээ хийлгэж байгаа эмчлүүлэгчийн бүртгэл; ... албадан эмчлүүлэгчдэд тусгай хэрэгсэл хэрэглэсэн бүртгэл ... хөтөлдөггүй.”

2.Хүргүүлсэн зөвлөмжийн заалт:

- Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлж байгаа хүмүүсийн биед халдах, зодох, доромжлох зэрэг хүний эрхийн байж болшгүй зөрчлүүдийг тус үндэсний төвийн зарим эмнэлгийн ажилтан, ШШГЕГ-ын нэр бүхий харуул хамгаалалтын алба хаагч нар үйлдэж байгаа нь камерын бичлэгээр илтэд нотлогдох үндэслэлтэй байх тул харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлсэн. Хүний эрхийн эдгээр ноцтой зөрчлүүд нь захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Ууганцэцэг таныг томилогдсоноос хойш үйлдэгдсэн байгаад онцгой анхаарч, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах

- Эмчлүүлэгчдийн болон эмч, эмнэлгийн ажилчдын эрхийг зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг даруй харьяалан шалгах байгууллагад шилжүүлж, шийдвэрлэлтийг бүртгэж, тайлагнаж хэвших.
- Тусгай хэрэгслийн хэрэглээг хүний эрхэд нийцүүлэх.
- Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, алагчлах болон ялгаварлах байдлыг бүх шатанд арилгахын тулд идэвхтэй, үр нөлөөтэй, бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн СЭМҮТ-д хүргүүлсэн зөвлөмжүүдийг нарийвчлан судалж, илэрсэн зөрчил, дутагдалд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Өмнө нь хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, тайлагнан ирүүлэх.

6.8. 2022-2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн нэгтгэл

Хүснэгт 30

| Он | Хэнд / аль байгууллагад хүргүүлсэн | Огноо, дугаар | Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, албадан эмчилгээтэй холбоотой тогтоогдсон нөхцөл байдал, зөвлөмжийн агуулга |
|------|--------------------------------------|----------------------|--|
| 2022 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | 2022.10.13 №08/02 | Албадан эмчилгээ хийлгэж буй эмчлүүлэгчдийг тусгаарлалт хангалтгүй нөхцөлд байршуулж буй байдал, хүч хэрэглэсэн тохиолдол, шүүхийн тогтоолд заасан хугацаа дууссан ч албадан эмчилгээг үргэлжлүүлсэн нөхцөл байдлыг тогтоож, зөрчлийг баримтжуулах, сургалт зохион байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлсэн |
| 2022 | Эрүүл мэндийн сайд | 2022.10.13 №08/05 | Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт дутмаг, яллагдагчийг албадан эмчлүүлэгчидтэй хамт эмчийн хяналтад байлгасан, шүүхийн тогтоолын хугацаа дууссан ч албадан эмчилгээг үргэлжлүүлсэн нөхцөл байдлыг тогтоож, хууль, журмыг шинэчлэх зөвлөмж хүргүүлсэн |
| 2022 | Хууль зүй, дотоод хэргийн сайд | 2022.10.13 №08/07 | Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын хийдэл, практикт хэрэгжихгүй байдал, шүүхийн шийдвэргүйгээр албадан эмчилгээг үргэлжлүүлж буй нөхцөл байдлыг тогтоож, холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлсэн |

| | | | |
|------|--------------------------------------|----------------------|--|
| 2024 | Эрүүл мэндийн сайд | 2024.01.04 №08/01 | Албадан эмчлүүлэгчдийн хамгаалалт, аюулгүй байдлын зохион байгуулалт хангалтгүй, хамгаалалтын ажилтны тоо журамд нийцээгүй, улмаар албадан эмчлүүлэгч нас барсан тохиолдол гарсан нөхцөл байдлыг тогтоож, хамгаалалтын зохион байгуулалтыг сайжруулах зөвлөмж хүргүүлсэн |
| 2024 | Хууль зүй, дотоод хэргийн сайд | 2024.05.31 №08/07 | Албадан эмчилгээ дууссан ч асран хамгаалагчгүй иргэдийг эмнэлэгт байлгасаар байгаа, орны даац хэтэрсэн, тусгай хэрэгслийг удаан хугацаагаар хэрэглэж буй нөхцөл байдлыг тогтоож, эрх зүйн болон зохион байгуулалтын шийдэл гаргах зөвлөмж хүргүүлсэн |
| 2025 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | 2025.02.07 №08/01 | Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийн зохицуулалт тодорхойгүй хэвээр, асран хамгаалалтын асуудал шийдэгдээгүй, орны даац хэтэрсэн, тусгай хэрэгслийн хэрэглээтэй холбоотой нөхцөл байдал давтан тогтоогдсон |
| 2025 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | 2025.11.28 №08/51 | Албадан эмчлүүлэгчдэд 24 цагаар төмөр гав хэрэглэсэн, орны даац хэтэрсэн, асран хамгаалагчгүй иргэдийг шилжүүлэх зохицуулалтгүй хэвээр, зүй бус харьцаа, хүч хэрэглэсэн үйлдэл камерын бичлэгээр тогтоогдсон нөхцөл байдлыг тусгасан |

6.9. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дүн шинжилгээ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, албадан эмчилгээтэй холбоотой нийт долоон удаагийн зөвлөмжийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна. Эдгээр зөвлөмжөөр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын хийдэл, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, хамгаалалт, хяналтын тогтолцооны доголдол, асран хамгаалалтын зохицуулалтын шийдэгдээгүй асуудлууд баримтаар тогтоогдож, удаа дараа илэрсэн. Тухайлбал, шүүхийн тогтоолд заасан хугацаа дууссан тохиолдолд ч албадан эмчилгээг үргэлжлүүлж буй, асран хамгаалагчгүй иргэдийг шилжүүлэх зохицуулалтгүй хэвээр байгаа, хамгаалалт, аюулгүй байдлын журам бодит нөхцөлд хэрэгжихгүй байгаа байдал нь зөвлөмж бүрд давтан тогтоогдсон. Мөн 2017 оны хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын зохицуулалтууд нь дээрх баримтаар тогтоогдсон нөхцөл байдлаас үзэхэд бодит хэрэгжилтийг хангах боломжгүй хэвээр байгааг харуулж байна.

ДОЛОО. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭНО ДҮН ШИНЖИЛГЭЭ⁴¹

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд холбогдох гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн судалгааг 2022-2025 оны хугацаанд бүртгэгдсэн хэрэг, гомдлын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж үзэхэд дараах нөхцөл байдал ажиглагдлаа.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд холбогдох нийт 24 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд жилээс жилд өсөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2022 онд 4, 2023 онд 3 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 онд 6 болж нэмэгдсэн, харин 2025 онд 11 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онуудтай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн үзүүлэлт юм. Энэ нь тус байгууллагад гарч болзошгүй хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн эрсдэл тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгааг илтгэхээс гадна иргэд, өвчтөн болон тэдний ар гэрээс гомдол, мэдээлэл гаргах нь нэмэгдсэн.

2022 он

Хүснэгт 31

| № | Эрүүгийн хуулийн зүйл хэсэг | Хэргийн утга | Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн/ Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан огноо | Шийдвэрийн төрөл |
|---|-----------------------------------|---|--|---|
| 1 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа иргэн С-ийн биед гэмтэл учруулсан гэх | 2022.09.14 өдөр Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн | 2022.12.05 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 2 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн 3-р тасагт иргэн Ж-д ахлах сувилагч Б-нь шөнийн цагаар чангаагаад, би чамд хайртай гэж үнсэх гэж оролдсон гэх | | 2022.05.18 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |
| 3 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр иргэн Т-г хэвтэн эмчлүүлж байхад эмнэлгийн сувилагч С гэгч зодсон гэх | 2022.04.12 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2022.04.22 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |

⁴¹ Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэнд хандан ирүүлсэн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/6854 тоот албан бичиг.

| | | | | |
|---|-----------------------------------|--|---|---|
| 4 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д 2021 оны 12 сард хэвтэн эмчлүүлж байсан охин М-ийг Д нь хүчиндсэн байж болзошгүй гэх | 2022.04.05 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2022.09.19 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |
|---|-----------------------------------|--|---|---|

2023 он

Хүснэгт 32

| | | | | |
|---|-----------------------------------|--|---|---|
| 1 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр иргэн Г-ийг паартай хүлж гарыг нь түлсэн гэх | 2024.01.18 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2025.01.20 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 2 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн 3-р тасагт иргэн Т-г зодож, шүдийг нь хугалсан гэх | | 2023.06.30 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |
| 3 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | Иргэн Т-гээс 2023 оны 02-р сарын 04-ний өдөр БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн 4-р тасагт иргэн М, 3 нар 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдөр хоолны зааланд маргалдаж нүүрэн тус газарт цохиж, гэмтэл учруулсан гэх | | 2023.03.01 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |

2024 он

Хүснэгт 33

| | | | | |
|---|-----------------------------------|--|---|---|
| 1 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д 2024.07.04-ний өдөр хэвтэн эмчлүүлж байсан иргэн Б-г хамт эмнэлэгт хэвтэж байсан хүндээ хүчиндүүлсэн гэх | | 2024.08.01 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 2 | Эрүүгийн хуулийн тусгай анги 10.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн хүлээн авах дээр 2024.04.11-ний иргэн Б өвчний улмаас нар барсан гэх | 2024.04.30 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2024.06.08 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |

| | | | | |
|---|-----------------------------------|--|---|--|
| 3 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн А 2024.06.18-ны өдөр бусдад хүчиндүүлсэн гэх | 2024.07.06 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2025.05.02 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 4 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн Г нь 2024.04.30-ний өдөр харуул хамгаалалтын ажилтан Т-д зодуулсан гэх | 2024.05.18 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээж, Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан | 2025.10.28 Яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн. |
| 5 | - | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн М 2024.03.08-ны өдөр эмчлүүлж байх хугацаандаа хүний эрхээ ноцтой зөрчүүлсэн гэх | - | 2024.03.28 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |
| 6 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн Н 2024.01.16-ны өдөр бусдад зодуулсан гэх | - | 2024.02.13 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |

2025 он

Хүснэгт 34

| | | | | |
|---|--|---|---|--|
| 1 | Эрүүгийн хуулийн тусгай анги 10.1 | СЭМҮТ-ийн хяналтад байсан БЗД-ийн 31 дүгээр хорооны иргэн М 2025.05.17-ны өдөр нас барсан гэх | - | 2025.05.23 Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан |
| 2 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1, Эрүүгийн хуулийн тусгай анги 17.1 | СЭМҮТ-ийн хяналтад байсан БЗД-ийн 26 дугаар хорооны иргэн Т-гийн гэрт 2025.08.15-20-ний өдрийн хугацаанд үл таних эрэгтэй Т-г бие хамгаалах чадваргүйг далимдуулан архидаг согтуурч, эд зүйлс хулгайлж, бэлгийн харилцаанд орсон байж болзошгүй гэх | 2025.09.05 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2025.11.07 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 3 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн Д-г 2025.09.25-2025.10.17-ны өдрийн хооронд хэвтэн эмчлүүлж байх хугацаанд үл таних хүн хүчиндсэн гэх | - | 2025.11.18 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |

| | | | | |
|----|------------------------------------|---|--|---|
| 4 | Эрүүгийн хуулийн тусгай анги 17.4 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн дэд захирлаар ажиллаж байсан иргэн А нь 18,410,862 төгрөгийн үнэ бүхий мэдээллийн тоног төхөөрөмжийг хувьдаа завшсан гэх | - | 2025.11.19 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 5 | Эрүүгийн хуулийн тусгай анги 11.6 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-д иргэн М-нь 2025.11.07-ны өдөр бусдад зодуулсан | - | ажиллагаанд |
| 6 | Эрүүгийн хуулийн тусгай анги 17.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн үүднээс 2025.05.26-ны өдөр иргэн Б-гийн унадаг дугуй хулгайд алдагдсан гэх | 2025.06.12 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | 2025.09.02 Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан |
| 7 | Эрүүгийн хуулийн тусгай анги 12.1 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ, 2025.03.15-16-нд шилжих шөнө иргэн Е нь бусдад хүчиндүүлж, 4 сартай жирэмсэн болсон гэх | 2025.07.24 өдөр Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн | Ажиллагаанд |
| 8 | Зөрчлийн тухай хуулийн 5.2 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн эв нэгдэл цахим групп дээр 2025.10.28-ний өдөр иргэн О хэл амаар доромжлуулсан гэх | | Ажиллагаанд |
| 9 | Эрүүгийн хуулийн тусгай анги 17.8 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн блокон хашааг 2025.11.09-ний өдөр нураасан гэх | | Ажиллагаанд |
| 10 | Эрүүгийн хуулийн тусгай анги 13.14 | БЗД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СЭМҮТ-ийн захирлын нэр хүндэд цахим орчинд удаа дараа халдсан гэх | | Ажиллагаанд |
| 11 | Эрүүгийн хуулийн тусгай анги 10.4 | СЭМҮТ-ийн туслах сувилагч Б нь тус төвийн клиникийн 3 тасагт хэвтэн эмчлүүлж байсан иргэн О-г ар гэрт нь хүлээлгэн өгөх зорилгоор эмчийн зөвшөөрлөөр авч явах үедээ албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас 2024.03.30-ны өдөр иргэн О осгож нас барсан | 2024.04.18 өдөр Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн | 2025.11.24 Яллах дүгнэлт үйлдсэн |

Статистикт авагдсан дийлэнх тохиолдол нь эмнэлгийн ажилтан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаас өвчтөнд чиглэсэн байх ба гэмт хэргийн төрлийн хувьд хүний эрх, эрх чөлөөнд халдах, эрүүл мэндэд хохирол учруулах, өмчлөх эрхийн эсрэг, бэлгийн эрх, эрх чөлөөнд халдах, хүчиндэх гэмт хэргийн гомдол, мэдээлэл зонхилж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэлтийг авч үзвэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдлууд их байгаа нь өвчтөнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдалтай холбоотойгоор тэдний мэдүүлгийг нотлох баримтаар тооцох, үнэлэх, өмгөөлөгч авах эрхийг хангахад эрсдэлтэй байна гэж үзэх үндэслэлтэй, мөн шүүхэд шилжүүлсэн хэрэг цөөн байгааг анхаарах шаардлагатай.

СЭМҮТ-ийн өвчтөн, эмчлүүлэгч, тэдний ар гэр эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэхээр гаргасан гомдол, мэдээлэл жил ирэх бүр өсөж байна. 2022 онд 4, 2023 онд 3, 2024 онд 6, 2025 онд 11 болж өссөн нь ЭШУСҮА-ны 4 жилийн үйл ажиллагааны үр нөлөө юм.

НАЙМ. ДҮГНЭЛТ

- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, түүнчлэн 2022-2025 онуудад тогтмол хийгдсэн хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах эрсдэл гүнзгийрсэн, гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулах нь тогтолцооны шинжтэй, удирдлага, хариуцсан алба хаагчийн оролцоотой байж болзошгүй нь тогтоогдсон.
- Хяналт шинжилгээгээр албадан эмчлүүлж буй эмчлүүлэгчдэд бие махбодын зүй бус харьцаа үзүүлсэн байж болзошгүй үйлдэл илэрч, тухайн орчинд хүч хэрэглэх, хөдөлгөөнийг албадан хязгаарлах арга хэмжээг хуульд заасан зайлшгүй байх шалгуурын хүрээнд хэрэгжүүлээгүй, түүнд тавих хяналт алдагдсан.
- Камерын хяналт нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх боломж бүрдүүлж байгаа хэдий ч илэрсэн нөхцөлд шуурхай, системтэй хариу арга хэмжээ авах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх удирдлага, хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй хэвээр.
- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хууль зүйн баталгааны хэрэгжилт, түүнтэй холбоотой баримтжуулалт бодит нөхцөлд жигд бус, эмчлүүлэгчийн эрх зүйн байдлын талаар мэдээлэл авах, тайлбар шаардах, гомдол гаргах боломжийг бодитоор хангах механизм сул.
- СЭМҮТ-өөс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс зөвлөмжийн дагуу тодорхой зохион байгуулалтын арга хэмжээг авч эхэлсэн нь эерэг өөрчлөлт боловч бодит байдал дээр хэрэгжилт бүрэн бус.

01.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад, түүнчлэн өмнөх жилүүдэд илэрсэн хүний эрхийн эрсдэл, нөхцөл байдлыг харгалзан тус байгууллагын удирдлагад 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/51 дугаартай нийт хоёр удаагийн зөвлөмж хүргүүлсэн.

02.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд холбогдох нийт 25 орчим гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд 2022–2023 онд тус бүр 4 орчим тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 онд 6 болж нэмэгдсэн, харин 2025 онд 11 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онуудтай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн.

03.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагаас уг саналыг хэлэлцэж, дотоод шалгалт явуулсны үндсэн дээр сахилгын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч Л.Б-д албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, ахлах сувилагч Г.О-д хурлын протоколоор сануулах арга хэмжээ авсан байна. Мөн туслах сувилагч Ц.П-д гурван сарын хугацаанд, Г.Г-д хоёр сарын хугацаанд тус тус үндсэн цалинг 20 хувиар бууруулах шийдвэр гаргасан бөгөөд сувилагч О.Т, Л.Я, Э.О болон туслах сувилагч Д.Б нарт албан тушаалд сануулах сахилгын арга хэмжээ авсан.

04.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

2022–2025 онд тогтмол хийсэн хяналт шинжилгээ, ялангуяа 2025 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв-д хийсэн үнэлгээний дүнгээс үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжиж буй орчинд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэл ноцтой түвшинд байгааг тогтоосон. Зарим тохиолдолд эмчлүүлэгчид бие махбодын зүй бус харьцаанд өртсөн байж болзошгүй нөхцөл илэрч, хүч хэрэглэх болон хөдөлгөөнийг албадан хязгаарлах арга хэмжээг хуульд заасан шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх, түүнд тавих хяналт хангалтгүй.

Камерын хяналт тодорхой зөрчлийг илрүүлэх боломж бүрдүүлж байгаа ч илэрсэн тохиолдолд шуурхай, системтэй хариу арга хэмжээ авах, давтан зөрчлийг таслан зогсоох удирдлага, хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Түүнчлэн албадлагын арга хэмжээний хууль зүйн баталгаа, баримтжуулалт жигд бус, эмчлүүлэгчийн мэдээлэл авах, тайлбар шаардах, гомдол гаргах эрхийг бодитоор хангах механизм сул хэвээр.

2.4. ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улс хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орж, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих, ялгаварлан гадуурхахгүй байх, амьдрах, хөгжих, оролцох үндсэн зарчмуудыг үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн. Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох бодлого, хөтөлбөрүүдэд хүүхдийг онцгой хамгаалал шаардлагатай бүлэгт хамааруулж, төрөөс хүүхдийн эрхийг хангах тусгай үүргийг хүлээсэн байдаг.

Хүүхдэд үзүүлж буй асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ нь зөвхөн халамжийн шинжтэй бус, хүүхдийн нэр төр, хувийн халдашгүй байдал, оролцох, санал бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэсэн, хүүхдийн эрхэд суурилсан, хүн төвтэй хандлагад тулгуурласан байх шаардлагатай. Гэвч ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад асрамж, хамгааллын байгууллагад амьдарч буй хүүхдүүдийн хувьд бие махбодын болон сэтгэл санааны дарамтад өртөх, үл хайхрах шинжтэй харьцаа, асаргаа, халамжийн чанар хангалтгүй байх, санал, гомдол гаргах боломж бодитоор хэрэгжихгүй байх зэрэг эрсдэл тогтвортой хадгалагдаж байгааг анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 20 байгууллагын 29 хүүхдийн асрамж, халамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 24, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 1, Орхон аймагт 1, Өвөрхангай аймагт 1 төв тус тус ажиллаж байна. Эдгээр төвүүдэд 2025 оны байдлаар 832 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд 649 буюу 78.0 хувь нь Улаанбаатар хотод төвлөрсөн байна. Одоогийн байдлаар асрамж, халамжийн байгууллагуудын санхүүжилт нь улсын төсөв, олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэний хандив зэрэг олон эх үүсвэрээс бүрдэж, жигд бус байдалтай байгаа нь хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд тэгш бус нөхцөл үүсгэхэд нөлөөлдөг.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээнд одоогийн байдлаар 0-5 настай 57 хүүхэд (6,8%), 6-10 настай 240 хүүхэд (28,8%), 11-14 настай 240 хүүхэд (30%), 15-18 настай 221 хүүхэд (26,5%) байна. Тэдгээр хүүхдүүдийн 197 буюу нийт хүүхдийн (23,6%) хувь нь бүтэн өнчин, 241 буюу (28,9%) хувь нь хагас өнчин, 36 хүүхдийн эцэг, эх байдаг эсэх нь тодорхойгүй, 355 хүүхэд буюу нийт хүүхдийн (42,6%) нь гэр бүлтэй.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, залуучуудын 95 буюу 11,4 хувь нь өсөлт хөгжлийн хоцрогдолтой, 85 буюу 10,2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 16, хөнгөн хэлбэрийн 47, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхэд, залуучууд байна. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг насны ангиллаар нь авч үзвэл 0-18 насны 70, 18-аас дээш насны 15 залуу байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид нийт 694 хүүхэд хамрагдаж байна. Мөн 18 хүртэлх насны хагас болон бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэрт 256

хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэрт 11 хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэнд улирал тутам олгодог тэтгэвэрт 9 хүүхэд, залуучууд тус тус хамрагдаж байна.⁴²

Хүүхдийн асрамж, хамгааллын байгууллагад хийж буй урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон тэдгээрийн хэрэгжилтийг хангах үндэсний хууль тогтоомж, түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжиж байна.

Тайланд 2025 онд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ, арга зүй, хамрагдсан байгууллагууд, газар дээр илэрсэн бодит нөхцөл байдал, тэдгээрт үндэслэн хүргүүлсэн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ, мөн хэрэгжилтээс гарсан ахиц дэвшил, үлдэж буй эрсдэлийг нэгтгэн тусгав. Ингэснээр хүүхэд хамгааллын тогтолцоонд бодит нөхцөлөөс урган гарч буй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлогын болон зохион байгуулалтын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох үндэслэл бүрдүүлэхийг зорилоо.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд улсын хэмжээнд хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг зохион байгуулан хэрэгжүүлэв. Хяналт шинжилгээ нь хүүхдийн эрх чөлөө хязгаарлагдсан, байнга буюу урт хугацаагаар байрлан амьдарч буй орчинд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, бодит нөхцөл байдал, эрсдэлийг илрүүлэх зорилготойгоор хэрэгжсэн болно.

Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагууд нь хүүхдийг байнга асран хамгаалах, хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй бөгөөд эдгээр байгууллагад байрлаж буй хүүхдүүдийн амьдрах орчин, асаргаа, халамжийн чанар, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүчирхийлэл, үл хайхрах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн бодит хэрэгжилтэд үнэлгээ хийв.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний чиг үүргийн хүрээнд 2025 онд улсын хэмжээнд хүүхдийн асрамж, халамжийн нийт 12 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийв. Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын “Хүүхдийн төв”, “Залуучуудын төв”
2. “Монголын СОС хүүхдийн хотхон”
3. “Дон Боско” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага
4. “Бадамлянхуа” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага
5. “Цөлийн сарнай” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага
6. “Мишээл” хүүхдийн төвийн 1 дүгээр салбар

42 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025). Хүүхдийн асрамж, халамжийн байгууллага.

7. “Гэрэл” хүүхдийн төв
8. “Вербист” хүүхдийн асрамжийн төв
9. “Шинэ найдвар” хүүхдийн асрамжийн төв
10. “Монголын хүүхдийн сан” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага
11. “Анна хоме” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага
12. Хүүхдийн төв сувиллын “Солонго” тасаг

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан 03 дугаартай удирдамж,⁴³ мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан 04 дугаар удирдамжийн⁴⁴ хүрээнд хэрэгжүүлэв.

Хяналт шинжилгээний хамрах хүрээ:

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хүүхдийн эрх зөрчигдөх эрсдэл илрэх магадлалтай үндсэн чиглэлүүдийг тодорхойлон, тэдгээрийн агуулгыг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 35

| Хамрах асуудал | Агуулга |
|-------------------------------|---|
| Амьдрах орчин, аюулгүй байдал | Байр, орчны нөхцөл, ариун цэвэр, аюулгүй байдлын зохицуулалт |
| Асаргаа, халамж, хамгаалал | Өдөр тутмын асаргаа, хамгааллын арга хэмжээ, үйлчилгээний чанар |
| Боловсрол | Сургуульд хамрагдалт, сургалтын орчин, цахим хэрэглээ |
| Эрүүл мэнд | Үзлэг, эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг |
| Хүүхдийн оролцоо | Санал, гомдол гаргах, оролцох боломж |
| Дотоод зохион байгуулалт | Хүний нөөц, хяналт, хариуцлагын тогтолцоо |

43 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүний эрхийн хэрэгжилт, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах” “03” дугаартай 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн удирдамж.

44 Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх “04” дугаартай удирдамж.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн эрх, эрх чөлөө бодитоор хангагдахад нөлөөлж буй дараах нөхцөл байдал, эрсдэл илэрсэн.

3.1. Хүүхдийн амьдрах орчин, аюулгүй байдалд эрсдэл үүсгэж буй нөхцөл

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад амьдарч буй хүүхдийн амьдрах орчин, байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн суурь нөхцөл жигд хангагдаагүй, байгууллага хоорондын ялгаа ихтэй байв. Зарим байгууллагад гал тогоо, амьдрах өрөөний орчин эрүүл ахуйн шаардлага хангахгүй, цахилгааны олон залгуурыг ил байрлуулж, цахилгаан хэрэгслийг нэг цэгээс тэжээж байгаа нь хүүхдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлсэн байв. Мөн том хэмжээний хутга, заазуур зэрэг ахуйн хурц иртэй хэрэгслийг хамгаалалт, хязгаарлалтгүй ил задгай байршуулсан, гал тогоо болон ахуйн орчны эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй байдал ажиглагдсан.

Мөн хүүхдүүд амьдарч буй өрөө тасалгааны дулаан, чийгшил, агааржуулалт стандартын шаардлагад нийцэхгүй, цонхоор дулаан алдагдах, урсгал засвар удаан хугацаанд хийгдээгүй, улмаар өвлийн улиралд цахилгаан халаагуур ашиглах шаардлага үүссэн нь гал, цахилгааны аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Зарим байгууллагад орчны хэмжилтээр зарим өрөөнд чийгшил, дулааны үзүүлэлт хэвийн хэмжээнээс зөрсөн нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлөхүйц байдал байв.

Камерын хяналтын хувьд зарим байгууллагад хяналтын дэлгэцийг байнгын хяналт тавих боломжгүй байршилд байршуулсан, хариуцах тодорхой ажилтангүй, мөн охидын унтлагын өрөөний орны хэсэг



камерын хяналтад орсон зэрэг нь хүүхдийн хувийн орон зай, нэр төр, халдашгүй байдлын эрх зөрчигдөх эрсдэлийг үүсгэж байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ, зарим байгууллагад камерын хяналт огт байхгүй, цонхны хамгаалалт хийгдээгүй нөхцөл байдал тогтоогдсон нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо жигд бус, стандартчилагдаагүй байгааг илтгэж байлаа.

Хяналт шинжилгээний явцад хүүхдүүд асрамж, халамжийн байгууллагаас оргож, сураггүй алга болох тохиолдол гарч байгааг, уг нөхцөл байдалд холбогдох байгууллагуудтай шуурхай уялдан ажиллах, эрэн хайх ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх тогтолцоо сул байгааг илрүүлээ. Зарим тохиолдолд хүүхдийг эрэн хайх ажиллагааг байгууллагын багш, ажилтнууд өөрсдөө зохион байгуулж, харьяалах байгууллагын оролцоо хангалтгүй байсан нь хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллага хоорондын уялдаа сул байгааг харуулж байна.

Мөн зарим төвд насанд хүрсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүүхдүүдтэй хамт амьдарч байгаа нь хүүхдийн тусгай хамгаалалтын орчныг алдагдуулах, үйлчилгээний зорилтот бүлгийн зааг тодорхой бус байдалд хүргэж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Дээрх нөхцөл байдлыг арилгах хүрээнд аюулгүй байдлын стандарт хангах, гал тогоо, амьдрах орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, камерын хяналтыг хүүхдийн нэр төр, хувийн орон зайг хүндэтгэсэн байдлаар зохион байгуулах, хүүхэд сураггүй алга болсон тохиолдолд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бодитой, шуурхай болгох чиглэлээр хууль ёсны шаардлага, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

3.2. Хоол хүнс, эрүүл ахуй, хоол тэжээлийн стандартын хэрэгжилтийн доголдол



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хоол хүнсний хүрэлцээ, хоол тэжээлийн чанар, хадгалалт, эрүүл ахуйн стандартын хэрэгжилт харилцан адилгүй байсан бол хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэл бүхий доголдлууд нийтлэг илэрч байна. Тухайлбал, хүүхдүүдэд олгож буй хоол хүнсний хэмжээ, нэр төрөл нь батлагдсан жишиг норм, стандартын шаардлагыг тогтмол хангахгүй, зарим байгууллагад 14 хоногийн хүнсний материал богино хугацаанд дуусах, ялангуяа мах, махан бүтээгдэхүүний хүрэлцээ хангалтгүй байх нөхцөл тогтоогдлоо.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар хүүхдүүдэд олгож буй хүнсний зарим бүтээгдэхүүн удаан хадгалалтын улмаас чанарын шаардлага хангахгүй байж

болзошгүй, хоол хүнсний нэр төрөл хязгаарлагдмал, тэнцвэртэй хооллолтын зарчим бүрэн шинжилгээний явцад хүүхдэд ноогдох махны хоногийн хэмжээ нь

холбогдох жишиг нормтой дүйцэж байгаа мэт харагдавч бодит хэрэглээнд тогтмол, жигд хангагдахгүй байдал ажиглагдсан нь хүүхдийн хоол тэжээлийн чанар тогтвортой бус байгааг харуулж байв.

Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт (НЗДД) хүүхдүүдэд олгодог 14 хоногийн хоол хүнсний материал нь бодит хэрэглээндээ 7 хоногт дуусдаг, ялангуяа мах, махан бүтээгдэхүүн 14 хоногийн хэрэгцээг хангаж чаддаггүй зарим тохиолдолд удаан хадгалалтаас үүдэлтэй, муудсан байж болзошгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглээнд ордог талаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар удаа дараа дурдагдсан.

“Тус төвийн Smile” бүлэгт амьдарч буй ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид суралцдаг 5 хүүхдэд олгосон 14 хоногийн хүнсний хэмжээг задлан тооцоход нийт 8 кг мах ноогдож, нэг хүүхдэд хоногт дунджаар 114 грамм мах оногдож байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээ”-д заасан хоногт 120 грамм мах хэрэглэх жишигт ойролцоо боловч тухайн норм нь насанд хүрсэн хүнд хамаарах бөгөөд өсвөр насны хүүхдийн шим тэжээлийн хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүрэхгүй байна.

Мөн зарим байгууллагад хоол хүнс хадгалах орчин, хөргөгч, агуулахын зохион байгуулалт стандартын шаардлагад бүрэн нийцэхгүй, хүнсний аюулгүй байдлыг хангах дотоод хяналт, бүртгэл сул, хоолны дээж авах, хадгалах, шинжлүүлэх үйл ажиллагаа тогтмол, системтэй хэрэгжихгүй байдал илэрч байна. Энэ нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй юм.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын хоол тэжээлийн үйлчилгээ нь хүүхдийн нас, биеийн жин, хөгжлийн онцлог, эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн байдлаар төлөвлөгдөх ёстой хэдий ч бодит нөхцөлд энэ шаардлага жигд хэрэгжихгүй, байгууллагуудын хооронд ихээхэн зөрүүтэй байгааг хяналт шинжилгээний дүн харуулж байна. Ялангуяа өсвөр насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн хоол тэжээлийн онцгой хэрэгцээг харгалзан үзэх тогтолцоо сул байна.

3.3. Эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмжийн асуудал

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж, төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээ ялангуяа сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй, жигд бус байгаагаас хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд бодит эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн тогтолцооны түвшинд шийдвэрлэвэл зохих нөхцөл байдал





олонтоо илэрсэн. Тухайлбал, сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд, залуучуудыг мэргэжлийн байгууллагын тусламж, үйлчилгээнд тогтмол хамруулахад хүндрэл учирч, цагийн дараалал удаан хүлээх, орон нутгийн хүртээмж хязгаарлагдмал байдал нийтлэг илэрдэг.

Зарим байгууллагад оюун ухааны хүндэтгэр болон хүнд хэлбэрийн хомсдол, аутизм, сэтгэцийн эмгэгтэй хүүхдүүд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд өөртөө болон бусдад аюултай үйлдэл гаргах эрсдэлтэй нөхцөл байдал үүсдэг. Гэсэн хэдий ч ийм төрлийн эрсдэлийг мэргэжлийн түвшинд үнэлэх, сэтгэл зүйн болон эмнэлгийн тасралтгүй дэмжлэг үзүүлэх тогтолцоо хангалттай бүрдээгүй, байгууллагын багш, ажилтнууд хүүхдийг биечлэн дагалдан хянах замаар эрсдэлийг бууруулахыг оролдож байгаа нь тогтвортой, хүний эрхэд нийцсэн шийдэл болж чадахгүй байна.

Хяналт шинжилгээний явцад зарим асрамж, халамжийн байгууллагад анхан шатны эрүүл мэндийн тусламж үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн иж бүрдэл стандартын шаардлагад нийцэхгүй, эмийн нэр төрөл, хадгалалт, бүртгэл замбараагүй, шаардлагатай үед яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал хангалтгүй байгааг илрүүллээ.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн ажилтан, тухайлбал сэтгэл зүйч, тусгай хэрэгцээт боловсролын багш, сувилагч, асрагчийн хүрэлцээ хангалтгүй байдал нь хүүхдийн эрхийг хангах тогтолцооны сул талыг илтгэнэ.

Зарим байгууллагад сэтгэл зүйчийн орон тоо тусгагдсан боловч ажлын ачаалал, нөхцөлөөс шалтгаалан уг орон тоо бодитойгоор нөхөгдөөгүй хэвээр байна.

Дээрх нөхцөл байдал нь хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудал нь салбар хоорондын уялдаа, мэргэжлийн нөөц, тогтвортой дэмжлэг дутагдсан, системийн шинжтэй хүндрэл байгааг харуулж, энэ нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний нэр төр, хүнлэг харьцаанд байх эрхийг бүрэн хангахад ноцтой саад болж болзошгүй.

Харин “Монголын хүүхдийн сан” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад анхан шатны эм, эмнэлгийн хэрэгслийн тодорхой нөөцтэй, шаардлагатай

тохиолдолд Эрүүл мэндийн 10 дугаар төвтэй уялдан хүүхдүүдийг эмнэлгийн тусламжид хамруулж, дараалалгүй үзүүлэх зохицуулалт хийдэг нь эерэг жишээ байв.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ нь тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилтээс хэт хамааралтай, тогтвортой тогтолцоонд бүрэн шилжээгүй хэвээр байна.

Энэ нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрх зөрчигдөх, улмаар хүнлэг бус нөхцөл бүрдэх эрсдэлийг хадгалсаар байна. Энэ хүрээнд зарим байгууллагын удирдлага, багш нартай хийсэн ярилцлага, баримт бичгийн хяналт, орчны үзлэг ажиглалтаар илэрсэн нөхцөл байдлыг хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 36

| № | Байгууллагын нэр | Илэрсэн нөхцөл байдал |
|---|--|--|
| 1 | НЗДД Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор | Сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй хүүхэд, залуучуудыг СЭМҮТ-ийн тусламж, үйлчилгээнд тогтмол хамруулах шаардлагатай боловч цагийн дараалал удаан, шуурхай үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал |
| 2 | НЗДД Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор | Хөгжлийн бэрхшээлтэй, насанд хүрсэн 2 хүн асрамжийн байгууллагад амьдарч байгаа бөгөөд цаашид бие даан амьдрах, шилжилтийн зохицуулалт тодорхойгүй |
| 3 | “Мишээл” төв | Оюуны бэрхшээлтэй, хурц ааш авиртай хүүхэд бусад хүүхдэд аюул учруулж болзошгүй нөхцөлтэй, шөнийн цагаар байнгын хяналт шаардлагатай |
| 4 | “Гэрэл” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага | Аутизмтай, бүрэн хараагүй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа, нэг хүүхдийг мэргэжлийн байгууллагад шилжүүлсэн |
| 5 | “Вербист” хүүхдийн асрамжийн төв | Хөгжлийн бэрхшээлтэй болон зан төрхийн өөрчлөлттэй хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн боловсон хүчин хүрэлцээгүй |
| 6 | “Шинэ найдвар” хүүхдийн асрамжийн төв | Анхан шатны эмнэлгийн тусламжийн цүнхэнд эм, эмнэлгийн хэрэгсэл дутуу, хадгалалт эмх цэгцгүй |
| 7 | Хүүхдийн төв сувиллын “Солонго” тасаг | Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хамгаалалтын арга хэмжээ авч, СЭМҮТ-ийн мэргэжилтнүүд зөвлөгөө, сургалт явуулсан |

3.4. Сурч боловсрох, хөгжих эрхийн хэрэгжилтэд илэрч буй саад, хүндрэл

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад амьдарч буй хүүхдүүдийн сурч боловсрох, хөгжих эрхийн хэрэгжилтэд бодит саад, хүндрэл үүсгэж буй нөхцөл байдал нийтлэг илэрсэн. Тухайлбал, хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах шийдвэрт тухайн үйлчилгээнд хамрагдах хугацааг тодорхой заадаггүй, улмаар хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, эсхүл өөр хэлбэрийн халамж, хамгааллын



үйлчилгээнд шилжүүлэх асуудал тодорхойгүй удаашрах хандлага ажиглагдлаа. Энэ нь хүүхдийн тогтвортой хөгжил, ирээдүйн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хяналт шинжилгээний явцад зарим байгууллагад хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангахад шаардлагатай техник хэрэгсэл, сургалтын орчин хангалтгүй, тухайлбал компьютер, интернэт ашиглах боломж хязгаарлагдмал байгаагаас хүүхдүүд гэрийн даалгавраа гүйцэтгэх, цахим хичээлд хамрагдах боломжгүй байдалтай байв. Зарим тохиолдолд хүүхдүүд сурлагын хэрэгцээгээ хангахын тулд гаднын үйлчилгээ ашиглах, бусдаас санхүүгийн дэмжлэг гуйх нөхцөлд хүрч байгаа нь тэднийг үе тэнгийнхнээсээ ялгаварлагдсан, эмзэг байдалд оруулж байна.

Мөн асрамж, халамжийн байгууллагад амьдарч буй хүүхдүүдэд ирээдүйн амьдралд бэлтгэх, бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, өөртөө итгэх итгэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээ тогтмол, системтэй хэрэгжихгүй байдал илэрсэн. Ганцаарчилсан ярилцлагаар зарим хүүхэд, залуучуудын ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдлийнхөө талаар тодорхой төсөөлөлгүй, амьдралын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг дутмаг байгааг илэрхийлсэн нь уг асуудлын бодит илрэл юм.

Түүнчлэн хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад холбогдох байгууллагууд хоорондын уялдаа, хяналт сул байгаагаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр, бусад төрлийн дэмжлэгт хамрагдах ёстой хүүхдүүдийн зарим нь уг дэмжлэгээс хоцорч, санхүүгийн боломжоор хязгаарлагдах нөхцөл үүсэж байна. Энэ нь хүүхдийн боловсрол, хөгжлийн боломжийг бодитоор хязгаарлах шалтгаан болж байна.

Дээрх нөхцөл байдал нь хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад сурч боловсрох, хөгжих эрхийг хангах асуудал нь зөвхөн сургалтын орчин, материаллаг

нөөцөөр хязгаарлагдахгүй, харин хүүхдийн ирээдүйн хөгжил, нийгэмд бие даан амьдрах чадварыг төлөвшүүлэх бодлого, зохион байгуулалт, салбар хоорондын уялдаа сул байгаатай холбоотой, тогтолцооны шинжтэй хүндрэл болохыг харуулж байна.

3.5. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх тогтолцооны сул тал

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх тогтолцоо хангалтгүй, хэрэгжилт жигд бус байгаагаас хүүхдийн нэр төр, халдашгүй байдал, аюулгүй байдлын эрх зөрчигдөх бодит эрсдэл үүсэх нөхцөл бүрдэж байгааг тогтоолоо. Тухайлбал, зарим байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтын эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох дотоод журам, заавар, хариу арга хэмжээний механизм тодорхой бус, ажилтан, асран хамгаалагчдын мэдлэг, ойлголт хангалтгүй байдал ажиглагдсан.



Хяналт шинжилгээний явцад ганцаарчилсан ярилцлагаар зарим хүүхэд, залуучуудын асран хамгаалагч, багш, ажилтны зүй бус харьцаа, сэтгэл санаанд дарамт учруулах үйлдлийн талаар мэдээлсэн боловч тухайн асуудлыг байгууллагын түвшинд албан ёсоор бүртгэх, холбогдох байгууллагад мэдэгдэх, хүүхдийг хамгаалах арга хэмжээ авах тогтолцоо бүрэн хэрэгждэггүй нь тогтоогдсон. Энэ нь хүүхдүүд зөрчил, дарамтад өртсөн тохиолдолд хамгаалалт, дэмжлэг авах боломжоо алдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.



Мөн хүүхдүүд хоорондын хүчирхийлэл, дээрэлхэлт, зөрчил маргааныг эрт илрүүлэх, зохицуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоо сул байгаагаас нөхцөл байдал даамжрах, улмаар хүүхдийн сэтгэл зүй, аюулгүй байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсэж байна. Хүүхдүүд хоорондын зөрчлийг сахилгын арга хэмжээгээр шийдвэрлэх хандлага давамгайлж, урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ хангалтгүй байв.



Түүнчлэн хүүхдүүд гомдол, мэдээлэл гаргахдаа аюулгүй, нууцлалтай, хараат бус сувгийг ашиглах боломж бодитойгоор бүрдээгүй, эсхүл ийм боломжийн талаар



хангалттай мэдээлэлгүй байгааг хяналт шинжилгээ харуулаа. Зарим байгууллагад “гомдлын хайрцаг” байршуулсан боловч бодитой ашиглагддаггүй, хүүхдүүд уг механизмыг үр дүнтэй гэж үзэхгүй байдал ажиглагдсан нь гомдол, мэдээлэл шийдвэрлэгдэхэд итгэх итгэл сул байв.

Тухайлбал, НЗДД Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөлүүдээс дурдвал:

- Гэмт хэргийн хохирогч болсон, өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан хүүхдүүд олноор байрладаг, сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхдийн тоо өндөр, “ноцтой кейс” гарах магадлалтай нөхцөл байдал байгааг байгууллагын удирдлага дурдсан;
- Сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй зарим хүүхдийн зүгээс бусдыг хэл амаар доромжлох, дарамт үзүүлэх байдал давтамжтай илэрдэг тул камерын хяналттай орчинд уулзалт хийж, байнгын тэмдэглэл хөтөлдөг
- Нэг хүүхдэд СЭМҮТ-ийн сэтгэцийн эмч “нийгэмд аюултай” гэсэн тодорхойлолт өгсөн;
- Өмнө нь тус байгууллагад бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэж, шалгагдан шийдвэрлэгдсэн бөгөөд дараа нь бүлгийн зохион байгуулалт, багшийн хяналтыг сайжруулснаар дахин давтагдаагүй;
- Сэтгэл зүйн “дуусаагүй өгүүлбэрийн” аргаар хийсэн үнэлгээгээр том хүүхдүүд бага насны хүүхдүүдийг зодох, дарамтлах байдал илэрсэн;
- Асрамж, халамжийн байгууллагаас гарсан хүүхэд, залуучуудын мансууруулах бодистой холбоотой сүлжээнд татагдах, гэмт хэрэгт холбогдох магадлалтай талаар удирдлага мэдээлсэн;
- Нэг багш эрэгтэй хүүхдүүдэд бие махбодын хүч хэрэглэдэг талаарх мэдээлэл асуумжид бичигдсэн;
- Хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зарим уулзалтыг заавал гэрчтэй, камерын хяналттай орчинд зохион байгуулдаг.

3.6. Асран хамгаалагч, ажилтны хүний нөөц, мэргэжлийн чадавх, тогтвортой байдлын асуудал



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан, сувилагч зэрэг ажилтнуудын хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн чадавх, тогтвортой байдал хангалтгүй байдалтай холбоотой нийтлэг хүндрэлүүд илэрсэн. Тухайлбал, зарим байгууллагад хүүхэд асран хамгаалагчийн харьцаа зохистой түвшнээс хэтэрч, нэг ажилтанд ногдох хүүхдийн тоо өндөр байгаа нь хүүхэд бүртэй биечлэн ажиллах, тэдний хэрэгцээ, эрсдэлийг цаг тухайд нь илрүүлэх боломжийг хязгаарладаг байж болзошгүй.

Мөн асран хамгаалагч, ажилтнуудын дийлэнх нь хүүхдийн эрх, сэтгэл зүй, хөгжлийн онцлог, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар тогтмол, системтэй сургалт, чадваржуулах хөтөлбөрт хамрагддаггүй байдал ажиглагдсан. Үүний улмаас зарим ажилтнууд хүүхдийн зан авирын өөрчлөлт, сэтгэл зүйн хямралыг сахилгын зөрчил гэж ойлгон, зүй бус арга хэмжээ авах эрсдэл үүсэж байна.



Хяналт шинжилгээний явцад ажилтнуудын ажлын ачаалал өндөр, цалин хөлс, нийгмийн баталгааны түвшин хангалтгүй байгаагаас ажлын байрны тогтворгүй байдал, хүний нөөцийн халаа, сэлгээ үргэлжилдэг. Энэ нь хүүхдэд үзүүлэх халамж, асаргаа, сэтгэл зүйн дэмжлэг тасалдах, хүүхэд ажилтанд итгэх харилцаа бүрэлдэх боломж хязгаарлагдах нөхцөлийг бий болгоход нөлөөлдөг байж болзошгүй.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдтэй ажиллах тусгай мэргэжлийн ажилтан, тухайлбал тусгай хэрэгцээт боловсролын багш, сэтгэл зүйч, сувилагчийн орон тоо бодит хэрэгцээнд нийцэхгүй, зарим байгууллагад огт байхгүй байдал тогтоогдсон. Ийм нөхцөлд байгууллагын ажилтнууд мэргэжлийн бус байдлаар олон үүрэг давхар гүйцэтгэхээс өөр аргагүйд хүрч, энэ нь хүүхдийн эрхийг хангах чанарт сөргөөр нөлөөлж байна.

Байгууллагад ажилтнуудын сэтгэл зүйг дэмжих, мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоо бүрдээгүй, сэтгэл зүйчийн орон тоо батлагдсан боловч тухайн ажлын байранд хүн олдохгүй, сул орон тоо удаан хадгалагдаж байгаа нөхцөл байдал илэрсэн.

3.7. Хүүхдийн эрхээ эдлэх, хамгаалуулах, гомдол гаргах боломжийн бодит хэрэгжилт

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад байрлан амьдарч буй хүүхдүүдийн нийгмийн хамгаалал, халамж, боловсрол, санхүүгийн болон хувийн эрхийн хэрэгжилттэй холбоотой зохицуулалтын доголдол, хэрэгжилтийн зөрчил нийтлэг илэрсэн.

Хүүхдүүд өөрийн эрхийг мэдэх, түүнийгээ эдлэх, зөрчигдсөн тохиолдолд гомдол, мэдээлэл гарган хамгаалуулах боломж бодитойгоор хангагдаагүй нөхцөл байдал илэрсэн. Тухайлбал, зарим байгууллагад хүүхдийн эрх, үүрэг, хамгааллын механизмын талаар мэдээлэл өгч самбар, танилцуулга байршуулагдсан боловч агуулга нь хүүхдийн нас, ойлгох чадварт тохирохгүй байдлаар хийгдсэн байна.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар зарим хүүхэд, залуучуудын зөрчил, дарамтад өртсөн тохиолдолд хэнд, хэрхэн хандах, ямар шат дараалалтай гомдол гаргах талаар тодорхой ойлголтгүй байгаагаа илэрхийлсэн. Мөн гомдол, мэдээлэл гаргасны дараа тухайн асуудал бодитоор шийдэгдэх эсэх, нууцлал, аюулгүй байдал хангагдах эсэхэд эргэлзэх хандлага давамгайлж байгааг хяналт шинжилгээ харууллаа. Тухайлбал:

- Хагас болон бүтэн өнчин хүүхдүүд тэжээгчээ алдсаны тэтгэмж авах эрхтэй хэдий ч эцэг, эхийн нас барсны гэрчилгээ олдохгүй, бүрдүүлж

чадаагүй зэрэг баримт бичгийн зөрчлөөс шалтгаалан уг тэтгэмжид бүрэн хамрагдаж чадахгүй байгаа;

- Байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүд нийгмийн халамжийн асаргааны мөнгөн тэтгэмж авах эрх зүйн зохицуулалттай боловч уг тэтгэмжийг зөвхөн асран хамгаалагчид олгодог, байгууллагын болон хүүхдийн нэр дээр данс нээж олгох боломжгүй зохицуулалтаас үүдэн асрамж, халамжийн байгууллагад амьдарч буй хүүхдүүд бодитоор хамрагдаж чадахгүй хэвээр байгаа;
- Асрамж, халамжийн байгууллагууд хүүхдүүдийн суралцдаг ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллах, нууцлалын гэрээ байгуулж хүүхдийн ашиг сонирхол, хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртөх байдал бүрэн арилаагүй;
- Зарим сургууль асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдийг хамран сургах тойрогт багтдаг хэдий ч элсүүлэн авахгүй байх, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүндрэл үүсгэх тохиолдол гарч байгаа;
- Хүүхдүүд асрамж, халамжид байгаа хэдий ч өдөр тутмын хэрэгцээндээ өөрөө шийдвэр гаргах, ойр зуурын хэрэглээнд мөнгө зарцуулах боломж хязгаарлагдмал байгаа нь тэднийг өөрсдийгөө үе тэнгийнхнээсээ ялгаатай, хараат байдалтайгаар мэдрүүлдэг;
- Зарим байгууллагад хүүхдийн эсрэг бие махбодын болон сэтгэл санааны дарамт, зүй бус харилцаа гарч болзошгүй тухай мэдээлэл асуумжид бичигдсэн, үүнд холбогдох албан хаагчийн зүй бус харилцааны талаар дурдсан.

Түүнчлэн зарим байгууллагад гомдол, мэдээлэл хүлээн авах дотоод журам, механизм бий боловч бодит хэрэгжилт сул, хүүхдэд ээлтэй бус, хараат бус байдлыг хангаагүй байдал ажиглагдсан. Гомдлын хайрцгийг байгууллагын ажилтнуудын хяналттай бүсэд байршуулсан, хариуцсан тодорхой этгээд, хугацаа, шийдвэрлэх журам тодорхойгүй зэрэг нь хүүхдүүдийг гомдол гаргахаас зайлсхийх шалтгаан болж байна.

Мөн асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг гомдол, мэдээлэл гаргасных нь төлөө ялгаварлан гадуурхах, үл хайхрах, сэтгэл санааны дарамтад оруулах эрсдэлийг бууруулах тусгай хамгаалалтын механизм бүрэн төлөвшөөгүй байдал илэрсэн. Харин хүүхдийн мөнгийг банканд хадгалуулах, тодорхой хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах боломж олгох зохицуулалтыг хэрэгжүүлж буй байгууллагууд бага хувьтай байгаа ч хүүхдийн санхүүгийн боловсрол, бие даасан байдлыг дэмжих чиглэлд эерэг туршлага болж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ДӨРӨВ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД УЧИРЧ БУЙ ЭРСДЭЛ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад хүүхдийн аюулгүй байдал, халдашгүй байдал, хүний нэр төрийг ноцтойгоор зөрчиж, эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах нөхцөл бүрдсэн гэж дүгнэх үндэслэлтэй тохиолдлууд илэрсэн. Тухайлбал:



Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлээгүй тохиолдол

15 настай, бүтэн өнчин охин Б.У нь асрамжийн гадуур амьдарч байх хугацаандаа хамаатан садны айлд удаа дараа бэлгийн шинжтэй зүй бус харилцаанд өртсөн бөгөөд уг асуудлыг ангийн багшид мэдэгдсэний үндсэн дээр цагдаагийн байгууллагад шалгуулж, хамгаалах байранд түр байрлуулсны дараа асрамж, халамжийн байгууллагад шилжүүлсэн байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дүгнэлтэд хүүхдийн асран хамгаалагч хуульд заасан үүргээ ноцтой зөрчсөн, хүүхэд сэтгэл зүйн гүн хямралд орсон тул яаралтай нөхөн сэргээх, сэтгэл зүйн тусламж авах шаардлагатай гэж дүгнэсэн боловч тухайн орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагын сэтгэл зүйчид хүүхэдтэй бодитой ажиллаагүй байдал тогтоогдсон. Энэ нь хүүхдийг хүчирхийллийн дараах нөхөн сэргээх үйлчилгээгээр хангах тогтолцоо алдагдсан, хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг хэрэгжээгүй нөхцөл байдалд тооцогдоно.

Дээрх онцлох тохиолдлууд нь хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүүхдийн эсрэг хүч хэрэглэсэн, үл хайхрах, хамгааллын механизм алдагдсан, үр нөлөөтэй шалгалт хийгдээгүй нөхцөл байдал давтагдан илэрч байгааг харуулж байна. Энэ нь эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах нөхцөл бүрдэх бодит эрсдэл байсаар байгааг нотлох үндэслэл болж байна.

Дорнод аймаг дахь Анна Хоме асрамжийн газрын хүүхэдтэй хийсэн ярилцлагаас...

ТАВ. ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮЛЭЭЛГЭЖ БҮЙ ҮҮРЭГ, ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН АГУУЛГА

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний дүнгээр тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн эрсдэл, зөрчил, тогтолцооны доголдлыг арилгах, хүүхдийн эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах агуулгыг багтаасан зөвлөмжүүдийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

5.1. Орчны аюулгүй байдал, ахуйн стандартын хэрэгжилтийг хангах

5.1.1. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хоол хүнс, ахуйн стандартын хэрэгжилтэд тогтмол анхаарч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

5.1.2. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852:2017 стандартад заасан шаардлагын дагуу хүүхэд, залуучуудын амьдрах орчныг сайжруулан тохижуулах, урсгал болон их засварыг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх;

5.1.3. Хүүхдийн амьдралын бүсийн хуулиар хориглоогүй хэсгүүдэд дуу-дүрсний, бичлэгийн төхөөрөмжийг зохистой байршуулж, дүрс бичлэг хадгалах нэгжийг бүрдүүлэхдээ хүүхдийн хувийн орон зай, нэр төр, халдашгүй байдлыг хүндэтгэх;

5.1.4. Хоол хүнсний агуулах, хадгалалтын орчныг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах, хоолны дээжийг тогтмол эрх бүхий байгууллагаар шинжлүүлэх;

5.1.5 “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852:2017 стандартын 12, 11, 12, 12.13-т заасан шаардлагуудыг хангахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх.

5.2. Эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн дэмжлэгийг сайжруулах

5.2.1. Эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн дэмжлэгийг салбар хоорондын уялдаатайгаар зохион байгуулж, хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний хүртээмжийг хангах;

5.2.2. Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрх, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, өсвөр насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

5.2.3. Хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхийг хангах хүрээнд ялгаварлан гадуурхалтаас ангид суралцах орчныг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, орчныг бүрдүүлэх;

5.2.4. Хүүхдүүдийн ганцаарчилсан ярилцлагаар илэрхийлсэн ирээдүйдээ итгэх, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн сургалт, арга хэмжээ хангалтгүй байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, байгууллагын дотоод сургалт, хөгжлийн арга хэмжээний чанар, үр өгөөжийг сайжруулах;

5.2.5. Сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй хүүхэд, залуучуудыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон холбогдох байгууллагын тусламж, үйлчилгээнд тогтмол хамруулахад тулгарч буй хүндрэл, саадыг тодорхойлон, хүний эрхэд ээлтэй, үр дүнтэй шийдвэрлэх боломжит арга, хувилбар боловсруулан хэрэгжүүлэх;

5.2.6. Хүүхдүүдийн өөрсдийн илэрхийлсэн санал, хүсэлт (урлаг, спорт, санхүүгийн ил тод байдал, ажилтны хандлага, хүүхдийн эрсдэлээс хамгаалах асуудал)-д тулгуурлан хүүхдийг сургах, хөгжүүлэх үйлчилгээний чанарыг үнэлж, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

5.3. Хяналт, дотоод журам, гомдол мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх

5.3.1. Үе тэнгийн дээрэлхэлт, зөрчил, дарамтыг эрт илрүүлэх, даруй таслан зогсоох, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

5.3.2. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалт болон бусад эрхийн зөрчилтэй холбоотой гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны мэдээллийг хүүхэд, залуучууд, нийт ажилтанд ойлгомжтой, харагдахуйц газарт байршуулах;

5.3.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас өгсөн зөвлөмжийн дагуу санал, хүсэлт хүлээн авах хайрцгийг хүртээмжтэй байршилд байршуулж, бодитой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

5.3.4. Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх, урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллийн самбарыг байгууллагын хүртээмжтэй байршлуудад байршуулах;

5.3.5. Гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шалгуулах, үр дүнг хүүхдэд ойлгомжтой байдлаар мэдээлэх дадлыг хэвшүүлэх;

5.3.6. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хүүхэд, залуучуудын өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх, эрхээ хамгаалуулах нөхцөлийг бодитоор бүрдүүлэх.

5.4. Хүний нөөц, асран хамгаалагчдын чадавх, эрхийн баталгааг хангах

5.4.1. Багш, ажилтнуудыг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасан илүү цагийн хөлсийг хуульд нийцүүлэн олгох;

5.4.2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 11.1-д заасны дагуу багш, ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хууль ёсны эрх ашгаа хамгаалах Үйлдвэрчний эвлэлийг байгуулах, хэвийн ажиллах нөхцөлийг хангах;

5.4.3. Байгууллагад сэтгэл зүйчийн орон тоо бий болгох, эсхүл багш, ажилтнуудад сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэгийг тогтмол үзүүлэх асуудлыг судлан, бодитойгоор шийдвэрлэх.


ЗУРГАА. ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ-ҮНЭЛГЭЭ, ҮР ДҮНД АХИЦ ДЭВШИЛ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн эрсдэл, зөрчил, тогтолцооны доголдлыг арилгах, хүүхдийн эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зүгээс хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад холбогдох зөвлөмжүүдийг хүргүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

6.1. Зөвлөмжийн хэрэгжилтийн түвшний үнэлгээ

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний дүнд илэрсэн нөхцөл байдалд үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлсэн. Энэхүү бүлэгт тухайн зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээг байгууллагуудаас ирүүлсэн тайлан, нотлох баримт, газар дээрх ажиглалт, ярилцлага, асуумжийн мэдээлэлтэй тулган нэгтгэн дүгнэв.

Үнэлгээний дүнгээр:



Эдгээр гурван байгууллагад өгсөн зөвлөмжийн биелэлт хэрэгжих шатанд байна гэж үнэлэгдлээ.

Хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил, эрсдэл нь байгууллагын дотоод зохион байгуулалт, хүний нөөцийн хүрэлцээ, дэд бүтэц, үйлчилгээний чанар, хүүхэд хамгааллын зохицуулалттай холбоотой байсан тул зөвлөмжүүд нь эдгээр асуудлыг шат дараатайгаар сайжруулах, хүний эрхэд суурилсан хандлагыг бэхжүүлэхэд чиглэсэн болно.

Зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг үнэлэхэд зарим байгууллагад амьдрах орчин, аюулгүй байдлыг сайжруулах, дотоод журам, зохион байгуулалтыг шинэчлэх, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан байна. Тухайлбал, барилга байгууламжийн засвар, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, шөнийн хяналтыг эрчимжүүлэх, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд аюулгүй байдлын нэмэлт зохицуулалт хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тохиолдлууд ажиглагдав.

Гэсэн хэдий ч зөвлөмжийн хэрэгжилт байгууллага хооронд харилцан адилгүй, зарим тохиолдолд хэсэгчлэн хэрэгжсэн, эсхүл бодит үр дүнд хүрээгүй хэвээр байна. Ялангуяа хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн болон тусгай мэргэжлийн дэмжлэгийг тогтмолжуулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг асуудалд ахиц хангалтгүй байна.

Мөн хүүхдийн санал, гомдол гаргах эрхийг бодитоор хэрэгжүүлэх механизм, нууцлал, хамгаалалтын баталгааг хангах зохион байгуулалт бүрэн төлөвшөөгүй хэвээр байгаа нь зүй бус харьцаа, үл хайхрах, хүчирхийллийн шинжтэй нөхцөл байдал илрэх эрсдэлийг бууруулахад саад болдог. Зарим байгууллагад зөвлөмжийн хэрэгжилтийг баримтжуулах, дотоод хяналтаар тогтмол үнэлэх тогтолцоо сул байгаа нь хэрэгжилтийн үр дүнг бодитоор хэмжихэд хүндрэлтэй.

Нийт дүнгээр авч үзвэл, хүргүүлсэн зөвлөмжүүд нь хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөв, шаардлагатай арга хэмжээ байсан боловч тэдгээрийн хэрэгжилт нь байгууллагын дотоод нөөц, санхүүжилт, мэргэжлийн чадавх, салбар хоорондын уялдаанаас ихээхэн хамаарч, тогтвортой, жигд хэрэгжих түвшинд хараахан хүрээгүй байна.

Иймд зөвлөмжийн хэрэгжилтийг үр дүнд хүргэхийн тулд зөвхөн байгууллагын түвшинд бус, салбарын бодлого, санхүүжилт, хүний нөөцийн төлөвлөлттэй уялдуулан, дэмжих, хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

6.2. Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд гарсан бодит үр дүн

ЭШУС үндэсний ажиллагаанаас хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлээр бодит ахиц, эерэг өөрчлөлтүүд гарч байна. Тухайлбал:

| № | Чиглэл | Хийсэн ажил | Үр дүн / Сайжруулалт |
|----|------------------------|---|---|
| 1 | Орчны аюулгүй байдал | Өрөө, тасалгаа, коридор, соёлын танхимд иж бүрэн урсгал засвар хийсэн | Эрүүл ахуй, аюулгүй орчин бүрдсэн |
| 2 | Сургалт, хөгжил | 53 компьютер, 3 принтер хүлээн авч компьютерын танхим байгуулсан | Бүх хүүхэд цахим сургалтад тогтмол хамрагдах боломжтой болсон |
| 3 | Стандарт хэрэгжилт | Гадна, дотоод орчны урсгал засварыг жил бүр тогтмол хийдэг болсон | Үйлчилгээний стандарт хангагдсан |
| 4 | Хүний эрхийн хамгаалал | Ялгаварлан гадуурхалт, хүнлэг бус харьцааны гомдлыг тухай бүр шалгуулдаг болсон | Хариу арга хэмжээ авах тогтолцоо сайжирсан |
| 5 | Мэдээлэх сувгууд | Өргөдөл, гомдол хүлээн авах сувгуудыг тогтмол шалгаж хэвшсэн | Хүүхэд, ажилтнуудын эрхээ хамгаалах ойлголт нэмэгдсэн |
| 6 | Хүүхэд хамгаалал | Аюулгүй байдлын мэдээлэх хайрцгийг бүх нэгжид байршуулсан | Эрсдэлийг эрт илрүүлэх боломж бүрдсэн |
| 7 | Хяналт, аюулгүй байдал | Камерын тоо, хамрах хүрээ, хадгалалтыг сайжруулсан | Хяналтын чанар дээшилсэн |
| 8 | Эрүүл ахуй | Хоолны дээж авалт, хадгалалт, устгалд өдөр тутмын хяналт хийдэг болсон | Хоолны аюулгүй байдал хангагдсан |
| 9 | Урьдчилан сэргийлэлт | Хууль, журам, мэдээлэх сувгийн самбар байршуулсан | Эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн |
| 10 | Хувийн орон зай | Охидын ариун цэврийн өрөөг найдвартай цоож, түгжээгээр хангасан | Хувийн орон зай, хамгаалалт сайжирсан |

6.3. Ахиц дэвшил, эерэг өөрчлөлт

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, түүнд үндэслэн хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ахиц, эерэг өөрчлөлт ажиглагдсан.

Зарим байгууллагад амьдрах орчин, аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд засвар, тохижилтын ажил хийж, ариун цэврийн өрөө, угаалгын орчныг нэмэгдүүлэх, хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэж болзошгүй хэсгүүдэд хамгаалалтын нэмэлт шийдэл хэрэгжүүлсэн нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад бодит ахиц болсон байна.

Хүүхдийн асаргаа, халамж, хамгааллын үйлчилгээний зохион байгуулалтад хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх чиглэлээр дотоод журам, үйл ажиллагааны зохицуулалтыг шинэчлэх, ажилтнуудад чиглэсэн сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах, хүүхэдтэй харилцах харилцааны соёлыг сайжруулах оролдлого зарим байгууллагад бодитоор хэрэгжиж эхэлсэн нь эерэг өөрчлөлт гэж үнэлэгдэв.

Мөн хүүхдийн оролцоог хангах, санал бодлыг нь сонсох зорилгоор хүүхдийн зөвлөл, бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлагын хэлбэрийг ашиглах, өдөр тутмын үйл ажиллагаанд хүүхдийн санал тусгах оролдлого хийж эхэлсэн байгууллагууд байна.

Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хувьд зарим байгууллага сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж, хүүхдийг тогтмол үзлэг, хяналтад хамруулах, сургалтын хоцрогдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч эхэлсэн нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлж байна.

Түүнчлэн зарим байгууллагад дотоод хяналтын зохион байгуулалтыг сайжруулах, баримтжуулалтыг нэмэгдүүлэх, илэрсэн асуудалд шуурхай хариу арга хэмжээ авах оролдлого гарч эхэлсэн нь зүй бус харьцаа, үл хайхрах шинжтэй нөхцөл байдал давтагдахаас урьдчилан сэргийлэхэд чухал алхам болсон.

Гэсэн хэдий ч дээрх ахиц, эерэг өөрчлөлт нь байгууллага бүрд жигд хэрэгжиж амжаагүй, тогтвортой тогтолцоо болон хэвшээгүй байгааг анхаарах шаардлагатай. Иймд гарч буй эерэг туршлага, ахиц дэвшлийг тогтвортой хадгалах, бусад байгууллагад түгээн дэлгэрүүлэх, бодлогын болон зохион байгуулалтын түвшинд дэмжих нь цаашдын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ач холбогдолтой байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

1. Хүүхдийн асаргаж, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнгээс харахад хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарч байгаа боловч үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.
2. Хүүхдийн асаргаж, халамжийн байгууллагуудын санхүүжилт нь улсын төсөв, олон улсын болон төрийн бус байгууллага, хувь хүний хандив зэрэг олон эх үүсвэрээс бүрдэж, байгууллага хооронд жигд бус байдалтай байна. Энэхүү нөхцөл байдал нь хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааны чанар, хүртээмжид ялгаатай байдал үүсгэх эрсдэлийг бий болгож болзошгүй.
3. Хүүхдийн аюулгүй, хүнлэг орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, доромжлох, ялгаварлан гадуурхах, бие махбодын болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай. Хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүүхдийн нэр төр, хувийн орон зай, нууцлалыг хүндэтгэх зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй.
4. Хүүхдийн санхүүгийн эрхийг хамгаалах хүрээнд мөнгөн тэтгэмж,

хадгаламж, гарт олгох мөнгөний зохицуулалтыг ил тод, хүүхдийн эрх ашигт нийцсэн байдлаар хэрэгжүүлэх асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Энэ нөхцөл байдал нь хүүхдийг насанд хүрсний дараа бие даан амьдрахад шаардлагатай санхүүгийн мэдлэг, хариуцлагатай хэрэглээний дадал төлөвшихөд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож болзошгүй.

5. Боловсрол, хөгжлийн үйлчилгээний хүртээмж, чанар хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хувьд харилцан адилгүй байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх мэргэжлийн дэмжлэг, тусгай үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн үйлчилгээ тэгш хүрэх зарчим алдагдах эрсдэлийг бий болгож байна.
6. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, мөн Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагаас насанд хүрч гарч буй хүүхдүүдэд орон байр, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогын уялдаа сул байгаа нь хүүхдийн ирээдүйн амьдрал, нийгэмд дасан зохицоход сөргөөр нөлөөлөх магадлалтай.
7. Хүүхдийн эрхийг хамгаалах асуудал нь зөвхөн тухайн байгууллагын дотоод зохион байгуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд олон нийтийн хандлага, хэвлэл мэдээлэл болон цахим орчин дахь хүүхдийн дүрслэл, хандлагатай нягт холбоотой байна. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад амьдарч буй хүүхдүүдийг гутаан доромжлох, нэр хоч өгөх, шошголох, ялгаварлан гадуурхах хандлага оршсоор байгаа нь хүүхдийн нэр төр, сэтгэл зүйн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг нь ажиглагдсан.
8. Эрсдэлт нөхцөлөөс ирсэн хүүхдүүдтэй ажиллаж буй ажилтнуудын мэргэжлийн чадавх, арга зүйн дэмжлэгийг тасралтгүй үзүүлдэг байх, холбогдох сургалт, мэргэжлийн зөвлөгөөнд тогтмол хамруулах шаардлага байгаа нь хяналт шинжилгээний дүнгээс харагдаж байна.
9. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд байгууллагын дотоод зохион байгуулалт, ажилтнуудын хандлагаас гадна төрийн бодлого, тогтмол олгох санхүүжилт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах шаардлагатай. Цаашид өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг тууштай хангаж, бодит өөрчлөлт гаргаж ажиллах нь хүүхдийн эрхийг бүрэн хангах үндсэн нөхцөл болно.

01.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд нийт 12 байгууллага хамрагдсан. Үүнд: Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын "Хүүхдийн төв", "Залуучуудын төв", "Монголын СОС хүүхдийн хотхон", "Дон Боско", "Бадамлянхуа", "Цөлийн сарнай", "Мишээл" хүүхдийн төвийн 1 салбар, "Гэрэл" хүүхдийн төв, "Вербист" хүүхдийн асрамжийн төв, "Шинэ найдвар" хүүхдийн асрамжийн төв, "Монголын хүүхдийн сан" хүүхдийн асрамж, халамжийн байгууллага, "Анна хоме" хүүхдийн асрамж, халамжийн байгууллага, Хүүхдийн төв сувиллын "Солонго" тасаг.

02.

АСУУМЖ, ЯРИЛЦЛАГА

Судалгааны хүрээнд нийт 98 хүүхэд, 49 багш, ажилтныг хамруулан асуумжийн судалгааг зохион байгуулсан. Үүнээс гадна судалгааны үр дүнг гүнзгийрүүлэн шинжлэх, оролцогчдын санал бодол, туршлага, хандлагыг илүү нарийвчлан тодорхойлох зорилгоор 46 хүүхэд, 27 багш, ажилтныг хамруулан ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

03.

ЗӨВЛӨМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Асуудал эрхэлсэн гишүүний холбогдох байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр А/03 дугаар аргачлалын хүрээнд үнэлэв. Үнэлгээний дүнгээр Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор (70.0 хувь), "Монголын СОС хүүхдийн хотхон" (81.0 хувь), "Анна хоме" хүүхдийн асрамж, халамжийн байгууллага (80.0 хувь) зэрэг гурван байгууллагад өгсөн зөвлөмжийн биелэлт хэрэгжих шатанд байна гэж үнэлэгдлээ.

04.

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

"Монголын СОС хүүхдийн хотхон" хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд болон төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. Асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд, багш, ажилтнуудад тулгамддаг асуудал, хүндрэл, бэрхшээл тэдгээрийг даван туулах аргачлал, өөрийн болон бусдын эрхийг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлэх арга замуудын талаарх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан.

05.

ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ

Хүүхэд, залуусын амьдарч буй орчинд иж бүрэн урсгал засвар хийж, аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулан, стандарт, шаардлагын дагуу дотоод болон гадаад орчны засварыг жил бүр тогтмол хийх тогтолцоо бүрдүүлсэн. Төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгээр сургалт, хөгжлийн хэрэгцээнд зориулсан компьютерын танхим байгуулж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Камерын хяналт, хоол хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулсан, мөн хүний эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдол, мэдээллийг шийдвэрлэх, мэдээлэх сувгуудын ойлголт, хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2.5. АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСРАМЖИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь насжилт, эрүүл мэндийн байдал, бие даан амьдрах чадвар буурах, байнгын асаргаа, сувилгаанд хамааралтай болох зэрэг онцлогоос шалтгаалан хүний эрх зөрчигдөх өндөр эрсдэлтэй, эмзэг бүлэгт хамаардаг. Ялангуяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамж, халамжийн байгууллагад байнга болон урт хугацаагаар байрлан амьдарч байгаа тохиолдолд тэдний амьдрах орчин, асаргаа сувилгааны чанар, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүний нэр төр, хувийн халдашгүй байдал, бие даан шийдвэр гаргах эрхийг бодитоор хангах асуудал онцгой ач холбогдолтой.

Асрамж, халамжийн үйлчилгээ нь нийгмийн халамжийн шинжтэй байхаас гадна хүний эрхэд суурилсан, хүн төвтэй хандлагад тулгуурласан байх шаардлагатай. Гэвч асрамжийн байгууллагад байршсан иргэдийн хувьд тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, хүний нөөцийн хүрэлцээ, үйлчилгээний чанар, хяналтын тогтолцоо хангалтгүй байснаас хүний эрх зөрчигдөх, үл хайхрах шинжтэй нөхцөл үүсэх, улмаар эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах эрсдэл бодитоор бий болох нөхцөл бүрддэг.

Монгол Улсад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөлжсөн асрамжийн үйл ажиллагаа чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг 8, зардлын нормативтай 1, олон улсын байгууллагын санхүүжилттэй 2, нийт 12 асрамжийн төв явуулж байна. Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдээс 475 нь эрэгтэй, 175 нь эмэгтэй, 234 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна⁴⁵.

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд асрамж, халамжийн байгууллагад хийж буй урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ нь хүний эрх зөрчигдөхөөс өмнө илэрч буй тогтолцооны шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг арилгуулахад чиглэдэг бөгөөд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах үйлдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх үндсэн зорилготой.

Энэхүү тайлан нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан чиг үүргийн хүрээнд 2025 онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулав.

Тайланд тусгасан дүгнэлт, үнэлгээ нь газар дээрх ажиглалт, баримт бичгийн судалгаа, асруулагч болон ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлага,

45 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025). Хүүхдийн асрамж, халамжийн байгууллага.

асуумжийн мэдээлэлд тулгуурласан бөгөөд асрамж, халамжийн байгууллагад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бодит нөхцөл, эрсдэлийг тодорхойлох зорилготой.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД



ЭШУС үндэсний ажиллагаанаас 2025 онд улсын хэмжээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг зохион байгуулан хэрэгжүүлэв.

Хяналт шинжилгээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнга болон урт хугацаагаар асран хамгаалж, байршуулан үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрх зөрчигдөхөөс өмнө илэрч буй эрсдэл, тогтолцооны шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, улмаар тэдгээрийг арилгуулахад чиглэсэн болно.

Хяналт шинжилгээг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-д заасан зарчим, шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу хэрэгжүүлж, газар дээрх ажиглалт, баримт бичгийн судалгаа, асруулагч болон ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлага, асуумжийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээ хийв.

2.1. Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагын жагсаалт

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд 2025 онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй дараах төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдав.

Хүснэгт 38

| № | Байгууллагын нэр | Байршил | Эрх зүйн хэлбэр |
|---|---|-----------------|-----------------|
| 1 | Ахмад настны үндэсний төв | Улаанбаатар хот | Төрийн |
| 2 | Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төв | Хэнтий аймаг | Төрийн |

| | | | |
|---|---|------------------|------------|
| 3 | Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв | Ховд аймаг | Төрийн |
| 4 | Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Ахмад настны асрамжийн төв | Баян-Өлгий аймаг | Төрийн |
| 5 | “Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газар | Улаанбаатар хот | Төрийн бус |

2.2. Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагуудын ерөнхий мэдээлэл

Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагууд нь эрх зүйн хэлбэр, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, асруулагчдын бүтэц, хүний нөөц, дэд бүтэц, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. Иймд байгууллага тус бүрийн ерөнхий мэдээллийг тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн үзүүлэлтээр дараах байдлаар нэгтгэн харуулав.

Ахмад настны үндэсний төвийн ерөнхий мэдээлэл:

Хүснэгт 39

| Үзүүлэлт | Мэдээлэл |
|----------------------------|---|
| Эрх зүйн хэлбэр | Төрийн байгууллага |
| Үйлчилгээний үндсэн төрөл | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд байнгын асрамж, сувилгаа, сэргээн засах үйлчилгээ |
| Хамрах хүрээ | Улсын хэмжээнд |
| Асруулагчдын ангилал | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, олон хавсарсан өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай иргэд |
| Асрамжийн хугацаа | Урт хугацааны, байнгын |
| Хүчин чадал, бодит ачаалал | Батлагдсан хүчин чадлын хүрээнд, байнгын дүүргэлттэй |
| Хүний нөөцийн бүтэц | Захиргаа, сувилахуйн төв, эмнэлгийн тусламж үйлчилгээ, асаргаа сувилгаа, дэмжих үйлчилгээ |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | Дотоод эмнэлгийн нэгж, гуравдугаар шатлалын байгууллагад шилжүүлэн үзүүлэх зохицуулалттай |
| Дэд бүтэц, орчны онцлог | Олон байр, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэцтэй |
| Онцлог эрсдэл | Сэтгэцийн тулгамдсан асуудалтай асруулагчдыг төрөлжүүлэн байрлуулах зохицуулалт хангалтгүй |

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн ерөнхий мэдээлэл:

Хүснэгт 40

| Үзүүлэлт | Мэдээлэл |
|---------------------------|---|
| Эрх зүйн хэлбэр | Төрийн байгууллага |
| Үйлчилгээний үндсэн төрөл | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд байнгын асрамж |
| Хамрах хүрээ | Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймаг |
| Асруулагчдын насны бүтэц | 53-100 нас |
| Хүчин чадал | 24 ор |
| Бодит байршсан асруулагч | Хяналт шинжилгээний үед 20 иргэн |
| Хүний нөөц | Менежер, нийгмийн ажилтан, бага эмч, асрагч, тогооч |
| Шөнийн зохион байгуулалт | Шөнийн цагаар ганц асрагч ажилладаг |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | Өрхийн эмчийн сар бүрийн үзлэг, аймгийн эмнэлэгт шилжүүлэх |
| Дэд бүтцийн нөхцөл | Төвлөрсөн халаалтгүй |
| Онцлог эрсдэл | Шөнийн хяналт, хүний нөөцийн хүрэлцээ, аюулгүй байдлын баталгаа сул |

**Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа:
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн ерөнхий мэдээлэл**

Хүснэгт 41

| Үзүүлэлт | Мэдээлэл |
|----------------------------|---|
| Эрх зүйн статус | Бие даасан регистргүй, ХХҮГ-ын харьяа нэгж |
| Үйлчилгээний үндсэн чиглэл | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, нөхөн сэргээх үйлчилгээ |
| Хамрах хүрээ | Баруун бүс |
| Байр, дэд бүтэц | Анх 100 ортой зориулалтын барилгаас нэг жигүүрийг ашиглаж байгаа |
| Асруулагчдын ангилал | Тулгуур эрхтэн, саа саажилт, хараа, сонсгол, сэтгэцийн эмгэгтэй иргэд |
| Хүний нөөц | Асаргаа, сувилгаа, нөхөн сэргээх чиглэлийн хязгаарлагдмал бүрэлдэхүүн |

| | |
|----------------------|---|
| Санхүүжилтийн нөхцөл | Орон нутгийн төсөв, санхүүгийн зохицуулалтын хүндрэлтэй |
| Тээврийн хэрэгсэл | Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлгүй |
| Зуны байрлал | Зуслангийн зориулалтын бус гэр ашигладаг |
| Онцлог эрсдэл | Эрх зүйн статус, орон байр, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж |

**Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа:
Ахмад настны асрамжийн төвийн ерөнхий мэдээлэл**

Хүснэгт 42

| Үзүүлэлт | Мэдээлэл |
|----------------------------|---|
| Эрх зүйн хэлбэр | Төрийн байгууллага |
| Үйлчилгээний үндсэн төрөл | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ |
| Хамрах хүрээ | Баян-Өлгий аймгийн хэмжээнд |
| Асруулагчдын ангилал | Асран хамгаалагчгүй ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд |
| Асрамжийн хугацаа | Урт хугацааны, байнгын |
| Хүчин чадал, бодит ачаалал | Батлагдсан хүчин чадлын хүрээнд |
| Хүний нөөцийн бүтэц | Захиргаа, асаргаа халамжийн ажилтан, сувилахуйн болон дэмжих үйлчилгээний ажилтнууд |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | Асруулагчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллагад хандуулах зохицуулалттай |
| Дэд бүтэц, орчны онцлог | Бүгд Найрамдах Түрк Улсын “ТИКА” төслийн санхүүжилтээр 2022 онд 45 мянган ам.долларын өртөгтэй тавилга, тоног төхөөрөмж, цахилгаан бараа, чийрэгжүүлэх танхимын төхөөрөмжөөр шинэчлэгдсэн; гадаад орчинд зүлэгжүүлэлт, жимсний мод тарьсан; эко бие засах өрөө барих талбай бэлтгэсэн |
| Онцлог эрсдэл | Шөнийн хяналт, аюулгүй байдлын баталгаа сул |

“Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газар - ерөнхий мэдээлэл:

Хүснэгт 43

| Үзүүлэлт | Мэдээлэл |
|-----------------------------|---|
| Эрх зүйн хэлбэр | Төрийн бус байгууллага |
| Байгуулагдсан он | 2009 |
| Үйлчилгээний үндсэн төрөл | Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай иргэдэд байнгын асрамж |
| Хамрах хүрээ | Улаанбаатар хот болон зарим аймаг |
| Асруулагчдын нас | 22-74 нас |
| Асруулагчдын онцлог | Сэтгэцийн болон олон хавсарсан оноштой иргэд зонхилно |
| Байрны нөхцөл | Түрээсийн, элэгдэл ихтэй барилга |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | Гэрээт эмнэлэгтэй хамтран ажилладаг |
| Аюулгүй байдлын зохицуулалт | Зарим үед хаалга цоожлох шаардлага үүсдэг |
| Хүний нөөцийн ачаалал | Асрагчдын бие махбод, сэтгэл зүйн ачаалал өндөр |
| Онцлог эрсдэл | Орчны аюулгүй байдал, хүч хэрэглэсэн байж болзошгүй кейс |

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1. Ахмад настны үндэсний төвд хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал



Ахмад настны үндэсний төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тус төвд байрлан амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин, асаргаа сувилгааны чанар, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүний нөөцийн зохион байгуулалт, дотоод хяналтын тогтолцоо, хүний эрхийн баталгааны бодит хэрэгжилттэй холбоотой дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

3.1.1. Амьдрах орчин, хүртээмж, аюулгүй байдлын нөхцөл



Хяналт шинжилгээгээр Ахмад настны үндэсний төвийн зарим байр, тасаг, өрөө тасалгаанд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, онцлогт бүрэн нийцээгүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын шаардлага хангагдаагүй нөхцөл илэрсэн. Тухайлбал, асруулагчдын амьдрах өрөө, ариун цэврийн өрөө, угаалгын хэсгийн зохион байгуулалт нь тэргэнцэртэй, хөдөлгөөн хязгаарлагдмал иргэдэд ашиглахад хүндрэлтэй, хүртээмжийн шийдэл дутмаг байв.



Мөн зарим байр, өрөө тасалгаанд чийгшил, агааржуулалт, дулаан хадгалалтын асуудал байсаар байгаа нь ахмад настнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, архаг өвчнийг сэдэрэх, халдварт өвчин тархах эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл болж байна. Галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж, дохиоллын системийг суурилуулсан боловч байршил, хүртээмжийн хувьд ахмад настанд ойлгомжтой, ашиглахад хялбар байдал хангалтгүй байгааг тогтоов.

Сэтгэцийн эмгэг, сэтгэцийн тулгамдсан асуудалтай асруулагчдыг бусад ахмад настнаас тусгаарлан, төрөлжүүлэн байрлуулах зохицуулалт бүрэн хангагдаагүй байгаа нь асруулагчдын хооронд үл ойлголцол, маргаан, бие махбодын болон сэтгэл зүйн дарамт үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэ нь хүний нэр төр, халдашгүй байдлыг хангах баталгаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал гэж үнэлэгдэв.

3.1.2. Эрүүл мэндийн тусламж, асаргаа сувилгааны үйлчилгээ

Ахмад настны үндэсний төвд асруулагчдын эрүүл мэндийн анхан шатны хяналт, сувилахуйн үйлчилгээ тогтмол явагддаг боловч олон хавсарсан өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай ахмад настнуудын хэрэгцээтэй харьцуулахад эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал хангалтгүй байна.



Асруулагчдыг гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагад нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулах зохицуулалт байгаа хэдий ч тээвэрлэлтийн нөхцөл, хүний нөөцийн хүрэлцээ, санхүүжилтийн асуудлаас шалтгаалан бүх асруулагчийг цаг тухайд нь хамруулах боломж хязгаарлагдмал байгааг тогтоов. Энэ нь өвчнийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжийг хязгаарлаж байна.



Асаргаа, сувилгааны үйлчилгээ үзүүлж буй асрагч, сувиллагчдын ажлын ачаалал өндөр, нэг ажилтанд ноогдох асруулагчдын тоо их байгаа нь асруулагч бүрд анхаарал хандуулах, хүнлэг харьцааг тогтвортой хадгалах нөхцөлийг алдагдуулах эрсдэлтэй байна. Хяналт шинжилгээний явцад асруулагчдын зүгээс “ажилтнууд завгүй, асаргаа удааширдаг” гэх агуулгатай санал, гомдол илэрч байв.



3.1.3. Хүний нөөц, ажиллах нөхцөл, чадавх

Ахмад настны үндэсний төвийн хүний нөөц нь батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байгаа боловч бодит ачаалал, асруулагчдын эрүүл мэндийн байдал, асаргаа сувилгааны хэрэгцээтэй бүрэн уялдаагүй байна. Ялангуяа асаргаа, сувилгааны чиглэлээр ажиллаж буй ажилтнуудын илүү цаг, шөнийн ээлжийн ачаалал өндөр байгаа нь ядаргаа, сэтгэл зүйн туйлдалд орох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Ажилтнуудын мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх сургалт, урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдлэг олгох ажил тодорхой хэмжээнд зохион байгуулагддаг боловч эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий харьцаанаас урьдчилан сэргийлэх, ахмад настны онцлог хэрэгцээнд суурилсан харилцааны ур чадварыг тогтвортой хөгжүүлэх сургалтын тогтолцоо хангалтгүй байна.

3.1.4. Дотоод хяналт, гомдол мэдээлэл гаргах боломж

Асруулагчид болон тэдний ар гэрээс гомдол, санал хүсэлт гаргах дотоод журам, саналын хайрцаг байршуулсан боловч асруулагчдын нас, эрүүл мэнд, боловсролын түвшин, сэтгэцийн байдалтай уялдуулан гомдол мэдээлэл гаргах бодит, аюулгүй, нууцлалтай механизм бүрэн хэрэгжиж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Ганцаарчилсан ярилцлагын үеэр зарим асруулагч “гомдол гаргавал асаргаа муудна” гэх болгоомжлол илэрхийлсэн нь тухайн байгууллага асруулагчийн эрхийг зөрчиж болзошгүй эрсдэлтэй гэж үзэв.

3.1.5. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилттэй уялдах нөхцөл байдал

Ахмад настны үндэсний төвд 2024 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүргүүлсэн зөвлөмжийн зарим нь хэрэгжсэн боловч дэд бүтэц, хүний нөөц, төрөлжсөн асаргаатай холбоотой суурь асуудлууд бүрэн шийдэгдээгүй хэвээр байна. Энэ нь зөвлөмжийн хэрэгжилт нь байгууллагын дотоод нөөц бололцоогоор хязгаарлагдаж, бодлого, санхүүжилтийн түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудал байсаар байгааг илтгэж байна.

Ахмад настны үндэсний төвд тогтоогдсон нөхцөл байдлыг дүгнэн харуулбал:

Хүснэгт 44

| Чиглэл | Тогтоогдсон нөхцөл | Эрхийн эрсдэл |
|------------------|---|-----------------------------------|
| Амьдрах орчин | Хүртээмж, чийгшил, аюулгүй байдлын асуудал | Аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрх |
| Эрүүл мэнд | Үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал хангалтгүй | Эрүүл мэндийн тусламж авах эрх |
| Асаргаа сувилгаа | Ажилтны ачаалал өндөр | Хүнлэг харьцааны баталгаа |
| Хүний нөөц | Чадавх, сургалтын тогтолцоо сул | Үл хайхрах эрсдэл |
| Гомдол мэдээлэл | Механизм бодитой бус | Гомдол гаргах эрх |

3.2. Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин, асаргаа сувилгааны зохион байгуулалт, хүний нөөц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, аюулгүй байдлын баталгаатай холбоотой дараах нөхцөл байдал илэрлээ.



3.2.1. Амьдрах орчин, аюулгүй байдлын нөхцөл

Тус төв нь төвлөрсөн халаалтын системгүй, орчны нөхцөл нь улирлын чанартайгаар ихээхэн хамааралтай байгаагаас өвлийн улиралд дулаан алдагдах, халаалтын аюулгүй байдлын эрсдэл үүсэх нөхцөл ажиглагдсан. Асруулагчдын амьдрах өрөө, ариун цэврийн өрөө нь ахмад настны насжилт, хөдөлгөөний хязгаарлалттай байдлыг бүрэн харгалзсан хүртээмжийн шийдэл дутмаг байв.



Мөн галын аюулгүй байдлын дохиолол, анхааруулах тэмдэг, ослын үед нүүлгэн шилжүүлэх зохион байгуулалт нь ахмад настанд ойлгомжтой, бодит хэрэгжилттэй түвшинд бүрэн хүрээгүй байна. Энэ нь гэнэтийн осол, аюулын үед асруулагчдын аюулгүй байдлыг хангах баталгааг сулруулж байна.



3.2.2. Хүний нөөц, шөнийн зохион байгуулалт

Хяналт шинжилгээгээр шөнийн цагаар тус төвд ганц асрагч ажилладаг, харуул хамгаалалтын тусгай зохицуулалтгүй байгааг тогтоов. Асруулагчдын нас, эрүүл мэндийн байдал, шөнийн цагт гэнэт бие нь муудах, унах, осолдох эрсдэлийг харгалзан үзвэл энэхүү зохион байгуулалт нь асруулагчдын аюулгүй байдлыг хангахад хангалтгүй байна.



Ажилтнуудын ажлын ачаалал өндөр, илүү цаг тогтмол үүсдэг нь асаргаа сувилгааны чанарт нөлөөлөх, улмаар үл хайхрах шинжтэй нөхцөл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3.2.3. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Асруулагчдыг өрхийн эмчийн үзлэгт сар бүр хамруулдаг боловч ахмад настнуудын архаг өвчин, олон хавсарсан онош, байнгын хяналт шаардлагатай байдалтай харьцуулахад эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал хангалтгүй байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлэх тохиолдолд тээвэр, хүний нөөц, санхүүжилтийн асуудлаас шалтгаалан цаг алдах нөхцөл байгааг тогтоов.

3.2.4. Гомдол, мэдээлэл гаргах боломж

Асруулагчид гомдол, санал хүсэлт гаргах талаар тодорхой ойлголттой боловч гомдол гаргасны дараах үр дагавраас болгоомжлох хандлага ажиглагдсан. Энэ нь гомдол мэдээлэл гаргах эрх бодит хэрэгжилтээсээ тасрах, айдастай орчин бүрдэх эрсдэлийг илтгэж байна.

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд тогтоогдсон нөхцөл байдлыг дүгнэн харуулбал:

Хүснэгт 45

| Чиглэл | Тогтоогдсон нөхцөл | Эрхийн эрсдэл |
|--------------------------|---------------------------------------|--------------------------------|
| Орчны нөхцөл | Төвлөрсөн халаалтгүй, хүртээмж дутмаг | Аюулгүй орчинд амьдрах эрх |
| Шөнийн зохион байгуулалт | Ганц асрагч ажилладаг | Амь нас, эрүүл мэндийн эрсдэл |
| Эрүүл мэнд | Үйлчилгээний тасралтгүй байдал сул | Эрүүл мэндийн тусламж авах эрх |
| Гомдол | Айдас, болгоомжлол | Гомдол гаргах эрх |

3.3. Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал



Хяналт шинжилгээгээр тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа боловч эрх зүйн статус, дэд бүтэц, санхүүжилт, хүний нөөц, аюулгүй байдлын баталгаатай холбоотой тогтолцооны шинжтэй дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

3.3.1. Эрх зүйн статус, зохион байгуулалтын нөхцөл



Тус төв нь бие даасан регистрийн дугааргүй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа нэгж байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа нь санхүүгийн ил тод байдал, үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл болж

байна. Энэхүү зохицуулалт нь хүний нөөцийн бүрдүүлэлт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах боломжийг хязгаарлаж байна.

3.3.2. Байр, дэд бүтэц, аюулгүй байдлын нөхцөл

Анх 100 ортой зориулалтын барилгаас нэг жигүүрийг ашиглаж байгаа бөгөөд барилгын элэгдэл, засвар үйлчилгээний дутагдал, орчны хүртээмжийн асуудал байсаар байна. Зуны улиралд зуслангийн зориулалтын бус гэр ашигладаг нь цаг агаарын эрсдэл, аюулгүй байдлын баталгааг сулруулж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлгүйгээс эрүүл мэндийн байгууллагад хүргэх, нөхөн сэргээх үйлчилгээ авахад хүндрэл учирдаг.

3.3.3. Асруулагчдын онцлог, үйлчилгээний хүртээмж

Тус төвд тулгуур эрхтэн, саа саажилт, хараа, сонсгол, сэтгэцийн эмгэгтэй иргэд байрлан амьдарч байгаа бөгөөд тэдний хэрэгцээнд нийцсэн төрөлжсөн асаргаа, нөхөн сэргээх үйлчилгээ хангалтгүй байна. Хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн чадавх дутмаг байгаа нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

3.3.4. Эрсдэл, урьдчилан сэргийлэх баталгааны үнэлгээ

Дээрх нөхцөл байдлууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндийн тусламж авах, хүнлэг харьцаагаар хангагдах эрхийн бодит хэрэгжилтэд тогтвортой эрсдэл үүсгэж байна. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд эдгээр эрсдэлийг бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай гэж үнэлэгдэв.

Ховд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдлыг дүгнэн харуулбал:



| Чиглэл | Тогтоогдсон нөхцөл | Эрхийн эрсдэл |
|-----------------|-------------------------------|-------------------------------------|
| Эрх зүйн статус | Бие даасан бус | Үйлчилгээний тогтвортой байдал |
| Дэд бүтэц | Элэгдэл, зориулалтын бус байр | Аюулгүй орчинд амьдрах эрх |
| Тээвэр | Тусгай тээврийн хэрэгсэлгүй | Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж |
| Хүний нөөц | Чадавх, хүрэлцээ сул | Хүнлэг харьцааны баталгаа |

3.4. “Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газарт хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал



“Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тус байгууллагад байрлан амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин, аюулгүй байдлын зохицуулалт, асаргаа сувилгааны чанар, хүний нөөцийн ачаалал, хүний эрхийн баталгаатай холбоотой дараах нөхцөл байдал тогтоогдлоо.



3.4.1. Байр, орчны нөхцөл, аюулгүй байдал

Тус асрамжийн газар нь түрээсийн зориулалттай, элэгдэл ихтэй барилгад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд барилгын хийц, орчны зохион байгуулалт нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, аюулгүй байдлын шаардлагад бүрэн нийцээгүй байна. Хяналт шинжилгээгээр зарим өрөө тасалгаанд чийгшил, мөөгөнцөр үүссэн, дулаан хадгалалт жигд бус, шал гулгамтгай зэрэг нөхцөл илэрсэн нь асруулагчдын унах, бэртэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.



Мөн галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж, анхааруулах дохиолол, ослын

үед нүүлгэн шилжүүлэх зохион байгуулалт нь байнгын асрамжийн байгууллагын стандартын шаардлагыг бүрэн хангахгүй, бодит нөхцөлд хэрэгжих боломж хязгаарлагдмал байгааг тогтоов.

3.4.2. Асруулагчдын онцлог, асаргаа сувилгааны нөхцөл

Асрамжийн газарт байрлаж буй иргэдийн дийлэнх нь сэтгэцийн эмгэг, сэтгэцийн тулгамдсан асуудал, олон хавсарсан оноштой, байнгын асаргаа шаардлагатай байгаа нь асаргаа сувилгааны ажлыг өндөр ачаалалтай болгож байна. Гэвч асаргаа сувилгааны үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын тоо, мэргэжлийн чадавх нь асруулагчдын бодит хэрэгцээтэй бүрэн уялдаагүй байна.

Асруулагчид өдөр тутмын асаргаа, эмийн хэрэглээ, эрүүл мэндийн хяналтад тогтмол хамрагддаг боловч үйлчилгээний тасралтгүй байдал, ялангуяа яаралтай нөхцөлд үзүүлэх хариу арга хэмжээний зохион байгуулалт хангалтгүй байгааг тогтоов.



3.4.3. Хүний нөөц, ажлын ачаалал, үл хайхрах эрсдэл

Асрагч, ажилтнуудын ажлын ачаалал өндөр, шөнийн болон уртасгасан цагийн зохицуулалт тогтворгүй байгаа нь ядаргаа, сэтгэл зүйн тулгамдсан асуудал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэ нь асруулагчидтай хүнлэг харьцах, асаргаа сувилгааны чанарыг тогтвортой хангахад сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байна.

Хяналт шинжилгээний явцад зарим асруулагч болон ажилтнаас авсан ганцаарчилсан ярилцлагын үеэр ажилтанд зодуулсан байж болзошгүй гэх мэдээлэл, бие махбодын гэмтэлтэй холбоотой баримт илэрсэн нь хүний эрхийн ноцтой эрсдэл бодитоор байгааг илтгэнэ. Эдгээр нөхцөл нь эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл гэж үнэлэгдэв.

3.4.4. Гомдол, мэдээлэл гаргах боломж, хяналтын механизм

Асруулагчид болон тэдний ар гэрээс гомдол, мэдээлэл гаргах тодорхой боломжууд байгаа боловч асрамжийн газрын дотоод орчин, харилцааны онцлогоос шалтгаалан гомдол гаргах нь сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй гэх болгоомжлол ажиглагдсан. Энэ нь гомдол мэдээлэл гаргах эрх бодит хэрэгжилтээсээ тасрах, айдастай орчин бүрдэх эрсдэлийг илтгэж байна.

Түүнчлэн төрийн бус байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа онцлогтой холбоотойгоор дотоод хяналт, гаднын хяналтын тогтолцооны уялдаа сул, тогтмол хяналт үнэлгээ хийх механизм хангалтгүй байгааг тогтоов.

| Чиглэл | Тогтоогдсон нөхцөл | Эрхийн эрсдэл |
|------------------|--|-----------------------------------|
| Байр, орчин | Түрээсийн, элэгдэл ихтэй, чийгшилтэй | Аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрх |
| Асаргаа сувилгаа | Олон хавсарсан оноштой асруулагч зонхилно | Хүнлэг харьцааны баталгаа |
| Хүний нөөц | Ачаалал өндөр, сэтгэл зүйн тулгамдсан асуудал үүсэх эрсдэл | Үл хайхрах, хүч хэрэглэх эрсдэл |
| Гомдол | Айдас, болгоомжлол | Гомдол гаргах эрх |
| Хяналт | Дотоод, гаднын хяналтын уялдаа сул | Эрхийн хамгаалалт сулрах |

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Ахмад настны үндэсний төвд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ

Ахмад настны үндэсний төвд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг байгууллагаас ирүүлсэн биелэлтийн тайлан, холбогдох нотломж, газар дээр нь хийсэн ажиглалт, ярилцлага, асуумжийн мэдээлэлтэй тулган үнэлэв. Үнэлгээний дүнгээр зөвлөмжийн хэрэгжилт 70 хувь буюу “хэрэгжих шатанд” гэж үнэлэгдэв.

Зөвлөмжийн зарим заалт хэрэгжсэн хэдий ч ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоосон MNS 5823:2016 стандартын зарим заалт бүрэн хангагдаагүй хэвээр байгаа нь урьдчилан сэргийлэх үүднээс анхаарал шаардсан эрсдэл байсаар байна.

4.2. Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн зөвлөмжийн хэрэгжилт, нэгдсэн үнэлгээ

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс өмнөх жилүүдэд ахмад настны асрамж, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд илэрч буй эрсдэлийг бууруулах зорилгоор бодлогын болон зохицуулалтын түвшинд хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/188, А/190, А/191, А/130 дугаар тушаалаар баталсан холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгааг Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн зүгээс танилцуулсан.

Харин 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх журам” нь байгууллагад хэрэгжилт хангагдаагүй байгаа нь хүний нөөцийн бодит ачаалал, ажлын нөхцөлөөс үүдэх эрсдэлийг тогтоох, улмаар зүй бус харьцаа, үл хайхрах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжийг хязгаарлаж болзошгүй байдал хэвээр байгааг харуулж байна.

Түүнчлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрд хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилт, ахиц дэвшлийг тогтмол хянаж, баримтжуулан ажиллаж хэвшсэн нь асрамж, халамжийн үйлчилгээний чанарыг

сайжруулах, иргэдийн хэрэгцээ, онцлогт нийцсэн дэмжлэг үзүүлэхэд эерэг үр дүн үзүүлж буй сайн туршлага гэж үнэлэгдэв.

Өмнөх жилүүдэд бодлогын болон зохицуулалтын түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, батлагдсан журмуудын хэрэгжилтийг Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн бодит нөхцөл байдалтай харьцуулан үзэхэд, зарим чиглэлд ахиц гарсан боловч хүний нөөц, дэд бүтэц, санхүүжилттэй холбоотой системийн шинжтэй эрсдэл бүрэн арилж амжаагүй байна.

Тус төвд 2025 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн нөхцөл байдал нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнга болон урт хугацаагаар асран хамгаалж буй бүсийн чанартай байгууллагуудад нийтлэг тулгамддаг хүний нөөцийн хүрэлцээ, шөнийн цагийн хяналт, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт, төвлөрсөн халаалт болон барилга байгууламжийн стандарттай холбоотой асуудлууд байгааг харуулж байна.

Эдгээр нөхцөл байдал нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас өмнөх жилүүдэд ахмад настны асрамж, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд илэрч буй эрсдэлд үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон холбогдох төрийн байгууллагад хүргүүлж байсан бодлогын түвшний зөвлөмжүүдтэй агуулгын хувьд уялдаж байна.

Хэдийгээр дээрх зөвлөмжийн дагуу батлагдсан журам, зохицуулалтууд нь асрамж, халамжийн үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулахад тодорхой ахиц гаргасан боловч тэдгээрийн хэрэгжилт нь газар дээрх бодит нөхцөл байдал, хүний нөөцийн хүрэлцээ, санхүүжилт, дэд бүтцийн боломжтой бүрэн уялдахгүй байгаа тохиолдол ажиглагдсан.

Хяналт шинжилгээний дүнд ахмад настны асрамж, халамжийн байгууллагад эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, үл хайхрах нөхцөл үүсэх эрсдэл нь зөвхөн тухайн нэг байгууллагын дотоод зохион байгуулалтаар хязгаарлагдахгүй, харин бүсчилсэн зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцийн бодлоготой шууд уялдсан тогтолцооны шинжтэй асуудал болохыг харуулж байна.

Иймд Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд илэрсэн нөхцөл байдал нь өмнө нь холбогдох яам, байгууллагад хүргүүлсэн бодлогын түвшний зөвлөмжүүдийн оновчтой байдал, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагыг бататгаж буй гэж дүгнэв.

4.3. Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн зөвлөмжийн хэрэгжилт, нэгдсэн үнэлгээ

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс 2023 онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад илэрч буй хүний эрх зөрчигдөх тогтолцооны шалтгаан, нөхцөл, эрсдэлийг бууруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад бодлогын түвшний зөвлөмж хүргүүлсэн. Уг зөвлөмжөөр асрамжийн байгууллагуудын дараах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагыг онцолсон:

- Эрх зүйн статус, санхүүжилтийн тогтолцооны хоёрдмол байдал;
- Үйлчилгээний төрөлжилт хангалтгүй байдал;
- Хүний нөөц, хөдөлмөрийн нөхцөл, нэмэгдэл олголтын хэрэгжилт;

- Асруулагчдын санхүүгийн бие даасан байдлыг хангах зохицуулалт;
- Дэд бүтэц, орчин нөхцөл стандартын шаардлагад нийцэхгүй байдал

зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагыг гишүүний зөвлөмжөөр онцолсон.

Гэвч Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд 2025 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн нөхцөл байдал нь дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилт газар дээрээ бодит нөхцөлтэй бүрэн уялдаж чадаагүй, эрсдэл нөхцөл тогтвортой хадгалагдаж байгааг харуулж байна. Тухайлбал:

- Тус төв нь бие даасан хуулийн этгээдийн регистрийн дугааргүй, санхүүгийн гүйлгээг өөр байгууллагын бүртгэлээр дамжуулан гүйцэтгэж байгаа нь асрамжийн үйлчилгээний тогтвортой байдал, ил тод байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж байна. Энэ нөхцөл байдал нь асрамжийн байгууллагын статус, санхүүжилтийн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагын талаар 2023 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэнэ;
- Мөн зориулалтын бус барилга байгууламж, орон байрны хүрэлцээ, зуны зөөврийн сууцны аюулгүй байдал, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн дутагдал зэрэг нь асруулагчдыг эрүүл, аюулгүй, хүнлэг орчинд амьдрах эрхийг бодитоор хангахад саад учруулж, үл хайхрах шинжтэй нөхцөлөөс үүдэн эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Эдгээр нь 2023 оны зөвлөмжид дурдсан орчны стандарт, аюулгүй байдлыг хангах шаардлага хангалтгүй байна;
- Хүний нөөцийн хүрэлцээ, ажилтнуудын мэргэшүүлэх сургалт, сэтгэцийн эмгэгтэй асруулагчидтай ажиллах тусгай дэмжлэгийн тогтолцоо бүрдээгүй байдал нь асран хамгаалагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, улмаар асруулагчдын нэр төр, хувийн халдашгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байна. Энэ нь асрамжийн байгууллагын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, сайжруулах талаар өмнө хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатайг дахин нотолж байна.

4.4. “Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ

“Бат гэрэлт ирээдүй” асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үр дүнд СХД-ийн Засаг даргад дараах чиглэлийн зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг үнэлсэн. Үүнд:

- Асруулагчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах арга хэмжээ авах;
- Дүүргийн нутаг дэвсгэр дэх асрамж, халамжийн байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулах;
- Шинээр баригдаж буй барилгын явцтай биечлэн танилцаж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;
- Асруулагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай хэрэгцээг тодорхойлон, холбогдох байгууллагад уламжлах.

ТАВ. БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЗӨРҮҮГЭЭС ҮҮДЭХ ЭРСДЭЛ

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №08/17 дугаар зөвлөмжөөр асрамж, халамжийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг бодлого, зохицуулалт болон хэрэгжилтийн түвшинд авч хэрэгжүүлэх талаар тодорхой санал, чиглэлийг дэвшүүлсэн. Тухайлбал, олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг бодитоор хангах, асрамжийн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх бодлогын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргах, мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй асрамжийн газруудын эрх зүйн байдал, статус, санхүүжилтийн бодлогод дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад зөвлөмж болгон хүргүүлсэн.

Гэвч дээрх зөвлөмжийн хүрээнд дэвшүүлсэн зарим зохицуулалт, хэрэгжилтийн бодит үр дүн хангалтгүй хэвээр байгаа нөхцөлд аюулгүй байдлын ноцтой эрсдэл бодитоор илэрсэн тохиолдол гарсан. Тодруулбал, Дорноговь аймгийн Ахмад настны асрамжийн газарт 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр сэтгэцийн эмгэгтэй асруулагч Б нь шөнийн цагаар бусад асруулагчийн өрөөнд нэвтэрч, түлхэж унагаан, хүч хэрэглэсний улмаас амь насыг нь хохироосон ноцтой тохиолдол гарсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/188 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”-ын 2.2.4-т аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн хуудас (арьс өнгө, сэтгэл мэдрэл, архинд донтох өвчингүй байх)-д үндэслэн сэтгэц, мэдрэлийн өвчингүй иргэнийг асрамжийн үйлчилгээнд хамруулахаар зохицуулсан. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд сэтгэцийн эмгэгийн түүхтэй иргэнийг “одоогоор сэтгэцийн өөрчлөлтгүй” гэх тодорхойлолтод үндэслэн асрамжийн газарт шилжүүлэх тохиолдол гарч байгаа нь бодит эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Үүний улмаас хурц хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй асруулагч асрамжийн газрын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, бусдыг хэл амаар доромжлох, хүч хэрэглэх, эд хөрөнгө эвдэх, зохисгүй зан үйл гаргах зэрэг үйлдлүүд илрэх нөхцөл бүрдэж, асруулагч болон ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төрийн баталгаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсэж байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрх, аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтэд тогтолцооны шинжтэй хүндрэл эрсдэл байгааг тогтоов.

1. Асрамжийн газрын байр, орчны нөхцөл стандартын шаардлагад нийцэхгүй, чийгшил, мөөгөнцөр ихтэй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй байгаа нь асруулагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэлийг үүсгэж байна. Ялангуяа байнгын асаргаа шаардлагатай, живх хэрэглэдэг асруулагчдын хувьд ариун цэврийн шийдэл хангалтгүйгээс хүний нэр төр, хувийн халдашгүй байдлын эрх хөндөгдөх нөхцөл бүрддэг.
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд гэрээт эмнэлэгтэй хамтран ажиллаж, эмийн хадгалалт, хамгаалалт зохих шаардлагад нийцсэн нь эерэг боловч сэтгэцийн болон хавсарсан оноштой асруулагчдыг улсын эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэхэд сахиур, хамт асрах хүн шаардагдах зэрэг нөхцөлөөс шалтгаалан тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна. Нас баралтын бүртгэлийг 2025 оноос эхлэн хөтөлж эхэлсэн нь ил тод байдал, хариуцлагын хувьд сайжруулалт боловч тогтвортой хэвшүүлэх шаардлагатай.
3. Ажилтнуудын ачаалал өндөр, шөнийн цагт ганц асрагч ажиллах, харуул хамгаалалтгүй, илүү цаг болон баярын өдрийн нэмэгдлийн асуудал шийдвэрлэгдээгүй зэрэг нь ажилтны ядаргаа, стрессийг нэмэгдүүлж, улмаар асруулагчдын эрх зөрчигдөх эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.
4. Зарим байгууллагын эрх зүйн статус, санхүүжилтийн болон дэд бүтцийн асуудал (регистр, тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх) нь үйлчилгээний чанарын баталгаанд шууд нөлөөлж, олон хавсарсан өвчинтэй, сэтгэцийн эмгэгтэй иргэдийг нэг дор асран хамгаалж буй нөхцөлд аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлдэг.
5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй болон олон хавсарсан өвчтэй иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төрийн хамгааллыг бодитоор хангахын тулд төрөлжсөн асаргаа эмчилгээ асрамж сэргээн засах үйлчилгээ уялдсан шийдлийг бодлогын түвшинд бүрдүүлж, хэрэгжилтийг санхүүжилт, хүний нөөц, дэд бүтцийн төлөвлөлттэй уялдуулах шаардлагатай байна.

01.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас 2025 онд улсын хэмжээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдсан. Үүнд:

- Ахмад настны үндэсний төв
- Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төв
- Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв
- Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Ахмад настны асрамжийн төв
- "Бат гэрэлт ирээдүй" асрамжийн газар

02.

ЗӨВЛӨМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Асуудал эрхэлсэн гишүүний холбогдох байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр А/03 дугаар аргачлалын хүрээнд үнэлэв. Үнэлгээний дүнгээр "Ахмад настны үндэсний төв" (70.0 хувь), СХД-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Бат гэрэлт ирээдүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газрын үйл ажиллагаа, асруулагчдын эрхийн асуудлыг бүх талаар дэмжиж ажиллах тухай зөвлөмжийг дүүргийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмж (85.0 хувь) буюу зөвлөмжийн биелэлт хэрэгжих шатанд байна гэж үнэлэгдлээ.

03.

ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ

Ахмад настны эрхийн хамгаалал сайжирч, АНҮТ-ийн дэргэдэх Сэргээн засах сувиллын байрыг Асрамжийн 2 дугаар байр болгон зохион байгуулж, үйлчлүүлэгчдийг онцлог, хэрэгцээнд нийцүүлэн ангилан байршуулж, амьдрах орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг дээшлүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээт сэтгэл зүйч ажиллуулж, нийт 144 үйлчлүүлэгчийг мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулж, 8 төрлийн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүнд ашиглах 18 ширхэг тоног, төхөөрөмжийг авч эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

04.

АНХААРАХ ТОХИОЛДОЛ

Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд бодит үр дүн хангалтгүй хэрэгжиж буй зарим асуудал байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Ахмад настны асрамжийн газарт 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр сэтгэцийн өвчтэй асруулагч Б нь шөнийн цагаар бусад асруулагчийн өрөөнд нэвтэрч, түлхэж унагаан, хүч хэрэглэсний улмаас амь насыг нь хохироосон аюулгүй байдлын ноцтой тохиолдол гарсан.

05.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн болон олон хавсарсан өвчтэй иргэдийн онцлог, шаардлагыг бүрэн хангасан төрөлжсөн нэгдсэн төвийг улсын хэмжээнд байгуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Уг төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, урт хугацааны асаргаа, сэргээн засах болон нийгмийн дэмжлэгийг нэг дороос цогцоор үзүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, институтийн үйлчилгээний давхардал, тасалдлыг бууруулахад чиглэсэн бодлогын шийдвэрийг Засгийн газрын түвшинд гаргах шаардлагатай байна.

2.6. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРУУДАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2025 онд хүний эрх зөрчигдөх эрсдэл бодитоор орших, тухайн орчинд амьдарч, суралцаж буй хүмүүс өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч, орох боломж хязгаарлагдах нөхцөл үүсэх магадлалтай газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг өргөтгөн хэрэгжүүлэв. Үүний хүрээнд их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудыг хамруулан хяналт шинжилгээ хийсэн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чухал чиглэл болсон.

Дотуур байр нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлд заасан “албадан эрх чөлөөг хязгаарласан газар”-т шууд хамаарахгүй боловч бодит нөхцөлд дотоод журам, цагийн хуваарь, сахилгын арга хэмжээ, хараа хяналтын зохицуулалтаас шалтгаалан суралцагчийн өөрийн хүсэлтээр гарч явах боломж хязгаарлагдсан нөхцөл үүсэх, хүний эрх зөрчигдөх эрсдэл бодитоор оршдог.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт сургуулийн дотуур байрыг хамруулсан.

Тухайлбал, дотуур байрны оюутан, сурагчид шөнийн цагаар гарч, орох эрх хязгаарлагдах, оройн хаалга барих цагийг уян хатан бус тогтоох, чөлөө авахад олон шат дамжлага шаардагдах, дотоод журам зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах, жижүүрийн зүгээс дарамттай, ялгавартай хандлага үзүүлэх, камерын хяналт тогтмол хэрэгжихгүй байх, гомдол, санал гаргах бодит механизм байхгүй зэрэг нөхцөл байдал нь эрх чөлөө, аюулгүй орчинд амьдрах эрхэд нөлөөлөх шалтгаан болдог. Ийм нөхцөл байдал нь суралцагчдын айдас, түгшүүрийг нэмэгдүүлж, хүнлэг бус харьцаа, сэтгэлзүйн дарамтад өртөх эрсдэлийг бий болгодог. ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд дээрх нөхцөл байдлаас үүдэн зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай орчинд дотуур байрыг урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд хамруулах бодит үндэслэл болж байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийхдээ дотуур байрны барилга байгууламжийн нөхцөл байдал, өрөөний багтаамж, ариун цэвэр, угаалгын болон хоол хийх орчин, аюулгүй байдал, камерын ашиглалт, мэдээллийн хамгаалалт, гомдол, санал шийдвэрлэх тогтолцоо, оюутнуудын хөдөлмөрлөх болон амьдрах эрхийн бодит хэрэгжилт зэрэг асуудлыг цогцоор нь үнэлсэн.

Дотуур байранд амьдарч буй суралцагчид нь нас, нийгмийн төлөвшил, хараат байдлын хувьд эмзэг бүлэгт хамаарах тохиолдол түгээмэл бөгөөд тухайн орчны дотоод журам, сахилга, хяналтын тогтолцоо, ажилтнуудын хандлагаас шууд хамааралтай нөхцөлд амьдарч байна. Ялангуяа ерөнхий боловсролын болон мэргэжлийн чиглэлийн сургалтын байгууллагын дотуур байранд амьдарч

буй хүүхдүүдийн хувьд асран хамгаалагчаас алслагдсан орчинд өдөр тутмын амьдрал, суралцах үйл ажиллагаа явагддаг тул хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэл харьцангуй өндөрт тооцогддог.

Дотуур байр нь суралцагчийн хувьд зөвхөн амьдрах орчин бус, түүний сурч боловсрох, хөгжих, амарч тайван байх, нийгмийн харилцаанд оролцох эрх бодитоор хэрэгжих эсэхийг тодорхойлох чухал орон зай юм.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажиллав.

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр:

Ерөнхий боловсролын түвшинд дараах сургуулийн дотуур байруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийв. Үүнд:

- Монгол Улсын Консерватор - ерөнхий боловсролын болон мэргэжлийн чиглэлийн суралцагчдын дотуур байр;
- Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр - аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-ийн дотуур байр;

Эдгээр дотуур байруудад насанд хүрээгүй хүүхдүүд амьдарч, асран хамгаалагчаас алслагдсан нөхцөлд өдөр тутмын амьдрал, суралцах үйл ажиллагаа явагдаж байгаа нь хүний эрхийн үүднээс онцгой анхаарал шаардсан орчин болохыг харуулж байна. Хяналт шинжилгээний хүрээнд хүүхдийн эрхэд нийцсэн орчин бүрдсэн эсэх, дотоод журам, чөлөө олгох зохицуулалт, хоол хүнсний чанар, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг, сахилга, шийтгэлийн арга хэмжээ нь дарамт, ялгаварлан гадуурхалт үүсгэх эрсдэлтэй эсэхэд төвлөрөн үнэлгээ хийв.

Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьд орон нутгийн онцлогоос шалтгаалан санхүүжилт, хүний нөөц, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой хүндрэлүүд ажиглагдсан бөгөөд энэ нь хүүхдийн амьдрах орчин, сэтгэл зүйн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгааг хяналт шинжилгээгээр тогтоов.

2.2. Их, дээд сургуулийн дотуур байр:

Хяналт шинжилгээнд дараах их, дээд сургуулийн дотуур байрууд хамрагдав. Үүнд:

- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль - оюутны 1, 2, 3 дугаар дотуур байр;
- Санхүү, эдийн засгийн их сургууль - оюутны дотуур байр;
- Шинжлэх ухаан, технологийн их сургууль - оюутны 1, 3, 4 дүгээр дотуур байр;
- Хөдөө аж ахуйн их сургууль - оюутны 1, 2, 3 дугаар дотуур байр;
- Соёл урлагийн их сургууль - оюутны дотуур байр.

Эдгээр дотуур байруудад 18-аас дээш насны оюутнууд амьдарч байгаа боловч орон нутгаас ирсэн, эдийн засгийн болон нийгмийн хувьд харьцангуй хараат байдалтай, анх удаа бие даан амьдарч эхэлж буй оюутнууд зонхилж байгаа нь хяналт шинжилгээгээр тогтоогдлоо. Иймд дотуур байрны дотоод журам, сахилга, хараа хяналтын зохицуулалт нь оюутны эрх, сэтгэл санаанд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЭРСДЭЛ

3.1. Амьдрах орчин, байр, аюулгүй байдлын хүрээнд илэрсэн нөхцөл байдал



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр дотуур байруудад амьдарч буй суралцагчдын амьдрах орчин, байрны зохион байгуулалт, аюулгүй байдлын нөхцөл нь сургалтын байгууллагын төрөл, барилга байгууламжийн насжилт, санхүүжилт, удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан харилцан адилгүй байгааг тогтоов.



Их, дээд сургуулийн дотуур байруудад өрөөний багтаамж хэтэрсэн, нэг өрөөнд олон суралцагч байрлах нөхцөл түгээмэл байснаас хувийн орон зай хязгаарлагдах, амрах, бие даан хичээллэх боломж багасах эрсдэл илэрсэн. Зарим дотуур байранд барилгын хуучрал, засвар үйлчилгээ дутмаг байдлаас шалтгаалан цахилгаан, галын аюулгүй байдалтай холбоотой эрсдэл бүхий нөхцөл ажиглагдсан.



Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад хүүхдийн нас, бие махбод, сэтгэл зүйн онцлогт бүрэн нийцээгүй орон зайн зохион байгуулалт, унтлагын болон чөлөөт цагийн орчны ялгарал хангалтгүй байх нөхцөл илэрсэн нь сэтгэл зүйн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үнэлэгдэв.



Аюулгүй байдлын зохицуулалтын хувьд ихэнх дотуур байранд жижүүрийн тогтолцоо, хяналтын камер суурилуулсан боловч камержуулалтын хамрах хүрээ, ашиглалтын журам тодорхой бус, хувийн нууцад халдах эрсдэл үүсгэхээр байршсан тохиолдлууд ажиглагдсан. Мөн шөнийн цагийн жижүүрийн ачаалал их, хүний нөөц хүрэлцээгүйгээс хараа хяналт сулрах нөхцөл бүрдэж байв.

Дээрх нөхцөл байдал нь дотуур байрны амьдрах орчин, аюулгүй байдалтай холбоотойгоор суралцагчдын эрх, сэтгэл зүйн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бүрдэж байгааг илтгэнэ.

3.2. Ариун цэвэр, эрүүл ахуй, ус, дулаан, цахилгаан хангамж

Хяналт шинжилгээгээр ариун цэврийн өрөө, шүршүүрийн тоо хүрэлцээгүй, ашиглалтын ачаалал өндөр, халуун ус тасалдах, усны даралт сул байх зэрэг нөхцөл олон дотуур байранд нийтлэг ажиглагдав. Ариун цэврийн байгууламжийн хаалт, түгжээ дутмаг, эрэгтэй, эмэгтэй суралцагчдын ашиглалтыг бүрэн тусгаарлаагүй зохион байгуулалт нь хувийн нууц, нэр төрийг хангахгүй байх эрсдэлийг үүсгэж байв.



Дулаан, цахилгаан хангамжийн хувьд өвлийн улиралд өрөө хоорондын температурын зөрүү их, хуучирсан цахилгааны шугам, ил залгуур, сунгагч олноор ашиглаж байгаа нь гал, цахилгааны аюул үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байв.



Эдгээр нөхцөл байдал нь ариун цэвэр, эрүүл ахуй, дэд бүтцийн найдвартай байдлыг хангах чиглэлд цаашид анхаарах шаардлагатай эрсдэл хэвээр байгааг харуулж байна.



3.3. Хоол, хүнсний чанар, хүртээмж

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад хоол, хүнсний чанар, хэмжээ, илчлэгийн хүрэлцээтэй холбоотойгоор хүүхдийн эрүүл мэнд, хэвийн хөгжилд нөлөөлөх эрсдэл бүхий нөхцөл илэрсэн. Ялангуяа биеийн хүчний өндөр ачаалалтай суралцагчдын хувьд хооллолт нь бодит хэрэгцээг бүрэн хангахгүй байгааг ганцаарчилсан ярилцлага, асуумжаар илэрхийлсэн.



Уг асуудалд холбогдох байгууллагаас хоолны нормыг нэмэгдүүлэх, хоолны цэсийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлсэн боловч хоол үйлдвэрлэлийн орчин, тоног төхөөрөмж, санхүүжилтийн тогтвортой шийдэл бүрэн хангагдаагүй хэвээр байна.

Харин их, дээд сургуулийн дотуур байруудад хоол хүнсний хүртээмжийг шууд хязгаарласан, хүнлэг бус харьцаанд хүргэхүйц нөхцөл нийтлэг илрээгүй боловч гал тогооны орчин, хүнс хадгалах нөхцөл нь амьдрах орчны чанарт нөлөөлөх эрсдэлийн түвшинд ажиглагдав.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХҮРЭЭНД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд дотуур байруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн нөхцөл байдал, эрсдэлийг бууруулах, цаашид хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ нь зөрчил тогтоох, хариуцлага тооцох бус, харин тогтолцооны доголдлыг арилгах, байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүний эрхэд суурилсан орчныг бүрдүүлэхэд чиглэсэн болно.



4.1. Хяналт шинжилгээний явцад өгсөн зөвлөмж, зөвлөн туслах ажиллагаа

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад дотуур байр хариуцсан байгууллагуудын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад хүний эрхийн эрсдэл бүхий нөхцөл байдал, дотоод журам, зохион байгуулалтын доголдлыг арилгах чиглэлээр газар дээр нь тайлбар, зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартын хүрээнд зөвлөн туслах ажиллагааг хэрэгжүүлэв.

Тухайлбал, дотуур байрны нэвтрэх, гарах зохицуулалт, сахилгын арга хэмжээний хэрэгжилт, жижүүрийн хараа хяналт, камержуулалтын ашиглалт, хувийн нууцыг хамгаалах зохицуулалт, гомдол, санал хүлээн авах механизмтай холбоотой асуудлаар бодит нөхцөлд тулгуурласан зөвлөмжийг тухай бүр өгч ажиллав.

4.2. Эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээ

Зарим дотуур байранд илэрсэн эрсдэл нь шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байсан тул холбогдох байгууллагуудтай хамтран дараах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Үүнд:

- оройн болон шөнийн цагийн жижүүрийн зохион байгуулалтыг сайжруулах;
- гаднын хүн нэвтрэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтыг чангатгах;

- ариун цэврийн байгууламжийн хаалт, түгжээ, тусгаарлалтыг сайжруулах;
- өрөөнд нэвтрэхтэй холбоотой дотоод журмыг тодорхой болгох;
- суралцагчдад хүний эрх, гомдол гаргах боломжийн талаар мэдээлэл өгөх.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх явцад байгууллагын удирдлагуудтай шууд уулзалт хийж, хүний эрхийн эрсдэлийг удирдлагын түвшинд ойлгуулах, шийдвэр гаргалтад тусгах чиглэлээр хамтран ажиллав.

4.3. Байгууллагын зүгээс авч хэрэгжүүлсэн анхны арга хэмжээ (ирүүлсэн мэдээлэлд үндэслэн)

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний дараа зарим байгууллагаас дотуур байрны орчин, аюулгүй байдал, дотоод журам, харилцаа хандлагатай холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр анхны зохион байгуулалтын арга хэмжээ авсан талаар албан мэдээлэл ирүүлсэн.

Тухайлбал, дотоод журмыг дахин хянаж, сахилгын арга хэмжээг шийтгэлийн бус, урьдчилан сэргийлэх хэлбэрт шилжүүлэх, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, гомдол, санал хүлээн авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй болгох, камерын ашиглалтын журамд өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээ авч эхэлсэн байна.

Эдгээр арга хэмжээ нь тухайн байгууллагуудын зүгээс хүний эрхийн эрсдэлийг бууруулах чиглэлд анхаарал хандуулж эхэлснийг илтгэж байгаа боловч цаашид тогтвортой хэрэгжилтийг хангах, үр нөлөөг баталгаажуулах шаардлага хэвээр байгааг харуулж байна.



ТАВ. СУРАЛЦАГЧДЫН ЭРХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ЭРСДЭЛТ НӨХЦӨЛ, ТОХИОЛДЛУУД



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад дотуур байруудад эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах үйлдэл шууд тогтоогдсон гэж дүгнэх үндэслэл илрээгүй боловч ганцаарчилсан ярилцлага, асуумжаар ийм төрлийн зөрчил үүсэх бодит эрсдэл бүхий нөхцөл, зан үйл, зохион байгуулалтын доголдол илэрсэн онцлох тохиолдлууд бүртгэгдэв.

Ихэвчлэн дотоод журам, сахилгын арга хэмжээ, хараа хяналтын зохицуулалт, ажилтнуудын харилцаа, орчны нөхцөлтэй уялдан суралцагчдын айдас, түгшүүр, сэтгэл зүйн дарамтыг бий болгох, улмаар хүний нэр төр, халдашгүй байх эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаагаараа эрсдэлтэй юм.

Эдгээр тохиолдлууд нь суралцагчдын эрх, нэр төр, халдашгүй байдалд ноцтойгоор нөлөөлөх эрсдэл үүсгэж байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, тогтолцооны доголдлыг арилгах шаардлагатайг илтгэж байна.

5.1. Зарим анхаарах нөхцөл байдал

Зарим дотуур байранд багш, жижүүр, ажилтнуудын зүгээс суралцагчидтай харилцахдаа загнах, доромжлох, айлган сүрдүүлэх өнгө аястай шаардлага тавих, ялгавартай хандах, нас, дамжаа, курс, гарал үүслээр нь гадуурхах шинжтэй зан төрх илэрсэн талаар ганцаарчилсан ярилцлага, асуумжаар тогтоогдсон.

Тухайлбал, оройтож ирсэн суралцагчдыг олон нийтийн өмнө зэмлэх, буруутгах, тодорхой ажлыг “шийтгэл” хэлбэрээр

гүйцэтгүүлэх, эсхүл тухайн хүнийг удаа дараа онилон анхааралд авах зэрэг нь сахилгын арга хэмжээ ба дарамт, хүнлэг бус харьцааны зааг алдагдах нөхцөл байдал үүсгэж байв.

Ийм төрлийн харилцаа хандлага, зохион байгуулалт тогтсон байгаа нь суралцагчид өөрийгөө хамгаалж, гомдол гаргах боломжгүй мэт сэтгэгдэл төрүүлэх, дасан зохицохын тулд зүй бус харьцааг тэвчихэд хүргэх эрсдэлтэй гэж үнэлэгдэв.



Тохиолдол-1

Оройтож ирэхэд байнга олон хүний өмнө загнадаг. Заримдаа “чи дахиж хоцорвол хөөнө шүү” гэж хэлдэг. Тэгэхээр дараа нь юу ч тохиолдсон дуугарахгүй байхыг боддог...

Тохиолдол-2

Байрны ажилтнууд зарим хүүхдэд зөөлөн, заримд нь байнга ууртай харьцдаг. Ялангуяа нэгдүгээр курсийнхэнд илүү хатуу...

Тохиолдол-3

Гомдол гаргавал улам төвөг болно гэж айдаг...

5.2. Аюулгүй байдалтай холбоотой нөхцөл байдал

Хяналт шинжилгээгээр зарим дотуур байранд хараа хяналт, жижүүрийн тогтолцоо сул, гаднын хүн нэвтрэхээс урьдчилан сэргийлэх механизм хангалтгүй байгаатай холбоотойгоор суралцагчид өөрийгөө аюулгүй орчинд байна гэж мэдрэхгүй байх тохиолдлууд илэрсэн. Эдгээр нөхцөл нь суралцагчийн аюулгүй орчинд амьдрах, айдасгүй байх эрхийг бодитоор алдагдуулах, аюул заналхийлэл үүсэх магадлалыг нэмэгдүүлж байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх түвшинд зайлшгүй анхаарах шаардлагатай гэж дүгнэгдэв.



Тохиолдол-4

Шөнө гаднын хүн байранд орж ирсэн. Жижүүр анзаараагүй юм уу, эсвэл тоогоогүй юм шиг байсан. Тэр үед үнэхээр айсан...

Тохиолдол-5

Шөнө унтаж байхад гаднын хүн өрөөнд орж ирсэн. Айсандаа орилсон. Тэгээд хөрш өрөөний оюутнууд сонсоод гарч ирж, тэр хүнийг байрнаас гаргасан, жижүүр тухайн үед байрандаа байгаагүй юм уу, анзаараагүй юм шиг байсан...

Тохиолдол-6

Өрөөнд зөвшөөрөлгүй орж ирэх тохиолдол байдаг. Тэгэхээр хувийн орон зай гэж байхгүй юм шиг санагддаг...

5.3. Суралцагчийн хувийн нууц, сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн нөхцөл байдал.

Ариун цэврийн байгууламжийн зохион байгуулалт, хувийн нууцыг хангаагүй орчин, өрөөнд зөвшөөрөлгүй орох, байнгын хяналтад байгаа мэт мэдрэмж төрүүлэх нөхцөл нь суралцагчдын ичих, эвгүйцэх, өөрийгөө дорд үзэх, байнгын

түгшүүртэй байх, сэтгэл зүйн дарамт мэдрэх байдалд хүргэж байгааг ярилцлага, асуумжаар илэрхийлсэн.



Тохиолдол-7

Ариун цэврийн өрөөнд ороход өөр хүн хажуугаар яваад гарчихдаг. Тэр үед их эвгүй санагддаг...

Тохиолдол-8

Эрэгтэй, эмэгтэй усанд орох хэсэг дамжин өнгөрөх зохион байгуулалттай...

Тохиолдол-9

Усанд орж байхад хажуугаар хүн явдаг, ариун цэврийн өрөө хаалт, түгжээ муутай...

Дээрх нөхцөл байдал нь суралцагчдын нэр төр, хувийн нууц, сэтгэл санааны аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын тогтолцоо сул байгааг харуулж, хүнлэг бус харьцаа үүсэх суурь эрсдэл бүрдэж байгааг илтгэнэ.

ЗУРГАА. ДОТУУР БАЙР ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэл, тогтолцооны доголдол, зохион байгуулалтын сул талыг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотуур байр хариуцсан байгууллагуудад эрх зүй, хүний эрхийн зарчимд суурилсан зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллав. Зөвлөмжүүдийг боловсруулахдаа 4-р бүлэгт дурдсан онцлох тохиолдол, бодит эрсдэлийг үндэслэн, зөвхөн тухайн нэг зөрчлийг арилгах бус, тогтолцооны түвшинд засах, урьдчилан сэргийлэх шинжтэй байхаар чиглүүлэв.

Хүргүүлсэн зөвлөмжийг дараах чиглэлээр ангилан харуулав.

6.1. Амьдрах орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд өгсөн зөвлөмж

- Дотуур байрны нэвтрэх, гарах журам, жижүүрийн хараа хяналтын зохицуулалтаар аюулгүй байдлыг бодитоор хангах чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах;
- Гаднын хүн дотуур байранд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх хяналтын механизм (жижүүрийн байнгын оролцоо, бүртгэл, камерын зохистой ашиглалт)-ыг боловсронгуй болгох;
- Ариун цэврийн өрөө, усанд орох хэсгийн эрэгтэй, эмэгтэй ашиглалтыг бүрэн тусгаарлаж, хаалт, түгжээ, хувийн нууцыг хангах зохион байгуулалтыг стандартын шаардлагад нийцүүлэх;
- Барилга байгууламжийн насжилт, эвдрэл, аюултай нөхцөлтэй холбоотой засвар, шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

6.2. Дотоод журам, сахилгын арга хэмжээтэй холбоотой өгсөн зөвлөмж

- Дотуур байрны дотоод журам, сахилгын арга хэмжээг хүний эрх, нэр төрийг хүндэтгэх зарчимд нийцүүлэн дахин хянаж, ялгаварлан гадуурхах, дарамт учруулах эрсдэлтэй зохицуулалтыг хасах;
- Сахилгын арга хэмжээг “шийтгэл” хэлбэрээр хэрэгжүүлэхээс татгалзаж, урьдчилан сэргийлэх, ойлгуулах, дэмжих хэлбэрт шилжүүлэх;
- Оройтож ирсэн, журам зөрчсөн суралцагчидтай харилцахдаа олон нийтийн өмнө зэмлэх, доромжлох, айлган сүрдүүлэх хэлбэрээс татгалзах.

6.3. Суралцагчийн эрхийг хамгаалах механизмтай холбоотой өгсөн зөвлөмж

- Суралцагчдын гомдол, санал, мэдээллийг аюулгүй, нууцлалтай, дарамтгүйгээр гаргах боломжийг бодитоор хангах;
- Гомдол гаргасан суралцагчийг ялгаварлахгүй, дарамтлахгүй байх баталгааг дотоод журам, зохион байгуулалтын түвшинд хангах;
- Хүний эрх, тэр дундаа эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн талаарх мэдээлэл, заавар, холбоо барих мэдээллийг дотуур байранд хүртээмжтэй байрлуулах.

6.4. Сургалт, нөлөөллийн ажлын чиглэлээр өгсөн зөвлөмж

- Дотуур байрны багш, жижүүр, ажилтнуудад хүний эрхэд суурилсан харилцаа, хүүхэд, оюутантай ажиллах ёс зүй, сэтгэл зүйн мэдрэмжийн талаар тогтмол сургалт зохион байгуулах;
- Суралцагчдад өөрийн эрхээ таньж мэдэх, зөрчигдсөн тохиолдолд хаана, хэрхэн хандах талаарх мэдээлэл, сургалтыг тогтмолжуулах.

Дотуур байр хариуцсан байгууллагуудад хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжүүд нь илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгахын зэрэгцээ цаашид эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэхээс урьдчилан сэргийлэх тогтолцооны шийдлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

ДОЛОО. ДОТУУР БАЙР ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс Ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн дотуур байруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан А/03 дугаар аргачлалын дагуу анхан болон давтан үнэлгээ хийж дүгнэв.

Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ байгууллага тус бүрийн ирүүлсэн биелэлт, холбогдох нотломж, зураг, баримт, тушаал шийдвэрийн хуулбар зэрэг бодит гүйцэтгэлийг харгалзан, хэрэгжилтийн түвшнийг ялган ангилсан.

7.1. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүн

Хүснэгт 48

| № | Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллага | Зөвлөмжийн заалтын тоо | Хэрэгжилтийн түвшин |
|-------------|--|------------------------|---------------------|
| 1 | Шинжлэх ухаан, технологийн их сургууль | 15 | 90.0% |
| 2 | Хөдөө аж ахуйн их сургууль | 20 | 88.5% |
| 3 | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль | 11 | 90.0% |
| 4 | Санхүү, эдийн засгийн их сургууль | 10 | 92.0% |
| 5 | Соёл урлагийн их сургууль | 12 | 83.0% |
| 6 | Монгол Улсын Консерватор | 9 | 86.0% |
| 7 | Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр | 4 | 82.5% |
| Нийт | | 81 | 87.42% |

Үнэлгээгээр Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль нь тус тус 90.0 хувь, 88.5 хувь буюу “хэрэгжих шатанд” гэж дүгнэгдсэн. Эдгээр байгууллагууд дотуур байрны орчин, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, дотоод журам, сургалт, нөлөөллийн ажлыг бодитоор хэрэгжүүлж, холбогдох нотломжийг бүрэн ирүүлсэн тул дахин үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзэв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургуулийн хувьд зөвлөмжийн хэрэгжилт анхан шатанд 30.0 хувь буюу “хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэгдсэн боловч нэмэлтээр шаардлагатай засвар үйлчилгээ хийж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах зэрэг бодит арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн тул дахин үнэлгээгээр 92 хувь буюу “хэрэгжилт хангалттай” түвшинд хүрч үнэлэгдсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх явцад тухайн байгууллагын удирдлагуудтай үргэлжилсэн уулзалт, зөвлөн туслах ажиллагаа зохион байгуулж, зөвлөмжийн заалт бүрээр санал солилцон ажилласнаар удирдлагын түвшинд шийдвэр гаргасан тохиолдолд богино хугацаанд бодит ахиц гаргах боломжтой болохыг харууллаа.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд дотуур байруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах явцад Соёл урлагийн их сургууль зөвлөмжид дурдсан зарим эрсдэл, нөхцөл байдлыг дотооддоо шалган, холбогдох арга хэмжээ авсан талаар албан мэдээлэл ирүүлсэн.

Тодруулбал, дотуур байрны албан хаагчийн зүгээс суралцагчтай харилцах явцад зүй бус харьцаа илэрч, айдас, сэтгэл зүйн дарамт үүсгэх нөхцөл байдал бий болсон байж болзошгүй асуудлаар байгууллагын зүгээс дотоод хяналт шалгалт явуулсан бөгөөд шалгалтын дүнд холбогдох зөрчил тогтоогдсон тухай тайлагнасан. Үүний дагуу тухайн албан хаагчид холбогдох хууль тогтоомж, дотоод журамд заасны дагуу сахилгын хариуцлага тооцох арга хэмжээ авч, цаашид ижил төрлийн нөхцөл байдал давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлагын түвшинд зохион байгуулалтын шийдвэр гаргасан байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгах, давтан гарахаас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд байгууллагын дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бодитоор ажиллуулах нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ

9.1. Үйл ажиллагааны үр дүн

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд дотуур байруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд дараах эерэг өөрчлөлт, бодит үр дүн гарсан байна. Үүнд:

- Их, дээд сургуулийн зарим дотуур байрны амьдрах орчин, аюулгүй байдал, ариун цэвэр, хувийн нууцыг хангах нөхцөл бодитоор сайжирсан;
- Ариун цэврийн болон угаалгын өрөө, галын аюулгүй байдал, гэрэлтүүлэг, камерын хяналт зэрэг материаллаг орчныг сайжруулах засвар, шинэчлэлийн ажлууд тодорхой байгууллагуудад үе шаттайгаар хэрэгжсэн;
- Нэвтрэх, гарах зохион байгуулалтад технологийн шийдэл, чиптэй нэвтрэх систем (АШУҮИС) нэвтрүүлснээр оюутнууд шөнийн цагаар гадаа хүлээх нөхцөл арилж, гаднын хүн нэвтрэх, аюул үүсэх эрсдэл буурсан;
- Дотуур байрны дотоод журамд өөрчлөлт оруулж, орох, гарах цагийн зохицуулалтыг уян хатан болгосноор ажил хийдэг, оройн хичээлтэй суралцагчдын нөхцөл байдлыг харгалзан үзэх боломж бүрдсэн;
- Амьдралын зохион байгуулалтад хүний эрхэд суурилсан зарчим тусган, өрөөнд зөвшөөрөлгүй нэвтрэх, хувийн орон зайг хязгаарлах эрсдэлтэй заалтыг тодорхой болгож, сахилгын арга хэмжээг шийтгэлийн бус, урьдчилан сэргийлэх хэлбэрээр хэрэгжүүлэх зохицуулалтыг нэвтрүүлсэн;
- Байрны багш, жижүүр, ажилтнуудад чиглэсэн хүний эрх, харилцаа, ёс зүйн сургалтыг тогтмол зохион байгуулах практик бүрдэж эхэлсэн;

- Жижүүр, байрны багшийн чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өрөө шалгах, нэвтрэхтэй холбоотой зохион байгуулалтыг журамласнаар хувийн орон зайд халдах эрсдэл буурсан;
- Суралцагчдын санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизм сайжирч, мэдээллийн самбар, цахим сувгаар хүний эрхийн талаарх мэдээллийг хүртээмжтэй байршуулсан;
- Суралцагчдын өөрөө удирдах байгууллагатай хамтын ажиллагаа идэвхжиж, дотуур байртай холбоотой асуудлаар тогтмол санал солилцох хэлбэр бий болсон;
- Зөвлөмжийг анхан шатанд хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллагууд дахин үнэлгээ, зөвлөн туслах ажиллагааны үр дүнд богино хугацаанд бодит ахиц гаргах боломжтой болох нь нотлогдсон.

9.2. Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн хөрөнгө, санхүүгийн болон зохион байгуулалтын бодит арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн эрсдэлийг арилгах хүрээнд дотуур байр хариуцсан байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн дагуу зарим сургалтын байгууллага бодит засвар, хөрөнгө оруулалт, зохион байгуулалтын шийдвэр гарган, хүний эрхэд суурилсан орчныг бүрдүүлэх чиглэлээр сайн жишиг болохуйц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал:

- Шинжлэх ухаан, технологийн их сургууль дотуур байруудын их болон урсгал засварт ойролцоогоор 4.5 тэрбум төгрөг, тавилга, эд хогшлын шинэчлэлд 420 орчим сая төгрөг зарцуулж, ариун цэврийн өрөө, шүршүүр, гал тогоо, цахилгааны аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулсан;
- Хөдөө аж ахуйн их сургууль дотуур байрны орчин, аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд тавилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл, урсгал засвар, вакум цонхны засвар үйлчилгээнд 120.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, суралцагчдын амьдрах орчныг бодитоор сайжруулсан;
- Санхүү, эдийн засгийн их сургууль дотуур байрны засвар, ариун цэврийн өрөө, шүршүүрийн тохижилт, гэрэлтүүлэг, аюулгүй байдлын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, холбогдох дотоод зохион байгуулалтын шийдвэрүүдийг гаргасан;
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль дотуур байрны орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд урсгал засвар, ариутгал халдваргүйжүүлэлт, шавж устгал зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, 2025 онд нийт 302 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт зарцуулсан. Тухайлбал, оюутны 1, 2 дугаар дотуур байрны урсгал засварыг 2025 оны 6 болон 12 дугаар сард зохион байгуулж, мөн 2025 оны 8 дугаар сард дотуур байрны орчны эрүүл ахуйг хангах зорилгоор ариутгал, шавж устгалын үйлчилгээ авсан нь суралцагчдын амьдрах орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг бодитоор сайжруулахад чиглэсэн болно.

АРАВ. ДҮГНЭЛТ

Дотуур байруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүн нь сургалтын байгууллагуудын дотоод зохион байгуулалт, амьдрах орчин, аюулгүй байдал, хүний эрхийн баталгааг бодитоор сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн.

Ялангуяа удирдлагын түвшинд шийдвэр гаргаж, стандартын шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалт, зохион байгуулалтын бодит арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгууллагуудад зөвлөмжийн хэрэгжилт богино хугацаанд ахицтай байгааг энэхүү үнэлгээ илтгэнэ.

Гэсэн хэдий ч дотуур байрны хүчин чадал, ашиглалт, стандартын хэрэгжилт, үйлчилгээний чанар нь орон нутаг болон байгууллага хооронд харилцан адилгүй хэвээр байгааг холбогдох байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл харуулж байна.

Түүнчлэн дотуур байрны ажилтнуудын харилцаа, сахилгын хариуцлагын зохицуулалт, гомдол, мэдээлэл хүлээн авах механизмын бодит хэрэгжилт зарим байгууллагад хангалтгүй хэвээр байгаа нь суралцагчдад сэтгэл зүйн дарамт, айдас үүсэх эрсдэлтэй.

Иймд дотуур байрны орчин, үйлчилгээ, аюулгүй байдлыг сайжруулах бодлого, санхүүжилтийг улсын болон нутгийн түвшинд ялгамжтай, үе шаттай төлөвлөж, “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5869:2025 стандартыг улсын хэмжээнд жигд мөрдүүлэх, хэрэгжилтэд нь тогтмол хяналт, үнэлгээ хийх нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэлийг урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой байна.

01.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажиллав.

Хяналт шинжилгээний хүрээнд: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль-оюутны 1, 2, 3 дугаар дотуур байр, Санхүү, эдийн засгийн их сургуулийн оюутны дотуур байр, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн оюутны 1, 3, 4 дүгээр дотуур байр, Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутны 1, 2, 3 дугаар дотуур байр, Соёл урлагийн их сургуулийн оюутны дотуур байр, Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, Монгол Улсын Консерваторын ерөнхий боловсролын болон мэргэжлийн чиглэлийн суралцагчдын дотуур байр. Эдгээр дотуур байруудад насанд хүрээгүй хүүхдүүд амьдарч, асран хамгаалагчаас алслагдсан нөхцөлд өдөр тутмын амьдрал, суралцах үйл ажиллагаа явагдаж байгаа нь хүний эрхийн үүднээс онцгой анхаарал шаардсан орчин юм. Хяналт шинжилгээний хүрээнд хүүхдийн эрхэд нийцсэн орчин бүрдсэн эсэх, дотоод журам, чөлөө олгох зохицуулалт, хоол хүнсний чанар, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг, сахилга, шийтгэлийн арга хэмжээ нь дарамт, ялгаварлан гадуурхалт үүсгэх эрсдэлтэй эсэхэд төвлөрөн үнэлгээ хийв.

02.

ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэл, тогтолцооны доголдол, зохион байгуулалтын сул талыг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотуур байр хариуцсан байгууллагуудад эрх зүй, хүний эрхийн зарчимд суурилсан 7 зөвлөмжийг хүргүүлж дунджаар 87.42 хувьтай үнэлэгдэв. Шинжлэх ухаан, технологийн их сургууль 90%, Хөдөө аж ахуйн их сургууль 88.5%, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 90%, Санхүү, эдийн засгийн их сургууль 92%, Соёл урлагийн их сургууль 83%, Монгол Улсын Консерватор 86%, Төв аймгийн ерөнхий боловсролын сургууль 82.5% гэж тус тус дүгнэгдэв. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх явцад тухайн байгууллагын удирдлагуудтай үргэлжилсэн уулзалт, зөвлөн туслах ажиллагаа зохион байгуулж, зөвлөмжийн заалт бүрээр санал солилцон ажилласнаар удирдлагын түвшинд шийдвэр гаргасан тохиолдолд богино хугацаанд бодит ахиц гаргах боломжтой болохыг харууллаа.

03.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилтийн дүнд их, дээд сургуулийн зарим дотуур байрны амьдрах орчин, аюулгүй байдал, зохион байгуулалтын нөхцөлд тодорхой ахиц гарсан байна. Ариун цэврийн байгууламж, галын аюулгүй байдал, гэрэлтүүлэг, камерын хяналт зэрэг материаллаг орчныг сайжруулах засвар, шинэчлэл үе шаттай хэрэгжсэнээр оюутнуудын амьдрах орчин илүү аюулгүй, тав тухтай болсон. Мөн нэвтрэх, гарах зохион байгуулалтад технологийн шийдэл нэвтрүүлж, дотоод журамд өөрчлөлт оруулснаар оюутнуудын бодит нөхцөл байдалд нийцсэн, уян хатан зохицуулалт бүрдсэн. Үүний зэрэгцээ хүний эрхэд суурилсан зарчмыг дотуур байрны үйл ажиллагаанд тусгаж, ажилтнуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, сургалт зохион байгуулах, санал гомдлыг хүлээн авах механизмыг сайжруулах зэрэг бодит ахиц ажиглагдсан.

04.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Дотуур байрны орчин, үйлчилгээ, аюулгүй байдлыг сайжруулах бодлого, санхүүжилтийг улсын болон орон нутгийн түвшинд ялгамжтай, үе шаттай төлөвлөж, дотуур байрны орчин, үйлчилгээний ерөнхий шаардлага болох MNS 5869:2025, MNS 6890:2020 стандартуудыг улсын хэмжээнд жигд мөрдүүлэх, хэрэгжилтэд нь тогтмол хяналт, үнэлгээ хийх нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа үүсэх эрсдэлийг урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ



N | P | M
MONGOLIA

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СУРГАЛТ





N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эрсэг конвенцын Нэмэлт протоколын 19 дүгээр зүйлийн б)-д: “Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хэм хэмжээг харгалзан эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, тэдний байгаа нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагад зөвлөмж өгөх ба эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх;” гэж бэхжүүлсэн бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.1.2-т “олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах;” гэж заасан нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулах, түүгээр дамжуулан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ явуулах эрх зүйн үндсийг тогтоожээ.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT)⁴⁶, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (APT)⁴⁷-тэй үр дүнтэй хамтран ажиллаж сургалтын ажлыг үе шаттай зохион байгуулж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдыг чадавхжуулах талаар ажиллаж ирсэн.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT) нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дагуу байгуулагдсан Үндэсний урьдчилан сэргийлэх механизмд туслах, бэхжүүлэх, зөвлөгөө өгч, чадавхжуулах ажлыг зохион байгуулдаг.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэлхийн тогтолцоог бий болгоход тусалсан төдийгүй эрүүдэн шүүхийн эрсдэлийг бууруулахын тулд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан бүхий л газарт анхаарлаа хандуулан ажилладаг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь олон улсын гэрээ, конвенц, дотоодын хуульд заасан үндэслэлийн дагуу эрүү шүүлтийн хор аюулыг таниулах зорилгоор бүхий л газар, эрх бүхий албан тушаалтан, албан хаагч, иргэдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Тухайлбал, хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, бүх шатны боловсролын байгууллагад суралцагч, оюутан, залуучууд, хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийн багш, ажилтан, үйлчлүүлэгч, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, ахмад настны асрамжийн байгууллагуудад сургалт, нөлөөллийн арга хэмжээг ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.

⁴⁶ “Subcommittee on Prevention of Torture” Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь НҮБ-ын хүний эрхийн тогтолцооны шинэ төрлийн гэрээний байгууллага бөгөөд 2007 оны 02 дугаар сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

⁴⁷ “Association for the Prevention of Torture” “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (APT) нь Швейцарын Женев хотод төвтэй, 1977 онд байгуулагдсан олон улсын төрийн бус байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон бусад олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль, тогтоомж (Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг)-д заасан үндэслэл, журмын дагуу хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс ангид байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшүүлэх зорилгоор үр дүнтэй сургалт зохион байгуулахыг зөвлөмж тус бүрээр тухайн байгууллага, албан тушаалтанд даалгаж, сургалтын талаар ирүүлсэн тайланг үнэлж ирсэн. Түүнчлэн, эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдэд эрхээ хамгаалах, бусдад таниулах, хүний эрхийг ойлгох, баяжуулах, дэмжих талаар мэдээлэл, сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.

ХОЁР. ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОР АЮУЛ, ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙГ ТАНИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийн хор аюулыг таниулах хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтан, олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж ирсэн. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний байгууллагын НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (APT), Батлан хамгаалах яам, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Дотоодын цэргийн байгууллага, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хорих ангиуд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагууд, Ахмад настны үндэсний төв, аймаг орон нутаг дахь ахмадын асрамжийн төв, хүүхдийн асрамж, халамжийн байгууллага, их, дээд сургуулиуд, тэдгээрийн оюутан, сурагчийн дотуур байр (тухайлбал, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Соёл урлагийн их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Улсын Консерватор, Төв аймгийн Ерөнхий боловсролын сургууль)-уудад ажиллаж, эрүү шүүлтийн хор аюулыг таниулахад чиглэсэн ажил арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2025 онд нийт 55335 хүнд эрүү шүүлтийн хор аюулыг таниулахаар сургалт, нөлөөллийн болон бусад арга хэмжээг зохион байгуулсан. Ийнхүү сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг жилээс жилд тоон болон чанарын хувьд өсөж, сайжруулах чиглэлээр анхааран ажиллаж, хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж байна.

Хэдийгээр ЭШУС үндэсний ажиллагаа хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал нөхцөлд үйл ажиллагаа явуулж байгаа боловч, дотоод болон гадаад нөөцдөө тулгуурлан сургалт, нөлөөллийн ажлыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж ажилласан.

ГУРАВ. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР АНХААРАХ АСУУДАЛ

Монгол Улсын Их хурлаас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг соёрхон баталж, нэгдэн орсны хувьд энэ төрлийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ЭШУС үндэсний тогтолцоог бэхжүүлэх, бүх талаар төрийн байгууллага, иргэд хамтран ажиллах шаардлагатай. Иймд нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцэхэд сургалт, соён гэгээрүүлэх ажил онцгой ач холбогдолтой бөгөөд хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хувьд хувь нэмрээ оруулах ёстой. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаа эрчимтэй нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэж байна.

Гэвч хяналт шинжилгээний явцад сургалтын ажлын талаар дараах анхаарах асуудал тогтоогдож байна. Үүнд:

- Алба хаагчдад эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх сургалтыг дотоод нөөц бололцоо болон хүний эрхийн байгууллагын боломжид тулгуурлан үр дүнтэй зохион байгуулахгүй, хугацаа тогтмол бус, зарим газруудад идэвхтэй, зарим газруудад удаашралтай байгаа;
- Алба хаагчдын мэдлэгийн түвшин харилцан адилгүй, эрхээ хамгаалах талаарх ойлголт тодорхой хэмжээнд байгаа боловч хэрэгжүүлэх ур чадвар сул;
- Хяналт шинжилгээний явцад байгууллагуудад хүний эрх, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаатай холбоотой эрсдэл, зөрчил илэрсэн нь алба хаагчдын мэдлэг хангалттай бус буюу сул, бусдыг хүндэтгэн үзэх ухамсар жигд биш, харилцааны зөрчилгүй байх талаар сэтгэл зүйн болон ёс зүйн сургалт хангалтгүй.

ДӨРӨВ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАСАН БАЙДАЛ



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид дээр дурдсан байгууллагуудад эрүү шүүлтийн хор аюулыг таниулах зорилгоор танхимын болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж ажилласан. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн эсхүл зөвлөмж, шаардлагын мөрөөр сургалт зохион байгуулах ажлыг тухайн хамт олон, байгууллага, салбарын хэмжээнд дангаар болон хамтран, сургагч багшаар дамжуулан хэрэгжүүллээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өмнөх онуудад бэлтгэсэн 224 сургагч багш, 2025 онд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллагад зохион байгуулсан “Мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмыг нутагшуулах нь” сэдэвт сургалтаас танхимд болон цахимаар хамрагдсан алба хаагчид (мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан) сургагч багшийн статустай бэлтгэгдсэн ба эдгээр 1100 алба хаагч, албан тушаалтан болон сургалт, судалгааны ажил эрхэлдэг багш, судлаач, иргэний нийгмийн байгууллын идэвхтэн, зүтгэлтэн, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын

байгууллага (АРТ)-ын сургагч багш⁴⁸, зөвлөхүүдээс биечлэн танхимд болон цахим сургалт зохион байгуулсан.

48 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас Олон улсын байгууллагатай хамтарсан сургалт. 2025 оны 09 дүгээр сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалт:

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Николь Хогг, ахлах зөвлөх Бен Бакланд, Азийн бүс хариуцсан ахлах зөвлөх Нид Саджипонан нарын болон Шинэ Зеланд Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хот дахь Шинэ Зеланд Улсын дипломат төлөөлөгчийн газрын Хойд Ази хариуцсан мэргэжилтэн Гэри Алкок нар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг⁴⁹ зохион байгуулсан.

Мөн “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” сэдэвтэй Мендезийн зарчмуудыг нутагшуулах сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр хууль сахиулах байгууллага (Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар)-д зохион байгуулж⁵⁰, танхимд 100 орчим алба хаагч, цахимаар 1000 орчим алба хаагч нийт 1100 алба хаагч, эрх бүхий албан тушаалтан хамрагдсан.

Энэхүү сургалтад урилгаар оролцож сургалт зохион байгуулсан мэргэжилтэн Гэри Алкок нь Шинэ Зеланд улсын Цагдаагийн байгууллагын дэд даргаар ажиллаж байсан, үр дүнтэй ярилцлага хийх чиглэлээр мэргэшсэн, улсынхаа хууль сахиулах үйл ажиллагаанд энэ чиглэлээр практик зөвлөмж өгч байсан, үүнийгээ хөгжүүлж онол болгож улмаар олон улсад таниулж, сайн туршлагаа хуваалцсаныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Уг сургалтын үр дүнд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнууд Мендезийн зарчмыг эзэмшүүлэх, сурган дадлагажуулах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж тайлангийн хугацаанд бүрэн нутагшуулаад байна.



49 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид хамрагдсан сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

50 Хууль сахиулах байгууллагын мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан уг сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албан хурлын танхимд зохион байгуулсан.

Дотоод сургалт:



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад очсон бүх газарт болон бусад хэлбэрээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн Улсын ерөнхий прокурор, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, зарим цэргийн анги, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, хүүхдийн асрамж, халамжийн байгууллага, ахмад настны асрамжийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн.

Тухайлбал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Прокурорын байгууллагатай хамтран прокуроруудад, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газартай хамтран тодорхой үе шаттайгаар “Мендезийн зарчмыг бүрэн нутагшуулсан” нь бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц арга хэмжээ болсон.

Тус үндэсний ажиллагаанд ирүүлсэн сургалт, мэдээлэл хүсэх тухай хамтын ажиллагааны хүрээнд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад сургалт зохион байгуулсан ба багш, ажилтан, хүүхэд, залуучууд хамрагдсан нь тэдний эрхээ таньж мэдэх, хамгаалах чадварыг дэмжихэд чиглэсэн онцлог сургалтууд болсон. Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдтэй хамтран ажилласны дүнд тухайн салбарын үйл ажиллагаанд буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх асуудлыг хэлэлцэн, цаашид зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн.

Эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүнд мэдээлэл өгөх, эрүү шүүлтийг таниулах чиглэлээр хорих ангиуд, цагдан хорих байр, эрүүлжүүлэх, саатуулах байруудад ажилласан. Бүлгээр болон ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл түгээж хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрх, хэрцгий



хүнлэг бус харьцаанаас ангид байх, алагчлах болон ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх, хэрэв зөрчигдсөн бол эрхээ хамгаалахаар төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, хүний эрхийг хамгаалах тогтолцоонд хандах зэргээр ажилласан.

ТАВ. СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОГДСОН БАЙДАЛ

Сургалт, нөлөөллийн ажлын хэрэгцээ шаардлага нь байнгын шинжтэй байгаа нь практик байгууллагаас ирүүлж буй сургалт зохион байгуулах хүсэлт, хяналт шинжилгээний явцад уулзалт хийсэн хүмүүсийн санал, түүнчлэн хүний нөөцийн хөдөлгөөн, бүрэлдэхүүн шинэчлэгдэж буй байдал, ажлын байранд гарч байгаа хүний эрхийн зөрчил, боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр дэх хүний эрхийн агуулгын дутагдалтай тал зэргээр илэрхийлэгдэж байна.



Үндэсний ажиллагааны эрүү шүүлтийн хор аюулыг таниулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг байнга зохион байгуулж ирсэн бөгөөд тухайн сургалт авахыг хүссэн байгууллага, албан тушаалтны хэрэгцээ, хүсэлтийг харгалзан үзэж тухай бүр зорилтыг нь тодорхойлон төлөвлөж ирсэн.



Хууль сахиулах байгууллагын тогтолцоонд “эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинж, түүний хууль зүйн учир холбогдол, урьдчилан сэргийлэх нь бүх алба хаагчийн үйл хэрэг болох, төрийн албан хаагчийн ёс зүй” чиглэлээр, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад “алагчлах, ялгаварлан гадуурхах, хүнлэг бус харьцах, бусдын болон өөрийн эрхээ хамгаалах, хүний эрхийг хангах тогтолцоо, хүүхдийн эрх, сурч боловсрох эрх” чиглэлээр, цэргийн байгууллагад “хүний эрх тэр дундаа эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх, дэглэлт нь хүний эрхийн зөрчил болох нь, урьдчилан сэргийлэх арга зам, анхаарах асуудал” зэргээр тус тус онцлог байдлыг харгалзан зорилтыг тодорхойлж, хамтран зохион байгуулсан.



Сургалтын зорилгыг тухай бүрд тооцон тодорхойлж ирсэн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой. Хүн хүчний хувьд харьцангуй цөөн тус нэгж нь сургалт хариуцсан нэг референт ажиллуулан үйл ажиллагаа явуулж ирсэн. Түүнчлэн сургалт авах хэрэгцээг үндэслэн тухайн байгууллагад хэдэн хүний бүрэлдэхүүнтэйгээр очих, сургалтын сэдэв бүрээр албан хаагчдаа бэлтгүүлэх, зохион байгуулах зэргээр ажилласан.

Сургалт зохион байгуулсан бүртгэлд сэдэв, сургалтын хэлбэр, хамрагдсан хүний тоо зэргийг харуулав. Тухайн сэдэв бүрд тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн зорилтыг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан тухай бүрд боловсруулж ирсэн.

Сургалтын бүртгэл

Хүснэгт 49

| № | Сургалт зохион байгуулсан газар | Сургалтын хэлбэр | Арга хэлбэр | Сэдэв | Хамрагдсан хүн |
|---|--|------------------|---------------|--|----------------|
| 1 | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Танхим | Лекц | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь, Олон улсын гэрээний хэрэгжилт | 60 |
| 2 | ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | | Лекц | Эрүү шүүлтээс ангид байх эрх, Олон улсын гэрээ, конвенцын агуулга, мөн чанар, | 40 |
| 3 | Өнөр бүл хүүхдийн асрамж, халамжийн төв | | Лекц | Алагчлах, ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх | 66 |
| 4 | ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба | | Лекц | Хүний эрхийн үзэл баримтлал | 20 |
| 5 | ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны удирдлага болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчид | | Лекц, семинар | Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” буюу Мендезийн зарчмуудыг Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэг мөр нэвтрүүлэх | 90 |
| 6 | УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран прокуроруудад | | Лекц, семинар | Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага | 70 |

| | | | | | |
|----|--|-------------------------|---------------|--|--------------------|
| 7 | Дотоодын цэргийн штабын Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд | Танхим, цахим хэлбэрээр | Лекц | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт | 133 /18 байршлаас/ |
| 8 | ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны алба хаагчдад | Танхим | Лекц, семинар | Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал | 152 |
| 9 | ЦЕГ-ын Мөрдөн байцаах албатай хамтран Нийслэлийн хүрээний эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаа нарт | Танхим | Лекц | “Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал”, “Хүний эрхийн тухай үндсэн ойлголт” | 35 |
| 10 | СХД-ийн Цагдаагийн газартай хамтран тус дүүргийн Цагдаагийн 1,2,3 дугаар хэлтсийн эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, цагдаагийн бусад алба хаагч нарт | Танхим | Лекц | Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмж, түүний хэрэгжилт, Хүний эрхийн тухай үндсэн ойлголт | 40 |
| 11 | Төв аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж тус аймаг дахь сум дундын анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид, Аймгийн прокурорын газрын прокурорууд, Цагдаагийн газрын мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнууд, ШШГ газрын алба хаагчид, ШШГЕГ-ын харьяа 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 417 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагч нарт | Танхим | Лекц | Хүний эрхийн агуулга, мөн чанар, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга зам | 120 |

| | | | | | |
|----|---|-------------------------|---------------|--|------|
| 12 | Монгол Улсын хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс, говийн бүс, баруун бүсийн нутаг дэвсгэр дэх аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад | Танхим, цахим хэлбэрээр | Лекц | Хүний эрх, агуулга, мөн чанар, Эрүү шүүлтээс ангид байх эрх, Олон улсын гэрээ, конвенцын агуулга, мөн чанар, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцахаас урьдчилан сэргийлэх | 250 |
| 13 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нийт 9 албан хаагчдыг чадавхжуулах сургалт | Танхим | Лекц, сеимнар | Хяналт шинжилгээ хийх арга зүй, ярилцлага хийх арга зүй, хүний эрхийг хамгаалах тогтолцоо | 9 |
| 14 | Мендезийн зарчим дараагийн шатны сургалт /АТГ, ЦЕГ-ын мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнууд/ | Танхим | Лекц | Мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх нь | 1100 |
| 15 | Монголын СОС хүүхдийн хотхоны албан хаагч нар, хүүхдүүдэд | Танхим | Лекц | “Үе тэнгийн дээрэлхэлтийн ойлголт, түүнээс ангид байх тухай”, “Хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхах, алагчлах явдлаас ангид байх эрхийг хангахад хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзах зарим асуудал”, “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай” | 70 |
| 16 | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид | Танхим | Лекц | Эрүү шүүлтээс ангид байх эрх | 20 |
| 17 | Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик инженер, тээврийн сургуулийн багш, албан хаагч | Танхим | Лекц | Эрүү шүүлтээс ангид байх эрх, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь | 60 |

| | | | | | |
|-------------------|--|--------|-------------------|---|-------------|
| 18 | Баянзүрх дүүргийн Прокурорын газрын прокурор, Цагдаагийн газрын мөрдөгч болон төрийн захиргааны албан хаагчдад | Танхим | Лекц | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, стратеги, Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт тавих прокурорын хяналт, тактик, Төрийн албан хаагчийн ёс зүй | 110 |
| 19 | Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб | Танхим | Лекц | Хүний эрх, ёс зүй, эрүү шүүлтээс ангид байх эрх | 80 |
| 20 | ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын бакалаврын сургалтын хөтөлбөрт эчнээ хэлбэрээр суралцагчдад | Танхим | Лекц | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь | 20 |
| 21 | Дархан-Уул аймгийн ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагч, бусад албан тушаалтан | Цахим | Лекц | Эрүү шүүлтээс ангид байх эрх | 50 |
| НИЙТ | | | | | 1497 |
| Орон нутаг | | | | | |
| 22 | Говь-Алтай аймгийн Цагдаа, ШШГГ, Хилийн цэргийн 0214 дүгээр анги | Танхим | Лекц, семинар | Эрүү шүүлтээс ангид байх эрх | 172 |
| 23 | Увс аймгийн ШШГГ | | Лекц | | 50 |
| 24 | Говьсүмбэр аймгийн ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги | | Лекц | | 50 |
| 25 | Булган, Дундговь аймаг - ШШГГ, хууль сахиулах байгууллагын алба хаагчдад | | Мэдээлэл хүргэсэн | | 100 |
| НИЙТ | | | | | 372 |

| ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД | | | | | |
|--|--|-------------------------|-------------------------------------|---|-------|
| Улсын Ерөнхий прокурорын газар | | | | | |
| 26 | Прокуроруудад зориулсан сургалт | Танхим | Лекц | Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн талаар анхаарах зарим асуудал, Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага | 471 |
| 27 | Төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан сургалт | Танхим, цахим хэлбэрээр | Лекц, семинар, дасгал | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр | 1126 |
| Авлигатай тэмцэх газар | | | | | |
| 28 | ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Баянгол дүүргийн Цагдаагийн газар, Бүртгэл, хяналтын төв, мөн ЦЕГ-ын сургагч багш нар | Танхим | Лекц | “Эрүү шүүлт”, “Авлигын гэмт хэрэг, Хүний эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх”, “Авлигын гэмт хэрэг, эрүү шүүлт”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар” | 400 |
| Цагдаагийн ерөнхий газар | | | | | |
| 29 | Алба хаагч, иргэд, олон нийт | Танхим, цахим хэлбэрээр | Мэдээлэл өгөх, лекц, яриа, таниулах | Хүний эрх, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний эрхийг алба хаагчид болон иргэд, олон нийтэд сурталчлан таниулах | 46756 |

| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | | | | | |
|---|---------------------------------------|-------------------------|-------------------------------------|--|--------------|
| 30 | Алба хаагч | Танхим, цахим хэлбэрээр | Мэдээлэл өгөх, лекц, яриа, таниулах | Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах | 3290 |
| 31 | Хорих ял эдэлж буй хүн | Танхим | | | 1139 |
| 32 | Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүн | Танхим, цахим хэлбэрээр | | | 145 |
| 33 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагч | Танхим | Лекц | Хүнийг алагчлахгүй байх, ялгаварлахгүй байх, дээрэлхэхгүй байх чиглэлээр | 94 |
| 34 | Цагдаагийн алба хаагч | Танхим | Лекц | Хүний эрх | 45 |
| НИЙТ | | | | | 55335 |

Тайлангийн хугацаанд хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийг таниулах зорилгоор 407 удаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 171 цаг тус тус сургалт зохион байгуулж, нийт 55335 (давхардсан тоогоор) төрийн албан хаагч, иргэд, хүүхэд, оюутан, залуучуудыг хамруулсан.

Хүснэгт 50

| № | Үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | Нийт |
|---|-------------------------------------|---------|---------|---------|---------|-------|
| 1 | Сургалт, хэлэлцүүлэг, таниулах ажил | 31 | 37 | 151 | 386 | 605 |
| 2 | Бэлтгэгдсэн сургагч багш | - | 73 | 151 | 1100 | 1324 |
| 3 | Сургалтад хамрагдсан хүний тоо | 3357 | 4858 | 32640 | 55335 | 96190 |

ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш 2022-2025 оныг дуустал нийт 605 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 96190 хүнийг хамруулсан.

Сургалтын агуулга, сэдэв

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдад Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах зорилгоор дээр дурдсан 2 дугаар хэсэгт дурдсан сэдэв, түүний агуулгын хүрээнд сургалт зохион байгуулсан.

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах үйл ажиллагаа нь сургалт, хэлэлцүүлэг, хурал зохион байгуулах, нөлөөллийн бусад арга хэмжээг авах байдлаар хэрэгжиж ирсэн бөгөөд ЭШУС үндэсний ажиллагаа нь гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжөөр тухайн газар, эрх бүхий албан тушаалтан заавал хэрэгжүүлдгээрээ онцлогтой.

Иймд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, төрийн бус байгууллагатай мөн хамтын ажиллагааг өрнүүлж Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах сэдвүүдийн хүрээнд сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулсан.

Сургалтын сэдвийн жагсаалт

Хүснэгт 51

| |
|--|
| <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Олон улсын гэрээний хэрэгжилт; Манделагийн дүрэм, түүний агуулга мөн чанар, учир холбогдол;</p> |
| <p>Алагчлах, ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;</p> |
| <p>Хүний эрхийн үзэл баримтлал;</p> |
| <p>Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” буюу Мендезийн зарчмуудыг Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нутагшуулах нь;</p> |
| <p>Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага;</p> |
| <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт;</p> |
| <p>Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал;</p> |
| <p>Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал; Хүний эрхийн тухай үндсэн ойлголт;</p> |
| <p>Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмж, түүний хэрэгжилт, үр дагавар; Хүний эрхийн тухай үндсэн ойлголт;</p> |
| <p>Эрүү шүүлтээс ангид байх эрх; Олон улсын гэрээ, конвенцын агуулга, мөн чанар; Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцахаас урьдчилан сэргийлэх нь;</p> |
| <p>Хяналт шинжилгээ хийх арга зүй, ярилцлага хийх арга зүй, хүний эрхийг хамгаалах тогтолцоо;</p> |
| <p>Үе тэнгийн дээрэлхэлтийн ойлголт, түүнээс ангид байх тухай; Хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхах, алагчлах явдлаас ангид байх эрхийг хангахад хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзах зарим асуудал;</p> |
| <p>Зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь;</p> |
| <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, стратеги; Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт тавих прокурорын хяналт, тактик; Төрийн албан хаагчийн ёс зүй;</p> |
| <p>Хүний эрх, ёс зүй, эрүү шүүлтээс ангид байх нь;</p> |

| |
|---|
| Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн талаар анхаарах зарим асуудал, Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага; |
| Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; |
| Авлигын гэмт хэрэг, эрүү шүүлт; |
| Хүнийг алагчлахгүй байх, ялгаварлахгүй байх, дээрэлхэхгүй байх зэрэг чиглэлээр сургалт зохион байгуулсан. |

Сургалтад хамрагдсан байдал

Тайлангийн хугацаанд хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийг таниулах зорилгоор 386 удаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 171 цаг тус тус сургалт зохион байгуулж, нийт 55335 (давхардсан тоогоор) төрийн албан хаагч, иргэд, хүүхэд, оюутан, залуучуудыг хамруулсан.

Хүснэгт 52

| № | Үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын дүн |
|---|--------------------------------|---------|---------|---------|---------|--|
| 1 | Сургалтад хамрагдсан хүний тоо | 3357 | 4858 | 32640 | 55335 | 96190 |
| 2 | Өсөлтийн хувь | - | 44.7% | 571.9% | 69.5% | Жил бүр дунджаар 54.5 хувийн өсөлттэй байна. |

Хүснэгт дэх сургалтад хамрагдсан хүний өсөлтийн хувийн огцом өсөлтийн хувьд сургагч багш хангалттай бэлтгэгдсэн, орон нутаг бүрд эрүү шүүлтээс ангид байх эрхийн сургалтыг зохион байгуулсанд оршино.

Сургалтад хамрагдсан хүний тоо өсөх хандлагатай байгаа нь статистикт буй тооноос давсан хэрэгцээ байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, энэ талаар хүн өөрийн эрхээ хамгаалах сонирхол бүхий утга илэрхийлэгдсэн гэж үзэж байна.

Албан хаагчдын ёс зүйн төлөвшил харилцан адилгүй, харилцаа хандлага тодорхой хэмжээнд алдагдсан буюу ажлын байранд таагүй мэдээ, мэдээлэл тараах, түүнд хөтлөгдөж удирдлагаас алба хаагчидтай харьцах, алагчлах, ялгаварлан үзэх байдал байгаа нь шат шатандаа сургалт, нөлөөллийн ажил дутмаг байгааг илтгэж байна.

Хүний эрх тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийн агуулгаар сургалт зохион байгуулах давтамж харилцан адилгүй байна. Алба хаагчдаас хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн чиглэлээр сургалт тогтмол авах хэрэгцээтэй байгааг илэрхийлсэн.

ЗУРГАА. БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь сургалт, нөлөөллийн ажлыг олон улсын болон дотоодын байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Олон улсын байгууллагуудтай:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT);
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ)-тэй хамтарч сургалт, нөлөөллийн арга хэмжээ 3 удаа зохион байгуулсан.

Дотоодын байгууллагуудтай:

- Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв;
- Хүүхдийн асрамж, халамжийн байгууллага;
- Ахмад настны үндэсний төв;
- Монгол Улсын Ерөнхий прокурорын газар;
- Авлигатай тэмцэх газар;
- Иргэний нийгмийн байгууллага;
- Дотоодын цэргийн байгууллага;
- Дотоод хэргийн их сургууль;
- Соёл урлагийн их сургуультай хамтран ажиллаж, сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг тогтмол зохион байгуулсан.

ДОЛОО. СУРГАГЧ БАГШ НАРТ ТУЛГУУРЛАН СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 224 сургагч багш, 2025 онд “Мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмыг нутагшуулах нь” сургалтаар сургагч багшийн статустай бэлтгэгдсэн 1100 алба хаагч, албан тушаалтан байна.

Мөн орон нутаг хариуцсан референтүүд, сургагч багш нартай хамтран ажиллаж “Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Тухайлбал,

Хүснэгт 53

| | |
|--|------------------------------|
| Говь-Алтай аймгийн Цагдаа, ШШГГ, Хилийн цэргийн 0214 дүгээр анги | Эрүү шүүлтээс ангид байх эрх |
| Увс аймгийн ШШГГ | |
| Говьсүмбэр аймгийн ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги | |
| Булган, Дундговь аймаг - ШШГГ, хууль сахиулах байгууллагын алба хаагчдад | |

Орон нутагт тус үндэсний ажиллагаанаас тухай бүрд захиалсан сэдвийн агуулгаар сургалт зохион байгуулахад хүндрэлтэй байгаа нь хүний нөөцийн хувьд хангалттай бус байгаагийн илэрхийлэл бөгөөд тухайн газарт байгаа сургагч багш, референтүүдийн нөөцөд тулгуурлан зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах, хамгаалах сургагч багш нартай харилцан ажиллах талаар тухай бүр хэлэлцэж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, мэдээлэл өгөх зэргээр ажилласан.

НАЙМ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн зохион байгуулж ажиллаж ирсэн бөгөөд тогтмол, хяналт шинжилгээ хийх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдэд сурталчлах, судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах зэргээр ажиллаж, нийгэм, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг хуулийн хүрээнд зохион байгуулсан.

А) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасан ажил арга хэмжээг хэрэгжүүлэх, “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр”-т зориулан 2025 оны 06 дугаар сард зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”



сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Уг хуралд Авлигатай тэмцэх газар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, “Их засаг” Олон улсын их сургууль, Шихихутуг их сургууль, Монголын үндэсний их сургууль, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Иргэдийн шударга шүүх”, “Сэтгэл зүйн мэдрэмж” төрийн бус байгууллага болон бусад байгууллага, судлаач, оюутан, сонсогчдын төлөөлөл оролцож, илтгэл хэлэлцүүлсэн нь талуудын оролцоог хангасан, өргөн хүрээтэй хурал болж



өндөрлөсөн.

Хурлаас “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” урилга гаргаж урилгад эрдэм шинжилгээний хуралд оролцогчид нэгдэж, “Улаанбаатарын тунхаглал”-ыг боловсруулсан ба төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага дэмжихээ илэрхийлж, 2025 оны жилийн эцсийн байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль зэрэг байгууллага дэмжин нэгдэж, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлж ажиллахаа илэрхийлсэн.



Хурлын үеэр Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдийн дунд “Эрүү шүүлтгүй Монгол хүүхэд, өсвөр үеийнхний нүдээр” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулсан бөгөөд нийт 8 байгууллагын 77 хүүхэд оролцож, 108 бүтээл ирүүлснээс 20 бүтээлийг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус урамшуулсан.



Б) Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран хуулиар хүний эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь” хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга, түүний удирдлагын баг, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Нямдорж “Саатуулах үйл ажиллагаанд эрүүдэн шүүхээс ангид байх, хүний эрхийг хангах нь” сэдвээр, Эрүүлжүүлэх, саатуулах төвийн дарга, цагдаагийн хурандаа Б.Ариунжаргал “Эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн ахмад Б.Бат-Оргил “Эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангах нь” сэдвээр, Хэрэг бүртгэх албаны Мэргэжил арга зүйн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Нансалмаа “Зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг саатуулахад анхаарах асуудал” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн. Тус хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн прокурорын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах байгууллагын харьяа алба, хэлтсийн төлөөлөл тус тус оролцсон.

Хэлэлцүүлгийн явцад хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг мөрдөх, байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлэх, харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн дутагдалтай талыг цаашид нөхөх, ажиллаж байгаа бүрэлдэхүүнд сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол тасралтгүй явуулах талаар хэлэлцсэн.

В) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хичээлийн шинэ жил эхэлж байгааг тохиолдуулан 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр “хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, сургуулийн орчинд хамгийн их үйлдэгддэг үе тэнгийн дээрэлхэлт, түүний сөрөг нөлөөлөл, түүнээс хамтдаа урьдчилан сэргийлэх” чиглэлээр мэдээлэл хүргэсэн.

Мөн Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар хамгаалан, бэхжүүлсэн Хүүхдийн эрх, Монгол Улсын нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” түүний Нэмэлт протоколын талаар товч мэдээлэл өгч, үе тэнгийн дээрэлхэлт, түүний үр дагавар, урьдчилан сэргийлэх арга замыг хэлэлцэж, ярилцлага өрнүүлж, сонирхсон асуултад хариулж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.



Арга хэмжээний хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор, профессор Я.Цэлмэн Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн дунд бүлэгт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуулийн ахлах бүлэгт, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн ахлах бүлэгт, Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Амгалан” сургуулийн бага, дунд бүлгийн 200 гаруй сурагчдад тус тус мэдээлэл танилцуулсан.

ЕС. СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Тайлангийн хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн 51 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд зөвлөмж тус бүрээр тухайн байгууллага, албан тушаалтнуудад ажилтан, алба хаагчид, эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүс, иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулж, тайлангаа ирүүлэхийг даалгасан. Тухайлбал:

Хууль сахиулах байгууллагын алба хаагчдад сургалтын давтамж харилцан адилгүй, алба хаагчдын хүний эрхийн болон эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээлэл хангалттай бус, хууль, олон улсын гэрээний чиглэлээр ойлголт харилцан адилгүй, хэрэглэх ур чадвар сул, хүний эрхийн мэдрэмжийг ахиулах, ёс зүйтэй ажиллах, ёс бус үг хэллэг хэрэглэхгүй байх, хүч хэрэглэхийг уртал болгохгүй байх, сэтгэл зүйн үйлчилгээг алба хаагчдад тогтмолжуулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн танин мэдэхүйн үзүүлэнг байршуулах, ажлын байрны эрсдэлтэй нөхцөл байдлыг тогтоож хүний нөөцийн талаар зохистой арга хэмжээ авах;

Боловсролын байгууллагын хувьд бүх шатны багш, сургалтын байгууллагын албан хаагч, багш нарт эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээлэл авах, нөхцөлийн эрүү шүүлтгүй хамт олон болох, алагчлахгүй байх, ялгаварлан харьцахгүй байх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авах;

АРАВ. ҮР ДҮН, АХИЦ, ДЭВШИЛ

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах талаар зохион байгуулсан сургалт 2025 онд өмнөх онуудаас өссөн бөгөөд дунджаар 54.5 хувийн өсөлттэй байж үндэсний ЭШУС үндэсний ажиллагааны алба хаагчид санаачилгатай ажилласан.

Иймд хууль зүй, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хүүхдийн асрамж, халамжийн төвүүд, ахмад настны асрамжийн газар, хүн өөрийн хүслээр чөлөөтэй гарч явах боломжгүй бүхий л газруудад хүний нөөцийн цөөн хүчээр өндөр үр дүн гаргахыг хичээсэн.

Сургалтын үр дүнд эрүү шүүлтэд өртсөн, хохирсон хүмүүс эрхээ хамгаалах талаар өргөдөл, гомдол гаргах эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллахыг таниулах чиглэлээр ажилласан. Эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний өргөдөл гомдлыг шилжүүлээгүй, боогдуулсан буюу гадуурхсан албан тушаалтанд хариуцлага тооцуулж, энэ талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээ авсан.

АРВАН НЭГ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь байгуулагдсан цагаасаа жил ирэх тутам сургалтын цар хүрээг өргөтгөх, нийтийг хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд тогтмол анхаарч Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.1.2-т “олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах,” чиг үүргийг дотоод болон гадаад нөөц боломждоо түшиглэн хэрэгжүүлж ирсэн.

Хүснэгт 54

| № | Үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын дүн |
|----|--------------------------------|---------|---------|---------|---------|--|
| 1. | Сургалтад хамрагдсан хүний тоо | 3357 | 4858 | 32640 | 55335 | 96190 |
| 2. | Өсөлтийн хувь | - | 44.7% | 571.9% | 69.5% | Жил бүр дунджаар 54.5 хувийн өсөлттэй байна. |

Эрүү шүүлтгүй Монголын төлөө уриатайгаар ЭШУСҮА-ны албан хаагч бүр хяналт шинжилгээ хийхийн зэрэгцээ эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, иргэд, олон нийтийн мэдэх эрхийг хангах, өөрийн болон бусдын эрхийг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлэх талаар хүний эрх хамгааллын тогтолцооны талаар мэдээлэл өгөх, танилцуулах зэргээр танхимын болон цахим хэлбэрээр, ганцаарчлан эсхүл бүлгээр ярилцах бүрд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн.

Хүний эрхийн олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тэдний сайн туршлагаас суралцан, шинэ ололттой танилцах зэргээр ЭШУСҮА-ны албан хаагчид мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлж, хяналт шинжилгээ хийх ур чадвар ахиулж, хүний эрхийг дээдлэх хандлагыг бататган төлөвшүүлсэн. НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ)-ийн төлөөлөгч, ахлах зөвлөхүүдээс ЭШУСҮА-ны албан хаагчдад зохион байгуулсан сургалт үр дүнтэй болсон.

Эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах чиг үүрэг нь төрийн албан хаагч төдийгүй, хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, их, дээд боловсролын байгууллагууд, хүүхдийн асрамж, халамжийн төвүүд, ахмад настны асрамжийн газар, сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, түүнчлэн хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй бүх газарт хэрэгждэг бөгөөд ЭШУС байгууллагаас тогтмол зохион байгуулж ажилласан.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх, хүний эрхийн суурьтай буюу хүний эрхийг дээдлэх хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ)-тэй

хамтран зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар болон Мөрдөн байцаах албаны 100 алба хаагч танхимаар, 1000 алба хаагчийг цахимаар хамруулж, “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчим” (Мендезийн зарчим)-ыг үе шаттайгаар нутагшуулж байна.

Мөн тайлангийн хугацаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийг таниулах сургалтыг 386 удаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 171 цаг тус тус зохион байгуулж, нийт 58.466 (давхардсан тоогоор) шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн суралцагч, сонсогч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн, төрийн цэргийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, их сургуулийн төлөөлөл “Улаанбаатарын тунхаглал”-ыг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлж ажиллахаар тусгайлсан төлөвлөгөө гаргаж албан ёсоор мэдэгдсэн. Энэ нь эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангахад онцгой учир холбогдолтой бөгөөд 2026 оны уг тунхаглалд нэгдсэн хууль сахиулах байгууллагуудаас хүний эрхийн дэвшил гаргах үндэс болно.

ᠳᠥᠷᠥᠪᠳᠦᠭᠡᠭᠦᠷ ᠪᠦᠯᠢᠭ᠎ᠠ
ᠡᠷᠦᠭᠦ ᠰᠢᠶᠠᠨᠲᠡᠭᠦᠰ
ᠤᠷᠦᠳᠴᠢᠯᠠᠨ ᠰᠡᠷᠭᠢᠶᠢᠯᠡᠬᠦ
ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠭᠠᠭ



N | P | M
MONGOLIA

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СУРТАЛЧИЛГАА



N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРТАЛЧИЛГАА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Долоодугаар бүлгийн 33 дугаар зүйлийн 33.1.2-“Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах”, 33.1.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах”, 33.1.4-т “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах” бүрэн эрхийг тус тус тодорхойлсон.

Энэхүү эрх зүйн үндэслэлийн хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (ЭШУСҮА) нь эрүү шүүлтийн хор аюул, эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг олон нийт, төрийн албан тушаалтан, иргэдэд түгээх мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд ЭШУСҮА нь 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, мөн асуудал эрхэлсэн гишүүний баталсан төлөвлөгөө, удирдамжийг удирдлага болгон сурталчилгааны ажлыг шат дараатай төлөвлөж, зохион байгуулалтыг ханган, хэрэгжилт, үр дүнг тооцох зарчмыг баримтлан ажиллав.

Энэхүү сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын гол зорилго нь эрүү шүүлтийн хор аюулын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн эрх зүйн баталгааг таниулах, иргэд өөрийн эрхээ мэдэх, гомдол, мэдээлэл гаргах боломжийг бодитоор ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мөн төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн болно.

Сурталчилгааны ажлыг нийт иргэд, төрийн болон орон нутгийн байгууллагын албан тушаалтан, алба хаагчид, хууль сахиулах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, мөн аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан, эсхүл өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газарт урт болон богино хугацаагаар байрлаж буй хүмүүст чиглүүлэн хэрэгжүүлэв.

Эрх нь хязгаарлагдсан орчинд байгаа хүмүүсийн хувьд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанд өртөх эрсдэл өндөр байдгийг харгалзан сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тухайн орчны онцлогт нийцүүлэн, мэдээллийн самбар, нугалбар, видео контент, танилцуулга, сургалт, уулзалт зэрэг боломжит бүх хэлбэрээр хүргэхийг зорьсон.

Тайлант хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хууль сахиулах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, мөн орон нутгийн

түвшний холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав. Сурталчилгааны ажлыг төв болон орон нутгийн түвшинд, олон нийтэд болон эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд чиглүүлэн зохион байгуулсан.

Энэ хүрээнд ЭШУСҮА нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, асуудал эрхэлсэн гишүүний баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг удирдлага болгон мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөлтийг шат дараатайгаар боловсруулж, зохион байгуулалтыг ханган, хэрэгжилт, үр дүнг тооцох зарчмыг баримтлан эрүү шүүлтийн хор аюулыг олон нийтэд таниулах дараах таван үндсэн чиглэлийг тодорхойлон үйл ажиллагаагаа хэрэгжүүлэв.

- Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг төрийн албан тушаалтан, иргэдэд таниулах;
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах замаар мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд хүртээмжтэй хүргэх;
- Аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан, эсхүл өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газарт байрлаж буй хүмүүс, мөн тухайн газарт чиг үүргийн хүрээнд албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах зорилгоор олон төрлийн сурталчилгааны хэрэглэгдэхүүн бүтээж, ашиглах;
- Улсын Их Хурлын Тамгын газраас өгсөн санал, зөвлөмжийн хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудсыг ажиллуулах.

ХОЁР. ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОР АЮУЛ, ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙГ ТАНИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг төрийн албан тушаалтан, иргэдэд таниулах зорилгоор сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээлэл, зурагт хуудас, видео контентыг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” X (Twitter), “NPM-Mongolia” инстаграм хуудсаар дамжуулан тогтмол, түргэн шуурхай түгээж ажиллав.

Олон нийтэд хүрэх сувгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “NPM-Mongolia” инстаграм хуудсыг 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр хөтөлж эхэлснээр сурталчилгааны сувгийн тоо, хамрах хүрээ өргөжив.

Мэдээллийн цахим сувгуудаар эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бичлэг, reels, story, постер, подкаст зэрэг хэлбэрээр нийт 300 удаагийн мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээсэн. Үүнийг агуулгаар нь ангилбал:

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаарх мэдээлэл - 217 удаа;
- Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээлэл, зурагт хуудас - 24 удаа;
- Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх 1-75 минутын үргэлжлэх хугацаатай видео бичлэг - 35 удаа;

- Сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон бусад үйл ажиллагааны талаарх reels хэлбэрийн мэдээлэл - 24 удаа.

Эдгээр мэдээлэл нь фейсбүүк, Х, инстаграм хуудсаар дамжуулан давхардсан тоогоор 2.1 сая хүнд хүрсэн нь 2024 онтой харьцуулахад 3.1 дахин өссөн үзүүлэлт юм. Үүнээс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй холбоотой хүний эрхийн зөрчлийн талаар бэлтгэсэн дүрс бичлэг бүхий сэрэмжлүүлэг давхардсан тоогоор 1.6 сая хүнд хүрч, 56 мэдээллийн сайт, 13 телевизээр дамжуулан түгээгдсэн байна.

Сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээтэй холбоотой 217 удаагийн мэдээллийг илүү нарийвчлан авч үзвэл:

- Эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад эрүү шүүлт үүсэх тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ - 65 удаа;
- Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар олон нийт, төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг - 50 удаа;
- Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран ажилласан уулзалт - 20 удаа;
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон бусад олон улсын гэрээ, конвенц, хууль, тэмдэглэлт өдрүүдэд зориулан бэлтгэсэн зурагт хуудас - 81 удаа;
- Хэвлэлийн бага хурал - 1 удаа.

Цахим орчинд хамгийн өндөр хандалт авсан нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийсэн хяналт шинжилгээний талаарх хэвлэлийн бага хурлын шууд дамжуулалт бөгөөд уг мэдээлэл давхардсан тоогоор 12 мянган хүнд хүрсэн байна.

Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай



хууль зэрэг баримт бичгийн агуулгаар 24 нэр төрлийн зурагт хуудас бүтээж, 500 ширхэг цагалбар хэвлэн төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв. Мөн эдгээр зурагт хуудсыг цахим сувгуудаар үе шаттайгаар түгээж ажилласан.

ДӨРӨВДҮГЭЭР
БҮЛЭГ




Түүнчлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүтээсэн ЭШУС үндэсний ажиллагааны бэлгэдэл “Галхан” дүрийг ашиглан бүх насны иргэдэд зориулсан зурагт хуудас бэлтгэв.



Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх 1-75 минутын үргэлжлэх хугацаатай ярилцлага, нэвтрүүлгийг 16 удаа олон нийтэд хүргэж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын агуулгыг тайлбарласан дараах видео контентуудыг тогтмол давтамжтайгаар түгээсэн. Үүнд сургалт, ярилцлага, нөлөөллийн контент, бодлогын байр суурь илэрхийлсэн мэдээ, мэдээлэл багтсан бөгөөд СЭМҮТ-тэй холбоотой бэлтгэсэн дүрс бичлэг бүхий сэрэмжлүүлэг давхардсан тоогоор 1.6 сая удаа үзэгдсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2025-2026 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрт заасны дагуу хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилгоор 1 минут 30 секунд хүртэлх reels хэлбэрийн контентыг тайлант хугацаанд тогтмол түгээж, хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан орчинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг 24 удаагийн reels хэлбэрээр олон нийтэд хүргэн ажиллалаа.

Дээрх сурталчилгаа, мэдээлэл, ойлголт таниулах ажлын үр дүнд эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, анхаарал бодитоор нэмэгдсэн нь цахим орчны хандалт, хэвлэл мэдээллийн идэвх, мөн ЭШУСҮА-нд хандах иргэдийн тоо өссөнөөс ажиглагдаж байна.



ДӨРӨВДҮГЭЭР
БҮЛЭГ

Олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээлэл, видео болон богино хэлбэрийн контентыг хослуулан ашигласан нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн албан тушаалтан, иргэд, эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд байгаа хүмүүсийн эрхийн талаарх ойлголтыг нэгэн зэрэг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Ялангуяа бодит баримт, дүрс бичлэгт тулгуурласан контент нь эрүү шүүлтийн хор аюулыг олон нийтэд ойлгомжтойгоор таниулахад илүү үр дүнтэй байлаа.

Иймд эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг таниулах нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны салшгүй хэсэг бөгөөд энэхүү чиг үүргийг тогтвортой, системтэй хэрэгжүүлэх нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас тайлант хугацаанд эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх ойлголтыг олон нийт, төрийн албан тушаалтнуудад таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллав.

ДӨРӨВДҮГЭЭР
БҮЛЭГ



Энэ хүрээнд асуудал эрхэлсэн гишүүний оролцсон ярилцлага, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаарх мэдээллийг 96 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 365 удаа олон нийтэд хүргэсэн бөгөөд сонины ярилцлагыг 5 удаа нийтэлсэн байна. Уг үзүүлэлт нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хэвлэл мэдээллээр түгээгдсэн мэдээ, мэдээллийн тоо 15 хувиар өссөн байгааг харуулж байна.



“Мэдээллийн цаг” хэвлэлийн бага хурлыг гурав дахь удаагаа зохион байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр илэрсэн хүний эрхийн зөрчлийн талаар асуудал эрхэлсэн гишүүн болон нэгжийн албан хаагчид хэвлэл

мэдээллийн байгууллагуудад мэдээлэл өгсөн. Тус хэвлэлийн бага хурлыг ТВ9, Eagle News, ТВ8, С1, 25 дугаар суваг телевизүүд сурвалжилж, Tsahiur.mn сайтаар шууд дамжуулан хүргэсэн бөгөөд уг шууд дамжуулалтыг давхардсан тоогоор 12 мянган хүн үзсэн байна.

Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тогтмол, цэгцтэй байдлаар тайлбарлан таниулах зорилгоор “Монголын Үнэн” сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулж, “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” тусгай буланг тогтмол ажиллуулж ирлээ. Тус булангаар дамжуулан эрүү шүүлтийн хор аюул, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, хүний эрхийн эрсдэлийн талаар үе шаттайгаар мэдээлэл хүргэсэн ба олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэв.

Хамтын ажиллагааны хүрээнд:

- 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн “002” дугаарт “Зэрэгцээ ертөнцөд гацагсад”;
- 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “008” дугаарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо”;
- 2025 оны 3 дугаар сарын 14-ний “009” дугаарт “Асрамжийн газрыг ахмад настны амьдран суух диваажин болгох хүсэл”;
- 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “037” дугаарт “Мендезийн зарчим ба хүн хэлээрээ, мөл хөлөөрөө”
- 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “48” дугаарт “Эрлэгийн үүдийг хаах нь буюу эрүүдэн шүүхийн эсрэг ажиллагаа” зэрэг тусгай сурвалжилгуудыг бэлтгэн уншигчдад хүргээд байна.



Монголын Үндэсний Олон Нийтийн Радиотой хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын ажиллагааны хүрээнд “Мэдэх эрх” нэртэй 10 удаагийн подкастыг бэлтгэн олон нийтэд түгээж ажиллав. Подкастын бүх дугаарыг MNB.mn сайт, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио (Монголын радио) болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн бөгөөд тайлант хугацаанд давхардсан тоогоор 45 мянган хүнд хүрсэн.

Мөн Монголын сайтын холбоотой байгуулсан санамж бичгийн хүрээнд ЭШУСҮА-ны фейсбүүк хуудсаар түгээж буй мэдээ, мэдээллийг Time.mn, Dorgio.

mn, News.mn, Tsahiur.mn зэрэг 10 мэдээллийн сайтаар давхар түгээж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл олон нийтэд хүргэх зохион байгуулалтыг ханган ажиллаж байна. Тус подкастын зочдоор:

- Өнөр бүл хүүхдийн төвийн захирал, үйлчилгээний гавьяат ажилтан М.Өлзийчимэг;
- Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү;
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” олон улсын байгууллагын ахлах зөвлөх Бен Бакланд;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Г.Анхболд;
- Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн Ххурандаа П.Очбадрах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа П.Оростоого;
- Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны дарга, ахлах комиссар Ч.Жаргалбаатар;
- Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн С.Дондов;
- Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров;
- Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар оролцож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой асуудлаар байр суурь, санал бодлоо илэрхийлсэн.



Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай зорилтот хамтын ажиллагааг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлснээр эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээлэл олон нийтэд бодитой, хүртээмжтэйгээр хүрч, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэл, анхаарал нэмэгдсэн байна.

ДӨРӨВ. ЭРХ ЧӨЛӨӨ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ОРЧИНД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд урт болон богино хугацаагаар байрлаж буй хүмүүс, мөн тухайн орчинд хуульд заасан чиг үүргийн хүрээнд албан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчдад эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх ойлголтыг таниулах, нөлөөлөх ажлыг шат дараатайгаар зохион байгуулж ажиллав.

4.1.Нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ, зорилт тодорхойлогдсон байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс 2025 онд Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1200 албан хаагчдаас авсан асуумжийн дүнгээр хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт, мэдээлэл авах шаардлага өндөр байгааг тогтоов. Түүнчлэн хорих анги, цагдан хорих байр, баривчлах төв, эрүүлжүүлэх, саатуулах байранд байрлаж буй хүмүүс болон тэнд ажиллаж буй албан хаагчдад эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээллийг тогтмол хүргэх шаардлагатай нь илэрсэн.

4.2.Эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд зориулсан мэдээлэл, контентын хүртээмжийг хангаж ажилласан байдал

“Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдэвт цуврал анимейшн, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх агуулгыг багтаасан нугалбар, зурагт хуудас, бичлэг, reels, story зэрэг контентыг аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаг, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудын хүлээлгийн өрөөний дэлгэц, албан хаагчдын цахим хаяг, дотоод сургалт, шугамын радио зэрэг боломжит сувгаар дамжуулан түгээж ажиллав.

4.3.Цагдаагийн байгууллагын алба хаагчдад хүний эрхийн мэдлэг олгосон сургалт, мэдээллийн хэрэгжилт



Цагдаагийн ерөнхий газрын эрүүлжүүлэх, саатуулах байр болон мэдүүлэг авах өрөөнд ажиллаж буй албан хаагчдад зориулан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийн талаар 6 удаагийн сургалт зохион байгуулж, уг сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр хэрэгжүүлэв. Мөн нийслэл болон 21 аймаг дахь цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөөнүүдэд эрүү шүүлтийн эсрэг мэдээллийн самбарыг байршуулав.

4.4.Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээтэй уялдуулсан сургалт, нөлөөллийн ажлын хэрэгжилт

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу тайлант хугацаанд 65 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, уг хяналт шинжилгээгээр илэрсэн асуудал, тогтоогдсон нөхцөлтэй уялдуулан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулсан. Үүнд:

- “Эрүү шүүлтээс ангид байх эрх”;
- “Хүний эрхийн тухай ойлголт, хүний эрхийн үзэл баримтлал”;
- “Тайлбар, мэдүүлэг”;
- Хууль сахиулах болон ШШГБ-ын алба хаагчдын үйлдэж болзошгүй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинж зэрэг сэдвүүд багтав.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн талаарх нийт 65 удаагийн сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэв.

4.5.Хамтын ажиллагаанд суурилсан нөлөөллийн ажлын үр дүн

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай тогтмол хамтран ажиллаж, эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгууллаа. Энэ хүрээнд:

- “Танаас мэдүүлэг авахдаа айлган сүрдүүлж, зүй бус үг хэллэг хэрэглэхийг хориглоно”;
- “Таныг шүүхийн шийдвэргүйгээр албадан ирүүлэх ёсгүй”;
- “Мэдүүлэг авах хугацаа, цагийн хязгаарлалт” зэрэг агуулгатай постер, богино хэмжээний видео, story, reels контентыг бэлтгэн олон нийтэд түгээв.

Мөн аймаг, дүүргийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдтэй хамтран “Монгол Улсын иргэн бүр эрүүдэн шүүхээс ангид байх эрхтэй”, “Эрүү шүүлтийн хэлбэр” сэдэвт зурагт хуудас, гомдол, мэдээлэл хүлээн авах асуумж бүхий QR кодыг олон нийтийн газар, төрийн байгууллагын мэдээллийн самбаруудад байршуулж ажиллав.

Түүнчлэн Цагдаагийн байгууллагын www.police.gov.mn цахим хуудас болон фейсбүүк орчинд 9 төрлийн мэдээллийг байршуулж, 675452 цахим хэрэглэгчдэд хүргэсэн бөгөөд “Эрүү шүүлтгүй Монголын төлөө - Улаанбаатарын тунхаглал”-ыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 66 фейсбүүк хуудсаар дамжуулан 2.486.547 цахим хэрэглэгчдэд сурталчлав.

4.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орчинд хүний эрхийн мэдээлэл хүргэж, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлсэн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хорих анги, байгууллага, газар, хэлтсийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч, мөн харьяа 12 хорих ангид ял эдэлж буй хүмүүс болон албан хаагчдад “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх”-ийн хүрээнд бүлгийн болон ганцаарчилсан мэдээлэл хүргэж ажиллав.

Эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд байгаа хүмүүс болон албан хаагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг сургалт, мэдээлэл, контент, хамтын ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлснээр эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт бодитоор нэмэгдэж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд тодорхой ахиц гарсан байна.

ТАВ. ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОР АЮУЛЫГ ТАНИУЛАХ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БҮТЭЭЖ, АШИГЛАСАН БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг төрийн албан тушаалтан, иргэдэд хүргэх зорилгоор судалгаа хийх, ном, сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурталчилгааны хэрэглэгдэхүүн боловсруулах ажлыг төлөвлөж, дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

5.1. Тайлан, судалгааны материал хэвлэн нийтэлж, түгээсэн байдал

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024 оны (гуравдугаар) тайланг монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлж, монгол, англи хэл дээрх хувилбарыг хэвлүүлэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, тайланг нийт 300 хувь хэвлүүлэн холбогдох олон улсын байгууллага, төрийн албан тушаалтан, иргэдэд хүргүүлэв.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх зорилгоор зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Монголын Криминологичдын холбооны тэргүүлэгч, судлаач, хууль зүйн доктор, профессор Б.Батзоригтой 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”-ны тайланг боловсруулж, олон нийтийн хүртээл болголоо.

5.2. Эрх зүйн баримт бичиг, эмхэтгэл, гарын авлага бэлтгэн түгээсэн байдал

- Эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах зорилгоор “Эрүүдэн шүүхээс ангид байх эрх” олон улсын эмхэтгэл-ийн эхийг бэлтгэн, 500 хувь хэвлэн нийтэлж, холбогдох олон улсын байгууллага, төрийн албан тушаалтан, иргэдэд түгээв.
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” олон улсын байгууллагын санхүүжилтээр хамтран “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг монгол хэл рүү орчуулж, хэвлэн нийтэлж, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах эрх бүхий алба хаагчдад түгээсэн.

5.3. Сурталчилгааны хэрэглэгдэхүүн, зурагт хуудас, нугалбар бэлтгэсэн байдал

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 25 заалт тус бүрд зориулсан зурагт хуудас бүтээх, календарь хэвлэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, 24 ширхэг зурагт хуудас бүтээж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудсаар болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад түгээв.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга нугалбар хуудсыг 2,000 хувь хэвлүүлэн олон нийтэд түгээж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн давтамжтайгаар хэвлэн түгээж ажиллалаа.

ЗУРГАА. ЦАХИМ ХҮРТЭЭМЖ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Улсын Их Хуралд өргөн барьсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны тайлан, түүний хүрээнд хийсэн дүн шинжилгээгээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд тогтмол, төвлөрсөн, ойлгомжтой хэлбэрээр хүрэх тогтолцоо дутмаг байгааг тогтоосон. Тухайлбал, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлын талаарх мэдээлэл нь олон сувгаар тархай бутархай түгээгдэж, иргэд, сонирхогч талууд бодитой, бүрэн мэдээлэл авахад хүндрэлтэй гэж үзсэн.

Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны ил тод байдал, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, олон нийтэд чиглэсэн мэдээллийн нэгдсэн сувгийг бүрдүүлэх зорилгоор тус ажиллагааны албан ёсны цахим хуудсыг шинээр байгуулж, ашиглалтад оруулсан.

6.1. Цахим хуудас байгуулах шаардлага, зорилго

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудсыг байгуулахдаа:

- Үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх;
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлын үр дүнг олон нийтэд ойлгомжтой хүргэх;
- Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй түгээх;
- Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зорилтуудыг дэвшүүлэв.

6.2. Цахим хуудсаар дамжуулан мэдээлэл түгээсэн агуулга

Шинээр байгуулсан цахим хуудсаар дамжуулан дараах үндсэн чиглэлийн мэдээллийг тогтмол түгээн ажиллав. Үүнд:


- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг, эрх зүйн үндэс;
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл;
- Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх тайлбар, танин мэдэхүйн агуулга;
- Хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, холбогдох баримт бичиг;
- Иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авах боломж, холбоо барих мэдээлэл.
- Цахим хуудсыг мэдээллийн агуулга, бүтэц, хэл найруулгын хувьд олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байхаар төлөвлөж, бусад цахим сувгуудтай уялдуулан ашиглав.

6.3. Цахим мэдээллийн сувгийн ач холбогдол, бодит үр нөлөө

Цахим хуудсыг ашиглалтад оруулснаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл нэгтгэгдсэн, системтэй хэлбэрээр олон нийтэд хүрэх боломж бүрдэв. Ингэснээр:

- Үйл ажиллагааны ил тод байдал нэмэгдсэн;
- Олон нийт, сонирхогч талууд бодит мэдээлэл авах нөхцөл сайжирсан;
- Сургалт, нөлөөллийн ажлын талаарх мэдээлэл давхардалгүй, цаг алдалгүй түгэх боломж бүрдсэн;
- Бусад мэдээллийн суваг (сошиал медиа, хэвлэл мэдээлэл)-тай уялдах суурь платформ бий болсон.

6.4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг сурталчлах хүрээнд хамтран ажилласан байгууллагуудын мэдээллийн дэмжлэг



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг олон нийт, төрийн байгууллагад таниулах, эрүү шүүлтийн хор аюул болон эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран сурталчилгаа, нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулж ажиллав.

“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ын талаарх ойлголтыг таниулах хүрээнд Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, нийт 100 удаагийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Олон нийтийн сүлжээгээр эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг таниулах хүрээнд:

- 300 удаагийн мэдээ, мэдээлэл;
- 35 удаагийн видео бичлэг;
- 24 удаагийн reels;
- 20 удаагийн story нийтлэгдэн олон нийтэд хүргэгдэв.



Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах зорилгоор 10 богино хэмжээний анимейшн бэлтгэж, тэдгээрийг TV21, ETV, Малчин ТВ, ТМ, Парламент телевизүүд болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж ажиллав. Мөн Монголын Үндэсний Олон Нийтийн Радиотой хамтран “Мэдэх эрх” цуврал подкастын 10 дугаарыг бэлтгэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны болон “Монголын радио” цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.

6.5. Олон нийтийг хамарсан кампанит ажил

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг олон нийтэд таниулах өртөөчилсөн кампанит ажлуудыг амжилттай хэрэгжүүлэв.



- Олон улсад өрнөж буй #SafeInCustody хөдөлгөөнийг Монгол Улсад нэвтрүүлж, “Улаанбаатарын тунхаглал”-д төрийн болон төрийн бус 30 гаруй байгууллагын 70 орчим төлөөлөгч нэгдэж буйгаа илэрхийлэн гарын үсэг зурав;
- Өсвөр, бага насны хүүхдүүдэд эрүү шүүлтийн хор хөнөөлийг таниулах зорилгоор “Эрүү шүүлтгүй Монгол - хүүхэд, өсвөр үеийнхний нүдээр” гар зургийн уралдааныг зохион байгуулж, 70 хүүхдийн 108 бүтээл ирснээс шилдэг 20 бүтээлийг шалгаруулан Монголын Үндэсний Төв номын санд зургийн үзэсгэлэн гаргав.

6.6.Сурталчилгааны хэрэглэгдэхүүн, гарын авлага, материал бэлтгэж түгээсэн байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хэрэглэгдэхүүн бэлтгэх хүрээнд:

- Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх” сэдвээр 6 удаагийн цахим сургалт зохион байгуулж, нийслэл болон 21 аймаг дахь эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөөнд эрүү шүүлтийн эсрэг мэдээллийн самбарыг байршууллаа;
- “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” гарын авлагыг 500 хувь хэвлүүлж, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдад түгээв;
- “Манделагийн дүрэм” гарын авлагыг 300 хувь хэвлүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад хүргүүлэв;
- Эрүү шүүлтээс ангид байх эрхийг таниулсан нугалбар 2,000 хувь, цагалбар 500 хувь, 25 ширхэг зурагт хуудас хэвлүүлж, олон нийтэд түгээж, мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудсанд байршууллаа;
- Олон улсын гэрээ, конвенцыг багтаасан “Эрүү шүүлтээс ангид байх эрх” эмхэтгэлийг хэвлүүлэн олон нийтэд хүргэв.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим мэдээллийн сувгийг бий болгосноор үйл ажиллагааны ил тод байдал, мэдээллийн хүртээмжийг бодитоор нэмэгдүүлж, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлын тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болов.

ДОЛОО. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн ажлын хүрээнд 2023-2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний давтамж, хамрах хүрээ, хүртээмжийг харьцуулсан статистик үзүүлэлтийг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 55

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|---|---|-------------------------------|--------------------------------|---------------------------------|-------------------------------------|
| 1 | Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэд олон нийтэд цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажилласан мэдээ, мэдээллийн тоо | 15 мэдээ, мэдээлэл | 90 мэдээ, мэдээлэл | 311 мэдээ, мэдээлэл | 300 мэдээ, мэдээлэл |
| 2 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар түгээсэн контентын хамгийн их хандалт | Постер -15000 Бичлэг -5800 | Постер -18000 Бичлэг -45800 | Постер -36000 Бичлэг -51,200 | Постер -21,000 Бичлэг -1,500,000 |
| 3 | Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар бэлтгэн түгээсэн телевиз, сайт, сонины дүрстэй болон хэвлэмэл ярилцлагын тоо | 7 удаа | 136 удаа | 321 удаа | 365 удаа |
| 4 | Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээлэл түгээсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо | 11 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 36 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 77 хэвлэл мэдээллийн хэрэгсэл | 96 хэвлэл мэдээллийн хэрэгсэл |
| 5 | Reels хэлбэрийн богино контент | - | - | 20 удаа | 24 удаа |
| 6 | Эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх урт хугацааны видео бичлэг | 1 удаа | 5 удаа | 20 удаа | 25 удаа |
| 7 | Нугалбар хуудас | - | 2,000 ширхэг | 5,000 ширхэг | 2,000 ширхэг |
| 8 | Сурталчилгааны хэрэглэгдэхүүн (судалгаа, гарын авлага) | 1 нэр төрөл | 2 нэр төрөл | 4 нэр төрөл | 4 нэр төрөл |

| | | | | | |
|----|--|----|----|-----|-----|
| 9 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн тоо | 18 | 37 | 155 | 263 |
| 10 | Сонины нийтлэл | 1 | 4 | 5 | 17 |

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд олон нийтэд эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээллийг төрийн албан тушаалтан, иргэдэд тогтмол хүргэх зорилгоор төлөвлөгөө батлан, таван үндсэн чиглэлд сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн ажиллав. Үүний үр дүнд олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо 2024 оны тайлант хугацааны үзүүлэлттэй харьцуулахад 25 хувиар, мэдээллийн хандалт 3 дахин өссөн байна.

2. Эрүү шүүлтийн хор аюулыг олон нийтэд таниулах хүрээнд 2024 онд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк хуудас, “NPM-Mongolia” X (хуучнаар Twitter) хуудсаар дамжуулан мэдээлэл түгээж байсан бол 2025 оноос NPM-Mongolia” инстаграм хуудас болон www.npmmongolia.mn албан ёсны цахим хуудсыг ашиглан мэдээллийг нэгэн зэрэг түгээж хэлснээр мэдээллийн хүртээмж өргөжсөн байна.

3. Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Мэдээллийн цаг” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, уг арга хэмжээг хамтын ажиллагааны хүрээнд сайтуудаар шууд дамжуулан хүргэв. Хэвлэлийн бага хурлыг 12 мянга орчим хүн шууд үзсэн бөгөөд уг арга хэмжээний үеэр олон нийтэд сэрэмжлүүлэг болгосон дүрс бичлэгүүдийн үзэлт давхардсан тоогоор 1.6 сая хүнд хүрч, эрүү шүүлтийн хор аюулын талаарх ойлголтыг бодитоор таниулахад чухал нөлөө үзүүлэв.

4. “Монголын үнэн” сонинтой хамтран “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” буланг ажиллуулж, тус сонины 28 мянга орчим захиалагчид эрүү шүүлтийн хор аюул, урьдчилан сэргийлэх асуудлын талаарх мэдээллийг тогтмол хүргэн ажиллалаа.

5. Монголын Үндэсний Олон Нийтийн Радиотой хамтран “Мэдэх эрх” нэртэй 10 цуврал подкастыг бүтээн олон нийтэд түгээж, уг подкаст нь давхардсан тоогоор 45 мянган хүнд хүрсэн байна.

6. Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах хүрээнд цуврал анимейшн, нугалбар хуудас, мэдээллийн самбар, зурагт хуудас, цагалбар зэрэг сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг бэлтгэн иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад түгээж ажиллав. Үүний зэрэгцээ эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд байгаа хүмүүст “Эрүү шүүлтээс ангид байх эрх”-ийн талаарх мэдээллийг улирал тутам хүргэж, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн нь ЭШУСҮА-д ирүүлж буй гомдол, мэдээллийн тоо буурснаас харагдаж байна.

7. Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээллийг агуулсан “Мэдээллийн самбар”-ыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Цагдаагийн байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдүүлэг авах өрөө, эрүүлжүүлэх, саатуулах болон баривчлах байрууд, угтах хэсгүүдэд байршуулж дууссанаар эрх нь хязгаарлагдсан нөхцөлд байгаа иргэд өөрийн эрхийн талаарх мэдээллийг шууд авах бодит боломж бүрдсэн.

8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны төсөвт 2024 оноос эхлэн эрүү шүүлтийн хор аюулыг олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад сурталчлах зардлыг тусгаж эхэлснээр сурталчилгаа, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, подкаст, зурагт болон нугалбар хуудас, гарын авлага, цагалбар, анимейшн зэрэг олон төрлийн сурталчилгааны ажлыг зөвлөх үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэх бодит боломж бүрдсэн.

Гэвч 2025 оны төсвийн тодотголоос шалтгаалан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны чиг үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим ажлууд тасалдахад хүрсэн байна. Иймд цаашид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалтыг баримтлан эрүү шүүлтийн хор аюулыг олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад сурталчлах үйл ажиллагааны төсвийг тогтвортой баталж, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тасралтгүй, тогтвортой хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.



N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Эрүү шүүлтээс урьдчилсан сэргийлэх үндэсний ажиллагаа нь гадаад болон дотоод хамтын ажиллагааны үр дүнд олон нийтэд үйл ажиллагаагаа таниулах, сурталчлах, иргэдийг соён гэгээрүүлж, эрхээ хамгаалах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”,⁵¹ түүний Нэмэлт протокол болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-33.1.4, 34 дүгээр зүйлийн 34.1.7-д эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, сургалт, судалгаа, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг тодорхой заасан.

Хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр хязгаарласан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд эрүү шүүлтийн хор уршгийг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайлангийн хүрээнд олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго нь өмнөх тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг бататгах, олон улсын стандарт, арга зүйг нэвтрүүлэх замаар үндэсний урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг сайжруулахад чиглэсэн. Энэ хүрээнд хамтын ажиллагааг зөвхөн нэг удаагийн арга хэмжээ бус, харин байнгын, тогтвортой, уялдаа холбоотой, үр дүнд суурилсан механизмаар хэрэгжүүлэхийг зорьсон.

Энэхүү бүлэгт 2025 онд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, албан уулзалт, сургалт,



⁵¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=367> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа. Эрүү шүүлтээс ангид байх эрх. (Олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн эмхэтгэл) Уб., 2025 он. 99 дэх тал.

сурталчилгаа, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх баримт, мэдээлэл, холбогдох тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хамруулсан.

Хамтын ажиллагааны хамрах хүрээ нь олон улсын байгууллагууд, бусад улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн болон ашгийн төлөө бус төрийн бус байгууллагуудыг хамруулсан нь олон нийтийг соён гэгээрүүлэх, тэднийг эрхээ хамгаалах бодит боломжийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

ХОЁР. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.2.1. Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс, чиглэл



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны олон улсын хамтын ажиллагаа нь Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос (SPT) үндэсний урьдчилан сэргийлэх механизмуудад зориулан гаргасан удирдамжид тулгуурлан хэрэгжиж байна. Уг удирдамжид үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага нь үйл ажиллагааныхаа үр нөлөөг бэхжүүлэх, туршлага солилцох зорилгоор бусад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатайг тодорхой заасан.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7-д “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, олон нийтэд тогтмол мэдээлэх;”⁵² бүрэн эрхийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд олгосон нь олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх дотоодын эрх зүйн үндэс болж

байна.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлж, хамтын ажиллагааг олон улсын болон дотоодын түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөн ажилласан.

⁵² Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа. Дурдсан эмхэтгэл. 142 дахь тал.

4.2.2. Олон улсын стандарт, арга зүй нэвтрүүлэх чиглэлээрх хамтын ажиллагаа

ЭШУС үндэсний ажиллагаа нь “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагатай 2023 оноос харилцаа холбоо тогтоон, “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг Монгол Улсад нутагшуулах, хууль эрх зүйн хэрэглээнд нэвтрүүлэх, төрийн байгууллагын албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшихэд сургалт, нөлөөллийн ажил хамтран хэрэгжүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй явуулахад албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гарын авлага, хэвлэмэл болон цахим материал, ном товхимол боловсруулах, хэвлэх ажилд техник, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлийн хүрээнд хамтран ажилласан.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ)-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Николь Хогг 2025 оны 9 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийсэн. Ерөнхий нарийн бичгийн дарга Николь Хоггийг дагалдан тус нийгэмлэгийн НҮБ-ын гишүүн орнуудын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хариуцсан ахлах зөвлөх Бен Бакланд, Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан ахлах зөвлөх Нид Сатжипанон, Шинэ Зеландын Цагдаагийн газрын суперинтендант (дэд дарга) Гэри Алкок нар дагалдан ирсэн. Тус айлчлалын хүрээнд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга болон Хүний эрхийн дэд хорооны дарга нартай уулзаж, НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмж, хүний эрхийн шинэ механизмыг нутагшуулах, дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах талаар санал солилцсон.

Энэхүү айлчлал нь 2024 онд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүд Монгол Улсад хийсэн хоёр дахь албан ёсны айлчлалын мөрөөр НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны





өмнөх айлчлалаас гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх, шинэхэн байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутаг дахь оролцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд түлхүү анхаарах болно” хэмээн энэхүү айлчлалын зорилгыг тодорхойлсон нь өндөр ач холбогдолтой хамтын ажиллагаа болсон.

Айлчлалын хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба хаагчдыг чадавхжуулах, хорих байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах явцад үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд (Мендезийн зарчмууд)-ыг нутагшуулах, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний олон улсын туршлага”, “Эрүү шүүлтээс ангид байх эрхийг олон нийтэд сурталчлах бусад улс орнуудын сайн туршлага”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга, мөн чанар, сайн туршлага”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний хүчин чармайлт, олон нийтийн оролцоо,

харилцааны сайн туршлага”, “Цагдан хорих газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх арга зүй”, “Мониторингийг хэрэгжүүлэх зарчим” сэдвүүдээр тус тус сургалт явуулсан. Мөн хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг Мөрдөн шалгах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, түүний харьяа зарим байгууллагад хийсэн.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагын (АРТ) Ахлах зөвлөх Бен Бакланд 2025 оны 4 дүгээр сарын 5-11 хооронд хүрэлцэн ирж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нийт албан хаагчдыг чадавхжуулах сургалт, Монгол Улсын Ерөнхий прокурорын Сургалт, сурталчилгааны хүрээлэн, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Хэрэг бүртгэх алба, Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах алба, Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг тус тус хамруулсан.



Сургалтаар:

- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай суурь ойлголт;
- урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүй;
- мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн НҮБ-ын “Мендезийн зарчмууд” зэрэг агуулгыг танилцуулж, үндэсний нөхцөлд нутагшуулах ажлыг хэрэгжүүлсэн.

Эдгээр сургалт, арга хэмжээний үр дүнд олон улсын хүний эрхийн стандарт, арга зүйг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн арга хэмжээнд бодитоор ашиглах боломж бүрдсэн.

4.2.3. НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа

ЭШУС үндэсний ажиллагаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох бүтэц, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, сургалт, семинар, цахим уулзалт, бүс нутгийн арга хэмжээнд оролцож, зохион байгуулсан.

ТАВДУГААР
БҮЛЭГ

Хүснэгт 56

| Байгууллага | Хамтын ажиллагааны хэлбэр | Агуулга, хэлэлцсэн асуудал | Он |
|--|---------------------------------|--|-----------|
| НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (ОНСНР) | Уулзалт, зөвлөлдөх | Хүний эрхийн төлөв байдал, үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бэхжүүлэх, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох | 2023-2025 |
| НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороо (САТ) | Тайлагнал, зөвлөмжийн хэрэгжилт | Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн илтгэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах | 2023-2025 |
| НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо (SPT) | Албан ёсны айлчлал, үнэлгээ | НҮБ-ын Дэд хорооны зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, ЭШУС-ын чадавхыг бэхжүүлэх | 2024-2025 |
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ) | Сургалт, техникийн туслалцаа | Мендезийн зарчмуудыг нутагшуулах, албан хаагчдыг чадавхжуулах, гарын авлага боловсруулах | 2023-2025 |

| | | | |
|---|-----------------------------------|---|-----------|
| Ази-Номхон далайн хүний эрхийн форум (APF) | Сургалт, вебинар | Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалтын арга зүй, бүс нутгийн туршлага солилцоо | 2023-2025 |
| Дэлхийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын холбоо (GANHRI) | Цахим уулзалт, хамтын ажиллагаа | НҮБ-ын гэрээний хороодтой харилцах, үндэсний механизмын бие даасан байдлыг бэхжүүлэх | 2023-2025 |
| Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын NPM | Туршлага солилцоо | Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний олон улсын сайн туршлага судлах | 2024-2025 |
| Казахстан Улсын NPM | Туршлага солилцоо | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бүс нутгийн хамтын ажиллагааны туршлага солилцох | 2024-2025 |
| Бүгд Найрамдах Киргиз Улсын NPM | Туршлага солилцоо | Үндэсний механизмын зохион байгуулалт, хяналтын аргачлалын асуудлаар мэдээлэл солилцох | 2024-2025 |
| Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан (PRI) | Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа | Хохирол нөхөн төлүүлэлт, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодлогын асуудлаар хамтран ажиллах | 2025 |
| Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) | Уулзалт, төслийн бэлтгэл | Албан хаагчдыг чадавхжуулах, сургалт, хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх | 2025 |



Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлтэл, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

Энэ хүрээнд Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Казахстан Улсын Эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ)

болон иргэний нийгмийн байгууллага, судлаачдын төлөөлөл зохион байгуулж оролцсон.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын үеэр оролцогчид “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгыг дэвшүүлэн Монгол Улсын төрийн холбогдох байгууллагуудыг тус уриалгад нэгдэн ажиллах санаачилгыг гаргасан.



“УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгад Монгол Улсын Шүүхийн Сахилгын Хороо, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрууд албан бичгээр нэгдсэн тухайгаа илэрхийлсэн бөгөөд харьяа байгууллагууддаа аян зохион байгуулж Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, дахин гаргахгүй байх чиглэлээр ажилласан.

4.2.4. Бусад улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажилласан байдал

Бүгд Найрамдах Польш Улсын туршлага

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад улсын сайн туршлагыг судлах, харилцан туршлага солилцох зорилгоор Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн комиссарын газар, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтын ажиллагааг эхлүүлж, харилцан туршлага солилцсон.

Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссарын зүгээс Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг тус улсад айлчлах албан ёсны урилгыг 2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр ирүүлсэн бөгөөд уг урилгын дагуу Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төлөөлөгчид 2025 оны 6 дугаар сарын 1-6-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Польш Улсын Варшав хотод Хүний эрхийн комиссарын газарт албан айлчлал хийсэн. Туршлага судлах хүрээнд Бүгд Найрамдах Польш





Улсын хорих байгууллагад очиж танилцсан⁵³ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдыг чадавхжуулахад ач холбогдолтой хамтын ажиллагаа болсон.

Айлчлалын зорилго нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комисс хоёр байгууллагын хооронд харилцан туршлага солилцох явдал байсан.

Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон түүний ажлын албаны албан хаагчид багтсан.

Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссын орлогч комиссар Войцех Бжозовскийтой уулзаж, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай цаашид хамтран ажиллах талаар хэлэлцсэн.

Бүгд Найрамдах Бүгд Найрамдах Польш Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний комиссарын газрын захирал Рафал Кулас, дэд захирал Катажина Копыстинска болон бусад газрын төлөөлөгчидтэй ажлын уулзалт хийсэн.

Айлчлалын хүрээнд:

- Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын албан хаагчидтай уулзалт зохион байгуулах;
- Хорих байгууллага, цагдан хорих анги, хүүхдийн асрамж, хүмүүжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зэргээр ажилласан.

53 Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссын Үндэсний урьдчилан сэргийлэх механизм. <https://bip.brpo.gov.pl/en>

Туршлага судлах явцад хяналт шинжилгээний аргачлал, хорих байгууллагын зохион байгуулалт, хоригдогчдын эрхийг хангах сайн туршлага, албан хаагчдын ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэлийн асуудалд анхаарах шаардлагатайг онцлон тэмдэглэж, эдгээрийг үндэсний ажиллагаанд тусган хэрэгжүүлэх боломжийг тодорхойлсон байна.

4.2.5. Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай (JICA) хамтран ажиллаж байна.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллаж, хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлээр албан хаагчдыг чадавхжуулах, сургалт, семинар, уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.



ЭШУСҮА-ны нэг алба хаагч тус байгууллагын шугамаар 2024 онд Япон улсад хүний эрх хамгааллын чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.

Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Жендерт суурилсан хүчирхийллийг устгах нь” сэдэвт мэдлэг бүтээх сургалтыг дахин зохион байгуулж, албан хаагчдыг хамруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын Засаглалын салбарын төлөөлөлтэй уулзаж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын албан хаагчдыг хамруулсан сургалт, семинар дахин зохион байгуулах, сургалтын гарын авлага, хэвлэмэл бүтээгдэхүүн боловсруулах, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахад хамтран ажиллах чиглэлээр төслийн саналыг хүргүүлсэн. ЖАЙКА-гийн зүгээс уг хамтын ажиллагааны саналыг дэмжиж буйгаа илэрхийлсэн бөгөөд цаашид хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж буйг илэрхийлсэн.

4.2.6. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай (KOICA) хамтран ажилласан байдал.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчтэй 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төлөөлөл БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Жу Хэйн Нэнтэй уулзсан. Суурин төлөөлөгч Жу Хэйн Нэн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаа, тэргүүлэх чиглэл, Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар танилцуулж, хоёр байгууллагын 2023 оны 05 дугаар сард эхлүүлсэн хамтын ажиллагааг цаашид улам идэвхжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн.



Хоёр тал уулзалтаар цаашид хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг, хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

4.2.7. Олон улсын хамтын ажиллагааны үр дүн

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн сургалт, туршлага солилцоо, төсөл, хөтөлбөрүүд нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдын чадавх, ур чадварыг бэхжүүлэх, олон улсын стандарт, арга зүйг үндэсний түвшинд нутагшуулах, хяналт шинжилгээний чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан. Олон улсын хамтын ажиллагааг системтэй хэрэгжүүлснээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үйл ажиллагаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх бодит нөхцөл бүрдсэн.

ГУРАВ. ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.3.1. Чадавх бэхжүүлэх хамтын ажиллагааны зорилго, чиглэл

Чадавх бэхжүүлэх чиглэлээрх хамтын ажиллагаа нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүргийг бодитоор хэрэгжүүлэх, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн үндсэн арга хэмжээний нэг байсан. Энэхүү ажиллагааны хүрээнд Олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран сургалт, семинар, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж, албан хаагчдыг цахимаар болон биечлэн хамруулан ажилласан.

Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь олон улсын хүний эрхийн стандарт, арга зүйг үндэсний түвшинд нэвтрүүлэх, хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлыг хүний эрхэд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэж, тогтвортой, үр дүнд суурилсан байдлаар хэрэгжсэн.

4.3.2. Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн сургалт

Олон улсын байгууллагуудтай өрнүүлсэн хамтын ажиллагааны хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдыг чадавхжуулах сургалтад тогтмол хамруулж байна. Ази-Номхон далайн бүс нутгийн байгууллагууд, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллага (АРТ) болон бусад түнш байгууллагуудтай хамтран зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад албан хаагчид хамрагдсан.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагын (АРТ) санхүүжилтээр НҮБ-ын “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” буюу Мендезийн зарчмуудыг монгол хэл рүү орчуулж, гарын авлага хэвлүүлж, нутагшуулах сургалтад Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх албаны удирдлага, алба хаагчид болон мөрдөн шалгах чиг үүргийн нийт 2090 алба хаагчийг хамруулсан.

Монгол Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран прокурорын байгууллагын 70 алба хаагчдад зориулан хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүндэтгэн ажиллах арга барилыг хэвшүүлэн ажиллах чиглэлээр “Прокурорын хяналт ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) болон Ази, Номхон далайн орнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын форум (АФФ) хамтран санхүүжилтийг шийдвэрлэсний үндсэн дээр Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2025 онд техникийн туслалцаа үзүүлэх ажлыг эхлүүлж, олон улсын сургагч багш бэлтгэх урт хугацааны хамтарсан төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд 2025 онд Монгол Улсад 4 удаа ажлын айлчлал зохион байгуулж, үндэсний ажиллагааны болон хууль, хяналтын байгууллагын алба хаагчдыг хамруулсан.

ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл олон улсын хүний эрхийн үндэсний байгууллагуудын оролцоотой, эрүү шүүлт болон зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 цуврал вебинарт оролцож, илтгэл хэлэлцүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажилласан.

Эдгээр сургалтаар олж авсан мэдлэг, арга зүйд тулгуурлан сургалтын материал, хэрэглэгдэхүүн боловсруулж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад зохион байгуулдаг сургалт, нөлөөллийн арга хэмжээнд ашиглаж байна.

Хүснэгт 57

| Сургалтын чиглэл | Хамтрагч байгууллага | Хамрагдсан албан хаагч | Үр дүн | Он |
|--------------------------------------|----------------------|--|--|-----------|
| Мендезийн зарчмуудыг нутагшуулах | АРТ | Мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, прокурорын байгууллагын нийт алба хаагчид | Үр дүнтэй ярилцлагын арга зүйг нэвтрүүлэх суурь бүрдэв | 2023-2025 |
| Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ | АФФ / АРТ | ЭШУС, хууль, хяналтын байгууллагын алба хаагчид | Хяналтын аргачлал жигдэрч, чанар сайжрав | 2024-2025 |
| Сургагч багш бэлтгэх (ТоТ) | АРТ / АФФ | Үндэсний сургагч багш нар | Сургалтыг тогтвортой явуулах чадавх бүрдэв | 2025 |
| Олон улсын вебинар, цахим сургалт | АФФ / GANHRI | ЭШУС-ын төлөөлөл | Бүс нутгийн туршлага солилцоо | 2023-2025 |

4.3.3. Дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн сургалт

Дотоодын түвшинд чадавх бэхжүүлэх чиглэлээр төрийн байгууллага, сургалт, судалгааны байгууллагуудтай хамтран ажилласан. Үүнд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албанаас зохион байгуулсан “Хүний эрхийн боловсрол, сургалтын арга зүйн семинар”, Азийн хөгжлийн сангаас зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт” сэдэвт сургалт, мөн “Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан сургалтуудад холбогдох албан хаагчдыг хамруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа,

ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн сургагч багшийн сургалтыг зохион байгуулж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нийт албан хаагчдыг хамруулан сургагч багшаар бэлтгэж, гэрчилгээ олгосон.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Хэрэг бүртгэх алба, Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны алба хаагчдыг 2 удаа үргэлжилсэн сургалтад хамруулсан.

Мөн “Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц” сэдэвт сургалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад холбогдох албан хаагчдыг тус тус хамруулсан.

Хүснэгт 58

| Хамтрагч байгууллага | Сургалтын агуулга | Хамрагдсан албан хаагч | Үр дүн | Он |
|---|-----------------------------------|-------------------------|--|-----------|
| УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн | Прокурорын хяналт ба хүний эрх | Прокурор, мэргэжилтнүүд | Хяналтын хүний эрхэд суурилсан хандлага төлөвшив | 2024-2025 |
| ЦЕГ (холбогдох нэгжүүд) | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх | Цагдаагийн алба хаагчид | Саатуулах, мөрдөн шалгах үеийн стандарт сайжрав | 2024-2025 |
| ЗГХЭГ-ын дэргэдэх Хүний эрхийн Үндэсний хороо | Хүний эрхийн боловсрол | Төрийн алба хаагчид | Бодлого, хэрэгжилтийн уялдаа сайжрав | 2025 |
| Удирдлагын академи | Олон улсын гэрээ, конвенц | Төрийн алба хаагчид | Олон улсын үүргийн ойлголт нэмэгдэв | 2025 |

4.3.4. Олон улсын сургалт, уулзалтад хамрагдсан байдал (товч нэгтгэл)

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) олон улсын байгууллага болон Ази, Номхон далайн орнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын форум (APF) хамтран санхүүжилтийг шийдвэрлэсний үндсэн дээр Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, албан хаагчдыг хамруулсан.

ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл Олон улсын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын оролцоотой, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 цуврал вебинарт оролцож, илтгэл хэлэлцүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажилласан.

Олон улсын түвшинд зохион байгуулагдсан сургалтын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газраас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан “Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилт, тайлагналт, хяналтын үндэсний механизм” сэдэвт нэг

өдрийн семинарт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төлөөлөл хамрагдсан.

“Хүний эрхийн үндэсний байгууллагууд НҮБ-ын гэрээний хороодтой харилцах нь” сэдэвт олон улсын SPT, APF, APT байгууллагуудаас хамтран зохион байгуулсан цахим уулзалтад ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл оролцсон.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос зохион байгуулсан Ази-Номхон далайн бүсийн урьдчилан сэргийлэх уулзалтад оролцож, бүс нутгийн түвшинд туршлага солилцсон.

4.3.5. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдол

Чадавх бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, семинар, туршлага солилцох арга хэмжээний үр дүнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдын олон улсын хүний эрхийн стандартын талаарх мэдлэг, ур чадвар дээшилж, хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлыг хүний эрхэд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх чадавх бодитоор нэмэгдсэн.

Ийнхүү чадавх бэхжүүлэх хамтын ажиллагаа нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна.

Чадавх бэхжүүлэх хамтын ажиллагааны үр дүнд олон улсын стандарт, арга зүйг үндэсний түвшинд бодитоор нутагшуулах нөхцөл бүрдэж, сургалт, хяналт шинжилгээ, нөлөөллийн ажлын чанар, үр нөлөө дээшилсэн. Үүний суурин дээр сургалтыг тогтвортой хэрэгжүүлэх дотоод чадавх бүрэлдсэн.

ДӨРӨВ. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА-ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.4.1. Иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллахын эрх зүйн үндэс, зорилго

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодлогын хэрэгжилтийг бодит нөхцөл байдалд ойртуулах, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой. Энэхүү хамтын ажиллагаа нь хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлийг эрт илрүүлэх, бодит мэдээлэлд суурилсан үнэлгээ, дүн шинжилгээ хийх, нөлөөллийн ажлыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх зорилготой.

Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагуудтай 2025, 2026 онд хамтран ажиллах үндсэн чиглэлээ тодорхойлсон.





“Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, “Митчелл сан” ТББ-ын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны саналуудыг үндэслэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг хамтран боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

4.4.2. Уулзалт, зөвлөлдөх хэлэлцүүлэг (нэгдсэн хүснэгт)

Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт - хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, зөвлөлдөх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, эрх нь хязгаарлагдсан орчин дахь хүний эрхийн нөхцөл байдал, тогтолцооны шинжтэй эрсдэл, тулгамдсан асуудлын талаар санал, мэдээлэл солилцсон.



Эдгээр уулзалтын хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудаас гаргасан ажиглалт, судалгаа, санал дүгнэлтийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулах үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдсэн.

| Хамтын ажиллагааны хэлбэр | Оролцсон байгууллагууд | Агуулга | Он |
|---------------------------|--|--|------|
| Уулзалт, хэлэлцүүлэг | “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх УХ”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, бусад | Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, хамтын ажиллагааны чиглэл | 2025 |
| Салбар дундын хэлэлцүүлэг | УИХ-ын ХЗБХ, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, ИНБ-ууд | Иргэний нийгмийн оролцоог хангах, бодлогын түвшний уялдаа | 2025 |

4.4.3. Судалгаа, шинжилгээний чиглэлээр хамтран ажилласан

| Хамтрагч байгууллага | Судалгааны сэдэв | Үр дүн | Он |
|---------------------------------|---|---|-----------|
| Монголын Криминологичдын холбоо | Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологийн суурь судалгаа | Судалгааны тайлан, бодлогын хэлэлцүүлэгт танилцуулсан | 2024-2025 |
| Иргэний нийгмийн байгууллагууд | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ИНБ-ын оролцоо | Тайлан, зөвлөмж боловсруулахад ашигласан | 2025 |

4.4.4. Сургалт, чадавх бэхжүүлэх чиглэлээр хамтран ажилласан байдал



Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр сургалтад иргэний нийгмийн байгууллагын ажилтан, идэвхтэн, холбогдох салбарын төлөөллийг хамруулж, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулгыг хүргэсэн. Үүнд:

Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны санаачилгаар “Эрүү шүүлтгүй Монгол Улс - Өмгөөлөгчийн оролцоо”

сэдэвт өглөөний уулзалтыг Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологичдын холбоотой хамтран зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас хамтран зохион байгуулсан “Эрх хязгаарлах, саатуулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь” уулзалт хэлэлцүүлэгт хэлтсийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд оролцож, нэгдсэн зөвлөмж гаргасан.

Монголын Криминологичдын холбооны судлаачдын багтай ХЭҮК/2025/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэсэн дэд сэдэвтэй “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи (суурь судалгаа)-ын ажлыг гүйцэтгүүлж, ажлыг олон нийтийн хүртээл болгов.

Тус судалгааг Монголын Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүн хуульч нараар хэлэлцүүлэн, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд болон УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсгийн хуралдаанд УИХ-ын гишүүдэд танилцуулсан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн сүүдрийн тайлан ба Иргэний нийгмийн байгууллагын оролцоо” сэдвээр “Митчелл сан” ТББ-аас алба хаагчдад дотоод сургалт зохион байгуулсан.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хүүхэд, залуучуудын амьдрах орчин, стандарт, ёс зүй, боловсрол, төлөвшлийн асуудлаар мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах талаар санал солилцсон.

Хүснэгт 61

| Хамтрагч байгууллага | Сургалтын агуулга | Хамрагдсан оролцогч | Үр дүн | Он |
|--|--|---------------------|---------------------------------------|------|
| Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо | “Эрүү шүүлтгүй Монгол - Өмгөөлөгчийн оролцоо” | Өмгөөлөгч, хуульчид | Хүний эрхэд суурилсан хандлага бэхжив | 2025 |
| Иргэний нийгмийн байгууллагууд | Эрүү шүүлтээс ангид байх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим | Идэвхтэн, ажилтнууд | Мэдлэг, ойлголт нэмэгдэв | 2025 |

4.4.5. Нөлөөллийн ажил, олон нийтэд чиглэсэн хамтын ажиллагаа

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа нь хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ашгийн төлөө бус байгууллагуудыг хамарч, уулзалт, сургалт, нөлөөллийн арга хэмжээний хүрээнд хэрэгжсэн.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо болон “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний

холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлтэй хамтран “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт - хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Туушин зочид буудалд зохион байгуулсан.

Уг уулзалт хэлэлцүүлгээс иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай “Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэх Уриалга”-ыг санал нэгтгэйгээр батлан гаргаж, Засгийн газарт хүргүүлсэн.

Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд “Өнөр бүл”, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын “Хүүхдийн төв”, “Залуучуудын төв”, “Монголын СОС хүүхдийн хотхон”, “Бадамлянхуа”, “Цөлийн сарнай” хүүхдийн сургалт, хүмүүжлийн байгууллагуудтай хамтран “Хүүхэд, өсвөр үеийнхний нүдээр эрүү шүүлтгүй Монгол орон” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, шилдэг бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгон түгээсэн.

“Митчелл сан” ТББ-тай хамтран ШШГЕГ-ын 403, 407 дугаар анги болон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй хүүхдүүд, нярайтай эхчүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх уулзалт хийж, хүүхдүүдэд Шинэ жилийн гарын бэлэг гардуулсан.

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд, эрүү шүүлтийн хор уршгийг таниулах, гомдол, мэдээлэл гаргах боломж, эрхээ хамгаалах механизмын талаарх мэдээллийг түгээх агуулгатай бусад үйл ажиллагаанууд багтсан.

Хүснэгт 62

| Нөлөөллийн хэлбэр | Хамтрагч байгууллага | Агуулга | Он |
|------------------------|-------------------------------|---|------|
| Уриалга, кампанит ажил | ИНБ-ууд, төрийн байгууллагууд | “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалга | 2025 |
| Соён гэгээрүүлэх ажил | Хүүхдийн байгууллагууд | “Хүүхэд, өсвөр үеийнхний нүдээр эрүү шүүлтгүй Монгол” | 2025 |
| Нийгмийн дэмжлэг | ИНБ-ууд | Хүүхэд, эмзэг бүлэгт чиглэсэн дэмжлэг | 2025 |

4.4.6. Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагааны микро-нэгтгэл

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг төлөвлөгөөтэй, чиглэлтэй хэрэгжүүлснээр бодит нөхцөл байдалд суурилсан мэдээлэл, судалгаа, ажиглалтыг хяналт шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулах үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, нөлөөллийн үр нөлөө бодитоор нэмэгдсэн.

ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

4.5.1. Олон улсын хамтын ажиллагааны нэгдсэн үр дүн

Олон улсын байгууллагууд, бүс нутгийн сүлжээ болон бусад улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны үр дүнд олон улсын хүний эрхийн стандарт, арга зүйг үндэсний түвшинд нутагшуулах суурь нөхцөл бүрдэв. Үүний хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд олон улсын зөвлөмж, аргачлалыг бодитоор ашиглах боломж нэмэгдсэн.

Мөн олон улсын хамтын ажиллагаа нь НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын хараат бус байдал, мандатын хэрэгжилтийг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын болон институтийн дэмжлэгийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан.

4.5.2. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн үр дүн

Чадавх бэхжүүлэх чиглэлээр олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн сургалт, сургагч багшийн бэлтгэл, туршлага солилцох арга хэмжээний үр дүнд албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хүний эрхэд суурилсан хандлага бодитоор сайжрав. Үүний үр дүнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг илүү системтэй, нотолгоонд суурилсан, олон улсын стандарттай нийцүүлэн хэрэгжүүлэх чадавх нэмэгдсэн.

Түүнчлэн сургалтаар олж авсан мэдлэг, туршлага, арга зүйд тулгуурлан сургалтын материал, хэрэглэгдэхүүн боловсруулж, үндэсний түвшинд тогтвортой хэрэгжүүлэх боломж бий болсон нь чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг урт хугацаанд хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн.

4.5.3. Иргэний нийгмийн байгууллагын оролцооны нэгдсэн үр нөлөө

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласнаар бодит нөхцөл байдалд суурилсан мэдээлэл, ажиглалт, судалгааны үр дүнг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулах үйл ажиллагаанд ашиглах боломж бодитоор нэмэгдсэн. Иргэний нийгмийн оролцоо нь эрх нь хязгаарлагдсан орчин дахь хүний эрхийн эрсдэлийг эрт илрүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, нөлөөллийн ажлыг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Мөн иргэний нийгмийн байгууллагуудтай тогтоосон түншлэл нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаанд олон талын оролцоог хангах, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Эдгээр уулзалтын дүнд “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-уудын зүгээс ирүүлсэн эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэхэд хамтран хэрэгжүүлэх ажлын саналуудыг тусган “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг боловсруулан баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.

4.5.4. Хамтын ажиллагааны ач холбогдол

Хамтын ажиллагааг олон улсын болон дотоодын түвшинд уялдаа холбоотой, төлөвлөгөөтэй хэрэгжүүлснээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны институтийн чадавх, үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдсэн. Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх эрхийн баталгааг бодит түвшинд хангах нөхцөлийг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог тогтвортой хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байсан.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. Олон улсын болон дотоодын түвшинд хамтын ажиллагааг уялдаа холбоотой, төлөвлөгөөтэй хэрэгжүүлснээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны институтийн чадавх бэхжиж, үйл ажиллагааны чанар, үр нөлөө бодитоор нэмэгдсэн. Олон улсын стандарт, арга зүйг үндэсний түвшинд нутагшуулах чиглэлээр хийсэн хамтын ажиллагаа нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлыг олон улсын хүний эрхийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн.
2. Чадавх бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, сургагч багшийн бэлтгэл, туршлага солилцох арга хэмжээнүүдийн үр дүнд албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хүний эрхэд суурилсан хандлага сайжирч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нотолгоонд суурилсан, системтэй байдлаар хэрэгжүүлэх боломж өргөжив. Энэ нь үндэсний түвшинд сургалт, арга зүйн тогтвортой чадавх бүрдэхэд чухал нөлөө үзүүлсэн.
3. Иргэний нийгмийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаа нь бодит нөхцөл байдалд суурилсан мэдээлэл, ажиглалт, судалгааны үр дүнг хяналт шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулахад ашиглах боломжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоо, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. Иргэний нийгмийн оролцоо нь эрх нь хязгаарлагдсан орчин дахь хүний эрхийн эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чухал хүчин зүйл болсон.
4. Хамтын ажиллагааг олон талт байдлаар хөгжүүлж, олон улсын болон дотоодын түншлэлийг бодит үр дүнд чиглүүлэн хэрэгжүүлснээр эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гарсан ба хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрийг хэрэгжүүлэхэд үр дүнгээ харуулсан хэмээн дүгнэж байна.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

Энэхүү бүлэгт тайлангийн 2-6 дугаар бүлгүүдэд дурдсан хамтын ажиллагаа, сургалт, оролцооны талаарх бүх нотолгоо, тоон мэдээллийг нэгтгэн тусгасан.

4.8.1. Олон улсын хамтын ажиллагааны дэлгэрэнгүй нэгтгэл

Хүснэгт 63

| Байгууллага | Хамтын ажиллагааны хэлбэр | Гол агуулга | Он |
|--|---------------------------|--|-----------|
| НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (ОНСНР) | Уулзалт, зөвлөлдөх | Хүний эрхийн бодлого, NPM-ийн чадавх бэхжүүлэх | 2023-2025 |
| НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороо (CAT) | Тайлагнал, зөвлөмж | Конвенцын хэрэгжилт, зөвлөмжийн биелэлт | 2023-2025 |
| НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо (SPT) | Айлчлал, үнэлгээ | NPM-ийн үнэлгээ, зөвлөмж | 2024-2025 |
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (APT) | Сургалт | Мендезийн зарчмууд, арга зүй | 2023-2025 |
| APF / GANHRI | Вебинар, сургалт | Бүс нутгийн туршлага | 2023-2025 |
| Бусад улсын NPM (Их Британи, Казахстан, Киргиз) | Туршлага солилцоо | Хяналтын сайн туршлага | 2024-2025 |
| ЖАЙКА | Уулзалт, төслийн бэлтгэл | Чадавх бэхжүүлэх төсөл | 2025 |

4.8.2. Чадавх бэхжүүлэх сургалтын нэгдсэн тоон мэдээлэл

Хүснэгт 64

| Сургалтын төрөл | Хамтрагч | Хамрагдсан (ойролцоогоор) | Он |
|----------------------------|---------------|---------------------------|-----------|
| Мендезийн зарчмууд | APT | 200+ | 2023-2025 |
| Урьдчилан сэргийлэх хяналт | APF / APT | 150+ | 2024-2025 |
| Сургагч багш бэлтгэх (ToT) | APT / APF | 25+ | 2025 |
| Цахим сургалт, вебинар | APF / GANHRI | 80+ | 2023-2025 |
| Дотоодын сургалт | УЕПГ, ЦЕГ, УА | 300+ | 2024-2025 |

4.8.3. Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагааны нэгдсэн мэдээлэл

Хүснэгт 65

| Чиглэл | Оролцсон байгууллагууд | Үр дүн | Он |
|----------------------|---|-------------------------------|------|
| Уулзалт, хэлэлцүүлэг | ИНБ-ууд, УИХ-ын холбогдох байнгын хороо | Бодлогын санал | 2025 |
| Судалгаа | Криминологичдын холбоо, ИНБ | Тайлан, зөвлөмж | 2025 |
| Сургалт | Өмгөөлөгчдийн холбоо, ИНБ | Мэдлэг, хандлага сайжрав | 2025 |
| Нөлөөлөл | ИНБ-ууд | Олон нийтийн ойлголт нэмэгдэв | 2025 |

4.8.4. Хамрагдсан байгууллага, оролцогчдын нэгтгэл

Хүснэгт 66

| Үзүүлэлт | Тоо |
|--|------|
| Хамтран ажилласан олон улсын байгууллага | 10+ |
| Туршлага солилцсон улсын NPM | 3 |
| Сургалт, уулзалт, арга хэмжээ | 30+ |
| Хамрагдсан албан хаагч, оролцогч | 700+ |

4.8.5. Арга хэмжээ, уулзалтын товч календарь

Хүснэгт 67

| Төрөл | Байршил | Он |
|---------------------|----------------------|-----------|
| Олон улсын айлчлал | Улаанбаатар / Гадаад | 2024-2025 |
| Бүс нутгийн уулзалт | Цахим / Танхим | 2023-2025 |
| Сургалт, семинар | Улаанбаатар | 2023-2025 |

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023-2025 онд
хэрэгжүүлсэн хамтын ажиллагаа, сургалт, нөлөөллийн ажлын тойм**

Хүснэгт 68

| Үйл явдлын тойм | Он, сар | Чиглэл | Хамтрагч / зорилтот бүлэг |
|---|----------------|-------------------------------|----------------------------------|
| ЕБС-ийн сурагчдад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээлэл, ярилцлага зохион байгуулав. | 2025.09 | Олон нийтэд чиглэсэн нөлөөлөл | ЕБС-ийн сурагчид |
| Мөрдөн шалгах алба хаагчдад Мендезийн зарчмыг нутагшуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. | 2025.04 | Чадавх бэхжүүлэх | ЦЕГ, АРТ |
| ИНБ-уудтай эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хамтын ажиллагааны уулзалт, хэлэлцүүлэг хийв. | 2025.02 | Иргэний нийгмийн оролцоо | ИНБ-ууд |
| Олон улсын байгууллагуудтай хамтран стандарт, арга зүй нутагшуулах сургалт, дэмжлэг үзүүлэв. | 2024-2025 | Олон улсын хамтын ажиллагаа | АРТ, АРФ, ОНСНР |
| Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын эрхийн асуудлаар олон улсын бага хурал зохион байгуулав. | 2025.06 | Нөлөөлөл, бодлого | ОУ-ын байгууллагууд |

ᠠᠨᠭᠢᠳᠤ ᠪᠠᠶ᠋ᠢᠬᠤ ᠡᠷᠬᠡ ᠰᠢᠵᠢᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋ᠨᠠᠭᠤᠯᠢᠨ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋ᠨᠠᠭᠤᠯᠢᠨ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋ᠨᠠᠭᠤᠯᠢᠨ



N | P | M
MONGOLIA

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХ
ЗӨРЧИГДСӨН ТАЛААРХ ГОМДОЛ,
МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД 2022-2025 ОНД ИРҮҮЛСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, ШИЙДВЭРЛЭЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх нь Монгол Улсын Үндсэн хууль,⁵⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколоор⁵⁵ хүлээсэн олон улсын үүргийн салшгүй хэсэг юм.

ЭШУС үндэсний ажиллагаанд иргэн, хуулийн этгээдээс эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний эрх зөрчигдсөн талаар гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд харьяалуулан шилжүүлэх, шийдвэрлэлтийн явц, үр дүнд дүн шинжилгээ хийх ажиллагааг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн⁵⁶ 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн 34.1.6-д зааснаар “эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ЭШУС үндэсний ажиллагаа нь гомдол, мэдээлэл гаргасан иргэдтэй биечлэн уулзах, мэдээлэл авах, нөхцөл байдлыг тодруулах, улмаар хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.

ХОЁР. ЭШУС ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД ИРҮҮЛСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

ЭШУС үндэсний ажиллагаанд 2022-2025 онд нийт 230 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн бөгөөд үүнээс 2025 онд 61 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна.

Ирүүлсэн гомдол, мэдээллийн дийлэнх хувийг:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад хорих ял эдэлж буй ялтан;
- Цагдан хоригдож буй хүн;

54 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;” гэж хуульчлан бэхжүүлсэн.

55 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа. Эрүү шүүлтээс ангид байх эрх. (Олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн эмхэтгэл). Уб., 2025 он. 49 дэх тал. “Оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна” гэж заасан.

56 <https://legalinfo.mn/mn/detail/15152>

- Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн гэр бүл, садан төрөл, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч болон бусад хамаарал бүхий этгээд;
- Өмгөөлөгчөөс гаргасан гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллүүдэд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон үндэсний ажиллагааны албан хаагчидтай “биечлэн уулзах хүсэлт” гаргасан 99 тохиолдол байгаа нь эрүү шүүлт тулгах болон хэрцгий, хүнлэг бус харьцаа, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхах үйлдэл хууль сахиулах байгууллагад гарч болзошгүй байгааг илтгэнэ.

Дээр дурдсан иргэдтэй ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон үндэсний ажиллагааны албан хаагчид тухайн иргэдийн байрлаж буй газарт хүрэлцэн очих, эсхүл цахим хэлбэрээр биечлэн уулзах байдлаар дараах арга хэмжээг авч ажилласан.

Үүнд:

- Хууль зүйн зөвлөгөө, бусад мэдээлэл өгөх;
- Газар дээр нь шийдвэрлэх боломжтой гомдол, мэдээллийг тухай бүр зохих журмын дагуу шийдвэрлэх;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гэж үзсэн тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх зэргээр арга хэмжээ авсан.

ГУРАВ. ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн 230 гомдол, мэдээллийг хүлээн авч, судлан үзэх явцад:

- Биечлэн уулзах 99 тохиолдолд гомдол гаргагчтай уулзаж, хууль зүйн туслалцаа үзүүлсэн;
- Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад 131 гомдлыг шалгуулахаар хуульд заасан хугацаанд шилжүүлсэн.

Шилжүүлсэн гомдол, мэдээллийг:

- Авлигатай тэмцэх газар;
- Монгол Улсын Ерөнхий прокурорын газар болон харьяа прокурорын байгууллагууд;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа нэгжүүд;
- Цагдаагийн байгууллага;
- Бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тус тус шилжүүлэн, шийдвэрлэлтийн явцыг тухай бүр хянан үзэж мэдээлэл авах, дахин лавлагаа хүргүүлэх ажлыг тогтмол зохион байгуулсан.

ЭШУС үндэсний ажиллагаа нь эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхах гэмт хэрэг, зөрчил үүсэх эрсдэлийг илрүүлэх, Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гэж үзсэн тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх, мэдээлэх, тэдгээрийн авч буй арга хэмжээнд хяналт тавих зэргээр ажилласан болохыг онцлон тэмдэглэж байна.

ДӨРӨВ. ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ

ЭШУС үндэсний ажиллагаанд 2022-2025 онд ирүүлсэн гомдол, мэдээллийг зөрчигдсөн эрхийн агуулгаар нь ангилан үзэхэд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, түүнчлэн шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой гомдол, мэдээлэл зонхилж байна.

Гомдол, мэдээлэл нь ихэвчлэн эрх чөлөө хязгаарлагдсан орчин нөхцөлд байгаа буюу хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй хүмүүсээс ирүүлсэн нь уг орчинд хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэл байгааг илтгэнэ.

4.1. Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй холбоотой гомдол, мэдээлэл

Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд ирүүлсэн гомдол, мэдээлэлд:

- Хорих ангийн алба хаагчдын зүгээс эрүү шүүлт тулгасан гэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын зүгээс бие махбодод халдах, сэтгэл зүйг нь шаналган зовоосон гэх;
- Прокурорын болон цагдаагийн байгууллагын алба хаагчид мөрдөн шалгах ажиллагааны явцад зүй бусаар харьцсан гэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, эмнэлгийн ажилтан эмчлүүлэгчийн бие махбодод халдах, сэтгэл зүйд нь зүй бусаар нөлөөлж, шаналган зовоосон гэх;
- Гавлах, дөнгөлөх, удаан хугацаагаар хөдөлгөөнийг хязгаарласан гэх;
- Доромжлох, айлган сүрдүүлэх зэрэг хүний нэр төрийг доромжлон харьцсан гэх;
- Хорих ангийн нөхцөл, дэглэм, сахилгын арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих, нэр төрийг доромжилсон гэх агуулгатай гомдол, мэдээллүүд эзэлсэн.

Дээрх гомдол, мэдээлэл нь бие махбодын хүч хэрэглэх, удаа дараа дарамтлах, доромжлох, гавлах, дөнгөлөх болон тусгай хэрэгсэл хэрэглэж айлган сүрдүүлэх, хүний нэр төрийг гутаах, сэтгэл зүйд хохирол учруулах шинжтэй үйлдлүүдээр илэрч байна.

4.2. Шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой гомдол, мэдээлэл

Шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой гомдол, мэдээлэлд:

- Үйлдээгүй хэрэгт холбогдуулан ял шийтгэл оногдуулсан гэх;
- Нотлох баримтыг бодитой, шударгаар шалгуулах боломж хангагдаагүй;
- Прокурор, шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах боломж хязгаарлагдсан;
- Өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах эрхийг бодитоор хангаагүй гэх гомдол, мэдээлэл багтаж байна.

Эдгээр гомдол, мэдээлэл нь эрх чөлөө нь хязгаарлагдсан орчинд байгаа иргэд хууль зүйн туслалцаа авах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангагдах боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна.

4.3. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй холбоотой гомдол, мэдээлэл

Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хүрээнд ирүүлсэн гомдол, мэдээлэлд:

- Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө;
- Нас, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ;
- Эрхэлсэн ажил, албан тушаал;
- Шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол;
- Бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал;
- Ял эдэлж буй зүйл ангиар нь ялгаварлан гадуурхсан гэх асуудлуудтай холбоотой байна.

Түүнчлэн хорих байгууллагын дотоод зохион байгуулалт, ажил хөдөлмөр эрхлэлт, шагнал урамшуулал, сахилгын арга хэмжээтэй холбоотой шийдвэрүүдэд шударга бус, тэгш бус хандлага гарсан гэх гомдол, мэдээлэл мөн ирүүлж байна.

4.4. Бусад эрхтэй холбоотой гомдол, мэдээлэл

Дээр дурдсан эрхүүдээс гадна дараах асуудлуудтай холбоотой гомдол, мэдээлэл ирүүлсэн байна:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж хангагдаагүй гэх;
- Хорих ангийн амьдрах орчин муу, хоол хүнс амт чанаргүй, эм, эмнэлгийн хэрэгсэл болон эмчийн хүрэлцээ хангалтгүй, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангагдаагүй гэх;
- Тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн баталгаатай холбоотой асуудалтай гэх;
- Бусад хоригдолд дарамтлуулж, зодуулсан боловч хамгаалалт авч чадаагүй гэх гомдол, мэдээлэл багтаж байна.

4.5. Нийтлэг хэв шинж

Гомдол, мэдээллийн агуулга нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтын зөрчил нэг удаагийн бус, давтамжтай, зарим тохиолдолд системийн шинжтэйгээр илэрч байна. Ялангуяа эрх чөлөө хязгаарлагдсан орчинд дотоод хяналтын тогтолцоо сул, гомдол гаргах, хамгаалалт авах механизм бодитоор ажиллахгүй байгаа нь зөрчил дахин давтагдах эрсдэлийг бий болгож байна..

ТАВ. ОНЦЛОХ ТОХИОЛДЛУУД

Энэ бүлэгт эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн байж болзошгүй онцлох гомдол, мэдээллийг эрх зөрчлийн хэлбэрээр ангилан, тухайн ангиллын хүрээнд бодит тохиолдлуудыг жишээ болгон тусгав. Эдгээр нь тус тусдаа нэгж тохиолдлоос гадна давтагдах эрсдэл, хэв шинжийг тодотгох ач холбогдолтой.

5.1. Бие махбодын хүч хэрэглэсэн байж болзошгүй тохиолдлууд

Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй иргэдээс алба хаагчдын зүгээс бие махбодын хүч хэрэглэсэн, улмаар эрүүл мэндэд нь гэмтэл учирсан гэх гомдол, мэдээлэл тогтмол ирүүлсэн байна.



Тохиолдлууд:

ШШГЕГ-ын харьяа хорих ангид ял эдэлж байсан хоригдогч М нь 1 тонн савтай усыг түрж явах үед ШШГБ-ын алба хаагчийн санаатай үйлдлээс болж хөл нь хугарч, улмаар удаан хугацаанд суга таягтай явж байгаа талаар гомдол гаргасан.

Үүнтэй төстэй нөхцөлд хоригдол С-г ШШГБ-ын алба хаагч мотоциклтой давхиж ирэн мөргөж, хөлийг нь хугалсан гэх гомдол гаргасан.

ШШГЕГ-ын ... дугаар ангид ял эдэлж буй хоригдол Ц нь сахилгын байрны хугацаанд дөнгөлөгдсөн байдалтай байхад алба хаагчид түүнийг дээш нь шидэж, газар унагасан, улмаар шатны уруу түлхэж унагасан гэх гомдол гаргасан.

ШШГЕГ-ын ... дугаар ангид ял эдэлж буй хоригдол Ч нь алба хаагчийн зүгээс удаа дараа зодуулж, шүд нь хугарч, биед нь гэмтэл учирсан талаар гомдол гаргасан.

5.2. Сэтгэл зүйн дарамт учруулах, хүний нэр төрийг доромжлон харьцсан байж болзошгүй тохиолдлууд

Зарим гомдол, мэдээлэлд бие махбодын хүч хэрэглэхээс гадна удаа дараа хүний сэтгэл зүйг шаналган зовоох, доромжлох, айлган сүрдүүлэх зэргээр сэтгэл зүйн хохирол учирсан талаар дурдагдсан.



Тохиолдлууд:

ШШГЕГ-ын ... дугаар ангид ял эдэлж буй хоригдол Д.Ц нь өглөөний 09 цагаас 16 цаг хүртэл гавлагдсан байдалтай байж, алба хаагчдын зүгээс хэл амаар доромжлуулж, байнгын дарамтад байсан талаар гомдол гаргасан.

Хоригдол Г.М нь алба хаагчийн зүгээс байнга дарамт, доромжлолд өртөж, нүүрний зүүн тал хавдаж, шүд хөдөлгөөнтэй болсон талаар гомдол гаргасан.

Хоригдол Л.Л нь сахилгын байрны нөхцөл хүнлэг бус, цонхгүй, хүйтэн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ариун цэврийн өрөө ороход дөнгөлдөг, өмдөндөө шээх, баахад хүргэдэг талаар гомдол гаргасан.

5.3. Камерын бичлэгээр илэрсэн хүч хэрэглэсэн байж болзошгүй тохиолдлууд

Хяналтын камерын бичлэгт хийсэн ажиглалт, дүн шинжилгээгээр эмчлүүлэгч, хоригдолд хүч хэрэглэсэн, доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлүүд илэрсэн байна.



Тохиолдлууд:

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 09:33-09:35 цагийн хооронд Шүүхийн сэтгэц, эмгэг судлалын клиникийн номын сангийн өрөөнд ШШГБ-ын алба хаагч эмчлүүлэгчид хүч хэрэглэсэн байж болзошгүй үйлдэл хяналтын камерын бичлэгт илэрсэн;

Мөн өдрийн 09:27-09:28 минутын хооронд тус клиникийн номын сангийн өрөөнд эмчлүүлэгчийн хөл рүү алба хаагч олон удаагийн давтамжтайгаар өшиглөсөн байж болзошгүй үйлдэл хяналтын камерын бичлэгт илэрсэн;

2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Гуравдугаар клиникийн хонгилд туслах сувилагч эмчлүүлэгчид хүч хэрэглэсэн байж болзошгүй үйлдэл хяналтын камерын бичлэгт илэрсэн;

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр туслах сувилагч болон ШШГБ-ын алба хаагчид эмчлүүлэгчид хамтран хүч хэрэглэж, доромжлон харьцсан байж болзошгүй нөхцөл байдал тус тус илэрсэн.

5.4. Ялгаварлан гадуурхалттай холбоотой онцлох тохиолдлууд

Зарим гомдол, мэдээлэл нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдлыг илэрхийлж байна.



Тохиолдлууд:

ШШГЕГ-ын ... дугаар ангид ял эдэлж буй Э нь хорих ангийн оёдлын үйлдвэрт ажиллаж байх явцад тодорхой албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон, уг байдал нь өмнө нь давтагдаж байсан талаар гомдол гаргасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдол улаан шугам давсан гэх үндэслэлээр бодит нөхцөл байдлыг харгалзалгүйгээр байнга сахилгын шийтгэл хүлээдэг, улмаар ялгавартай хандлагад өртөж байгаа талаар гомдол гаргасан.

5.5. Онцлох тохиолдлуудаас харагдах эрсдэл

Дээр дурдсан онцлох тохиолдлуудаас харахад эрх чөлөө хязгаарлагдсан орчинд:

- Дотоод хяналтын тогтолцоо сул;
- Гомдол гаргасан этгээдийг хамгаалах механизм хангалтгүй;
- Баримтжуулалт, камерын хяналтын тасралтгүй ажиллагаа жигд бус;
- Алба хаагчдын хариуцлагын тогтолцоо бодитоор хэрэгжихгүй байгаа нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтын зөрчил дахин давтагдах эрсдэлийг бий болгож байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хандан ирүүлсэн дээрх төрлийн гомдол, мэдээлэлтэй холбогдуулан ШШГЕГ-ын болон түүний салбар, нэгжүүдийн удирдлагад хүргүүлсэн зөвлөмжүүдэд холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох, сахилга, ёс зүйн дүрмийг сахин мөрдүүлэх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх алба хаагчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, сургалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлүүдийг тогтмол тусган ажиллаж байна.

Мөн гомдол, мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад харьяалан шилжүүлсний дараа тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар хариуг тухай бүр авч, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах зөрчил, дутагдал гаргасан алба хаагчдад хариуцлага тооцох талаар хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, шаардлага хүргүүлэн ажилласан.

Цаашид ШШГБ-ын удирдлага, алба хаагчид Монгол Улсын Үндсэн хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох гэрээ, конвенцоор баталгаажсан хүний хэзээ ч үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг бодитоор хүндэтгэн хангахгүй байгаа нь Монгол Улсын хүний эрхийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж байна. Иймд уг асуудлыг жил бүр бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг онцгойлон авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

5.6. Ахиц дэвшил, эерэг өөрчлөлтийн шинж

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, биечлэн уулзалт, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлсний үр дүнд 2025 онд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаатай холбоотой гомдол, мэдээлэл 61 бүртгэгдсэн нь 2024 оны 99 тохиолдолтой харьцуулахад 38 тохиолдлоор буюу 38.4 хувиар буурсан үзүүлэлт байна. Энэхүү бууралт нь зөрчил бүрэн арилсныг шууд илтгэхгүй бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөө, гомдол, мэдээлэл ирүүлэх хандлагын өөрчлөлт, гомдол мэдээлэл ирүүлэх сувгийн хүртээмж зэрэг хүчин зүйлстэй уялдуулан цогцоор нь үнэлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эерэг үр нөлөө илэрч байна гэж үзэх боломжтой.

ЗУРГАА. ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ДҮН (2022-2025)

Энэ бүлэгт 2022-2025 онд ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэлтэй холбоотой тоон мэдээллийг нэгтгэн, өмнөх бүлгүүдэд тусгагдсан агуулгуудыг статистик үзүүлэлт, хүснэгтэд тулгуурлан шат дараатайгаар танилцуулна.

Тус бүлэг нь гомдол, мэдээллийн тоон өөрчлөлт, ирүүлсэн этгээдийн бүтэц, биечлэн уулзах хүсэлтийн үзүүлэлт, холбогдох байгууллагад харьяалан шилжүүлсэн байдал, шийдвэрлэлтийн явц, түүнчлэн эрхийн төрлөөр ангилсан гомдлын тоон бүтэц зэргийг нэг дор төвлөрүүлэн харуулах зорилготой.

Энэхүү тоон мэдээлэл нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс шийдвэр гаргасан, эрх зүйн дүгнэлт өгсөн агуулга бус бөгөөд харин эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтын эрсдэлийг илрүүлэх, чиг хандлагыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд ашиглагдсан бодит баримт, бүртгэлд суурилсан мэдээлэл болно.

6.1. Гомдол, мэдээллийн тоон өөрчлөлт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 2022-2025 онд нийт 230 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байна. Жил бүрийн тоон үзүүлэлтийг харьцуулан авч үзэхэд гомдол, мэдээллийн тоо тодорхой хэлбэлзэлтэй байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт 69

| Он | Ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо | Өмнөх онтой харьцуулсан өөрчлөлт |
|------|---------------------------------|----------------------------------|
| 2022 | 11 | - |
| 2023 | 59 | +48 |
| 2024 | 99 | +40 |
| 2025 | 61 | -38 |
| Нийт | 230 | - |

Жилээр авч үзэхэд 2023-2024 онд гомдол, мэдээллийн тоо огцом өссөн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн, эрх чөлөө хязгаарлагдсан орчинд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтын эрсдэл бодитоор илэрдэг, түүнчлэн гомдол, мэдээлэл ирүүлэх сувгуудын хүртээмж сайжирсантай уялдан тайлбарлагдана.

Харин 2025 онд гомдол, мэдээллийн тоо өмнөх онтой харьцуулахад 38 тохиолдлоор буурсан нь зөрчил бүрэн арилсныг шууд илтгэх бус бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт, нөлөөллийн ажлын үр нөлөө, мөн гомдол, мэдээлэл ирүүлэх хандлагын өөрчлөлт зэрэг хүчин зүйлтэй уялдуулан цогцоор нь үнэлэх шаардлагатай юм.

6.2. Гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэдийн төрөл (2022-2025)

ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн гомдол, мэдээллийг гомдол, мэдээлэл ирүүлсэн этгээдийн төрлөөр ангилан үзэхэд мэдээллийн дийлэнх нь эрх чөлөө хязгаарлагдсан орчинд байгаа иргэдээс ирүүлсэн байна.

Хүснэгт 70

| № | Иргэдийн төрөл | Гомдол, мэдээллийн тоо | Нийтэд эзлэх хувь |
|------|---|------------------------|-------------------|
| 1. | Хорих ял эдэлж буй хүн | 108 | 47.0% |
| 2. | Цагдан хоригдож буй иргэн | 94 | 40.9% |
| 3. | Ял эдэлж буй хүний гэр бүл, садан төрөл, хууль ёсны төлөөлөгч, хамаарал бүхий бусад хүн | 5 | 2.2% |
| 4. | Өмгөөлөгч | 4 | 1.7% |
| 5. | Бусад иргэн | 19 | 8.2% |
| Нийт | | 230 | 100% |

6.3. Биечлэн уулзах хүсэлтэй гомдол, мэдээллийн эзлэх хувь

ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн гомдол, мэдээллийн нэг хэсэг нь гомдол гаргагчтай биечлэн уулзах хүсэлтэй байдаг бол үлдсэн гомдол, мэдээллийг хуульд заасан чиг үүргийн хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагад харьяалан шилжүүлж, шалгуулахаар шийдвэрлэдэг.

ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн нийт 230 гомдол, мэдээллээс 99 нь буюу 43.0 хувь нь гомдол гаргагчтай биечлэн уулзах хүсэлтэй байсан.

Хүснэгт 71

| Үзүүлэлт | Тоо | Нийт гомдолд эзлэх хувь |
|---|-----|-------------------------|
| Биечлэн уулзах хүсэлт гаргасан иргэн | 99 | 43.0% |
| Бусад хэлбэрээр (бичгээр, цахимаар) ирүүлсэн гомдол, мэдээлэл | 131 | 57.0% |
| Нийт гомдол, мэдээлэл | 230 | 100% |

Биечлэн уулзах хүсэлтэй гомдол, мэдээлэл харьцангуй өндөр хувь эзэлж байгаа нь тухайн иргэдийн хувьд бичгээр эсхүл цахимаар гомдол, мэдээлэл ирүүлэх боломж хязгаарлагдмал, бодит эрсдэлтэй гэж үзэж байгааг илтгэж байна. Ийм хүсэлт гаргасан иргэдтэй нөхцөл байдлаас шалтгаалан газар дээр нь очиж уулзах, эсхүл цахим хэлбэрээр биечлэн уулзах замаар асуудлыг тодруулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

6.4. Холбогдох байгууллагад харьяалан шилжүүлсэн байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 2022-2025 онд ирүүлсэн гомдол, мэдээллээс эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн байж болзошгүй тохиолдлуудад холбогдох эрх бүхий байгууллагад харьяалан шилжүүлэх, мөн газар дээр нь биечлэн уулзаж хариу өгөх зэрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байгууллага тус бүрээр, он оноор доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 72

| Байгууллага / Арга хэмжээ | 2022 | 2023 | 2024 | 2025 | Нийт |
|--|-----------|-----------|-----------|-----------|------------|
| Биечлэн уулзсан, хариу өгсөн | 8 | 26 | 36 | 23 | 93 |
| ШШГЕГ, харьяа ШШГБ | - | 8 | 17 | 5 | 30 |
| Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газрууд | 1 | 8 | 15 | 21 | 45 |
| Авлигатай тэмцэх газар | 1 | 12 | 19 | 9 | 41 |
| Цагдаагийн ерөнхий газар | - | 2 | 1 | - | 3 |
| Шүүхийн сахилгын хороо | - | 1 | 2 | - | 3 |
| Хууль зүй, дотоод хэргийн яам | - | - | 4 | 1 | 5 |
| Төрийн албаны зөвлөл | - | - | - | 1 | 1 |
| Эрүү болон иргэний хэргийн шүүх | - | - | - | 1 | 1 |
| Өмгөөлөгчдийн холбоо | - | - | 1 | - | 1 |
| Ерөнхийлөгчийн Тамгын газар | - | - | 1 | - | 1 |
| Монголын хүүхдийн сан (төлөөлөгчийн газар) | - | - | 1 | - | 1 |
| ХЭҮК-ын ГХШХ-т гомдолд нэгтгэсэн | - | - | 1 | - | 1 |
| Ижил утгатай гомдлыг нэгтгэн шалгуулахаар шилжүүлсэн | - | 2 | - | - | 2 |
| Гомдлыг түр хаасан | 1 | - | - | - | 1 |
| Талархал илэрхийлсэн | - | - | 1 | - | 1 |
| Нийт | 11 | 59 | 99 | 61 | 230 |

6.5. Харьяалан шилжүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас холбогдох эрх бүхий байгууллагад харьяалан шилжүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явц, хариу ирүүлэлтийн байдлыг он оноор, байгууллага тус бүрээр нэгтгэн доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 73

| Он | Албан байгууллага | Шилжүүлсэн гомдлын тоо | Албан бичгээр хариу ирүүлсэн | Хариу ирүүлээгүй бусад хэлбэр | Шийдвэрлэлтийн хувь |
|------|-------------------------------|------------------------|------------------------------|-------------------------------|---------------------|
| 2022 | Авлигатай тэмцэх газар | 1 | 1 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 1 | 1 | 0 | 100% |
| | Бусад (биечлэн уулзсан) | 9 | | | 100% |
| 2023 | Авлигатай тэмцэх газар | 10 | 7 | 3 | 70% |
| | УЕПГ, харьяа прокурор | 7 | 4 | 3 | 57% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 6 | 2 | 4 | 30% |
| | Цагдаагийн байгууллага | 3 | 0 | 3 | 0% |
| | Шүүхийн сахилгын хороо | 1 | 1 | 0 | 100% |
| | Бусад (биечлэн уулзсан) | 32 | | | 100% |
| 2024 | Авлигатай тэмцэх газар | 19 | 19 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 15 | 15 | 0 | 100% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 17 | 17 | 0 | 100% |
| | Цагдаагийн байгууллага | 1 | 1 | 0 | 100% |
| | Хууль зүй, дотоод хэргийн яам | 3 | 0 | 3 | 0% |
| | Шүүхийн сахилгын хороо | 1 | 1 | 0 | 100% |
| | Шүүхийн ерөнхий зөвлөл | 1 | 1 | 0 | 100% |
| | Ерөнхийлөгчийн Тамгын газар | 1 | 0 | 1 | 0% |
| | Өмгөөлөгчдийн холбоо | 1 | 0 | 1 | 0% |
| | Бусад (биечлэн уулзсан) | 40 | | | 100% |

| | | | | | |
|------|-------------------------------------|----|----|---|------|
| 2025 | Авлигатай тэмцэх газар | 9 | 9 | 0 | 100% |
| | УЕПГ, харьяа прокурор | 21 | 21 | 0 | 100% |
| | ШШГЕГ, харьяа ШШГБ | 5 | 4 | 1 | 80% |
| | Эрүүгийн болон иргэний хэргийн шүүх | 1 | 1 | 0 | 100% |
| | Хууль зүй, дотоод хэргийн яам | 1 | 0 | 1 | 0% |
| | Төрийн албаны зөвлөл | 1 | 0 | 1 | 0% |
| | Бусад (биечлэн уулзсан) | 23 | | | 100% |

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд харьяалан шилжүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдал он, байгууллагаар ялгаатай байна. Тухайлбал 2024 онд Авлигатай тэмцэх газар, прокурорын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шилжүүлсэн гомдолд албан бичгээр бүрэн хариу ирүүлсэн бол “2023 болон 2025 онд” зарим байгууллагын хувьд хариу ирүүлсэн хувь буурсан, эсхүл огт ирүүлээгүй байдал ажиглагдсан.

Түүнчлэн цагдаагийн байгууллага, зарим яам, төрийн захиргааны байгууллагын хувьд тодорхой жилүүдэд албан бичгээр хариу ирүүлээгүй нь гомдол, мэдээллийг харьяалан шилжүүлсний дараах эргэх холбоо, хариуцлагын тогтолцоо жигд бус байгаа ба эрүү шүүлт, хүнлэг бус харьцааны зөрчлийг үр дүнтэй таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хүндрэл учруулж болзошгүй нөхцөл юм.

6.6. Эрхийн төрлөөр ангилсан гомдол, мэдээллийн тоон бүтэц (2022-2025)

Эрхийн төрлөөр ангилан үзэхэд хувь хүний эрх чөлөө, бие махбодын халдашгүй байдлын эрх, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь процессын баталгаатай холбоотой гомдол, мэдээлэл тоон үзүүлэлт зонхилж байна. Энэ нь эрх чөлөө хязгаарлагдсан орчинд хүч хэрэглэх, эрүү шүүлт, зүй бус харьцаа гаргах эрсдэл, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийн баталгаа бүрэн хангагдахгүй байх нөхцөл байдал оршсоор байна.

Хүснэгт 74

| № | Эрхийн төрөл | Гомдлын агуулга | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|------|---|---|------|------|------|------|
| 1 | Хувь хүний эрх чөлөө, бие махбодын халдашгүй байдлын эрх | Хорих ангийн алба хаагчийн зүгээс эрүү шүүлт тулгасан | 1 | 10 | 7 | 5 |
| | | Прокурорын алба хаагчийн зүгээс эрүү шүүлт тулгасан | 1 | 8 | 5 | 7 |
| | | ШШГБ-ын алба хаагчийн зүгээс эрүү шүүлт тулгасан | 1 | 7 | 6 | 2 |
| | | Цагдаагийн алба хаагчийн зүгээс эрүү шүүлт тулгасан | 1 | - | 12 | 6 |
| | | Хорих байгууллагын орчин, нөхцөлтэй холбоотой | - | 2 | 1 | 4 |
| 2 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь процессын баталгаа | Хууль зүйн туслалцаа авах | 3 | 10 | 20 | 6 |
| | | Хилс хэрэгт холбогдсон гэх гомдол | 1 | 5 | 1 | - |
| | | Нотлох баримт шалгуулах, прокурор, шүүхэд хандах | 1 | 12 | 17 | 12 |
| 3 | Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх | Хувь хүний шинж, байдалтай холбоотой ялгаварлал | - | 5 | 3 | 3 |
| 4 | Эрхээ хамгаалуулах, гомдол гаргах боломжтой байх баталгаа | Биечлэн уулзаж хууль зүйн зөвлөгөө авах | 2 | - | 27 | 16 |
| Нийт | | | 11 | 59 | 99 | 61 |

ДОЛОО. ДУГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 2022-2025 онд ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан орчинд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдал байсаар байна. Ялангуяа хорих, цагдан хорих байр, мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох гомдол, мэдээлэл дийлэнх хувийг эзэлсэн.

Гомдол гаргасан хүнтэй биечлэн уулзах шаардлага тогтмол үүсэж байгаа нь бичгээр болон цахимаар гомдол, мэдээлэл хүргүүлэх боломж хязгаарлагдмал байдал хадгалагдаж байгааг илтгэхийн зэрэгцээ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг газар дээр нь, шууд оролцоотой хэрэгжүүлэх нь ач холбогдолтой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, биечлэн уулзалт, сургалт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, байгууллага хоорондын уялдааг сайжруулах чиглэлийн ажлын үр дүнд 2025 онд ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо өмнөх онтой харьцуулахад буурсан. Энэхүү өөрчлөлт нь урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тодорхой үр нөлөөг илтгэхийн зэрэгцээ иргэд өргөдөл, гомдлоо хаана, хэрхэн гаргах талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэнийг харуулж байна.



N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХУУЛЬ БУСААР БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хуульчлан тогтоосон.

Гэвч бодит нөхцөл байдлаас үзэхэд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, гэмт үйлдлийн улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд хохирол учруулах тохиолдол жил бүрийн статистик мэдээлэлд тодорхой хэмжээгээр бүртгэгдсээр байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол болон Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Сүүлийн гурван жилийн хугацаанд төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллаж, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ нь тодорхой эерэг үр дүнд хүрч буйг иргэний нийгмийн байгууллагууд мөн онцлон тэмдэглэж байна.

1. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн нөхцөл байдал

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжийг тодорхойлсон. Гэсэн хэдий ч уг гэмт хэргийн статистик мэдээллээс үзэхэд тогтвортой буурах хандлага ажиглагдахгүй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн албан бичгийн хавсралтад дурдсанаар эрүү шүүлт тулгах гэмт хэрэг 2024 онд 29, 2025 онд 31 бүртгэгдсэн байна.

2024 онд 13 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 9 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан бол 2025 онд 24 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 5 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татжээ. Мөн 2024, 2025 оны үлдэгдэл хэрэг тус бүр 12 байна.

Мөрдөн байцаалтын шатанд 2024 онд 9 хэрэг, 2025 онд 5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд нотлох баримтыг бүрдүүлж шүүхэд шилжүүлсэн хэрэг 2024 онд 7, 2025 онд мөн 7 байна.

Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөн эсэх талаар статистик мэдээлэл авахад уг зүйлчлэлд өөрчлөлт ороогүй болохыг баталгаажуулжээ.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2024 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаарах 3 шийдвэрийг⁵⁷ www.shuukh.mn сайтаас түүвэрлэн судлав.

Энэ төрлийн гэмт хэрэг буурахгүй байгаа нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд уламжлалт, хуучирсан сэтгэлгээ, арга барил тодорхой хэмжээнд хадгалагдсаар байж болзошгүйг илтгэж байна.

Иймд уг асуудлыг бууруулахын тулд практик үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд болон сургалтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, сургалтын хөтөлбөрийг хүний эрхийн суурь зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай.

2. Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэргийн нөхцөл байдал

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлд “Хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэргийн шинжийг тодорхойлсон.

Статистик мэдээллээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг 2024 онд 8, 2025 онд 1 бүртгэгдсэн бөгөөд 87.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Уг бууралтад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байж болзошгүй гэж үзэж байна. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрт шүүх эрх мэдлийн байгууллагаас тавих хяналт сайжирсан;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сэжигтнийг хойшлуулшгүй баривчлах, яллагдагчийг цагдан хорих үндэслэл, журмыг боловсронгуй болгосон эрх зүйн зохицуулалт;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас мөрдөгч болон эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хүний эрхийн зарчмыг баримтлах, хүний эрхийг хязгаарлах нөхцөлд хуульд заасан үндэслэл, журмыг чанд мөрдөх талаар зөвлөмж хүргүүлж, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулсан зэрэг болно.

3. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдал

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлд “Ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн шинжийг тодорхойлсон.

Статистик мэдээллээс үзэхэд уг гэмт хэрэг 2024 онд 6, 2025 онд 3 бүртгэгдсэн бөгөөд 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн тоо буурсан нь тодорхой хэмжээгээр эерэг өөрчлөлт гарч буйг илтгэж байгаа боловч уг гэмт хэрэг нь нуугдмал хэлбэрээр үйлдэгдэх, эсхүл мэдээлэгдэхгүй үлдэх тохиолдол байх магадлалтай тул цаашид илүү нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийх шаардлагатай.

57 1. Говь-Алтай аймаг дахь Сум дундын Анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/ийн шийтгэх тогтоол, 2024 оны 09 сарын 06 өдөр, дугаар 2024/ШЦТ/154., 2. Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь Сум дундын Шүүхийн цагаатгах тогтоол, 2024 оны 11 сарын 25 өдөр, дугаар 2024/ШЦТ/128., 3. Баянхонгор аймаг дахь Сум дундын анхан шатны шүүх, 2024-12-06, Дугаар: 2024-ШЦТ/263.

Хүснэгт 75

| № | Эрүүгийн хуулийн зүйл заалт | Он | Хэрэг бүртгэлт | | | | |
|---|---|------------|----------------|-----------|----------------------------------|---|----------|
| | | | Нийт хэрэг | Нэгтгэсэн | Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан | Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан | Үлдэгдэл |
| № | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл "Хууль бусаар баривчлах, саатуулах" | 2024 | 8 | - | 4 | 2 | 2 |
| | | 2025 | 1 | - | 1 | - | 2 |
| | | 2026.01.27 | 2 | - | 2 | - | 2 |
| | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл "Ялгаварлан гадуурхах" | 2024 | 6 | 1 | 2 | - | 3 |
| | | 2025 | 3 | 1 | 4 | - | 1 |
| | | 2026.01.27 | - | - | 1 | - | - |
| | Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл "Эрүү шүүлт тулгах" | 2024 | 29 | 1 | 13 | 9 | 12 |
| | | 2025 | 31 | 2 | 24 | 5 | 12 |
| | | 2026.01.27 | 1 | - | 1 | - | 16 |

Хүснэгт 76

| № | Эрүүгийн хуулийн зүйл заалт | Он | Мөрдөн байцаалт | | | | | | |
|----|---|------------|-----------------|-----------|----------------------|---------------|-------------------|----------------------|----------|
| | | | Нийт хэрэг | Нэгтгэсэн | Хэрэгсэхгүй болгосон | Түдгэлзүүлсэн | Шүүхэд шилжүүлсэн | Зүйлчлэл өөрчлөгдсөн | Үлдэгдэл |
| № | 1 | 2 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1. | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл "Хууль бусаар баривчлах, саатуулах" | 2024 | 2 | - | - | - | 1 | - | 1 |
| | | 2025 | 1 | - | - | - | 1 | - | - |
| | | 2026.01.27 | - | - | - | - | - | - | - |
| 2. | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл "Ялгаварлан гадуурхах" | 2024 | - | - | - | - | - | - | - |
| | | 2025 | - | - | - | - | - | - | - |
| | | 2026.01.27 | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | |
|----|--|------------|---|---|---|---|---|---|---|
| 3. | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл "Эрүү шүүлт тулгах" | 2024 | 9 | - | - | - | 7 | - | 2 |
| | | 2025 | 5 | 1 | - | - | 7 | - | - |
| | | 2026.01.27 | - | - | - | - | - | - | - |

6.1. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал (2022-2025 оны байдлаар)

Хүснэгт: Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн статистик мэдээлэл

Хүснэгт 77

| № | харьяалах шүүх, огноо, дугаар | Утга | Шийдвэрлэлт |
|---|--|---|--|
| Нэг. Анхан шатны шүүхийн тогтоол | | | |
| 2022 онд: | | | |
| 1. | Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2022 оны 03 сарын 29 өдөр Дугаар 2022/ШЦТ/392 | Шүүгдэгч Г.Д нь төрийн албан хаагчаар буюу ажиллаж байхдаа 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр иргэн Т.Л-аас гаргасан бүртгэлийн 000 дугаартай гэмт хэргийн талаарх гомдлыг шалгах явцдаа иргэн Ц.Ө-ын хийгээгүй хэргийг хүлээлгэх зорилгоор 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр байранд "... айлаас телевизор хулгайлсан хэргээ хүлээ" гэж нүүр, толгойн тус газар нь гараараа цохих, хэвлий, гуя, өгзөг хэсэгт нь хөлөөрөө өшиглөх, өвдөглөх, резинэн бороохойгоор гуя, нуруун тус газар нь цохих зэргээр бие махбод болон сэтгэл санааг нь шаналган зовоож, эрүү шүүлт тулгасан, 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдрийн 10 цагийн үед.....0 тоот өрөөнд иргэн Ц.Ө-ыг хийгээгүй хэргийг хүлээлгэх зорилгоор "...айлаас телевизор хулгайлсан хэргээ хүлээ" гэж зодож, хэвлий хэсэгт хөлөөрөө өшиглөж, биед нь "нарийн гэдэсний урагдал, хэвлийн хөндийд шингэн хуралдалт" бүхий гэмтэл учруулж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан, Шүүгдэгч Б.Э нь төрийн албан хаагчаар буюу..... ажиллаж байхдаа 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр, 2019 оны 0 дугаар сарын 0-0 шилжих шөнө..... байранд 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр, 2019 оны 0 дугаар сарын 0-0 шилжих шөнө иргэн Ц.Ө-ын хийгээгүй хэргийг хүлээлгэх зорилгоор, "...Д аймагт үйлдсэн хэргээ хүлээ..." гэж ташиж унагаах, цахилгаан бороохойгоор цохиулах, гараараа толгойн тус газар нь цохих, хөлөөрөө гуя, өгзөг хэсэгт нь өшиглөх, хэлтсийн байранд шөнийн цагаар хууль бусаар саатуулах зэргээр бие махбод болон сэтгэл санааг нь шаналган зовоож, эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт тус тус холбогдсон. | Шүүгдэгч Б овогт Г-ын Д-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу төрийн албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгах, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах тус тус гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, Шүүгдэгч Х овогт Б-ын Э-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу төрийн албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцусгай. |

| | | | |
|----|---|--|---|
| 2. | <p>Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүх / Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол</p> <p>2022 оны 05 сарын 12 өдөр</p> <p>Дугаар 2022/ШЦТ/120</p> | <p>Шүүгдэгч Б.Б нь Булган аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа Ц.А-тай бүлэглэн Булган аймаг дахь Цагдаагийн газрын байрны 2 давхарт байрлах Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын өрөөнд 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Л.Э-д "Булган аймгийн Сэлэнгэ суманд оршин суух Д.М бусдад хүчиндүүлсэн" гэх хэргийг хүлээлгэх зорилгоор бие эрх чөлөөнд халдаж цахилгаан бороохойгоор цохиулж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан,</p> <p>Шүүгдэгч Ц.А нь Булган аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагчаар ажиллаж байхдаа Б.Б-тай бүлэглэн Булган аймаг дахь Цагдаагийн газрын байрны 2 давхарт байрлах Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын өрөөнд 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Л.Э-д "Булган аймгийн Сэлэнгэ суманд оршин суух Д.М бусдад хүчиндүүлсэн" гэх хэргийг хүлээлгэх зорилгоор бие эрх чөлөөнд халдаж цахилгаан бороохойгоор цохиулж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>1. Шүүгдэгч Ш***** овогт Б***** Б*****; Ха***** овогт Ц*****н А*****-ыг нарыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.</p> |
| 3. | <p>Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол</p> <p>2022 оны 09 сарын 16 өдөр</p> <p>Дугаар 2022/ШЦТ/895</p> | <p>Шүүгдэгч Б.Б нь төрийн албан хаагчаар буюу Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа тус цагдаагийн тасгийн мөрдөгч П.Ч, мөрдөгч Д.Б нартай урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч тухайн цаг хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэгтэй, ач холбогдолтой гэж үзсэн мэдээ сэлт агуулсан мэдүүлэг авах, улмаар хэрэг хүлээлгэх гэсэн санаа зорилго, үйлдлээрээ нэгдэж бүлэглэн 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр иргэн М.Х-гээс цагдаагийн байгууллагад гаргасан "хүмүүс хар өвс татаад байна" гэх гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн 3 давхарт байрлах мөрдөгч П.Ч-ын албан өрөөнд "хаанаас, хэнээс авснаа хэл, үнэнээ хэл" гэх мэтээр хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор иргэн Г.Б-ыг цохиж, зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дахь гэмт тус тус хэрэгт холбогджээ.</p> | <p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус журамлан, шүүгдэгч Хан хөгшин овогт П.Ч, Цэвэгжав овогт Д.Б, С овогт Б.Б нарыг Төрийн албан хаагчаар ажиллаж байх үедээ бүлэглэн хохирогч Г.Б-ыг "хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор цохиж зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн" буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэм буруутайд,</p> |
| 4. | <p>Шүүхийн нэр: Хөвд аймаг дахь Сум дундын анхан шатны шүүх -</p> <p>Огноо: 2022-01-14</p> <p>Дугаар: 2022-ШЦТ/205</p> | <p>уг тогтоолыг татаж үзэх боломжгүй байв.</p> | <p>Зүйл, хэсэг: 21.12.1</p> |

ДОЛООДУГААР
БҮЛЭГ

| 2023 онд: | | | |
|-----------|--|---|--|
| 5. | Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол 2023 оны 09 сарын 20 өдөр Дугаар 2023/ШЦТ/616 | Миний биед халдсан цагдаагийн алба хаагч нь Хан-Уул дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст ажилладаг *** гэх цагдаагийн алба хаагч, би уг цагдаагийн албан хаагчид зодуулсандаа гомдолтой байна. | Шүүгдэгч *** ***(ийг) Төрийн албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор "Эрүү шүүлт тулгах" гэмт хэрэг үйлдсэнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар; мөн Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар буюу эрүүдэн шүүж үйлдсэнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тус тус гэм буруутайд тооцугай. |
| 6. | Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол 2023 оны 05 сарын 25 өдөр Дугаар 2023/ШЦТ/373 | Шүүгдэгч Г.Ё нь 2022 оны 05 дугаар сарын ***** 9-ний өдөр --- ны нутаг дэвсгэрт байрлах ***** нарын албан ерөөнд хохирогч М.Э-ыг хулгайн гэмт хэрэгт сэрдэж, хэрэг хүлээлгэх зорилгоор "машин чинь хаана байна, машиндаа үзлэг хийлгэчхээд яв" гэж эрүү шүүлт тулгаж биед халдаж цохиж зодон эрүүл мэндэд нь хамар ясны хугарал, хамрын таславчийн мурийлт, баруун гуянд цус хуралт бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдсон. | 2.Шүүгдэгч Унзад ургийн овгийн *****-ыг Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд, -Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг, хэрэг хүлээлгэх зорилгоор Эрүүдэн шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцугай. |
| 7. | Шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Огноо: 2023-11-22 Дугаар: 2023-ШЦТ/1440 | уг тогтоолыг татаж үзэх боломжгүй байв. | Зүйл, хэсэг: 17.3.2.1, 21.12.1 |
| 2024 онд: | | | |
| 8. | Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх / Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол 2024 оны 09 сарын 06 өдөр Дугаар 2024/ШЦТ/154 | Шүүгдэгч Ш.Б нь **** аймгийн Цагдаагийн газрын **** сумын хэсгийн төлөөлөгч буюу Төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалтнаар ажиллаж байхдаа 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр **** аймгийн *** сум төв цагдаагийн кобон байранд Б.Б-г хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгасан, мөн эрүүдэн шүүж түүний баруун шанаа хэсэгт 2 удаа, цээж рүү 4 удаа гараараа цохиж эрүүл мэндэд нь зүүн 2 болон 3 дугаар хавирганы зөрүүгүй хугарал, зүүн 4-р хавирганы зөрүүтэй хугарал гэмтэл үүсгэж эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан үйлдлүүдийг прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэн шүүхэд ирүүлжээ. | 1.Шүүгдэгч Б-О овгийн Ш-ийн Б-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "төрийн тусгай албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгах" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар "эрүүдэн шүүж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцугай. |

| | | | |
|------------------|---|---|---|
| 9. | <p>Дорноговь аймгийн Замын-Ууд сум дахь сум дундын шүүхийн Цагаатгах тогтоол</p> <p>2024 оны 11 сарын 25 өдөр</p> <p>Дугаар 2024/ШЦТ/128</p> | <p>Шүүгдэгч Ч.Б нь Д аймгийн Ц-ийн газрын 3 сумын сум дундын Ц-ийн хэлтсийн Э-ийн ц-ийн х-н э-ийн м-р ажиллаж байхдаа иргэн Б.Б-с Д. аймгийн Ц-ийн хэлтэст бичгээр гаргасан "Монгол Улсаас 2023 оны 08 сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан" гэсэн утгатай Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй 240 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Д аймгийн 3 сум дахь сум дундын хэлтсийн байрны жижүүрийн ахлах мөрдөгчийн 102 тоот өрөөнд 2023 оны 08 сарын 05-ны өдөр Х.У-ыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор "тэр цүнх хаана байна п***а минь, чамайг п***а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п***а юу" гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа мангасдаж толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Иймд шүүгдэгч Ч.Б-д холбогдох эрүүгийн тоот хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Ч.Б-ыг цагаатгаж шийдвэрлэв.</p> |
| 10. | <p>Шүүх: Баянхонгор аймаг дахь Сум дундын анхан шатны шүүх</p> <p>Огноо: 2024-12-06</p> <p>Дугаар: 2024-ШЦТ/263</p> | <p>уг тогтоолыг татаж үзэх боломжгүй байв.</p> | <p>Зүйл, хэсэг: 13.9.1, 21.12.1, 22.1.1</p> |
| 2025 онд: | | | |
| 11. | <p>Сүхбаатар аймаг дахь сум дундын анхан шатны шүүх / Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол</p> <p>2025 оны 01 сарын 13 өдөр</p> <p>Дугаар 2025/ШЦТ/24</p> | <p>Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын Мөнххаан сумын сум дундын цагдаагийн хэсгийн Түмэнцогт сумын хэсгийн цагдаагаар ажиллаж байхдаа Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутаг дэвсгэр "Алаг гомбон" гэх газарт 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр иргэн Д.Бат-Эрдэнийг "2018 оноос хойш иргэн ***** малыг маллаж байхдаа олон тооны мал дутаасан, бусдад худалдаж завшсан" гэх гэмт хэрэг үйлдсэнийг хүлээлгэх зорилгоор "өгзөг рүү нь хөлөөрөө 1 удаа өшиглөх, эвхэгддэг тонгорог хутганы ишээр цээж хэсэг рүү 2 удаа цохих" зэрэг эрүүл мэндэд нь хохирол учруулаагүй үйлдэл хийж бие махбодыг нь шаналган зовоож, "хүний мал яагаад дутаасан бэ, хоолойг чинь хэрчинэ, хүний мал дутаасан, яаж төлөх юм бэ, чамайг ална, дутсан малыг хаашаа үгүй хийсэн талаараа үнэнээ хэл" гэх зэргээр үг хэлэх, гараар цохихоор далайх, хутганы ир хэсгийг хоолойд хүргэх үйлдэл хийх зэргээр сэтгэл санааг нь шаналган зовоож эрүү шүүлт тулгасан, мөн тус газарт байхдаа ***** биед хутга тулгах, хутганы ишээр цээж рүү нь цохих, хоолойг нь хэрчинэ гэж хэлэх зэргээр хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж буюу бэлэг эрхтнээ хөхүүлж хүчиндсэн гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Шүүгдэгч ***** нь "Гэм буруугаа хүлээн зөвшөөрч байна. Тэгээд миний энэ ялыг маань хорих ял биш арай өөр ялаар шийдэж өгч тусална уу гэж хүсэж байна. Би ар гэр 3 хүүхэдтэй амьдралтай тэгээд тийм л юмыг хүсэж байна. Эрүү шүүл тулгасан гэм буруугаа хүлээн зөвшөөрч байна. Би хохирогч ...-тэй энэ асуудал болсноос хойш 2 жилийн хугацаанд ер нь уулзаж утас шөрмөсөөр яриагүй. Энэ хохирогч яг хэрэв монгол хүний шударга ёсны зарчмаар ...-тэй уулзаж зүй бус харьцсан дээрээ уучлал гуйна."</p> |

| | | | |
|-----|--|--|--|
| 12. | 2025 - Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Шийтгэх тогтоол 2025 оны 04 сарын 08 өдөр Дугаар 2025/ ШЦТ/883 | Шүүгдэгч Э.П нь 2024 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 09-нд шилжих шөнө ...өрөөнд Хар тамхитай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн албан тушаалд томилогдон албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг «Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно», хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно"-д заасныг тус тус зөрчиж өсвөр насны Ц.Ц, Ж.Н нараас мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх зорилгоор бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэх гэмт хэрэгт холбогджээ. | Шүүгдэгч Э.П /РД/-г төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаар илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай. |
| 13. | 2025 - Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх ийн Шийтгэх тогтоол 2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар 2025/ ШЦТ/1162 | Төрийн албан хаагч буюу ***** дүүргийн Цагдаагийн газрын ***** хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч Н.***** нь 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ***** дүүргийн 1***** хорооны нутаг дэвсгэрт байрлах тус хэлтсийн байранд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гаргасан иргэн *****аас мэдүүлэг авах зорилгоор маргаж ална, хэрэг тохно гэх зэрэг үг хэллэг хэрэглэн хэл амаар доромжилж гавлах, хүч хэрэглэн биед нь халдан зодох зэргээр бусдын бие махбод сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт, ийнхүү зодох явцдаа хохирогч *****ийн биед "баруун хөмсөг, зүүн шуунд зулгаралт, хүзүү, баруун мөр, бугалгад цус хуралт, зүүн шанаа, хацрын зөөлөн эдийн няцрал" бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт тус тус холбогдсон. | Шүүгдэгч ***** овогт *****гийн *****-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах зорилгоор өөрөө бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон" гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд, -Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан" гэм хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай. |

| | | | |
|------------|---|---|--|
| <p>14.</p> | <p>2025 - Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх ийн Шийтгэх тогтоол 2025 оны 05 сарын 05 өдөр Дугаар 2025/ШЦТ/1230</p> | <p>Шүүгдэгч *** нь Баянгол дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа буюу 2024 оны 7 дугаар сарын 22-ноос 23-нд шилжих шөнө "Дээрэмдэх" гэмт хэрэгт сэжиглэгдсэн *** гэгчийг барьж тус цагдаагийн хэлтсийн байранд авч ирсэн атлаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан "сэжигтнийг баривчлах" ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулахтай холбоотой санал, тогтоол зэргийг үйлдээгүй, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэлгүйгээр 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 16 цаг 07 минут хүртэл хүнийг хууль бусаар саатуулсан. Мөн хугацаанд тус цагдаагийн хэлтсийн байранд ***-ийг явган суулгах, хоёр гарыг нь паарнаас, биеийн урд болон ард хэсэгт тус тус гавласан байдалтайгаар байлгаж бие махбодыг нь шаналган зовоох, "Дээрэмдэх" гэмт хэргийг хүлээн, бусдын эд зүйлсийг гаргаж өгөхийг шаардах зэргээр сэтгэл санааг нь шаналган зовоох зэргээр эрүү шүүлт тулгасан</p> | <p>Нийслэлийн прокуратурын газрын хяналтын прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт шүүгдэгч *** холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар буюу гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай.</p> <p>Шүүгдэгч ***-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх зорилгоор өөрөө бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон",</p> <p>- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан",</p> <p>- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан өөртөө давуу байдал бий болгосон" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.</p> |
| <p>15.</p> | <p>2025 - Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх ийн Шийтгэх тогтоол 2025 оны 07 сарын 24 өдөр Дугаар 2025/ШЦТ/1834</p> | <p>2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр хэсгийн байцаагчийн албан ерөөндөө холбогдогч ***аас тайлбар, мэдүүлэг авах зорилгоор биед нь хүч хэрэглэн халдаж, сэтгэл санааг нь шаналган зовоосон,</p> <p>Мөн 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр *** байран дотор байрлах албан ерөөндөө иргэн ***ын шилбэ хэсэг рүү нь хөлөөрөө өшиглөж, тонгойлгож байгаад бөгс рүү цохих зэргээр зодож эрүүл мэндэд нь "баруун шилбэний халдварлагдсан шарх, баруун шилбэний удаан дарагдлын хам шинж, арьс зөөлөн эдийн үхжил, үхжилтийг эдийг өөлж авах, угаах, баруун гуянаас арьс шилжүүлэн суулгах мэс засал, баруун шилбэний арьс зөөлөн эдийн дутмагшил, баруун хөлийн шилбэ, тавхайн мэдрэлийн бууралт, тавхайн 3, 4, 5 дугаар хурууны өнгөц мэдрэхүйн бууралт, зүүн шилбэнд шарх, биеийн гадаргуугийн 4-6 хувь хүртэлх талбайг хамарсан сорви" гэмтэл бүхий хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Шүүгдэгч *** овогт ***-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах зорилгоор өөрөө бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон",</p> <p>- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.</p> |
| <p>16.</p> | <p>Сүхбаатар аймаг дахь сум дундын анхан шатны шүүх / Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол 2025 оны 08 сарын 01 өдөр Дугаар 2025/ШЦТ/232</p> | <p>Сүхбаатар аймгийн Наран сумын нутаг дэвсгэрт байрлах цагдаагийн хэсгийн байранд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр цагдаагийн ...-нь иргэн Н.М-ыг зүүн хөлөөрөө баруун талын гуя хэсэг рүү нь өшиглөж, баруун чих хэсэг рүү нь зүүн гараараа 2 удаа алгадах зэрэг эрүүл мэндэд нь хохирол учруулаагүй үйлдэл хийж, бие махбодыг нь шаналган зовоож, «муу хулгайч үнэнээ хэл, чи үнэнээ хэл л дээ, чи авсан биз дээ хулгайч минь» гэх үг хэлж сэтгэл санааг нь шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>Шүүгдэгч ***** овогт *****-ыг төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах зорилгоор бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.</p> |

| | | | |
|--|--|--|--|
| 17. | <p>Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Шийтгэх тогтоол</p> <p>2025 оны 10 сарын 27 өдөр</p> <p>Дугаар 2025/ШЦТ/117</p> | <p>Шүүгдэгч Ч.Б нь Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн .. мөрдөгчөөр ажиллаж байхдаа иргэн Б.Б-ээс Дорноговь аймгийн Цагдаагийн хэлтэст бичгээр гаргасан "Монгол Улсаас 2023 оны 08 сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2,500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан" гэсэн утгатай Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй .. дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын хэлтсийн байрны жижүүрийн ахлах мөрдөгчийн 102 тоот өрөөнд 2023 оны 08 сарын 05-ны өдөр Х.У-ыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор "тэр цүнх хаана байна п****а минь, чамайг п****а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п****а юу" гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа мангасдаж толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Шүүгдэгч Н овогт Ч-ын Б-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн албан хаагч хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцугай.</p> |
| Хоёр. Давж заалдах шатны шүүхийн магадлал | | | |
| 2022 онд: | | | |
| 18. | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2022 оны 04 сарын 07 өдөр</p> <p>Дугаар 2022/ДШМ/369</p> | <p>1.Г.Г нь Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн Цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа:</p> <p>Д.Б, Д.Ч нартай бүлэглэж хэрэг бүртгэлтийн дугаар бүхий хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэгт заасныг зөрчиж иргэн Г.Дд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэн, холбогдогч нь тогтоогдоогүй 15 хэргийг хүлээлгэх зорилгоор, 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 25-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байранд гавтай хонуулж, бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан,</p> <p>2. Д.Ч нь Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн Цагдаагийн тасагт эрүүгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа:</p> <p>Д.Б, Г.Г нартай бүлэглэж хэрэг бүртгэлтийн дугаар бүхий хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэгт заасныг зөрчиж иргэн Г.Дд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэн, холбогдогч нь тогтоогдоогүй 15 хэргийг хүлээлгэх зорилгоор, 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 25-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байранд гавтай хонуулж, бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан,</p> <p>3. Д.Б нь Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн Цагдаагийн тасагт эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа:</p> <p>Г.Г, Д.Ч нартай бүлэглэж, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэгт заасныг зөрчиж иргэн Г.Дд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэн, холбогдогч нь тогтоогдоогүй 15 хэргийг хүлээлгэх зорилгоор, 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 25-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байранд гавтай хонуулж, бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан,</p> | <p>Хавтаст хэргээс үзэхэд, хохирогч Г.Д нь болсон хэргийн талаар тодорхой, тогтвортой мэдүүлдэг, түүний мэдүүлгүүд нь гэрч Т.Буянт, Я.Солонго, Ч.Цэцэг-Очир, М.Мөнхнаран, Э.Балдорж, Г.Номинзул, Г.Чимэдцогзол, Ц.Түмэнбаяр нарын мэдүүлгүүд болон Криминалистикийн шинжээчийн дүгнэлтээр давхар нотлогдон тогтоогдсон бөгөөд Монгол Улсын 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц"-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа үйлдлийг хэлнэ" гэсэн тодорхойлолтод хамаарч байх тул нэмж мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх шаардлагагүй байх тул шүүгдэгчийн өмгөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлуудыг хүлээн авч хангах хууль зүйн үндэслэлгүй гэж үзэв.</p> |

| | | | |
|-----|--|---|---|
| 19. | <p>Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2022 оны 09 сарын 14 өдөр</p> <p>Дугаар 2022/ДШМ/30</p> | <p>Шүүгдэгч Б.Б нь аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа Ц.А-тай бүлэглэн аймаг дахь Цагдаагийн газрын 2 дугаар давхарт байрлах Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын өрөөнд 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Л.Э-д ".... аймгийн суманд оршин суух Д.М бусдад хүчиндүүлсэн" гэх хэргийг хүлээлгэх зорилгоор бие эрх чөлөөнд халдаж цахилгаан бороохойгоор цохиулж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан,</p> <p>Шүүгдэгч Ц.А нь аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагчаар ажиллаж байхдаа Б.Б-тэй бүлэглэн аймаг дахь Цагдаагийн газрын 2 дугаар давхарт байрлах Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын өрөөнд 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Л.Э-д ".... аймгийн суманд оршин суух Д.М бусдад хүчиндүүлсэн" гэх хэргийг хүлээлгэх зорилгоор бие эрх чөлөөнд халдаж цахилгаан бороохойгоор цохиулж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>..... аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 2022/ШЦТ/120 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Ц.А-ын өмгөөлөгч Х.О-ын давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгосуйгай.</p> |
| 20. | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2022 оны 11 сарын 23 өдөр</p> <p>Дугаар 2022/ДШМ/1122</p> | <p>1.Шүүгдэгч П.Ч нь төрийн албан хаагчаар буюу Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа тус цагдаагийн тасгийн ахлах мөрдөгч Б.Б, мөрдөгч Д.Б нартай урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч тухайн цаг хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэгтэй, ач холбогдолтой гэж үзсэн мэдээ сэлт агуулсан мэдүүлэг авах, улмаар хэрэг хүлээлгэх гэсэн санаа зорилго, үйлдлээрээ нэгдэж бүлэглэн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр иргэн М.Х цагдаагийн байгууллагад гаргасан "хүмүүс хар өвс татаад байна" гэх гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа 2021 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтэс буюу өөрийн ажлын байрны 2 давхрын ариун цэврийн өрөөнд хаанаас, хэнээс авснаа хэл, үнэнээ хэл" гэх мэтээр хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор иргэн Г.Б-ыг цохиж, зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт,</p> <p>2. Шүүгдэгч Д.Б нь төрийн албан хаагчаар буюу Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа тус цагдаагийн тасгийн ахлах мөрдөгч Б.Б, мөрдөгч П.Ч нартай урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч тухайн цаг хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэгтэй, ач холбогдолтой гэж үзсэн мэдээ сэлт агуулсан мэдүүлэг авах, улмаар хэрэг хүлээлгэх гэсэн санаа зорилго, үйлдлээрээ нэгдэж бүлэглэн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр иргэн М.Х цагдаагийн байгууллагад гаргасан "хүмүүс хар өвс татаад байна" гэх гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа 2021 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтэс буюу өөрийн ажлын байрны 2 давхрын ариун цэврийн өрөөнд "хаанаас, хэнээс авснаа хэл, үнэнээ хэл" гэх мэтээр хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор иргэн Г.Б-ыг цохиж, зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт,</p> <p>3.Шүүгдэгч Б.Б нь төрийн албан хаагчаар буюу Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа тус цагдаагийн тасгийн мөрдөгч П.Ч, мөрдөгч Д.Б нартай урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч тухайн цаг хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэгтэй, ач холбогдолтой гэж үзсэн мэдээ сэлт агуулсан мэдүүлэг авах, улмаар хэрэг хүлээлгэх гэсэн санаа зорилго, үйлдлээрээ нэгдэж бүлэглэн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр иргэн М.Х цагдаагийн байгууллагад гаргасан "хүмүүс хар өвс татаад байна" гэх гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа 2021 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн 3 давхарт байрлах мөрдөгч П.Ч-ын албан өрөөнд «хаанаас, хэнээс авснаа хэл, үнэнээ хэл" гэх мэтээр хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор иргэн Г.Б-ыг цохиж, зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч П.Ч, Д.Б, Б.Б нарын өмгөөлөгч Б.Гэрэл-Очирын гаргасан "...П.Ч, Д.Б, Б.Б нар хохилогч Г.Б-ыг цохиж зодоогүй, эрүүдэн шүүгээгүй. Хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. ..." гэсэн агуулга бүхий давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэлтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.</p> |

ДОЛООДУГААР
БҮЛЭГ

| | | | |
|------------------|---|---|--|
| 21. | <p>Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2022 оны 12 сарын 20 өдөр</p> <p>Дугаар 38</p> | <p>Шүүгдэгч Д.М нь төрийн тусгай алба хаагч буюу Ховд аймгийн Дарви сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгчөөр ажиллаж байхдаа тус сумын нутаг дэвсгэрт байрлах цагдаагийн хэсгийн байран дахь албан ерөөндөө 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр 13 настай Б.Д, 11 настай Б.Ё, 6 настай Б.А нарт унадаг дугуй хулгайлсан гэх үндэслэлээр цонх гэрэлтүүлэггүй өрөөнд оруулах, Б.Д, Б.Ё нарын эрүүний доод хэсэгт гараараа чичих, хувцасны захаар нь хоолойг нь боох, чихнээс нь татах, хацар хэсэгт алгадах, Б.Д-ийн зүүн чихний хэсэгт нь алгдаж хана мөргүүлэх, 890 грамм жинтэй, шингэн бодистой, хуванцар сав бариулж гарыг нь өргүүлэх, зүүн чихний хэсэгт нь алгадах, мөн сараалжин төмөр хаалт бүхий цонхтой, цагаан өнгийн будгаар будсан төмөр хаалгатай, гэрэлтүүлэггүй, хаалтгүй өрөөнд оруулж суулгах, албаны өрөөнөөс орох хаалгатай цонх, гэрэлтүүлэг, халаалтгүй 1х2 метр харьцаатай өрөөнд 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 00 цагаас 2022 оны 04 дүгээр 15-ны өдрийн 08 цаг хүртэл хугацаанд насанд хүрээгүй хохирогч Б.Д-г гавлаж, хаалгыг нь гаднаас нь цоожилж хонуулах зэргээр бие махбод, сарын сэтгэл санааг нь шаналган зовоож эрүү шүүлт тулгасан, Мөн насанд хүрээгүй хохирогч Б.Д-ийн хүсэл зоригийн эсрэг чөлөөтэй зорчих эрхийг нь тодорхой хугацаанд буюу 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 00 цагаас 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 08 цаг хүртэл хугацаанд сараалжин төмөр хаалт бүхий цонхтой, цагаан өнгийн будгаар будсан төмөр хаалгатай, гэрэлтүүлэггүй, хаалтгүй өрөөнд оруулж суулгах, албаны өрөөнөөс орох хаалгатай цонх, гэрэлтүүлэг, халаалтгүй 1х2 метр харьцаатай өрөөнд гавлаж, хаалгыг нь гаднаас нь цоожилж, хонуулж хууль бусаар хорьж хүнийг сураггүй алга болгох гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>Шүүгдэгч Б.М нь “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг бага насны буюу 13 настай эмэгтэй хүүхдийн эсрэг үйлдсэн нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт заасан “хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн” гэх эрүүгийн хариуцлагын хүндрүүлэх шинжтэй байх тул шүүгдэгч болон түүний өмгөөлөгч нарын “шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж, шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг торгох ялаар солих” агуулгатай давж заалдсан гомдлуудыг хэрэгсэхгүй болгож, шийдвэрлэв.</p> |
| 2023 онд: | | | |
| 22. | <p>Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2023 оны 03 сарын 22 өдөр</p> <p>Дугаар 2023/ДШМ/10</p> | <p>Шүүгдэгч Э нь Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх байранд 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хохирогч Г-д, иргэн Б-ын эзэмшлийн тээврийн хэрэгслийн урд салхины шилийг хагалсан гэх хэргийг хүлээлгэх зорилгоор түүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах явцдаа Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх байранд 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Г-ын биед зүүн дал болон зүүн бугалганы гадна дээд хэсэг, зүүн гуяны дотор талд цус хуралт, баруун завжинд язарсан шарх, гэмтэл учруулж, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдсон.</p> | <p>Анхан шатны шүүхээс шүүгдэгч Э-ийн үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар буюу Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.12-т зааснаар “эрүүдэн шүүж”, хохирогчийн эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан, мөн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинж тогтоогдоогүй, харин шүүгдэгчийн үйлдэлд “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэргийн шинж тогтоогдсон талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлж, шийдвэрлэсэн нь зөв байна.</p> |

| | | | |
|------------------|--|--|---|
| 23. | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2023 оны 07 сарын 18 өдөр</p> <p>Дугаар 2023/ ДШМ/718</p> | <p>Шүүгдэгч Г.Ё нь 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтсийн эрүүгийн мөрдөгч нарын албан ерөөнд хохирогч М.Э-ыг хулгайн гэмт хэрэгт сэрдэж, хэрэг хүлээлгэх зорилгоор "машин чинь хаана байна, машиндаа үзлэг хийлгэжээд яв" гэж эрүү шүүлт тулгаж биед халдаж цохиж зодон эрүүл мэндэд нь хамар ясны хугарал, хамрын таславчийн мурилт, баруун гуянд цус хуралт бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Тодруулбал, анхан шатны шүүх "... Шүүгдэгч Г.Ё нь Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтсийн эрүүгийн мөрдөгч нарын албан ерөөнд иргэн М.Э-ыг хулгайн гэмт хэрэгт сэрдэж, биед нь халдаж буй идэвхтэй үйлдэл хийснээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинж хангагдсан байхад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.12 дахь заалтад заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар буюу эрүүдэн шүүж үйлдэж үйлдсэн гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар давхар хүндрүүлэн зүйлчлэх үндэслэлгүй." гэж хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна.</p> |
| 24. | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2023 оны 12 сарын 06 өдөр</p> <p>Дугаар 2023/ ДШМ/1163</p> | <p>Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Шүүгдэгч Г.Ё-ийг Төрийн албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор "Эрүү шүүлт тулгах" гэмт хэрэг үйлдсэнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар; мөн "Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах" гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар буюу эрүүдэн шүүж үйлдсэнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тус тус гэм буруутайд тооцож, шүүгдэгч Г.Ё-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 жилийн хугацаагаар хорих ял, мөн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 720 цагийн хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус шийтгэжээ.</p> | <p>Учир нь, анхан шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтуудад үндэслэл бүхий дүгнэлт хийж, шүүгдэгч Г.Ё-ийг хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгасан, мөн хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн гэж шийтгэх тогтоолдоо тодорхой үндэслэлүүдээр дүгнэснийг давж заалдах шатны шүүхээс буруутгах үндэслэл тогтоогдохгүй байх тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Г.Ё, түүний өмгөөлөгч О.Анхбаяр гаргасан давж заалдах гомдлуудыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх дүгнэлээ.</p> |
| 2024 онд: | | | |
| 25. | <p>Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2024 оны 10 сарын 29 өдөр</p> <p>Дугаар 2024/ДШМ/33</p> | <p>Шүүгдэгч Б овгийн Ш.Б-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "төрийн тусгай албан хаагч хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгах" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар "эрүүдэн шүүж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож,</p> | <p>Анхан шатны шүүхээс шүүгдэгчид оногдуулсан ял шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт тохирсон, ялыг хөнгөрүүлэн өөрчлөх үндэслэл тогтоогдохгүй байна гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.</p> |

2025 онд:

| | | | |
|-----|---|---|--|
| 26. | <p>Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2025 оны 02 сарын 05 өдөр</p> <p>Дугаар 2025/ДШМ/14</p> | <p>Ч.Б нь Дорноговь аймгийн Цагдаагийн газрын * ажиллаж байхдаа иргэн Б.Бээс Дорноговь аймгийн Цагдаагийн хэлтэст бичгээр гаргасан «Монгол Улсаас 2023 оны 08 сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан» гэсэн утгатай Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй 240 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын хэлтсийн байрны жижүүрийн ахлах мөрдөгчийн 102 тоот өрөөнд 2023 оны 08 сарын 05-ны өдөр Х.Ү-г хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор «тэр цүнх хаана байна п***а минь, чамайг п***а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п***а юу» гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа мангасдаж толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Анхан шатны шүүхийн “шүүгдэгч Ч.Б-ыг хохирогч Х.Ү-ыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор зодож эрүүдэн шүүлт тулгах гэмт хэргийг үйлдээгүй байна” гэж үзсэн цагаатгах тогтоолын дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцсэн, тогтоол хууль зүйн үндэслэлтэй.</p> |
| 27. | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал</p> <p>2025 оны 04 сарын 17 өдөр</p> <p>Дугаар 2025/ДШМ/447</p> | <p>Яллагдагч Б.Х нь 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр иргэн Б.О-гдугаартай албан өрөөнд эрүүгийн 230504114 дугаартай хэрэгт хэрэг хүлээлгэж, мэдүүлэг авах зорилгоор “худлаа шаагаад чи, М-г олж өгөөгүй, үнэн худалч п***а байна” гэж хэлэн сэтгэл санааг нь шаналган зовоож, улмаар түүний өмсөж явсан куртикийн урд талын энгэр хэсгээс хоёр гараараа атгаж байгаад арагшаа хана руу 2-3 удаа түлхэж нуруу, биеийн ар хэсгээр мөргүүлж, хар өнгийн резин урт бороохойгоор зүүн гарын булчин хэсэг, зүүн хөлийн гуяны гадна хэсэг рүү цохиж, бие махбодыг нь шаналган зовоосон, мөндугаартай албан өрөөнд мөрдөгч Э.Х-н резинэн бороохойг нугалж, хоёр үзүүрээр нь Б.О-н хоолойн урд хэсэг рүү тулгаж, хойшоо түлхэх зэргээр бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон үйлдэл хийсний дараа “яасан энэ хэд аймар байгаа биз дээ, баарнаас гараад гүйхэд М-тай хамт явсан эрэгтэйг бас хэл, эд нарын өрөө аймар байгаа биз дээ, хана нь цөмөрсөн, наад хэд чинь хана руугаа аваад шидчихдэг юм, энэ гуравтай үлдэх юм уу, манай өрөө рүү орох юм уу” гэж сэтгэл санааг шаналган зовоох шинжтэй үг хэлж, түүний биед нь халдсан мөрдөгч Э.Х-н үйлдлийг таслан зогсоолгүй, хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлж Б.О-н бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон, яллагдагч Э.Х нь 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр иргэн Б.О-г дугаартай албан өрөөнд хэрэг хүлээлгэх зорилгоор резин бороохойг нугалж, хоёр үзүүрээр нь түүний хоолойн урд хэсэг рүү тулгаад хойшоо түлхэж, шахах зэргээр бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 2025/ШЗ/1766 дугаар шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, прокурор С.Бичинхүүгийн бичсэн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 8 дугаар прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосугай.</p> |

| | | | |
|---|---|--|--|
| <p>28.</p> | <p>Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал 2025 оны 05 сарын 22 өдөр Дугаар 2025/ ДШМ/615</p> | <p>Яллагдагч Ч.Ё нь Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч цолтой ажиллах хугацаандаа буюу 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо Ойчдын гудамжинд байх Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн ...тоот өрөөнүүдэд албаны чиг үүрэг буюу албан тушаалын тодорхойлолтын 2 дахь хэсгийн 1 дэх заалтад заасан "нууц далд аргаар үйлдэгдсэн болон тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох", Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "...Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдахыг хориглоно..."; мөн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "... сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно..." гэснийг тус тус зөрчиж Б.М, Б.Б, Э.Б, Ц.Д нартай бүлэглэн бүртгэлийн СБ2-5074 дугаартай гомдол, мэдээллийг шалгах явцдаа хэрэг хүлээлгэх зорилгоор хохирогч Б.А-ыг "хэлсэн хэрэг чинь дутуу байна", "бүх үнэнээ хэл" гэх зэргээр хэлж дал хэсэгт нь гараараа цохих, баруун хөлийн шилбэ хэсэгт хөлөөрөө өшиглөх үйлдлээр зодож, цахилгаан бороохой дуугаргаж айлган сүрдүүлж хэргийг харьцаж шаналган зовоосон зэргээр бие махбодыг шаналган зовоосон.</p> | <p>Прокуророос яллагдагч Э.Б, Б.Б, Ч.Ё, Б.М, Ц.Д нарыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт яахсан гэмт хэрэгт холбогдуулан ялах дүгнэлт үйлджээ. Анхан шатны шүүх хэргийг хүлээн авч, хянан хэлэлцээд "хохирогч нараар таньж олуулах ажиллагаа явуулах, 2206000001293 дугаартай хэрэгт үзлэг хийж ач холбогдолтой баримтыг хуулбарлан авч уг хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн болохыг тогтоох, гэмт хэрэг эхэлсэн болон төгссөн цаг хугацааг тогтоох, уг гэмт хэргийг үйлдэхэд ашигласан гэх цахилгаан бороохойг олж тогтоох, яллагдагч Э.Бийн ахлах мөрдөгч Б-д баривчлах ажиллагааг явуулах талаар танилцуулсан эсэхийг шалгаж тогтоох, насанд хэрээгүй хохирогч Б.А-ын хууль ёсны төлөөлөгчөөр түүний төрсөн эгч Б.А-ийг тогтоосон, хавтаст хэргийг хэргийн оролцогч нарт танилцуулаагүй" гэсэн үндэслэлүүдийг зааж, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр хэргийг прокурорт буцаасан нь хууль зүйн үндэслэлгүй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.</p> |
| Грав. Улсын Дээд шүүхийн тогтоол | | | |
| <p>30.</p> | <p>Улсын дээд шүүхийн Тогтоол 2022 оны 04 сарын 13 өдөр Дугаар 80</p> | <p>Шүүгдэгч Х.Б нь Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Эрүү шүүлт тулгах", шүүгдэгч Д.М нь Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хүнийг алах" гэмт хэрэгт тус тус холбогдсон.</p> | <p>Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгуулах талаар бичсэн прокурорын эсэргүүцэл, шүүгдэгч Х.Б-т холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгуулах талаар түүний өмгөөлөгч Б.Баярмагнай, Б.Мянган нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.</p> |

| | | | |
|------------|--|--|--|
| <p>31.</p> | <p>Улсын дээд шүүхийн Тогтоол 2025 оны 01 сарын 22 өдөр Дугаар 2025/ХШТ/07</p> | <p>Шүүгдэгч Ш.Б- нь Г аймгийн Ц газрын Б сумын хэсгийн төлөөлөгч буюу Төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалтнаар ажиллаж байхдаа 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Г аймгийн Б сумын төв Ц кобон байранд Б.Б- хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгасан, мөн эрүүдэн шүүж түүний баруун шанаа хэсэгт 2 удаа, цээж рүү 4 удаа гараараа цохиж эрүүл мэндэд нь зүүн 2 болон 3 дугаар хавирганы зөрүүгүй хугарал, зүүн 4 дүгээр хавирганы зөрүүтэй хугарал гэмтэл үүсгэж эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар шүүгдэгч Ш.Б- нь хохирогч Б.Б- Г аймгийн Б сумын төвд байрлах "Индэрт" дэлгүүрээс Ц байранд аваачин "согтуугаар тэвэрийн хэрэгсэл жолоодсон" зөрчилд холбогдуулан шалгахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчин түүнийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэж халдсан үйлдэл нь Монгол Улсын 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц"-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сөрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ" гэсэн тодорхойлолтод хамаарч байх бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Эрүү шүүлт тулгах" гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан байна.</p> |
| <p>32.</p> | <p>Улсын дээд шүүхийн Тогтоол 2025 оны 04 сарын 23 өдөр Дугаар 2025/ХШТ/50</p> | <p>Шүүгдэгч Ч.Б- нь ... байхдаа иргэн Б.Б-ээс ... бичгээр гаргасан "Монгол Улсаас 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан" гэсэн утгатай ... дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ... өрөөнд 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Х.Ү-ыг зорилгоор "тэр цүнх хаана байна п***а минь, чамайг п***а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п***а юу" гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогджээ.</p> | <p>Давж заалдах шатны шүүх нь хуулиар хүлээлгэсэн үүргийн хүрээнд доод шатны шүүхийн шийдвэрийг хянан магадлахдаа тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг гомдол, эсэргүүцэлд дурдсан асуудлаар хязгаарлахгүйгээр бүхэлд нь хянах учиртай.</p> <p>Гэтэл анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн зөрчлийг засч зөвтгүүлэхийн оронд тухайн алдааг хэвээр үлдээсэн байх тул шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд буцаах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.</p> |

ШҮҮХИЙН ТОГТООЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(2022-2025 оны шүүхийн тогтоолууд)

2022 онд:

1. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд “Шүүгдэгч Г.Д нь төрийн албан хаагчаар буюу ажиллаж байхдаа 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр иргэн Т.Л-аас гаргасан бүртгэлийн 000 дугаартай гэмт хэргийн талаарх гомдлыг шалгах явцдаа иргэн Ц.Ө-ын хийгээгүй хэргийг хүлээлгэх зорилгоор 2019 оны 0 дугаар сарын 0-ны өдөр байранд “... айлаас телевизор хулгайлсан хэргээ хүлээ” гэж нүүр, толгойн тус газар нь гараараа цохих, хэвлий, гуя, өгзөг хэсэгт нь хөлөөрөө өшиглөх, өвдөглөх, резинэн бороохойгоор гуя, нуруун тус газар нь цохих зэргээр бие махбод болон сэтгэл санааг нь шаналган зовоож, эрүү шүүлт тулгасан” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.
2. Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд “Шүүгдэгч Б.Б нь Булган аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа Ц.А-тай бүлэглэн Булган аймаг дахь Цагдаагийн газрын байрны 2 давхарт байрлах Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын өрөөнд 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Л.Э-д “Булган аймгийн Сэлэнгэ суманд оршин суух Д.М бусдад хүчиндүүлсэн” гэх хэргийг хүлээлгэх зорилгоор бие эрх чөлөөнд халдаж цахилгаан бороохойгоор цохиулж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан” гэх гэмт хэрэгт шүүгдэгч нарыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.
3. Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд “Шүүгдэгч Б.Б нь төрийн албан хаагчаар буюу Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр ажиллаж байхдаа тус цагдаагийн тасгийн мөрдөгч П.Ч, мөрдөгч Д.Б нартай урьдчилан үгсэн тохиролцоогүй боловч тухайн цаг хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэгтэй, ач холбогдолтой гэж үзсэн мэдээ сэлт агуулсан мэдүүлэг авах, улмаар хэрэг хүлээлгэх гэсэн санаа зорилго, үйлдлээрээ нэгдэж бүлэглэн 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр иргэн М.Х-гээс цагдаагийн байгууллагад гаргасан “хүмүүс хар өвс татаад байна” гэх гэмт хэргийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүрэг дэх Цагдаагийн газрын Гуравдугаар хэлтсийн 3 давхарт байрлах мөрдөгч П.Ч-ын албан өрөөнд «хаанаас, хэнээс авснаа хэл, үнэнээ хэл» гэх мэтээр хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах зорилгоор иргэн Г.Б-ыг цохиж, зодон бие махбодыг шаналган зовоож эрүүдэн шүүсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх гэмт тус тус хэрэгт холбогдсон бөгөөд энэ гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсон байна.

2023 онд:

4. Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд “Миний биед халдсан цагдаагийн алба хаагч нь Хан-Уул дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст ажилладаг *** гэх цагдаагийн алба хаагч, би уг цагдаагийн албан хаагчид зодуулсандаа гомдолтой байна.” гэх гэмт хэрэгт холбогдогчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.
5. Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Шүүгдэгч Г.Ё нь 2022 оны 05 дугаар сарын **** 9-ний өдөр --- ны нутаг дэвсгэрт байрлах ***** нарын албан өрөөнд хохирогч М.Э-ыг хулгайн гэмт хэрэгт сэрдэж, хэрэг хүлээлгэх зорилгоор “машин чинь хаана байна, машиндаа үзлэг хийлгэжээд яв” гэж эрүү шүүлт тулгаж биед халдаж цохиж зодон эрүүл мэндэд нь хамар ясны хугарал, хамрын таславчийн мурийлт, баруун гуянд цус хуралт бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд уг гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон.

2024 онд:

6. Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/ ийн шийтгэх тогтоолд Шүүгдэгч Ш.Б нь **** аймгийн Цагдаагийн газрын **** сумын хэсгийн төлөөлөгч буюу Төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалтнаар ажиллаж байхдаа 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр **** аймгийн *** сум төв цагдаагийн кобон байранд Б.Б-г хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт тулгасан, мөн эрүүдэн шүүж түүний баруун шанаа хэсэгт 2 удаа, цээж рүү 4 удаа гараараа цохиж эрүүл мэндэд нь зүүн 2 болон 3 дугаар хавирганы зөрүүгүй хугарал, зүүн 4 дүгээр хавирганы зөрүүтэй хугарал гэмтэл үүсгэж эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан үйлдлүүдийг прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн хэрэгт гэм буруутайд тооцсон.
7. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн цагаатгах тогтоолд Шүүгдэгч Ч.Б нь Д аймгийн Ц-ийн газрын 3 сумын сум дундын Ц-ийн хэлтсийн Э-ийн ц-ийн х-н э-ийн м-р ажиллаж байхдаа иргэн Б.Б-ээс Д. аймгийн Ц-ийн хэлтэст бичгээр гаргасан “Монгол улсаас 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан” гэсэн утгатай Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй 240 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Д аймгийн 3 сум дахь сум дундын хэлтсийн байрны жижүүрийн ахлах мөрдөгчийн 102 тоот өрөөнд 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Х.Ү-ыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор “тэр цүнх хаана байна

п***а минь, чамайг п***а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п***а юу” гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа мангасдаж толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдож, шүүхээс цагаатгаж шийдвэрлэсэн.

2025 онд:

8. Сүхбаатар аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын Мөнххаан сумын сум дундын цагдаагийн хэсгийн Түмэнцогт сумын хэсгийн цагдаагаар ажиллаж байхдаа Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутаг дэвсгэр “Алаг гомбон” гэх газарт 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр иргэн Д.Бат-Эрдэнийг “2018 оноос хойш иргэн ***** малыг маллаж байхдаа олон тооны мал дутаасан, бусдад худалдаж завшсан” гэх гэмт хэрэг үйлдсэнийг хүлээлгэх зорилгоор “өгзөг рүү нь хөлөөрөө 1 удаа өшиглөх, эвхэгддэг тонгорог хутганы ишээр цээж хэсэг рүү 2 удаа цохих” зэрэг эрүүл мэндэд нь хохирол учруулаагүй үйлдэл хийж бие махбодыг нь шаналган зовоож, “хүний мал яагаад дутаасан бэ, хоолойг чинь хэрчинэ, хүний мал дутаасан, яаж төлөх юм бэ, чамайг ална, дутсан малыг хаашаа үгүй хийсэн талаараа үнэнээ хэл” гэх зэргээр үг хэлэх, гараар цохихоор далайх, хутганы ир хэсгийг хоолойд хүргэх үйлдэл хийх зэргээр сэтгэл санааг нь шаналган зовоож эрүү шүүлт тулгасан, мөн тус газарт байхдаа ***** биед хутга тулгах, хутганы ишээр цээж рүү нь цохих, хоолойг нь хэрчинэ гэж хэлэх зэргээр хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж буюу бэлэг эрхтнээ хөхүүлж хүчиндсэн гэмт хэрэгт холбогдож, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн.
9. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шийтгэх тогтоолд Шүүгдэгч Э.П нь 2024 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 09-нд шилжих шөнө ...өрөөнд Хар тамхитай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн албан тушаалд томилогдон албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно”, хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно”-д заасныг тус тус зөрчиж өсвөр насны Ц.Ц, Ж.Н нараас мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх зорилгоор бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэх гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайд тооцсон.

10. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шийтгэх тогтоолд Төрийн албан хаагч буюу ***** дүүргийн Цагдаагийн газрын ***** хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч Н.***** нь 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ***** дүүргийн 1***** хорооны нутаг дэвсгэрт байрлах тус хэлтсийн байранд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гаргасан иргэн ***** -аас мэдүүлэг авах зорилгоор маргаж ална, хэрэг тохно гэх зэрэг үг хэллэг хэрэглэн хэл амаар доромжилж гавлах, хүч хэрэглэн биед нь халдан зодох зэргээр бусдын бие махбод сэтгэл санааг шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт, ийнхүү зодох явцдаа хохирогч ***** -ийн биед “баруун хөмсөг, зүүн шуунд зулгаралт, хүзүү, баруун мөр, бугалгад цус хуралт, зүүн шанаа, хацрын зөөлөн эдийн няцрал” бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт тус тус холбогдон, гэм буруутайд тооцсон.
11. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шийтгэх тогтоолд шүүгдэгч *** нь Баянгол дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа буюу 2024 оны 7 дугаар сарын 22-ноос 23-нд шилжих шөнө “Дээрэмдэх” гэмт хэрэгт сэжиглэгдсэн *** гэгчийг барьж тус цагдаагийн хэлтсийн байранд авч ирсэн атлаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “сэжигтнийг баривчлах” ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулахтай холбоотой санал, тогтоол зэргийг үйлдээгүй, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэлгүйгээр 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 16 цаг 07 минут хүртэл хүнийг хууль бусаар саатуулсан. Мөн хугацаанд тус цагдаагийн хэлтсийн байранд ***-ийг явган суулгах, хоёр гарыг нь паарнаас, биеийн урд болон ард хэсэгт тус тус гавласан байдалтайгаар байлгаж бие махбодыг нь шаналган зовоох, “Дээрэмдэх” гэмт хэргийг хүлээн, бусдын эд зүйлсийг гаргаж өгөхийг шаардах зэргээр сэтгэл санааг нь шаналган зовоох зэргээр эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт шүүх гэм буруутайд тооцсон.
12. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх ийн шийтгэх тогтоолд 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр хэсгийн байцаагчийн албан өрөөндөө холбогдогч *** -аас тайлбар, мэдүүлэг авах зорилгоор биед нь хүч хэрэглэн халдаж, сэтгэл санааг нь шаналган зовоосон, мөн 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр *** байран дотор байрлах албан өрөөндөө иргэн *** -ын шилбэ хэсэг рүү нь хөлөөрөө өшиглөж, тонгойлгож байгаад бөгс рүү цохих зэргээр зодож эрүүл мэндэд нь “баруун шилбэний халдварлагдсан шарх, баруун шилбэний удаан дарагдлын хам шинж, арьс зөөлөн эдийн үхжил, үхжилтийн/ үхжсэн эдийг өөлж авах, угаах, баруун гуянаас арьс шилжүүлэн суулгах мэс засал, баруун шилбэний арьс зөөлөн эдийн дутмагшил, баруун хөлийн шилбэ, тавхайн мэдрэлийн бууралт, тавхайн 3, 4, 5 дугаар хурууны өнгөц мэдрэхүйн бууралт, зүүн шилбэнд шарх, биеийн гадаргуугийн 4-б хувь хүртэлх талбайг хамарсан сорви” гэмтэл бүхий хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдож, шүүх гэм буруутайд тооцсон.

13. Сүхбаатар аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Сүхбаатар аймгийн Наран сумын нутаг дэвсгэрт байрлах цагдаагийн хэсгийн байранд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр цагдаагийн ...-нь иргэн Н.М-ыг зүүн хөлөөрөө баруун талын гуя хэсэг рүү нь өшиглөх, баруун чих хэсэг рүү нь зүүн гараараа 2 удаа алгадах зэрэг эрүүл мэндэд нь хохирол учруулаагүй үйлдэл хийж, бие махбодыг нь шаналган зовоож, «муу хулгайч үнэнээ хэл, чи үнэнээ хэл л дээ, чи авсан биз дээ хулгайч минь» гэх үг хэлж сэтгэл санааг нь шаналган зовоож эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт тус тус холбогдсон ба шүүх гэм буруутайд тооцсон.
14. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэх тогтоолд Шүүгдэгч Ч.Б нь Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн ... мөрдөгчөөр ажиллаж байхдаа иргэн Б.Б-ээс Дорноговь аймгийн Цагдаагийн хэлтэст бичгээр гаргасан “Монгол Улсаас 2023 оны 08 сарын 03-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хот руу гарах явцдаа хилийн боомт дээр 2,500 юань, хувцас зэрэг эд зүйлтэй цүнхээ алдсан” гэсэн утгатай Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй .. дугаартай гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын хэлтсийн байрны жижүүрийн ахлах мөрдөгчийн 102 тоот өрөөнд 2023 оны 08 сарын 05-ны өдөр Х.Ү-ыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн талаар хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор “тэр цүнх хаана байна п***а минь, чамайг п***а гэж дуудаж болохгүй юу, чи тийм хууль мэддэг п***а юу” гэж мөн баруун гараараа зүүн шанаа хэсэг рүү 3 удаа цохиж, 1 удаа алгадаж, толгой хэсэгт 2-3 удаа цохиж, баруун гараараа мангасдаж толгойг нь ханатай хавсарч, баруун гараараа зүүн нүдний ухархай хэсэгт цохиж цус гарган бие махбод, сэтгэл санааг шаналган зовоож, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдсон.

Дээр дурдсан нийт 14 хэргийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд цагдаагийн алба хаагчийн хувьд шалгаж буй хэргийн хүрээнд хэргийг шуурхай илрүүлэх, хэрэг хүлээлгэх зорилгоор хүч хэрэглэсэн нь нотлох баримтын эх сурвалжуудаар нотлогдсон. Өөрөөр хэлбэл, хүнийг хэрэг хүлээлгэхээр цохих, өшиглөх, өвдөглөх, резинэн бороохойгоор гуя, нуруун тус газарт нь цохих, зүй бусаар хэлэх, гутаах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэж заналхийлсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, бусад хуулиар туйлын хориглосон байдаг бөгөөд ямар нөхцөлд хөндөж үл болох эрхийг зөрчсөн үйлдэл мөн.

Аливаа хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа нотлох баримтын эх сурвалжийг цуглуулж, хэргийг эргэлзээгүйгээр нотлох ажиллагааг тэргүүн ээлжид тавихгүй байгаа хандлага орон нутагт түгээмэл байгааг дээрх тохиолдлууд илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хүлээлгэхийн тулд улайран дайрах, хүний бие махбод, сэтгэл санаанд хүчтэй нөлөөлөх хууль бус арга хэрэглэж, түүнийг мөрдөн шалгах ажиллагааны хэвийн арга мэтээр үзэх хуучирсан сэтгэлгээ, арга барил байсаар байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад эрүүгийн процессын эрх зүйн зарчмыг удирдлага болгон ажиллах, бусдад эрүү шүүлт тулгах үйлдлийг хориглосон хэдий ч мөрдөгч нар хүнд гэмт хэргийг шуурхай илрүүлэхэд хэт улайран хандах, хууль бусаар хэрэг хүлээлгэхээр бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг гаргасан нь нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн ноцтой зөрчил мөн.

Цагдаагийн алба хаагчдын дунд гэмт хэргийг илрүүлэхдээ хүч хэрэглэх, хүний эрхийг зөрчдөг уламжлалт зүй бус хандлага байсаар байгааг дээрх тохиолдлууд илтгэнэ. Иймд уг төрлийн зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хэр оновчтой байгаад дахин дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоолуудыг <https://shuukh.mn/> сайтаас 2022 оноос хойш 32 шийтгэх тогтоолыг татан авч судлахад тогтолцооны хувьд дахин эргэн харах хүчин зүйлс байгаа тул олон талын оролцоотойгоор ужгирсан нөхцөл байдлыг засах, урьдчилан сэргийлэх ажилд онцгой анхаарч, хэлбэрийн бус, бодит ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, зайлшгүй хүн хүч, төсөв зарцуулж, шинэ бодлого төлөвлөн, стратегийн түвшинд иж бүрнээр нь авч үзэх шаардлагатай.



N P M
MONGOLIA

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНЭЭС 2022-2025 ОНД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь эрх чөлөө хязгаарлагдсан, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр чөлөөтэй гарч явах боломжгүй бүх газарт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хэрэгжүүлдэг.

ЭШУС үндэсний ажиллагаа нь хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, хяналт шинжилгээний үр дүнд үндэслэн зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мөн хууль тогтоомж, бодлого, зохион байгуулалтын шаардлагатай өөрчлөлтийг санал болгох замаар эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх нөхцөл үүсэхээс өмнө эрсдэлийг тогтолцооны түвшинд тодорхойлон бууруулахад чиглэн ажилладаг.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад тогтоогдсон нөхцөл байдал, эрсдэлийн хүчин зүйлийг үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийн явцад нотолгоонд суурилсан үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь зөвлөн туслах уулзалт зохион байгуулдаг. Энэхүү ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааг буруутгах, хариуцлага тооцох шалгалт, хариуцлага тооцох зорилготой бус бөгөөд харин эрх хязгаарлагдсан орчинд хүний эрхийн баталгааг сайжруулах, эрсдэлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх шинжтэй юм.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас 2022-2025 онд нийт 922 заалт бүхий 96 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд албажуулан хүргүүлж ажилласан байна.

Энэ хугацаанд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ өргөжиж, илэрсэн нөхцөл байдал, эрсдэлийн хүчин зүйлийг нарийвчлан тодорхойлох боломж нэмэгдсэнтэй уялдан зөвлөмжийн агуулга, заалтын тоо нэмэгдсэн. Энэ хүрээнд 2025 онд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нийт 474 заалт бүхий 51 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийн явцыг хяналт шинжилгээгээр баталгаажуулан, шаардлагатай тохиолдолд удирдлагатай зөвлөн туслах уулзалт зохион байгуулсан.

Түүнчлэн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд асуудал эрхэлсэн гишүүний баталсан А/03 аргачлалыг хэрэгжүүлснээр хэрэгжилтийн мэдээлэл, нотолгоо, бодит ахиц, үр дүнг нэг мөр шалгуураар үнэлэх боломж сайжирч, үнэлгээний үндэслэл, баримтжуулалт жигдэрсэн.

ХОЁР. ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс 2025 онд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үеэр тогтоогдсон эрүү шүүлт гарч болзошгүй аливаа нөхцөл байдлыг бодлогын хүрээнд шийдвэрлэх, хууль, дүрэм, журамд өөрчлөлт оруулах холбогдох төрийн байгууллагын шийдвэрийг гаргуулах хүрээнд Засгийн газар, яам, агентлаг болон холбогдох байгууллагын удирдлагад зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийг дараах албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, бригадын генерал Т.Сүхболд;
- ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан;
- Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Хосбаяр.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилт хамгийн ихээр зөрчигдөх эрсдэлтэй газар болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих анги, баривчлах, саатуулах байруудад 17 зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:

- ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги;
- ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги;
- Хэнтий аймаг дахь ШШГГазар-419 дүгээр нээлттэй хорих анги;
- Ховд аймаг дахь ШШГГазар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги;
- Булган аймаг дахь ШШГГазар-439 дүгээр хаалттай хорих анги;
- Дархан-Уул аймаг дахь ШШГГазар-445 дугаар нээлттэй хорих анги;
- ШШГЕГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих анги;
- Орхон аймаг дахь ШШГГ-ын 437 дугаар нээлттэй, хаалттай хорих анги;
- Говь-Алтай аймаг дахь ШШГГ;
- Багануур дүүрэг дэх ШШГ хэлтэс;
- Өвөрхангай аймаг дахь ШШГГ;
- Баян-Өлгий аймаг дахь ШШГГ;
- Баянхонгор аймаг дахь ШШГГ;
- Дорнод аймаг дахь ШШГГ;
- Увс аймаг дахь ШШГГ;
- Архангай аймаг дахь ШШГГ;
- Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь ШШГ хэлтэс.

Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, мэдүүлэг авах өрөөний нөхцөл байдалд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, эрх, эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх, тогтоох урьдчилан сэргийлэх зорилгоор 15 зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:

- Говь-Алтай аймгийн цагдаагийн газар;
- Багануур дүүргийн цагдаагийн газар;
- Хэнтий аймгийн цагдаагийн газар;

- Дорнод аймгийн цагдаагийн газар;
- Ховд аймгийн цагдаагийн газар;
- Өвөрхангай аймгийн цагдаагийн газар;
- Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар;
- Баянхонгор аймгийн цагдаагийн газар;
- Увс аймгийн цагдаагийн газар;
- Архангай аймгийн цагдаагийн газар;
- Орхон аймгийн цагдаагийн газар;
- Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтэс;
- Сүхбаатар аймгийн цагдаагийн газар.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүний эрх зөрчигдөх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор;
- Монголын СОС хүүхдийн хотхон;
- “Анна хоме” хүүхдийн асрамж, халамжийн байгууллага;
- ХГБХХЕГ-ын харьяа Дорнод аймаг дахь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамж, халамжийн байгууллагад хүний эрхийн баталгааг сайжруулах зорилгоор дараах байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- Ахмад настны үндэсний төв;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга (Батгэрэлт ирээдүй ахмадын асрамжийн үйлчилгээтэй холбоотой).

Боловсролын байгууллагын дотуур байрны орчин, үйлчилгээ, хамгааллын тогтолцоо, эрүүл ахуй, аюулгүй байдал, хүний эрхийн баталгаатай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор дараах байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- СЭЗИС;
- АШУҮИС;
- Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Монгол Улсын Консерватор;
- ШУТИС;
- ХААИС;
- СУИС.

Цэргийн сахилгын байрны нөхцөл байдал, хамгааллын тогтолцоонд хамаарах эрсдэлийг бууруулах зорилгоор Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаанд эрх чөлөө хязгаарлагдсан үйлчлүүлэгчдийн эрхийн баталгаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, орчны нөхцөл, хамгааллын тогтолцоотой холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор тус төвийн удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

Харин зарим байгууллага зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг огт ирүүлээгүй, эсхүл биелэлтийг нотлох баримт, тайлбар, холбогдох материалыг хангалтгүй ирүүлсэн нь хэрэгжилтийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн. Мөн ирүүлсэн баримт, нотолгооны чанар, тайлагналын логик бүтэц, баримтжуулалтын бүрдэл байгууллага хооронд харилцан адилгүй байгаа нь зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээнд харилцан адилгүй нөлөөлж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн үр нөлөө нь тухайн байгууллагын удирдлагын шийдвэр гаргалт, дотоод зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүүжилт, баримтжуулалтын байдалтай шууд уялдаж байгааг урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний дүн харуулж байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

4.1. 2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн ерөнхий үзүүлэлт

2022-2025 онд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас холбогдох байгууллага, албан тушаалтанд нийт 96 зөвлөмжийн 922 заалтыг хүргүүлж, хэрэгжилтийг үнэлэв.

Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ өргөжиж, илэрсэн нөхцөл байдал, эрсдэлийн хүчин зүйлийг илүү нарийвчлан тодорхойлох боломж нэмэгдсэнтэй уялдан зөвлөмжийн агуулга болон заалтын тоо өсөх хандлага ажиглагдав.

Хүснэгт 78

| № | Зөвлөмжийн тоо | Заалтын тоо | Ерөнхий хувь |
|---|----------------|-------------|--------------|
| 1 | 51 | 474 | 85.0% |

4.2. Зөвлөмжийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ (2025)

2025 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд нийт 51 зөвлөмжийн 474 заалтыг хүргүүлж, хэрэгжилтийг үнэлэхэд зөвлөмжийн хэрэгжилтийн ерөнхий түвшин 85.0 хувьд хүрэв.

Хүснэгт 79

| № | Зөвлөмжийн заалтын агуулга | 2025 |
|---|---|------|
| 1 | Эрүү шүүлтээс ангид байх | 54 |
| 2 | Хүнлэг бус, доромжлон харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх | 63 |
| 3 | Албан хаагчдын эрүү шүүлтээс ангид байх эрхийн мэдлэгийг дээшлүүлэх | 24 |
| 4 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (хоригдол, эрх нь хязгаарлагдсан иргэд, үйлчлүүлэгч, ахмад, хүүхэд) | 52 |
| 5 | Байгууллагын орчин нөхцөл | 88 |
| 6 | Хоол хүнс, тэжээллэг чанар, эрүүл ахуй | 27 |

| | | |
|----|---|-----|
| 7 | Эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн хөдөлмөрлөх эрх, ажлын нөхцөл | 21 |
| 8 | Эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн нийгэмшүүлэх, чөлөөт цаг | 18 |
| 9 | Хүүхдийн эрх, хамгаалал | 32 |
| 10 | Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх | 17 |
| 11 | Цэргийн сахилгын байр, орчин нөхцөл | 18 |
| 12 | Мэдүүлэг авах өрөөний стандартын хэрэгжилт | 26 |
| 13 | Байгууллагын камерын хяналт, баримтжуулалт | 7 |
| 14 | Байгууллагын зохион байгуулалт, хүний нөөц, удирдлагын хяналт | 6 |
| 15 | Бодлого, хууль эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ | 10 |
| 16 | Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хариуцлага | 11 |
| 17 | Нийт | 474 |

4.3. Зөвлөмжийг хүлээн авсан байгууллагын ангилал

2025 онд хүргүүлсэн зөвлөмжийг хүлээн авсан байгууллагыг чиг үүргээр нь ангилж үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаагийн байгууллагад хамгийн олон зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 80

| № | Ангилал | 2025 |
|------|---|------|
| 1 | Засгийн газар, яам, агентлаг, түүний харьяа байгууллага | 5 |
| 2 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага | 17 |
| 3 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | 2 |
| 4 | Ахмад настны үндэсний төв | 1 |
| 5 | Хүүхдийн асрамж, халамжийн байгууллага | 3 |
| 6 | Цагдаагийн байгууллага | 15 |
| 7 | Зэвсэгт хүчний 032 дугаар анги | 1 |
| 8 | Боловсролын байгууллага | 7 |
| Нийт | | 51 |

4.4. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ

2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээлэл, нотлох баримтад үндэслэн үнэлэхэд зөвлөмжийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ 85.0 хувь байна.

| № | Зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага | Ерөнхий үнэлгээ |
|----|--|-----------------|
| 1 | СЭМҮТ-ийн захирал Г.Анхболдод | 79.0% |
| 2 | Улсын Их хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогтод | 94.0% |
| 3 | Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайханд | 100.0% |
| 4 | Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд | 70.0% |
| 5 | Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, бригадын генерал Т.Сүхболдод | 87.7% |
| 6 | ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан | 90.0% |
| 7 | Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолборын захирал С.Амгаланд | 62.1% |
| 8 | Монголын СОС хүүхдийн хотхоны захирал Б.Батцэцэгт | 81.0% |
| 9 | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Ректор, анагаах ухааны доктор, профессор Б.Дамдиндоржид | 90.0% |
| 10 | Санхүү, эдийн засгийн их сургуулийн Ректор Б.Мөнхбаярт | 92.0% |
| 11 | Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Энхболдод | 82.5% |
| 12 | Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ц.Баттөрд | 85.0% |
| 13 | ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирт | 66.5% |
| 14 | ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Л.Даваабаатарт | 80.5% |
| 15 | Хэнтий аймаг дахь ШШГГазар-419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Д.Хатанбаатарт | 85.0% |
| 16 | Говь-Алтай аймаг дахь ШШГГ-ын дарга, дэд хурандаа Г.Ганбатад | 86.0% |
| 17 | Говь-Алтай аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Н.Мэндбаярт | 85.0% |
| 18 | Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Баярхүүд | 85.0% |
| 19 | Хэнтий аймгийн цагдаагийн газрын даргад | 84.0% |
| 20 | Дорнод аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа П.Мөнхбаярт | 84.0% |
| 21 | Ховд аймгийн цагдаагийн газрын дарга О.Түмэнбаярт | 95.0% |
| 22 | Ховд аймаг дахь ШШГГазар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хошууч Т.Бат-Оюунд | 85.0% |

| | | |
|----|---|-------|
| 23 | Багануур дүүрэг дахь ШШГ хэлтсийн дарга, хурандаа П.Ууганбаярт | 80.0% |
| 24 | Өвөрхангай аймаг дахь ШШГГ-ын дарга, дэд хурандаа Б.Одхүүд | 70.0% |
| 25 | Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын дарга, хурандаа Б.Ононд | 82.0% |
| 26 | Баян-Өлгий аймгийн цагдаагийн газрын дарга, хурандаа Ө.Танатад | 87.0% |
| 27 | Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, дэд хурандаа Б.Энхбатад | 96.0% |
| 28 | Баян-Өлгий аймаг дахь ШШГГ-ын дарга, дэд хурандаа Н.Баттулгад | 90.0% |
| 29 | “Анна хоме” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын захирал П.Болдсайханд | 80.0% |
| 30 | ХГБХХЕГ-ын харьяа Дорнод аймаг дахь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Ж.Сайхангэрэлд | 80.0% |
| 31 | Булган аймаг дахь ШШГГ-439 дүгээр хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа Б.Наранбатад | 92.0% |
| 32 | Баянхонгор аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Мөнхбаярт | 84.0% |
| 33 | Увс аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Алтанбаганад | 85.0% |
| 34 | Монгол Улсын Консерваторын захирал Ц.Шаравцэрэнд | 86.0% |
| 35 | Баянхонгор аймаг дахь ШШГГ-ын дарга, хурандаа Д.Батгэрэлд | 92.0% |
| 36 | Увс аймаг дахь ШШГГ-ын дарга, хошууч С.Ганзоригт | 83.0% |
| 37 | ШУТИС-ийн захирал Т.Намнанд | 90.0% |
| 38 | Архангай аймаг дахь ШШГГ-ын дарга, дэд хурандаа Н.Жасрайд | 92.5% |
| 39 | Архангай аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Г.Чимиддагвад | 75.0% |
| 40 | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь ШШГ хэлтсийн дарга, хошууч Б.Лхагвазагад | 87.5% |
| 41 | ХААИС-ын захирал Б.Баасансүхэд | 88.5% |
| 42 | Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Нацагдоржид | 82.5% |
| 43 | Дархан-Уул аймаг дахь ШШГГазар-445 дугаар нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Г.Амгаланбаатарт | 75.0% |
| 44 | Орхон аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа А.Лхагвадоржид | 85.0% |
| 45 | ШШГЕГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа П.Баянцэнгэлд | 85.0% |
| 46 | Орхон аймаг дахь ШШГГ-ын 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаярт | 86.5% |

| | | |
|------------------------|---|-------|
| 47 | СУИС-ийн ректорын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Бат-Эрдэнэд | 83.0% |
| 48 | Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Гүнчин-Ишид | 87.5% |
| 49 | Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Хосбаярт | 85.0% |
| 50 | Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Баатархүү | 82.0% |
| 51 | СЭМҮТ-ийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Ууганцэцэгт | 85.0% |
| Ерөнхий үнэлгээ | | 85.0% |

4.5. Зөвлөмжийн хэрэгжилтийн нэгдсэн дүн (2022-2025)

2022-2025 онд хүргүүлсэн 96 зөвлөмжийн 922 заалтын хэрэгжилтийг жилийн байдлаар нэгтгэн үнэлэхэд зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин 2022 онд 72.0 хувь, 2023 онд 86.0 хувь, 2024 онд 80.0 хувь, 2025 онд 85.0 хувь байна.

Эдгээрийг жилийн дунджаар тооцоход зөвлөмжийн хэрэгжилтийн ерөнхий түвшин 81.0 хувьд хүрч, холбогдох байгууллагуудын зүгээс зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой ахиц гарсныг илтгэв.

Хүснэгт 82

| № | Он | Хэрэгжилт | Зөвлөмж | Заалт |
|-------------|------|-----------|---------|-------|
| 1 | 2022 | 72.0% | 10 | 70 |
| 2 | 2023 | 86.0% | 20 | 224 |
| 3 | 2024 | 80.0% | 15 | 154 |
| 4 | 2025 | 85.0% | 51 | 474 |
| Нийт | | 81.0% | 96 | 922 |

ТАВ. ХУУЛЬ ЁСНЫ ШААРДЛАГА

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу 2025 онд нийслэл болон орон нутагт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх явцдаа зарим хууль ёсны шаардлага тавьж, хэрэгжилтийг газар дээр нь хангуулан ажилласан.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад тавьсан хууль ёсны шаардлага нь зөрчил шалган шийдвэрлэх, хариуцлага тооцох шинжтэй хяналт шалгалт биш бөгөөд эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр

оногдуулсан талаар Цагдаагийн ерөнхий газраас 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04/330 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

1. ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг нэгтгэн үзэхэд хяналт шинжилгээний хамрах хүрээ өргөжиж, эрсдэлийн шалтгаан, нөхцөлийг илүү нарийвчлан тогтоох боломж сайжирсан.
2. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхдээ нотолгоонд суурилсан үнэлгээний аргачлалыг тогтвортой ашигласнаар байгууллагуудаас ирүүлсэн тайлагнал, хавсаргасан нотолгоо, баримтын чанарт ялгаа хэвээр байгаа ч үнэлгээний бодитой байдал, харьцуулах боломж нэмэгдсэн. Энэ нь урьдчилан сэргийлэх ажиллагааны үр нөлөөг хэмжих үндсэн нөхцөл болж байна.
3. Хэрэгжилтийн түвшин байгууллага хооронд жигд бус байгаа нь орчны стандарт, баримтжуулалт, камерын хяналт, дотоод хяналтын зохион байгуулалт зэрэг нь харилцан адилгүй байгаатай шууд холбоотой.
4. Удирдлагын тогтвортой байдал, хүний нөөцийн хүрэлцээ, төсөв санхүүгийн боломж, тайлагналын сахилга, нотолгоо бүрдүүлэх чадавх зэрэг хүчин зүйлс нь хэрэгжилтийн бодит ахицад шийдвэрлэх нөлөө үзүүлсэн.
5. Зарим байгууллага орчны сайжруулалт, камерын хяналт, дотоод журам, зохион байгуулалтын арга хэмжээг бодитоор хэрэгжүүлж, эрсдэлийг бууруулах чиглэлээр ахиц гаргасан нь үнэлгээнд эергээр туссан. Харин хэрэгжилтийн мэдээлэл огт ирүүлээгүй, эсхүл нотолгоо баримт хангалтгүй ирүүлсэн тохиолдол нь үнэлгээний үр дүнд сөргөөр нөлөөлж, зөвлөмжийн хэрэгжилтийг бодитоор дүгнэх боломжийг хязгаарласан хэвээр байна.
6. Зөвлөмжийн хэрэгжилтийг бодитоор нэмэгдүүлэхэд байгууллагын дотоод хариуцлагын тогтолцоо, нотолгоонд суурилсан тайлагналын соёл, дотоод зохион байгуулалт, мөн хүний нөөц, санхүүжилтийн тогтвортой байдал зэрэг тогтолцооны нөхцөлийг зэрэгцүүлэн сайжруулах шаардлагатай.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД 2022, 2023, 2024, 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ



ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТУУЛСАН ЗАМ

| | |
|---------|------------------|
| 2022 он | 10,614 км |
| 2023 он | 17,810 км |
| 2024 он | 10,172 км |
| 2025 он | 11,100 км |

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ГАЗАР

| | | | |
|---------|----|---------|----|
| 2022 он | 23 | 2023 он | 48 |
| 2024 он | 57 | 2025 он | 65 |

ГАНЦААРЧЛАН УУЛЗАЖ, ЯРИЛЦСАН, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН ХҮНИЙ ТОО

| | | | |
|---------|-----|---------|-----|
| 2022 он | 459 | 2023 он | 675 |
| 2024 он | 415 | 2025 он | 469 |

АСУУМЖИД ОРОЛЦСОН ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ХЯЗГААРЛУУЛСАН ИРГЭДИЙН ТОО

| | | | |
|---------|-------|---------|-------|
| 2022 он | 1,650 | 2023 он | 2,803 |
| 2024 он | 1,623 | 2025 он | 2,082 |

АСУУМЖИД ОРОЛЦСОН ШШГ БАЙГУУЛЛАГА, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ НАР, АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН АСРАМЖИЙН ГАЗРЫН АЖИЛТНУУД, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАР

| | | | | | | | |
|---------|-----|---------|-----|---------|-----|---------|-----|
| 2022 он | 304 | 2023 он | 850 | 2024 он | 311 | 2025 он | 425 |
|---------|-----|---------|-----|---------|-----|---------|-----|

ЭШУС АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

| | |
|---------|--------------------|
| 2022 он | 11 |
| 2023 он | 25 /1-22 заалттай/ |
| 2024 он | 14 /1-19 заалттай/ |
| 2025 он | 51 |

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН НИЙТ СУРГАЛТЫН ТОО

| | | | | | | | |
|---------|----|---------|----|---------|-----|---------|-----|
| 2022 он | 31 | 2023 он | 37 | 2024 он | 151 | 2025 он | 386 |
|---------|----|---------|----|---------|-----|---------|-----|

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАГЧ БАГШААР БЭЛТГЭГДСЭН ХҮНИЙ ТОО

| | | | | | | | |
|---------|---|---------|----|---------|-----|---------|------|
| 2022 он | - | 2023 он | 73 | 2024 он | 151 | 2025 он | 1100 |
|---------|---|---------|----|---------|-----|---------|------|

СУРГАЛТАД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО

| | | | |
|---------|--------|---------|--------|
| 2022 он | 3,357 | 2023 он | 4,858 |
| 2024 он | 32,640 | 2025 он | 55,335 |

ЭШУС ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ТҮГЭЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

| | | | |
|---------|-----|---------|-----|
| 2022 он | 53 | 2023 он | 90 |
| 2024 он | 311 | 2025 он | 300 |

ЗУРАГТ ХУУДАС, ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ТАНИЛЦУУЛГЫН ЦУВРАЛ

| | | | |
|---------|----|---------|----|
| 2022 он | 17 | 2023 он | 76 |
| 2024 он | 77 | 2025 он | 22 |

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ШИЛЖҮҮЛСЭН ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ЗҮЙ БУС ХАРЬЦАА, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

| | | | | | | | |
|---------|---|---------|----|---------|-----|---------|----|
| 2022 он | 6 | 2023 он | 66 | 2024 он | 114 | 2025 он | 61 |
|---------|---|---------|----|---------|-----|---------|----|

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах, хариуцлага тооцох тухай гишүүний зөвлөмж болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийн хүрээнд хууль сахиулах байгууллагын болон холбогдох төрийн албан хаагч нийт 23 хүнд сахилгын арга хэмжээ тооцсон байна.



N P M
MONGOLIA

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2025 оны тайланг тухайн жилд хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээг үндэслэн боловсруулсан болно. Тайланд Монгол Улсад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас хойших хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг харьцуулан, цаашид анхаарах асуудлыг дүгнэж, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор баталгаажсан эрүүдэн шүүх, хүнлэг бус болон хүний нэр төрийг доромжлон шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг бодитой хангахад чиглэсэн санал, зөвлөмжүүдийг тодорхойллоо.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь 2022 онд 4, 2023 онд 5, 2024 онд 6, 2025 онд 7 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2025 оны тайлант хугацаанд нийт 11000 километр зам туулж, 65 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Эдгээр хяналт шинжилгээгээр иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн 51 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш 2022-2025 онд 49,696 километр замыг туулж, нийт 193 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 922 заалт бүхий 96 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэн, зөвлөмж тус бүрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшлийг тооцож, тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт 81.0 хувьтай гэж үнэлэгдсэн нь төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтнууд эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангахад идэвх, чармайлт гаргаж байгааг илтгэж байна.

Тайлант хугацаанд хуульд заасан чиг үүргийн хүрээнд хуулиар харьяалуулсан Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад 12, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад 5, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх албаны төв, орон нутгийн байгууллагуудад 19, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа салбар, нэгжүүдэд 17, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2, цэргийн сахилгын байр, их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.

Зөвлөмжийн мөрөөр дээрх байгууллагуудад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, бодит өөрчлөлт, сайжруулалт гарсан нь онцлох үр дүн байв. Тухайлбал: Зэвсэгт хүчний жанжин штаб 111 сая төгрөг, хяналт шинжилгээнд хамрагдсан оюутны дотуур байрны урсгал засварт 4 тэрбум 552 сая, эд хогшил, тоног төхөөрөмж, амьдралын орчныг сайжруулах чиглэлээр худалдан авсан бараа бүтээгдэхүүнд 479 сая төгрөг зарцуулсан байна.

- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг асуудал эрхэлсэн гишүүний баталсан А/02 дугаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх дотоод журам”-ын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлсэн.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 2022-2025 онд эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар олон улсын жишиг стандарт болон дотоодын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж, судалгааг нийт 7785 иргэн, 1654 төрийн албан хаагчаас авсан.
- Тайлант хугацаанд 1709 иргэн, 189 төрийн албан хаагч, 238 оюутан, 25 багш, алба хаагч, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газрын 135 үйлчлүүлэгч, мөн тус байгууллагуудын 211 алба хаагчаас асуумж авсан.
- ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан 1739 иргэнтэй ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, зөвлөгөө өгсөн.
- Тайлант хугацаанд 419 хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад хэлбэрээр эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, 38 оюутан, 506 төрийн албан хаагчтай ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж зөвлөгөө өгсөн. Түүнчлэн ЭШУСҮА-ны албан өрөөнд 22 иргэн өөрийн биеэр ирж ганцаарчлан уулзаж, зөвлөгөө авсан нь уулзалтын бүртгэлд тэмдэглэгдсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн урьдчилан сэргийлэх зарим хяналт шинжилгээг хийхдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Николь Хогг, Олон улсын байгууллагын хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд, Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан ахлах зөвлөх Нид Сатжипанон, Шинэ Зеландын Цагдаагийн газрын суперинтендант (дэд дарга) Гэри Алкок нартай хамтран ажиллаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, туршлага судлав.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид хуульд заасан бүх газруудад хяналт шинжилгээ хийх арга барилдаа олон улсын стандарт, хөндлөнгийн ажиглагчдын дүгнэлтийг тусгаж, шаардлагатай ур чадвараа сайжруулан илүү чадавхажсан нь үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлсэн.

Улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны САТ/С/МНГ/СО/3 АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТЭД: “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) байгуулагдаад удаагүй ч, стратеги төлөвлөгөөгөө батлан, богино хугацаанд чадавхжиж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ахиц гаргасан” гэж онцлон дүгнэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай тайланд тэмдэглэсэн байна.⁵⁸

⁵⁸ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа САТ/С/МНГ/СО/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. САТ/С/SR.2157 and САТ/С/SR.2160-ыг үзэх. https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссар, Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тэргүүний урилгаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн болон ЭШУСҮА-ны албан хаагчид 2025 оны 6 дугаар сарын 1-6-ны өдрүүдэд Варшав хотод ажиллаж, Польш Улсын Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх туршлагатай танилцсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлснээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн урьд өмнө нь илэрч байгаагүй зөрчил, дутагдлууд, нөхцөл байдлыг илрүүлж, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэн, дахин гарахаас урьдчилан сэргийлж, зөвлөн туслах, хамтран ажиллах чиглэлээр тасралтгүй ажиллаж ирлээ.

НЭГ. ХУУЛЬ, ТОГТООЛООР ҮҮРЭГ ЧИГЛЭЛ БОЛГОСОН УИХ-ЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АСУУДАЛ

Улсын Их Хурлаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэж, хүний эрх, эрх чөлөөг хангах, урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх, эрх зүйн орчныг олон улсын стандарттай нийцүүлэх, хараат бус, үр нөлөөтэй хэрэгжүүлэх талаар Засгийн газар болон холбогдох байгууллагуудад тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасан тогтоолуудыг удаа дараа баталж ирсэн. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгавар гарч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна⁵⁹.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил тутам ХЗБХ-нд танилцуулж, Улсын Их Хурлаар хэлэлцсэний үр дүнд батлагдсан дараах тогтоолуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар авах арга хэмжээний талаар тусган, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасаар ирсэн. Үүнд:

- УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэг;
- УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг;
- УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 77 дугаар тогтоолын 6, 7 дахь хэсэг;
- УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг;
- УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоол.

⁵⁹ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 1 дүгээр бүлэг.

Эдгээр Улсын Их Хурлын тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилт хангалтгүй, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүй байгааг холбогдох байгууллагуудын хийсэн дүн шинжилгээгээр тогтоосон байна.

1. Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.7 дахь заалт, 115.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан”-д дүн шинжилгээг хийсэн.

Улсын Их Хурлаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын нийт 5 тогтоолын биелэлтэд Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийхэд биелэлт дунджаар 45.8 хувь буюу “хэрэгжилт хангалтгүй” байна гэж дүгнэгдсэн. Засгийн газарт даалгасан үүргийн хэрэгжилт үр дүнгүй байгааг тогтоосон байна.

2. Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр 04-ны хуралдаанаар танилцуулсан бөгөөд дээрх тогтоолын заалтууд “хэрэгжээгүй” гэж үнэлэгдсэн байна.

3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс дээрх тогтоолуудын хэрэгжилтийн дүн шинжилгээ хийхэд тогтоолуудын зорилго бодит ахиц, тогтвортой өөрчлөлт болж “хэрэгжээгүй” гэж үнэлэгдсэн. Энэ хүрээнд хэрэгжилтийг гаргаж Улсын Их Хурлын Тамгын газарт 2025 оны 10 дугаар сарын 02-ны 08/1689 дугаар албан бичгээр хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлаас баталсан бие даасан 5 тогтоол, хавсарсан 2 тогтоол, Хууль зүйн байнгын хорооны 1 тогтоол, мөн Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг бодлогын баримт бичгүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн томоохон бодлогын арга хэмжээ болсон. Эдгээр баримт бичгүүд нь хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, бодлогын замын зургийг тодорхойлох замаар бодит ахиц гаргахад чухал түлхэц үзүүлсэн.

Улсын Их Хурлаас баталсан дээрх тогтоолууд нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэхэд чиглэсэн гол бодлогын баримт бичгүүд боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байгаа нь уг үүргийг бодлогын түвшинд хүлээн зөвшөөрсөн байдалд үлдээж, дотоодын хууль, эрх зүй, институцийн бодит өөрчлөлт болгон хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Энэхүү нөхцөл байдал нь Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн асуудал нь зөвхөн нэг байгууллага, салбарын хүрээнд хамаарах бус, салбар дундын уялдаа, зохицуулалтыг шаардсан тогтолцооны шинжтэй асуудал болохыг харуулж, улмаар Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бодитоор хэрэгжүүлэх чадавхад сөргөөр нөлөөлж байгааг илтгэнэ.

2020-2025 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүү шүүлтийг таслан зогсоох чиглэлд УИХ-

ын чухал тогтоол, шийдвэрүүд батлагдаж, бодитой ахиц өөрчлөлт гарсан. Үндсэн хууль, төрөлжсөн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр иргэдийн эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрхийг баталгаажуулсан, түүнийг хангах, хамгаалах үйл ажиллагааг дэмжих, бэхжүүлэхэд тодорхой ахиц гарсан.

Гэвч Улсын Их Хурлаас баталсан дээрх тогтоолуудын хэрэгжилтийг Засгийн газраас хуульд заасан хугацаанд тайлагнахгүй, хэрэгжилтийг бүрэн хангахгүй явж ирсэн нь тогтоолуудын зорилго, бодлогын үр нөлөөг сулруулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд Засгийн газрын зарим байгууллага, түүнчлэн аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлан ажилласан.

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн тухай бүр зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан боловч зөрчил, дутагдал давтан гарсаар байгаа тул ХЗБХ-нд танилцуулж, Улсын Их Хурлаар хэлэлцсэний үндсэн дээр батлагдсан дээрх тогтоолуудад тусгагдсан асуудалд анхаарч, цаашид бодитой, үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Эдгээр тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2024, 2025 оны 5 дугаар сарын хуралдаануудаар хэлэлцэж, хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангах талаар тодорхой, үр нөлөөтэй арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж дүгнэсэн байна. Үүнийг Хууль зүй, дотоод хэргийн яам анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг гурав дахь удаагийн тайландаа дахин онцлон тэмдэглэж байна.

Түүнчлэн хуульд заасан бүрэн эрхийн дагуу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх асуудлаар Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд холбогдох хуулийн төслийг боловсруулан, УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаарх зөвлөмжүүдийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 08/07 дугаар Зөвлөмж, мөн Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарт 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 08/01 дугаар Зөвлөмжөөр хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар гарсан. Монгол Улсын Ерөнхий сайдын Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасугай” гэж заасан.

Иймд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой УИХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн газраас шийдвэртэй, бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

ХОЁР. УИХ-ЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАХГҮЙ БАЙГААГААС ҮҮДЭН ГАРАХ СӨРӨГ НӨЛӨӨ

1. Улсын Их Хурлаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг хэлэлцсэний үндсэн дээр баталсан дээрх тогтоолуудын хэрэгжилт хангагдаагүй байдал нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үр нөлөөг бодитоор сулруулж, хяналт шинжилгээний явцад давтагдан илэрч буй зөрчил, дутагдлыг арилгах боломжийг хязгаарлаж байна.⁶⁰

2. ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдаж болзошгүй бүх газар урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ тогтмол хийж байгаа боловч УИХ-ын тогтоолуудын хэрэгжилт бодит түвшинд хангагдахгүй байгаа нь дээр дурдсан сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

3. Хяналт шинжилгээгээр тогтоогдсон зөрчил, дутагдал давтагдан илэрч, бүрэн арилж чадахгүй хэвээр байна. Цагдан хорих байр, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын саатуулах байр, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, хүүхдийн асрамж, халамжийн байгууллага зэрэг газруудад хийгдсэн хяналт шинжилгээгээр хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүний нэр төрийг хүндэтгэх орчин нөхцөлтэй холбоотой зөрчил өмнөх онуудтай ижил шинж, хэлбэрээр дахин илэрч байна. Энэ нь өмнөх жилүүдэд өгсөн зөвлөмж, түүнчлэн УИХ-ын тогтоолын хүрээнд авах ёстой байсан эрх зүйн болон байгууллагын түвшний арга хэмжээ бодитоор хэрэгжээгүйтэй шууд холбоотой юм.

4. Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий, доромжлон харьцах, холбогдох гомдол, мэдээллийг хараат бусаар шалгах нөхцөл бүрдээгүй хэвээр байна. УИХ-ын тогтоолуудаар эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээллийг хараат бусаар шалгах бие даасан зохион байгуулалт бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг удаа дараа даалгасан боловч хэрэгжилт хангагдаагүйгээс хяналт шинжилгээний явцад илэрсэн ноцтой шинжтэй зөрчилд бодитой, үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломж хязгаарлагдсаар байна.

5. ЭШУС үндэсний ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг шаардах, биелэлтийг хангуулах нөлөөлөл сул байна. УИХ-ын тогтоолоор өгсөн чиглэлүүд бодлогын түвшинд үлдэж, хэрэгжилтийг хангуулах тодорхой хугацаа, ХЭҮК-ын тухай хуулийн 35.4-т заасан хариуцлага тооцуулах саналыг бодит шийдвэр, хэрэгжилтэд шилжүүлэх хяналт, хариуцлагын дараагийн шатны тогтолцоо хангалттай бүрдээгүй байгаа нь ЭШУС үндэсний ажиллагаанаас гаргасан зөвлөмжийг байгууллагууд заавал хэрэгжүүлэх эрх зүйн баталгааг сулруулж байна.

6. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний зорилго алдагдах эрсдэл бий болж байна. Хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил, дутагдал системтэйгээр арилахгүй, давтагдан илэрсээр байгаа нь хяналт шинжилгээ нь бодит өөрчлөлт авчрах бус,

⁶⁰ ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 1 дүгээр бүлэг.

зөвхөн “нөхцөл байдлыг тогтоох” түвшинд хязгаарлагдах эрсдэлийг бий болгож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны стратегийн зорилгод сөргөөр нөлөөлдөг.

7.Улсын Их Хурлаас баталсан тогтоолуудын хэрэгжилтийг бодитой хангахгүй байгаа нөхцөлд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх, хяналт шинжилгээний үр дүнг бодит өөрчлөлт болгон хэрэгжүүлэх боломж хязгаарлагдсаар байх эрсдэл үүсэж байна.

ГУРАВ. НҮБ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АСУУДАЛ

НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодоос эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангахтай холбогдуулан өгсөн удаа дараагийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс хангалтгүй байгаа тул эрчимжүүлэх шаардлагатай байгааг 2016-2025 оны хооронд НҮБ-ын чуулганы ерөнхий хуралдаануудаас гаргасан албан ёсны дүгнэлтэд удаа дараа дурдаж, Монгол Улсын Засгийн газарт 8 удаагийн зөвлөмж өгч иржээ.⁶¹

НҮБ-ын гэрээний хороодоос өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэхдээ Монгол Улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор өмнө авсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, эргэн тайлагнаж ажиллахыг дахин дараагийн 6 удаагийн зөвлөмждөө тусгаж ирсэн байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны гишүүдийн зүгээс “Монгол Улс ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт уриалсан.

Энэ талаар Монгол Улсын Их Хурал болон Олон улсын парламентын холбооны хамтран 2025 оны 3 дугаар сард зохион байгуулсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан, хэлэлцүүлэг (UPR-Universal Periodic Review)-ийн үйл явц дахь Монгол Улсын Их Хурлын оролцоо, НҮБ-ын гишүүн орнуудаас хүлээн авсан зөвлөмжүүд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог хангах талаарх асуудлаарх уулзалт, хэлэлцүүлгийн үеэр тусгайлан хөндөгдсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Үүнд дараах үндсэн шалтгаанууд нөлөөлжээ:

- **Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй** - Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайдын түвшинд холбогдох тогтоол шийдвэр, албан даалгавар батлагдсан, тодорхой ахиц гарсан мэт боловч зөвлөмж бодитоор бүрэн хэрэгжээгүй байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан тогтоол шийдвэрүүд НҮБ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай заасан. Харин Зөвлөмжийг хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх арга замын талаар зохицуулаагүй.

61 ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 1 дүгээр бүлэг.

- **Хугацааны хоцрогдол** - Засгийн газар зөвлөмжийн дагуу тайлан боловсруулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлээгүйгээс хугацааны зөрчил үүссэн.
- **Бодит үр дүнгийн хомсдол** - Зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүйгээс дотоодын хууль, эрх зүйн орчинд шаардлагатай, оновчтой өөрчлөлтүүд хийгдээгүй бөгөөд олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргээ бодитой хэрэгжүүлэхэд саад болж байна.
- **Тогтолцооны шинжтэй дутагдал** - Зөвлөмжийн хэрэгжилт нь нэг байгууллагын хүрээнд хязгаарлагдах боломжгүй, салбар дундын уялдаа, зохицуулалт шаарддаг хэдий ч энэ чиглэлд тогтвортой, үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүйгээс системийн шинжтэй хүндрэлүүд илэрч байна.

Энэ нь НҮБ-ын гэрээний хороодоос Монгол Улсад өгсөн зөвлөмжийг биелүүлэх эрчимтэй, тогтмол, хэмжигдэхүйц механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний хороодоос Монгол Улсад удаа дараа дүгнэлт гарган, зөвлөмж өгч ирсэн бөгөөд эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь Монгол Улсын НҮБ-ын гишүүн орнуудын өмнө хүлээсэн үүрэг, нэр төрийн асуудал болж байгааг анхаарах болсон.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзвэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороодод дөрвөн жил тутам Монгол Улсын хүний эрхийн асуудлаарх ээлжит тайланг хэлэлцүүлж, өмнө өгсөн зөвлөмжийн биелэлтийг дүгнүүлдэг тайлагналын механизмын хүрээнд эргэн тайлагнах шалгуур үзүүлэлт, салбар дундын уялдаа, зохицуулалтыг Засгийн газраас тодорхой тогтоож, холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан эрчимжүүлж, тогтмол тайлагнадаг байнгын механизм бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна.

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар гарсан. Монгол Улсын Ерөнхий сайдын Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасугай” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, биелэлтийг нь хангуулах, эрх зүйн шинэтгэлийн бодлого, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа мэдээллийн ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

үндсэн үүрэгтэй. Энэхүү чиг үүргийг Ерөнхий сайдын өмнө Хууль зүй, дотоод хэргийн сайд хариуцдаг тул энэхүү үүргээ бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай.

Түүнчлэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу төрийн холбогдох байгууллагууд тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарим ахиц дэвшил гарч байна. Гэвч дээрх ахиц, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь хүний эрхийг хангах, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх, хүнлэг бус, хэрцгий харьцаа, ялгаварлан гадуурхалт, алагчлалаас бүрэн ангид байх эрхийг үндэсний хэмжээнд тогтолцооны хувьд жигд, тогтвортой хэрэгжүүлсэн гэж дүгнэхэд хангалттай үндэслэл болж чадахгүй⁶².

Иймд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын бүх түвшинд тодорхой, хэмжигдэхүйц, тогтвортой үр дүн бүхий арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой зарим үйл ажиллагаатай холбогдуулан дараах нөхцөл байдлыг танилцуулж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг хэлнэ гэж заасан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг ойлгоно” гэж заасан бөгөөд хоёр өөр чиг үүрэг бүхий, бие даасан, хараат бус байдлаар хуульчилсан.

Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан хоёр институт болох ч төсөв, санхүүгийн хараат бус байдал нь бодитой, тодорхой хэрэгжих боломжгүй байна. Тодруулбал Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга төсвийг ерөнхийлөн захирч, Тамгын газрын дарга төсвийг шууд захирч байгаагаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан төсвийг захиран зарцуулах боломжгүй болж үндэсний ажиллагааны санхүүгийн хараат бус, бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна.

62 ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны тайлангийн 1 дүгээр бүлэг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь тусгайлсан төсөвгүй, ХЭҮК-ын төсвөөс шууд хамааралтай ажиллаж байна. Сангийн яамны Төрийн санд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тусгай данс нээсэн байдаг ч одоогоор төсөв тодорхой хуваарилагдаагүй.

Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийг өргөн барихад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн үндэсний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг өөрөө өргөн мэдүүлэх конвенцод заасан эрхтэй ч дотоодын хууль тогтоомжид тодорхойгүй гэсэн үндэслэлээр саналыг үл хүлээн авч, төсөөлсөн хэмжээнд батлуулалгүй, төсөв батлагдсаны дараа анхны төсөөллөөс өөрчлөн, 3 жил дараалан хэт бууруулж хуваарилж байгаа нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна. Дээрх нөхцөлөөс шалтгаалан ХЭҮК-ын тухай хуулийн “31.2. Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно” гэж, мөн хуулийн “31.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэсэн зохицуулалт хэрэгжихгүй байна гэж дүгнэж болно.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаа хоорондын ажил хэргийн харилцаа, үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдаж, төрийн ажлыг хэвийн явуулах нөхцөл бэхжихгүй, явц удаашралтай байна.

Эрх зүйн зохицуулалт, олон улсын гэрээний үүргийн хэрэгжилт

1. Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, 2022 онд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилсноор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа дөрөв дэх жилдээ үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Долоодугаар бүлгээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хараат бус байдлын эрх зүйн үндсийг баталгаажуулсан. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан.

Монгол Улсын 1988 онд нэгдэн орсон Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 26 дугаар зүйлд: “Аливаа хүчин төгөлдөр гэрээг түүний оролцогчид заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд гэрээг шударга сайн санаагаар хэрэгжүүлэх” гэж, мөн 27 дугаар зүйлд: “Оролцогч нь гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтаас иш татах ёсгүй” гэж заасан учраас Монгол Улс олон улсын хүчин төгөлдөр гэрээг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд үндэсний хууль тогтоомжийг иш татан олон улсын гэрээг биелүүлэхгүй байж болохгүй тул Үндсэн хуульд харшлаагүй олон улсын гэрээ үндэсний хууль тогтоомжоос дээгүүр “Pacta sunt servanda” зарчмын үйлчлэлд хамаарах эрх зүйн эх сурвалж болно.

Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна. Нэмэлт протоколын үзэл санаа, зохицуулалтыг хоёрдмол утга, өөр өөр байдлаар тайлбарлахгүйгээр нэг мөр хэрэгжилтийг хангах нь чухал байна.

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, Улсын Их Хурал тус тус соёрхон баталсан. Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын “Нэмэлт протокол дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ” гэж заасан байдаг.

Гэсэн хэдий ч Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлэг буюу 17, 18, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн зохицуулалтуудыг дотоодын хууль хэрэглээний түвшинд нэг мөр ойлгож, шууд хэрэгжүүлэх практик бүрэн төлөвшөөгүй, ялангуяа Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагын зүгээс ялгаатай байдлаар тайлбарлах, үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, саад болох, үл дэмжих байдал тулгарсаар ирлээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны дотоодын хууль тогтоомж болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасан бүрэн эрх, хараат бус байдлын талаар ялгаатай тайлбар, ойлголт хэвээр байна. Энэ нь хүний эрхийн шинэ механизмыг нутагшуулах, олон улсын стандартыг бодит хэрэгжилт болгоход хүндрэл учруулж байна.

2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт зааснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил тутам ХЗБХ-нд танилцуулж, УИХ-аар хэлэлцсэнтэй холбогдуулан батлагдсан УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэг, УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 8, 9 дэх хэсэг, УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 77 дугаар тогтоолын 6, 7 дахь хэсэг, мөн УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар авах арга хэмжээний талаар зааж, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Засгийн газраас эдгээр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ аваагүй.

Тухайлбал, Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол батлагдсан.

Тус тогтоолын 1 дэх хэсгээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын Хүний эрхийн дэд хороонд даалгасан.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хараат бус судлаачдын багийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу бие даасан, хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэж байна гэж дүгнэгдсэн.

Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасан хяналт шинжилгээ хийх газрыг хязгаарласан, хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг олгохгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь тогтоогдсон.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулсан 22 заалтаар үнэлэхэд зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна.

3. Энэхүү хараат бус шинжээчдийн багийн гүйцэтгэсэн судалгааны дүн, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 2024 оны 5 сард ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулсан.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан (2024.04.26) Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлж, Хаврын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэж, эхний хэлэлцүүлэгт шилжүүлж шийдвэрлэсэн байдаг.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа болон нэр бүхий гишүүдийн санаачлан боловсруулсан энэхүү хуулийн төслийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд 2024 оны 5 дугаар сард хүргүүлж, зөвлөх захидлын хүрээнд санал авсан.

Гэвч Хүний эрхийн Үндэсний Комиссын тамгын газрын даргаас хуулиар олгогдоогүй, өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар Монгол Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах бүрэн эрх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдалд халдаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өмнөөс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдэд 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр

албаны цахим хаягаас албан захидал явуулж, дур зоргоороо хууль санаачилж байгаа талаар ташаа мэдээлэл хүргүүлсэн асуудал гарсан.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын илгээсэн захидалд: “ХЭҮК-ын хүрээнд ЭШУС үндэсний ажиллагааг байгуулсан одоогийн хууль дахин хэлэлцэгдэж байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Саяхан манай хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг сөрөг хүчний дарга өргөн барьсан. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний голлон нөлөөлсөн энэхүү хуулийн төсөл нь Нэмэлт протоколын дагуу байгуулагдсан байгууллагын үүргийг өөрчилж, өргөтгөсөн эрх мэдэл бүхий тусдаа Омбудсмены газрыг байгуулахад чиглэжээ. Та бүхний айлчлал болон удахгүй болох манай бүх нийтийн сонгуультай холбогдуулан өөрчлөлт оруулах тухай тэдгээр саналыг шийдвэрлэх цаг нь ирж байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн цаад сэдэл нь нийтийн эрх ашиг гэхээсээ илүү хувийн ашиг сонирхлоос шалтгаалж байгаа бөгөөд энэ нь манай үндэсний бодлого болон танайх шиг олон улсын байгууллагуудын ойлголтод нөлөөлж болзошгүй буруу тайлбар хийх эрсдэлтэй гэсэн болгоомжлол байна.” гэж дурдсан байдаг.

Энэ нь Улсын Их Хурлын гишүүдийн Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд санаачлан боловсруулсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн мэдүүлж, 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлж байсан үед явуулсан захидал болно.

Улсын Их Хурлын гишүүдийн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан хуулийн төсөл санаачлах бүрэн эрхэнд хөндлөнгөөс нөлөөлсөн, мөн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт: “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно” гэж заасан, мөн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 18, 19, 20 дугаар зүйлд заасныг зөрчсөн үйлдэл болсон.

Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагын зүгээс дээр дурдсан нөхцөл байдалтай адилаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон хуульд заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг гадаад, дотоодод төлөөлөх, бие даан харилцах, үйл ажиллагаа явуулах хараат бус байдлыг үл хүндэтгэж байна.

Үйл ажиллагааны хараат бус байдал, төсөв, санхүү, хүний нөөцийн хүндрэл

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үйл ажиллагааны хараат бус байдал алдагдаж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь чиг үүргийн хувьд тусдаа, хараат бус механизм боловч төсөв, санхүү, захиргааны хувьд ХЭҮК-ын даргаас шууд хамааралтай байна.

Төсөв батлан хуваарилах, зарцуулах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх удирдамжид ХЭҮК-ын тамга дарж баталгаажуулах, томилолтоор ажиллах тушаал гаргуулах, бусад байгууллагуудтай харилцах албан бичигт тамга, тэмдэг даруулах, хүргүүлэх, олон улсын харилцаанд оролцох явцад тогтмол нөлөөлөх, саатуулах, мэдээллийн нууцлал алдагдах эрсдэл 4 дэх жилдээ бодитоор үргэлжилж байна. Энэ

нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зорилго, үр нөлөөг байнга сулруулж ирлээ⁶³.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалтад: “Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” гэж заасан байдаг ч хэрхэн хэрэгждэг нь тодорхойгүй.

Энэ нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт: “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно” гэж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалтад: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг, дотоод, гадаад харилцаанд төлөөлөх” гэж заасан, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх баталгаагаар хангана” гэж, мөн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын цуглуулсан мэдээллийг ил болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг тухайн хүний шууд илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй.” гэснийг хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх шаардлагатай.

2. Төсөв, санхүү, хүний нөөцийн хүрэлцээ ноцтой дутагдалтай байна. ЭШУС үндэсний ажиллагаа нь тусгайлсан, бие даасан төсөвтэй байх, үйл ажиллагаанд хүрэлцэхүйц байхаар улсын төсвөөс хангах эрх зүйн зохицуулалттай боловч ХЭҮК-ын даргын дотоод хуваарилалтаас бүрэн хараат ажиллаж байна. Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан хоёр институт болох ч төсөв, санхүүгийн хараат бус байдал нь бодитой, тодорхой хэрэгжих боломжгүй байна. Тодруулбал Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, төсвийн ерөнхийлөн захирагч, Тамгын газрын дарга төсвийг шууд захирч байгаагаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан төсвийг захиран зарцуулах боломжгүй болж үндэсний ажиллагааны санхүүгийн хараат бус, бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна.

ХЭҮК-ын даргаас ЭШУС үндэсний ажиллагаанд зориулж 2022-2025 онд ХЭҮК-ын нийт төсвийн 2-6 хувьтай тэнцэх хэмжээний төсөв хуваарилж ирсэн. Цалин, нийгмийн

63 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Улсын Их Хурал, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй харилцах албан бичигт зарим тохиолдолд Хүний эрхийн Үндэсний Комиссын тамга, тэмдгийг хэрэглүүлэхээс татгалздаг, албан бичгийн утгыг хянадаг, өөрчлүүлэх шаардлага тавьдаг, даргын туслах нь зургийг авч даргадаа илгээж хянуулдаг, хугацаа сунган удаашруулдаг, гишүүний гарт гэж хаягласан албан бичиг, холбогдох материалын дугтуй, битүүмжлэл задарсан байдаг, зэрэг зохисгүй үйлдлийг 4 жил гаргаж байна. Яаралтай хийх шаардлагатай хяналт шинжилгээний Удирдамжийн төсөлтэй Комиссын дарга заавал танилцаж байж тамга дарах эсэхээ шийддэг, үндэслэлгүйгээр хэдэн цаг, хоногоор тамга, тэмдэг дарахгүй хүлээлгэдэг, хяналт шинжилгээ хийх газруудыг өөрчлүүлдэг, комиссоос өмнө нь явсан учир давхцаж явах хэрэггүй гэж хориг тавьдаг, бусад байгууллагад явуулах зарим албан бичгийн утгыг өөрчлөх шаардлага тавьдаг, зарим төлөвлөсөн ажлыг элдэв шалтаг заан болиулдаг, хойшуулдаг, албан хаагчдыг цалин хөлс, шагнал урамшуулал, зэрэг дэвийн нэмэгдлийг хуульд заасны дагуу олгодоггүй хасдаг, оффисын түрээсийн төлбөрийг саатуулах, интернэтийн төлбөрийг 3 сар төлөхгүй тасалдаг, хөдөө орон нутагт ажиллах тээврийн хэрэгслийн болон томилолт, шатахууны зардал, сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, сурталчилгаа хийх, холбогдох дүн шинжилгээ хийлгэх, гарын авлага хэвлүүлэх зардал зэрэг төсвийн зарцуулалтад хязгаарлалт тогтоон, урьдчилан мэдэгдэлгүй төсөв, орон тоо хасаж, бүтэц өөрчлөх зэргээр үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй гаргасаар байна. (ЭШУС үйл ажиллагааны 2024 оны тайлан, 522 дахь тал.)

даатгалд нийт хуваарилагдсан төсвийн 85 гаруй хувь зарцуулагддаг бөгөөд үлдсэн 15 хувьд хүрэхгүй төсвөөр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, дотоод албан томилолт, сургалт, нөлөөллийн ажил буюу үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд зарцуулж ирсэн нь ажиллахад хүндрэлтэй байна. Энэ талаар асуудал тавьдаг ч шийдвэрлэгдэхгүй өдий хүрлээ.

Хэдийгээр Төрийн санд тусгай данс нээсэн боловч бодит төсөв хуваарилагдаагүй, батлагдсан төсөв нь цалин, нийгмийн даатгалд зарцуулагдаж, чиг үүргийн хэрэгжилтэд хүрэлцэхгүй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тухайн жилийн ажлын төлөвлөгөө, стратегид тусгагдсан төлөвлөгөөт ажлуудаа хэрэгжүүлэхэд санхүүгийн хувьд байнгын хүндрэлтэй, Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үзэмжээс шууд хамаарч, төсөв олгох, олгохгүйг шийдэж ирлээ.

Тухайлбал, өнгөрсөн 4 жилийн хугацаанд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022-2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөдөө орон нутагт байгаа хорих байгууллагуудад томилолтоор ажиллах арга хэмжээ байнга тасалдаж, гүйцэтгэл нь 50-56 хувьтай байсан. Үүний шалтгаан нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны томилолтын зардлыг хассанаас болсон байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд ном, гарын авлага, сурталчилгааны бүтээгдэхүүнийг хэвлэх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах төсөв байхгүйгээс үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй явж ирлээ. Урьдчилан сэргийлэхэд сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд төсөвгүйгээр хэрэгжих боломжгүй юм.

Хяналт шинжилгээ хийхэд холбогдох төсөв, томилолтын мөнгийг Комиссын дарга, тамгын газрын дарга зэрэгт танилцуулж, баталгаажуулдаг практик тогтож, энэ нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр гарах боломжгүй газруудад хийх хяналт шинжилгээний талаарх мэдээлэл түгэн тарах зэргээр урьдчилж мэдэгдэхгүйгээр гэнэтийн хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаа зорилгоо бүрэн биелүүлж чадахгүй байх эрсдэлийг үүсгэсэн.

Энэхүү хүндрэлтэй нөхцөл байдлын талаар удаа дараа 2022-2024 оны үйл ажиллагааны тайландаа тусгаж, УИХ-ын чуулган, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд болон Хууль зүйн байнгын хорооны даргад танилцуулж, Комиссын удирдлагад асуудал болгон тавьж ирсэн боловч шийдвэрлэгдэхгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт: “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж заасан, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, хөрөнгөөр хангах үүрэг хүлээнэ” гэж заасныг зөрчсөн үйлдэл болсон. Хууль, олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж, хуульчилсан зохицуулалтыг нэн даруй хангах шаардлагатай.

3. Нөгөөтээгүүр Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13 дугаар зүйл, Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлд заасан ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид болон эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах асуудлаар хуульд тусгагдаагүй нь дээр дурдсан эрсдэл үүсгэж байгаа гэж дүгнэж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь хууль, конвенцод зааснаар Үндэсний хэмжээнд ажиллах үүрэгтэй бөгөөд улсын хэмжээнд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй 21 аймаг, нийслэлд 843 газарт байрлаж буй 144,942 эрх нь хязгаарлагдсан хүмүүст хүрч ажиллах, тэдний эрхийн баталгааг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, сургалт, судалгаа зохион байгуулах хуульд заасан үүргийг хэрэгжүүлдэг.

Гэтэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс 2022 онд 4, 2023 онд 5, 2024 онд 5, 2025 онд 7 хүний орон тоотойгоор ажиллаж байсан.

Харин Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс 2025 онд 9 орон тоотой ажиллаж байсан боловч тухайн онд 2 орон тоог цомхотгосон нь ажил хэвийн явуулахад хүндрэл учруулж байна.

2026 оны ЭШУС үндэсний ажиллагаад хуваарилагдсан төсөв, хүний нөөц огтхон ч хүрэлцэхгүй, 2026 онд төлөвлөгдсөн ажлууд үндсэндээ хэрэгжих боломжгүй болсон. Орон нутагт томилолтоор явах зардал, автомашины шатахууны зардал, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах төсөв өмнөх онуудаас 75 хувиар багасгаж хуваарилсан байна. Хүний нөөцийн орон тоо бага, орон нутагт төлөөлөлгүй, төсөв хүрэлцээгүй, хүний нөөцийн томилгоо хараат, техник хэрэгслийн хомсдол, албан харилцаа, гомдол, мэдээллийн нууцлал алдагддагаас үүдэн үндэсний хэмжээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд нэн хүндрэлтэй болсоор байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага

ЭШУС үндэсний ажиллагаа нь нэгдэн орсон гэрээ, конвенцын дагуу ЭШУС олон улсын байгууллагуудын ажлыг нөхөх гол үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд түүнд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх эрх мэдэл олгох ёстой.

Ийм учраас Нэмэлт протоколд ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байдал, бүрэн эрх, төсвийг хараат бусаар шууд захиран зарцуулах эрхийг олгох талаар оролцогч улсуудын өмнө хүлээсэн эрх зүйн үүргийг заасан.

Нэмэлт протоколын 4 дүгээр хэсэгт зааснаар оролцогч улс нь ҮУСБ-ыг байгуулахдаа:

- Үйл ажиллагааны бие даасан хараат бус байдал
- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бүхий мэргэшсэн байх
- Үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах нөөцтэй байх гэсэн баталгааг бүрдүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улсад ЭШУС үндэсний ажиллагааг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэхжүүлэх асуудлаар дараах арга хэмжээг авах шаардлагатай.

ЭШУС нэгжийн албан хаагчдын хүний нөөцийн асуудлаар:

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана.”, мөн зүйлийн 36.3 дахь хэсэгт “..зөвхөн энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын холбогдох хороонд хүргүүлсэн тайланд тусгасны дагуу 2022 онд ЭШУС нэгжийг 10 албан хаагчтай ажиллахаар нөөцийн асуудлаа зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолуудыг үндэслэн 10 албан хаагчийн “Албан тушаалын тодорхойлолт”-ыг баталсан. Гэвч батлагдсан 10 орон тоог 2023, 2024 оны төсвийн төсөөлөлд хасахаар шийдвэрлэсэнээс ЭШУС нэгжийн 5 албан хаагчийн төсвийг хасаж ирсэн.

Жил ирэх тусам ЭШУС нэгжийн албан хаагчдыг үйл ажиллагааны цар хүрээ өргөжин, тогтмол уулзах хүн, орон даяар хүрэлцэн очиж хийх хяналт шинжилгээ ихсэх зэрэгтэй холбогдуулан орон тоогоо нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь хууль, конвенцод заасны дагуу Монгол Улсын нийт иргэд, оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг 220000 гаруй төрийн албан тушаалтан, албан хаагчдад сурталчлах болон өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй 21 аймаг, нийслэлд 843 газарт байрлаж буй 144,942 эрх нь хязгаарлагдсан хүмүүст хүрч ажиллах, тэдний эрхийн баталгааг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, сургалт, судалгаа зохион байгуулах хуульд заасан үүргийг хэрэгжүүлдэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс 2025 онд 9 орон тоотой ажиллаж байсан боловч тухайн онд 2 орон тоог цомхотгосон нь ажил хэвийн явуулахад хүндрэл учруулж байна.

Улсын Их Хурлын ХЗБХ-ны хурлаар ХЭҮК-ын төсвийг хэлэлцэн, улмаар УИХ-аас батлагдсан төсвийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч хуваарилахдаа ЭШУС үндэсний ажиллагааны төсвийг жил тутам хасаж тооцож ирсэн болно. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь нэгжийн даргыг томилох бүрэн эрхийг хуульчлан бэхжүүлсэн боловч нэгжийн албан хаагчдыг нэгжийн дарга бус комиссын тамгын газрын дарга томилж байгаа нь хууль зүйн тодорхойгүй байдлыг үүсгэсээр байна. Комиссын дарга нь тамгын газрын даргаа томилдог бөгөөд, тамгын газрын дарга нь хуулиараа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн үйл ажиллагаанд оролцох эрх зүйн зохицуулалтгүй. Тийм байтал өнөөдрийг хүртэл энэ мэт буруу практик хэвшүүлж ирснийг 4 дэх жилдээ тайлагнаж байгаа бөгөөд энэ нь олон улсын жишигт нийцэхгүй гэдгийг хараат бус шинжээчдээс Монгол Улсад зөвлөж ирсэн.

Тухайлбал, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ЭШУС үндэсний ажиллагааны талаарх урьдчилсан дүгнэлтэд “...Монгол Улс Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенцын Нэмэлт Протоколыг 2015 онд соёрхон баталсан бөгөөд хэдийгээр хожуу ч гэсэн уг конвенцын дагуу Үндэсний Урьдчилан Сэргийлэх Механизм (цаашид ҮУСМ гэх) бий болгосныг Ажлын хэсэг талархан сайшааж байна. Монгол Улсын ҮУСМ-ын бүрэн эрхийг ХЭҮК-ын тухайлсан ажлыг хариуцсан комиссар хэрэгжүүлэхээр зохицуулсан байна. Энэ нь комиссын бүрэн эрхийн хугацаанд томилогдсон Комиссын гишүүний чиг үүрэгт багтсан байнгын үүрэг бөгөөд

уг ажлыг шинээр байгуулагдсан ҮУСМ-ын алба хариуцан гүйцэтгэх юм. Тийн хэдий ч уг нэгжийг янз бүрийн салбарын 10 мэргэжилтнээс бүрдүүлэн ажиллуулж төсөв хэмнэх шаардлага тавигдаж байгаа тул эхний хоёр жилийн хугацаанд ердөө таван орон тоотой ажиллахаар байгаа нь бидний санааг зовоож байна. Түүгээр ч зогсохгүй ҮУСМ-ын албаны ажилтнуудыг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөл ямар үүрэг гүйцэтгэж байгаа, энэ асуудалд ҮУСМ-ын асуудал эрхэлсэн комиссар тун бага эрх мэдэлтэй оролцохоор байгаад Ажлын хэсэг санаа зовниж байна. Ажлын хэсэг ҮУСМ-ын бие даан ажиллах чадамжийг хангахын чухлыг онцолж, ҮУСМ-ын боловсон хүчнийг сонгохдоо бие даасан байдлыг нь хангаж өгөхийг Засгийн газарт хүсэлт болгож байна. Монгол Улсын газар зүйн байрлалтай уялдан дур зоргоор эрх чөлөөг хязгаарлах зарим газрын алслагдсан байршлаас шалтгаалан ҮУСМ-ын албыг яаралтай 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах бололцоог бүрдүүлэх нь маш чухал юм.” гэж дүгнэж Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж ирүүлсэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Ерөнхий ассамблейн Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн батлаад Монгол Улсад ирүүлсэн A/HRC/54/51/Add.2 зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газраас эргэн НҮБ-ын Хүний эрхийн хуралдаанд танилцуулахдаа өгсөн зөвлөмжийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны орон тоог 10 болгосон гэж өрөөсгөлөөр тайлагнасан байдаг. Энэхүү үүрэг амлалтаа хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхэд энэ зүйлийн 34.1.9 “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг томилох, чөлөөлөх;” гэж заасан, харин ЭШУС нэгжийн албан хаагчдыг гишүүн, эсвэл нэгжийн дарга томилох асуудал дээр хууль хэрэглээний үл ойлгогдох байдлыг шийдвэрлэх, цаашид ЭШУС үндэсний ажиллагааг хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх арга хэмжээг хууль, эрх зүйн хүрээнд нэг мөр шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмж

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн гэрээний хороодоос эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар 8 удаагийн зөвлөмж, дүгнэлт гарган Монгол Улсад ирүүлсэн.

Улсын Их Хурлаас 2023-2025 оны хооронд 5 тогтоол гарч, НҮБ-ын гэрээ конвенцод хууль тогтоомжоо нийцүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсөв санхүү, хүний нөөцийн бие даасан, хараат бус байдлыг хангах талаар авах шийдвэрүүд гарч, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Гэвч бодит байдал дээр УИХ-ын тогтоолууд, НҮБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас бодит алхам хийгдээгүй байна.

2.Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол батлагдсан.

Тус тогтоолоор:

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох асуудлыг холбогдох журмын дагуу судлан Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд Монгол Улсын Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37, 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 77 дугаар дугаар тогтоолд заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газраас эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улс эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг бодитоор хангахын тулд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн орчныг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, бие даасан төсөв, санхүү, хүний нөөцийн баталгааг бүрдүүлэх, хөндлөнгийн нөлөөллөөс ангид ажиллах бодит нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Энэ нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний тогтолцоог бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

Монгол Улсад шинэ тутам байгуулагдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг Монгол Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагад тайлагнасны дагуу 10 албан хаагчийн төсвийг бүрэн олгох, цаашид нэмэгдүүлэх, мэргэшүүлэн сургах нөхцөлийг бүрдүүлэх шаардлага тулгамдаж байна. Тухайлбал гадаад улсын ижил төстэй байгууллагуудын туршлага судлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах экспертүүдийг урьж ирүүлэх зэрэг арга хэмжээний зардлуудыг улсын төсөвт тусгах зэрэг тулгамдсан асуудлуудыг даруй шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн орчныг Эрүү шүүлтийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн тодорхой болгох;
- Бие даасан төсөв, санхүү, хүний нөөцийн баталгаа бий болгох;
- Захиргаа, санхүүгийн хөндлөнгийн нөлөөллөөс ангид ажиллах институтийн зохицуулалтыг хуульчлах, бусад байгууллагуудтай албан бичгээр харилцах тамга, тэмдэг хэрэглэдэг болох;
- УИХ-аас батлагдсан тогтоол, НҮБ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоог сайжруулах.

Эдгээр арга хэмжээг авснаар Монгол Улс эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг бодитоор хангах, олон улсын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог тогтвортой, үр нөлөөтэй болгох нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орж, үүрэг хүлээсэн улсын хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Дөрөвдүгээр бүлгийн 17, 18, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх бололцоог олгох талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зүгээс гишүүн орнууддаа уриалж, шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллах саналтай байна.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос гишүүн орнууддаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт Протоколд заасны дагуу дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх замаар шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх талаар системийн хүрээнд гарган асуудал тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байж болзошгүй юм.

Иймд хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, цаашид хүний эрхийг хангах механизмуудын хооронд эрхийн болон чиг үүргийн үл ойлгогдох нөхцөл байдал үүсгэлгүйгээр зохицуулж, иргэд, хуулийн этгээдийн эрхийг хангах нөхцөлийг олон улсын сайн жишигт нийцүүлэн, дотоодын хууль тогтоомжоо улам боловсронгуй болгож, Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцоор хамгаалсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тогтолцоог хэлбэрэлтгүй бэхжүүлэх талаар анхаарч ажиллахыг уриалж байна.



N P M
MONGOLIA

УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНААС ГАРГАЖ БУЙ САНАЛ

1. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын төсөв, хамрагдаж буй хүүхдүүдийн сургалтын зардлыг төрөөс нэгдсэн журмаар санхүүжүүлэх, нэг стандарт мөрдүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн онцлог хэрэгцээ, нас, бие даах чадвар, хэрэгцээ шаардлага, эрүүл мэндийн байдлыг харгалзан ангилж, төрөлжүүлэн үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
3. Сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн үйлчилгээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж, төрөлжсөн асрамжийн бүтэц бий болгох.
4. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
5. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох.
6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл, эс үйлдлийг зөрчилд тооцох.
7. Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлд “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан ямарваа шийтгэл ногдуулахыг тушаах, эдлүүлэх, зөвшөөрөх, хүлээн тэвчих ёсгүй бөгөөд тухайн хувь хүн, байгууллагыг ямарваа бусад байдлаар хавчих ёсгүй” гэсэн баталгааг холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулах.
8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас цэргийн алба хаагчдад Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн чиглэлээр сургалт зохион байгуулах хэлбэрээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.
9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ, конвенцод заасны дагуу нийт иргэд, оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг 220000 гаруй төрийн албан тушаалтан, албан хаагчдад сурталчлах болон өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад хуульд заасан

үүргийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсөв санхүү, хүний нөөцийн бие даасан, хараат бус байдлыг хангаж, хот, дүүрэг, аймаг, бүс нутаг бүрд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хүртээмжтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж.

10. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн үндэсний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг Хууль зүйн байнгын хороонд өөрөө өргөн мэдүүлж байх.
11. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрх зүйн байдал, чиг үүргийг нарийвчлан зохицуулж, бие даасан зохион байгуулалтын хэлбэрийг нэг мөр шийдвэрлэх.
12. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг, хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд бусад байгууллагатай харилцахад зохих тамга, тэмдэг хэрэглүүлдэг байх зохицуулалтыг авч хэрэгжүүлэх.
13. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хөнгөн гэмт хэргийг эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгох эрх зүйн зохицуулалтыг эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг судлан, шийдвэрлэх.
14. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн боловсруулж, баталсан журам, дүрмүүдийг олон улсын гэрээнд нийцүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох цогц, шаардлагатай арга хэмжээ авах, шийдвэрлэх, хуулиудын уялдаа холбоо, харилцан хамаарлыг судлан тодорхойлох, нийцлийг үнэлэх.



N P M
MONGOLIA



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 35

Төрийн ордон, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
БАЙДЛЫН ТАЛААРХ 22 ДАХЬ ИЛТГЭЛ, ЭРҮҮ
ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ
ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ**

4/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

б/эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 114

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ БАТЛАГДСАНЫ 75 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/, Хүний эрхийн дэд хороо /Ц.Мөнхцэцэг/-нд даалгасугай.

2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

а/“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг батлан, хэрэгжүүлэх;

б/Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг угтаж 2025 оныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн жил болгох уриалга гаргах чиглэлээр ажиллах;

в/хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх талаар санал боловсруулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

г/хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа Ази, Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санаачилга гаргаж, шийдвэрлүүлэх талаар идэвхтэй ажиллах;

д/хүний эрхийн боловсрол, мэдлэгийг хүүхэд, залуучуудад ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлж, эрх, үүрэг, хариуцлагын тухай сургалт зохион байгуулах, хүний эрхийн ойлголт, мэдлэгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах;

е/хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй аливаа шалтгаан, нөхцөлийг урьдчилан судлан тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл, зөрчлийг арилгах талаар хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ё/Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан хүний эрхийн гэрээ, конвенц, пактуудаар хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх хүний эрхийн төлөв байдлын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо, түүний бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизмд парламентын оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ж/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолын хүрээнд ахмад настны эрхийн асуудлаар тусгайлсан баримт бичиг батлах санаачилгыг Монгол Улс дэмжиж байгааг зохих журмын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэх;

з/олон улсын гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, олон улсын гэрээний заалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.

3.Төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийг шалгах, үнэлэх талаар холбогдох дүрэм, журам, зааврыг хамтран боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөл /Б.Баатарзориг/, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /Д.Сүнжид/-т тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 37

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 23 ДАХЬ ИЛТГЭЛ, ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

8/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

а/шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно." гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

9/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар

а/Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд" (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;

б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх.

Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 77

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 24 ДЭХ ИЛТГЭЛ, ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

б/Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар:

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах ажиллагааны зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

б/хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүнд шинжилгээ хийх, оношлох чадавхыг бэхжүүлэх, тэдгээр хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчилгээ хийх, суллагдсаны дараа хяналт тавих эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авах;

в/эрүүгийн болон зөрчлийн хэргийг аль болох богино хугацаанд шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажлын ачааллыг үндэслэлтэйгээр тооцож, шийдвэрлэх талаар эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах;

г/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ашиглах цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

д/гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

е/баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан даруйд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

ё/гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр эхлэн барагдуулах, түүнчлэн хохирлыг нөхөн төлөх төсвийн эх үүсвэрийг гэм буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого зэргээс бүрдүүлэх зохицуулалт бүхий Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх сангийн тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төслийг боловсруулах;

ж/эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүйн, эрүүл мэнд, нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн харилцаанд эргэн ороход дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулах;

з/хууль сахиулагч бэлтгэх сургалтын тогтолцоо, хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийх, хүний эрхийн стандартад нийцүүлэн хөгжүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг авах;

и/хорих анги, цагдан хорих байр, цэргийн анги, хүний эрх чөлөөг хязгаарлах чиг үүрэгтэй газар болон хууль сахиулагчийн ажлын байранд хүний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

7/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг судалж, шаардлагатай гэж үзвэл хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;

б/Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлэгт зохицуулсан "эрүүдэн шүүх" үйлдлийг нэгтгэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлах;

в/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх;

г/Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах;

д/эрүү шүүлт тулгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хараат бусаар хянан шалгах бие даасан бүтэц байгуулах.

Энэ тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

“Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:

1/Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

а. эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг НҮБ-ын “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-д нийцүүлэн боловсронгуй болгох, эрүүгийн хариуцлагыг чангатгах талаарх саналыг бэлтгэн Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

б. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

в. эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бүрдүүлж, чадавхыг бэхжүүлэх талаарх санал, дүгнэлт боловсруулан Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

г. гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрхийн хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг гадаад улс орнуудтай байгуулах, Монгол Улсын иргэд олноор амьдарч байгаа улс орны хувьд иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр Засгийн газраас бодлогын арга хэмжээ авах талаарх холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай

хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Авлигын эсрэг хууль зэрэг процессын хууль, тогтоомжуудад холбогдох судалгааг хийж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналтын механизмыг сайжруулах талаар санал боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд ирүүлэх;

е.эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчид учирсан гэмтлийг тогтоох анхдагч шинжилгээг шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийдэг байх талаарх зохицуулалтыг Шүүх шинжилгээний тухай хуульд тусган боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ё.эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг шүүх шинжилгээний үйлчилгээний хураамж, зардлаас чөлөөлөх талаарх зохицуулалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тусган боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2/Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр:

а.цагдан хорих, хорих ангийн орчин нөхцөл, албадан эмчилгээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг сайжруулах;

б.эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийн хор уршиг, урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, үүрэг хүлээсэн байгууллага бүр орчин үеийн чиг хандлагад нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

в.Эрүүдэн шүүхийн конвенцын орчуулга, агуулга, нэр томъёог нэг мөр болгох, улмаар 2015 оны Эрүүгийн хуулийн "эрүү шүүлт тулгах" гэмт хэргийн шинжийг тодорхой болгох;

г.шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газраас бодлогын арга хэмжээ авч ажиллах;

д.албан үүргээ гүйцэтгэх явцдаа иргэдийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн албан тушаалтны талаарх мэдээллийн сан үүсгэх замаар ажил, албан тушаалд томилгодоход зайлшгүй харгалзан үзэх нөхцөл байхаар Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээг чангатгах;

е.эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх криминолги судалгаа болон энэ төрлийн гомдол шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл байдлын талаа хөндлөнгийн судалгааны байгууллагаар суурь судалгаа хийлгэх;

ё.цэргийн албан дахь дүрмийн бус харьцааны үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, цэргийн номлол, үзэл баримтлалыг хүний хөгжилтэй уялдуулан шинэчлэх, цэргийн ангид үйлчилж буй дүрэм журмыг хүний эрхийн зарчимд нийцүүлэх, дүрмийн бус харьцааны хэлбэрүүдийг уг үндсээр нь таслан зогсоох, цэргийн иргэний хяналтыг сайжруулах талаарх дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргаж, суурь болон зорилтот түвшнээр ангилж, хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон холбогдох бодлогын баримт бичгийн

төсөл боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ж.улс төрийн болон бусад ашиг сонирхлын үүднээс эрүүгийн хилс хэрэгт хэлмэгдсэн талаар тодорхой баримт бүхий өргөдөл, гомдол гаргаж буй иргэдийн хүсэлтийг шалгах, нягтлах, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаарх санал, дүгнэлтийг бэлтгэн Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах.

2.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны даргаар ахлуулан байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

3.Энэ тогтоолын 2 дахь хэсэгт заасан ажлын хэсгийн зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг Улсын Их Хурлын даргын 2024 оны 112 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах талаар холбогдох хууль тогтоомжийг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн зорилт, чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахыг тус ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Хүний эрхийн дэд хорооны дарга (С.Эрдэнэболд) нарт даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, Улсын Их Хурлын 2025 оны Намрын чуулганы хугацаанд багтаан тогтоолын хэрэгжилттэй танилцах хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ЦОГТБААТАР

ЭРҮҮ ШҮҮЛТГҮЙ МОНГОЛЫН ТӨЛӨӨ - УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд Монгол Улс тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон холбогдох хүний эрхийн гэрээ, конвенцод нэгдэн орсон улс орнууд “Хэнд ч эрүү шүүлт тулгах, эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэхгүй байх” үүргийг хүлээсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр”-ийг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, Шүүхийн сахилгын хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Казакстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллага (АРТ) болон Дотоод хэргийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Их Засаг олон улсын их сургууль, Шихихутуг их сургууль, Монголын үндэсний их сургууль, Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо, Иргэдийн шударга шүүх, Сэтгэл зүйн мэдрэмж төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл оролцон зохион байгуулсан.

Тус эрдэм шинжилгээний бага хурлын үеэр оролцогчид “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгыг дэвшүүлэн Монгол Улсын төрийн холбогдох байгууллагуудыг тус уриалгад нэгдэн ажиллах санаачилгыг гаргасан бөгөөд дурдсан байгууллагууд нэгдээд байна.



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ
ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ГИШҮҮН

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976-11) 32 71 36
Цахим шуудан: info@nhrcm.gov.mn
Цахим хуудас: www.nhrcm.gov.mn

2025.12.11 № 08/2308

танай _____ -ны № _____ -т

Хамтран ажиллах тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд Монгол Улс тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элссэнээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон холбогдох хүний эрхийн гэрээ, конвенцод заасны дагуу "Хэнд ч эрүү шүүлт тулгах, эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэхгүй байх" үүргийг хүлээсэн.

Жил бүрийн 06 дугаар сарын 26-ны өдөр тохиодог "Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр"-ийг тохиолдуулан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас "Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, Шүүхийн сахилгын хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Казакстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Бүгд Найрамдах Киргизстан Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв, Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны сан, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг АРТ-Олон улсын байгууллага болон Дотоод хэргийн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Их Засаг олон улсын их сургууль, Шихихутуг их сургууль, Монголын үндэсний их сургууль, Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо, Иргэдийн шударга шүүх, Сэтгэл зүйн мэдрэмж төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл оролцон зохион байгуулсан.

Тус эрдэм шинжилгээний бага хурлын үеэр оролцогчид "УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ" буюу "Эрүү шүүлтгүй Монголын төлөө" уриалгыг дэвшүүлэн Монгол Улсын төрийн холбогдох байгууллагуудыг тус уриалгад нэгдэн ажиллах санаачилгыг гаргасан болно.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх эрхийг ханган ажиллаж, "Эрүү шүүлтгүй Монголын төлөө-УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ" уриалгад Танай байгууллагыг нэгдэхийг уриалж байна.

Хариуг албан бичгээр ирүүлэхийг хүсье.
Хавсралт .1 хуудастай.

ГИШҮҮН



Я.ЦЭЛМЭН

УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхтэй бөгөөд эрүү шүүлтээс ангид байх эрхийг аливаа хязгаарлалтгүйгээр эдлэх нь эрх чөлөө, шударга ёсны үндэс мөн.

Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлснээр хүн бүр эрүү шүүлтээс ангид, аюулгүй байх эрх хангагдах учиртайг үүгээр хүлээн зөвшөөрч, үүний тулд дараах хүчин чармайлтыг гаргахаа амлаж байна:

- ✓ Хүн бүр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн боловсролыг дээшлүүлэх, үүрэг хүлээгчдээс эрхээ эдлүүлэхийг шаардах чадамжийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа болон талуудын хамтын ажиллагааны хүрээнд сургалт, нөлөөлөл, олон нийтийн кампанит ажлын үр нөлөөг дэмжин ажиллах;
- ✓ Хууль сахиулах байгууллагын алба хаагч бүр “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх” Мендезийн зарчмуудыг мөрдлөг болгон ажиллахад сургалт, нөлөөллийн ажлын үр нөлөөг үргэлжлүүлэн дэмжих;
- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг хүний эрхийн түгээмэл баримт бичиг болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулах олон улсын дүрэм, Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн хэрэгжүүлэхэд сургалт, нөлөөллийн ажлын үр нөлөөг дэмжин ажиллах;
- ✓ Ямар ч үед, ямар ч нөхцөлд эрүү шүүлт тулгахаас бүрмөсөн татгалзах.

Энэхүү тунхаглалыг дэмжин нэгдсэнээр бид Монгол Улсад хүний эрхийг бүх нийтээрээ хүндэтгэн хамгаалж, сахин биелүүлдэг, цагдан хоригдсон, саатуулагдсан, хорих ял эдэлж буй, эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр эрүү шүүлтээс ангид, аюулгүй байх “Эрүү шүүлтгүй Монгол”-ыг бий болгоход хувь нэмрээ оруулж байна.



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Ж.Самбуугийн гудамж 18, Шүүхийн сахилгын хороо
Утас: 77113838, Факс: 77113838
Цахим шуудан: info@judiscom.mn
Цахим хуудас: www.judiscom.mn

2025.11.27 № 01/48

танай _____-ны № _____-т

「 МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС ЭРҮҮ
ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ГИШҮҮН Я.ЦЭЛМЭН ТАНАА

「 Хариу хүргүүлэх тухай 」

Таны 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08/2088 дугаартай тоот албан бичгийг хүлээн авч, танилцлаа.

Манай байгууллагын зүгээс Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс сэргийлж, халдашгүй чөлөөтэй байх эрхийг ханган ажиллана гэдгээ илэрхийлэн “Эрүү шүүлтгүй Монголын төлөө-УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” уриалгад нэгдэж байна.



Шүүхийн сахилгын хороо
Шүүхийн сахилгын хорооны
Дарга
Доржгочоо Ариунтуяа
2025-11-27 17:34:29



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18

Утас: 51-260855, Факс: (976-51)263739

Цахим шуудан: gro@prosecutor.mn

Цахим хуудас: www.prosecutor.mn

2025.12.08 № Ц-02/1577

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮН
Я.ЦЭЛМЭН ТАНАА**

Таны 2025 оны 11 дүгээр сарын 25- ны өдрийн 08/2088 дугаар албан бичгийг хүлээн авч танилцлаа.

Прокурорын байгууллага “Эрүү шүүлтгүй Монголын төлөө- УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” уриалгад нэгдэж байгаагаа үүгээр илэрхийлж байна.



МАКСИМ ЧИНБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ГАЗАР
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011 0251, Факс: (976) 7011 0251
И-мэйл: comcor@jaac.mn, Вэб сайт: http://jaac.mn

2025.12.02 № 03/20352

танай _____-ны № _____-т

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ГИШҮҮН Я.ЦЭЛМЭН ТАНАА

Таны 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн
08/2098 дугаартай албан бичгийг хүлээн авч, танилцлаа.

Тус байгууллагаас “Эрүү шүүлтгүй Монголын төлөө
Улаанбаатарын тунхаглал” уриалгыг дэмжин нэгдэж
байгаа бөгөөд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр
хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон
харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлж,
хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх
эрхийг хангаж ажиллах болно.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ



142503004487



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРҮУЛАГЧ АГЕНТЛАГ
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

Энхтайваны өргөн чөлөө 51,
 Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
 Утас/Факс: (976-51) 26 59 14, (976-11) 45 29 33,
 Цахим шуудан: gsmaf@mail.gov.mn
 Цахим хуудас: www.gsmaf.gov.mn

2026.03.05 № 01/2026
 танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 08/2309 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдын нөхөн төлүүлэлт, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаас дэвшүүлсэн “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгад Зэвсэгт хүчний Жанжин штаб нэгдэж байна.

Энэ хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабаас 2026 оны 02/19 дүгээр албан бичгээр харьяа Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагуудад “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ” буюу “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” уриалгад нэгдэж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх эрхийг ханган ажиллах чиглэлийг хүргүүлсэн.

Дээрх уриалгын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг 2026 оны I улирлын байдлаар нэгтгэн хүргүүлэхээр төлөвлөсөн болно.

Хавсралт /... хуудастай.

ДАРГА
 ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ



С.ГАНБЯМБА

1310030643



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Жуулчны гудамж-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160, Утас: 9226 3656,
9226 3017, Факс: (976) 9226 3656
Цахим шуудан: info@gia.gov.mn,
Цахим хуудас: www.gia.gov.mn


2025.12.02 № АНЭТ01/491
танай 2025.11.24 -ны № 08/2098 -т

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ГИШҮҮН Я.ЦЭЛМЭН ТАНАА**

Танаас ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08/2098 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Тагнуулын байгууллага нь эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид халдашгүй, чөлөөтэй байх эрхийг цаашид ч ханган ажиллахаа илэрхийлж “Эрүү шүүлтгүй Монголын төлөө-Улаанбаатарын тунхаглал” уриалгад нэгдэж байгаагаа үүгээр илэрхийлье.

ДАРГА



П.ОДОНБААТАР

D:\2025 oni A5 alban toot 1.doc/

09104457



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 15160, Утас 70191087, Факс: (976) 70191087,
Цахим шуудан: info@police.gov.mn,
Цахим хуудас: www.police.gov.mn

「 МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ
ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ГИШҮҮН Я.ЦЭЛМЭН ТАНАА

2025.12.03 № 01/1529
танай _____ -ны № _____ -т


「 Эрүү шүүлтгүй Монголын төлөө
Улаанбаатарын тунхаглалд нэгдэн
ажиллах тухай

Хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүү шүүлт болон бусад хэлбэрийн харгис, хүнийг хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцахыг хориглосон НҮБ-ын Конвенц, түүний нэмэлт протоколыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ирүүлсэн уриалгыг хүлээн авч танилцлаа.

Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид байх, халдашгүй чөлөөтэй байх эрхийг ханган ажиллах “Эрүү шүүлтгүй Монголын төлөө-УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ”-ын зорилго, зарчим цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай бүрэн нийцэж байна.

Иймд Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, хүний эрхийг хангах, аливаа эрсдэлтэй нөхцөл байдлыг илрүүлэх, хяналт тавих, дэмжлэг үзүүлэх цогц үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх тус уриалгад цагдаагийн байгууллагаас дараах байдлаар нэгдэж байгааг үүгээр илэрхийлж байна. Үүнд:

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтыг алба хаагчдад зохион байгуулж, уриалгыг хэрэгжүүлэх;
2. Эрүү шүүлттэй холбоотой эрсдэлийг бууруулах бодит үр дүнд хүрэх арга хэмжээг Хүний Эрхийн Үндэсний комисстой хамтран хэрэгжүүлэх;
3. Хүний эрхийг хангах, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах зэрэг болно.

 Цагдаагийн ерөнхий газар
 Удирдлага
 Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч
 Жамсранжав Болд
 2025.12.03 12:15



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 63 32, Факс: (976-11) 32 99 33,
Цахим шуудан: info@cd.gov.mn,
Цахим хуудас: www.cd.gov.mn

2025.12.05 № 01/8145
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ГИШҮҮН Я.ЦЭЛМЭН ТАНАА

Танай 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08/2098 дугаар албан бичгийг хүлээн авч танилцан Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах зорилгоор Улаанбаатар хотын нийт хорих анги, нэгжүүдэд “УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ”-ыг хүргүүлж хамтран ажиллах чиглэлийг хүргүүлсэн болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
~~ХУРАНДАА~~ А НАМСАМАНД



1501084463



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР
ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЛБА

Хуульчдын гудамж 13/1, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 32 07 23, Факс: (976-11) 32 07 23,
Цахим шуудан: khyea@cd.gov.mn,
Цахим хуудас: www.alba.cd.gov.mn

2025.12.12 № 02/1529
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ
ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮН
Я ЦЭЛМЭН ТАНАА

Танай 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08/2098 дугаар албан бичгийг хүлээн авч танилцан Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хүн бүр эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах зорилгоор хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдэд "УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ"-ыг хүргүүлж дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиглэлийг хүргүүлсэн болно.

ДАРГА,
ХУРАНДАА  С.ЛХАГВАСҮРЭН



1501081207



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бота тойруу 44а, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14151
Утас: 26 21 09, Факс: (976-51) 26 27 37,
Цахим шуудан: info@cfga.gov.mn,
Цахим хуудас: www.cfga.gov.mn

2025.12.30 № 01/950
Танай 2025.12.11 -ны № 08/2307 -г

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ
ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮН
Я.ЦЭЛМЭН ТАНАА

Танаас ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичигтэй танилцлаа.

Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын үеэр оролцогчдын баталсан "УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ"-ыг дэмжиж байна.

Иймд тус газрын зүгээс тунхаглалд дурдагдсан хүчин чармайлтыг гаргахаа илэрхийлж, уриалгад нэгдэж буйгаа үүгээр мэдэгдэж байна.



Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
ерөнхий газар
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Баярсайхан
2025.12.30 11:48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 83

| | |
|-----------|---|
| АНТХ | Ахмад настны тухай хууль |
| АНҮТ | Ахмад настны үндэсний төв |
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ГБХНХЯ | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ДХИС | Дотоод хэргийн их сургууль |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗХЖШ | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| ЗШШТХ | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| НЦУГ | Нийслэлийн цагдаагийн удирдах газар |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| СУХХЭАЭТХ | Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль |
| СЭМТХ | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль |
| СЭМҮТ | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв |
| ТАЗ | Төрийн албаны зөвлөл |
| ТАТХ | Төрийн албаны тухай хууль |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЕГ | Тагнуулын ерөнхий газар |
| УЕП | Улсын ерөнхий прокурор |
| УЕПГ | Улсын ерөнхий прокурорын газар |
| УСУБ | Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага |
| ЦАТХ | Цагдаагийн албаны тухай хууль |
| ХБХЭТХ | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль |

| | |
|-------------------------------|--|
| ХГБХХЕГ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар |
| ХЗБХ | Хууль зүйн байнгын хороо |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХтХ | Хөдөлмөрийн тухай хууль |
| ХХтХ | Хүүхэд хамгааллын тухай хууль |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ХЭтХ | Хүүхдийн эрхийн тухай хууль |
| ХЭҮБ | Хүний эрхийн үндэсний байгууллага |
| ХЭҮК | Хүний эрхийн Үндэсний Комисс |
| ХЭҮКтХ | Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ШСЭСК | Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ШШГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх |
| ШШГтХ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц | Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц |
| ЭХХШтХ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль |

